ӨМНӨГӨВИЙН ХЭРЭГСЭЛИЙН
НОМЫН ФОНД



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 1

— Монгол Улсын Иргэний хууль
— Шинэчлэн найруулсан иргэний хуулийг дагаж мөрдөх журмын тухай Монгол Улсын хууль
— Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын хууль
— Хөдөлмөрийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын хууль
— Иргэний эрүүл мэндийн даатгалын хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын хууль
— Банкны хуульд өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын хууль
— Онцгой албан татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын хууль

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР

1995 он

ХҮНДЭТ УНШИГЧИД АА!

«Төрийн мэдээлэл», «Төр, засгийн ажилтанд тусламж» сэтгүүлийг захиалан уншиж байгаа нийт уншигчиддаа талархал илэрхийлье. Та бүхэн эдгээр сэтгүүлээ 1995 оны 2 дугаар улиралд захиалж алба ажилдаа ашиглахаа мартуузай.

«Төрийн мэдээлэл» сэтгүүлд:

— Улсын Их Хурлаас батлагдсан хууль тогтоомжууд;

— Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг захирамжууд;

— Засгийн газрын тогтоол шийдвэрүүд;

Үндсэн Хуулийн Цэцийн дүгнэлт тогтоолууд;

— Монгол Улсын Хуулийн талаарх Улсын Дээд Шүүхийн албан ёсны тайлбарууд бүрэн эхээрээ хэвлэгдэнэ.

«Төрийн мэдээлэл» сэтгүүлийн хавсралт **«Төр, засгийн ажилтанд тусламж»-д:**

— УИХ-аас батлан гаргаж буй хууль тогтоомжуудын хураангуй утга агуулга, зарим шинэлэг зүйлс, онол, практикийн чухал асуудал, тэдгээрийг хэрэгжүүлэх аргачлал, асуулт-хариултын хэлбэрээр ойлгомжтой өгүүлсэн аман ухуулгад ашиглах зориулалт бүхий ярианы сэдэв;

— Монгол Улсын иргэдээс төр, засагтаа хандаж хууль тогтоомж, төрийн байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгох, хууль тогтоомжийн сурталчилгааг сайжруулах талаар ирүүлсэн ажил хэрэгч санал хүсэлт, санаа авуушгай шүүмжлэл;

— Аймаг, хотын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, засаг даргын тамгын газруудын үйл ажиллагааны дэвшилт арга хэлбэр, туршлага;

— Гадаад орнуудын парламентын үйл ажиллагаатай холбогдсон сонирхолтой мэдээ, мэдээлэл нийтлэгдэнэ.

Зөвхөн «Төрийн мэдээлэл» сэтгүүл, «Ардын эрх» сонинд нийтлэгдсэн хууль тогтоомжуудыг албан ёсоор ашиглаж болох үндсэн эх гэж үзэхийг хуулиар заасан байдгийг эрхэм уншигч Танд сануулахад илүүдэх юун. Төр, засгийн албан ёсны үнэн зөв мэдээллийг анхдагч эхээр нь авч албан ажил, ахуй амьдралдаа ашиглая гэвэл Та **«Төрийн мэдээлэл»** сэтгүүл, түүний хавсралт **«Төр, засгийн ажилтанд тусламж»**-ийг захиалаарай.

— «Төрийн мэдээлэл» сэтгүүл нэг дугаар нь 350 төгрөг.

— «Төр, засгийн ажилтанд тусламж» сэтгүүл нэг дугаар нь 200 төгрөг. Улиралд хоёр сэтгүүл тус бүр 3 дугаар гарна.

Захиалгыг аймаг, хотын холбооны салбаруудаар дамжуулан хийж, үнийг «Монгол шуудан» компанийн 200002 тоот дансанд шилжүүлнэ.

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

(ХУУЛЬ, ТОГТООЛ, ЗАРЛИГ, ШИЙДВЭР, ХУУЛИЙН ТАЙЛБАР)

Монгол Улсын Их Хурлын Тамгын Газар

1995 оны I сар № 1 (32)

ГАРЧИГ

I. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

Монгол Улсын Иргэний хууль 1—138
Шинэчлэн найруулсан Иргэний хуулийг дагаж мөрдөх журмын тухай 139
Хууль, хуулийн заалт, хүчингүй болсонд тооцох, өөрчлөх тухай 140
Тогтоол, зарлиг хүчингүй болсонд тооцох тухай 142
Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 143
Зарлиг хүчингүй болсонд тооцох тухай 144
Агаарын зайд нислэг үйлдэх тухай Монгол Улсын хуульд нэмэлт оруулах тухай 145
Хөдөлмөрийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 146
Иргэний эрүүл мэндийн даатгалын хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай 148
Хууль хүчингүй болсонд тооцох тухай 150
Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татварын хуульд нэмэлт оруулах тухай 151
Банкны хуульд өөрчлөлт оруулах тухай 152
Онцгой албан татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 153

II. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

Монгол Улсын Иргэний хууль батлагдсантай холбогдуулж авах зарим арга хэмжээний тухай № 76 155
Улсын Их Хурлын гишүүний нэмэгдэл бий болгох тухай № 80 156
Монгол Улсын 1995 оны улсын төвлөрсөн төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулж авах зарим арга

хэмжээний тухай № 83
17. Төрөөс мөнгөний бодлогын талаар 1995 онд баримтлах чиглэлийг батлах тухай № 84
18. Тэтгэвэр бодох дундаж хөдөлмөрийн хөлсний тухай № 85
19. Норматив тогтоох тухай № 86
20. Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн тухай № 88
21. Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн тухай № 89
22. Өршөөл үзүүлэх хуулийн тухай № 90
23. Шалгалтын дагуу авах арга хэмжээний тухай № 91

III. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

24. Н. Бавууг Элчин сайдаар томилох тухай № 112
25. Д. Цахилгааныг Элчин сайдаар томилох тухай № 114
26. Л. Үдвалыг Элчин сайдаар томилох тухай № 116
27. Х. Дамдинд Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн цол олгох тухай № 117
28. Ц. Үенчид Монгол Улсын гавьяат жүжигчин цол олгох тухай № 118
29. Л. Оюунд Монгол Улсын гавьяат жүжигчин цол олгох тухай № 119
30. Б. Алагаад Монгол Улсын ойн гавьяат ажилтан цол олгох тухай № 120
31. Т. Чимэддоржийг Элчин сайдаар томилох тухай № 123
32. Санаачилгыг дэмжих тухай № 129
33. Л. Санжаад Монгол Улсын хүний гавьяат эмч цол олгох тухай № 130
34. И. Очирбалыг Элчин сайдаар томилох тухай № 140
35. Б. Шүхэртэд Монгол Улсын гавьяат эдийн засагч цол олгох тухай № 141
36. Сэнгийн Эрдэнэд Монгол Улсын Ардын уран зохиолч цол олгох тухай № 155
37. Цэвэгжавын Хасбаатарт Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн цол олгох тухай № 156
38. Дүгэржавын Маамд Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн цол олгох тухай № 157

IV. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

39. Ц. Жигжиджавын нэрэмжит болгох тухай № 173
40. Журам батлах тухай № 175
41. Комиссыг өөрчлөн байгуулах тухай № 176
42. Түлш, эрчим хүчний үйлдвэрүүдийн талаар авах зарим арга хэмжээний тухай № 177
43. Азийн суперкомпьютерийн судалгааны төв байгуулах тухай № 191
44. Журам батлах тухай № 212
45. Худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай № 221

V. МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

46. Монгол Улсын захиргааны хариццагын тухай хуулийн 30[1] дүгээр зүйлийг тайлбарлах тухай № 177
47. Эрүүгийн хуулийн зарим зүйлд заасан гэмт хэргийн харьяаллын тухай № 178

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

4 оны 11 дүгээр
ын 01-ний өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙ ХУУЛЬ

(шинэчилсэн найруулга)

I хэсэг

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Үндсэн зүйл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1. Иргэний хууль нь иргэний гүйлгээнд оролцогчдын зүйн байдлыг тодорхойлж, эд хөрөнгийн болон түүнтэй боотой эд хөрөнгийн бус амины харилцааг уг харилцаанд лцогчдын эрх тэгш байдал, хүсэл зоригийн болон эд өнгийн бие даасан байдлыг үндэслэн зохицуулна.

2. Захиргааны талаар нэг этгээд нь нөгөөдөө захиргтай холбогдсон эд хөрөнгийн харилцаа, түүнтэй холбоо- эд хөрөнгийн бус амины харилцаанд Иргэний хууль члэхгүй.

2 дугаар зүйл. Иргэний хууль тогтоомж

1. Иргэний хууль тогтоомж нь Үндсэн хууль, энэ хууль он тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоом- с бүрдэнэ.

2. Үндсэн хууль, энэ хуулийн ерөнхий үндэслэлийг зөрч- бусад хуулийг шүүх хэрэглэхгүй.

3. Энэ хуульд заасан эрх, үүрэгтэй холбогдсон маргаа- шийдвэрлэхэд шүүх нь төрийн захиргааны байгууллагын хэмжээ тогтоосон аливаа шийдвэрийг хэрэглэхгүй.

4. Хуульд шууд зааснаас бусад тохиолдолд иргэний нь тогтоомжийг буцаан хэрэглэхгүй.

5. Иргэний хууль хүчин төгөлдөр болохоос өмнө байгуул- гэрээнээс үүсэх харилцааг энэ хуулийн 165 дугаар зүйлд наар зохицуулна.

3 дугаар зүйл. Иргэний эрх зүйн харилцаа үүсэх үндэслэл

Иргэний эрх зүйн харилцаа дараахь үндэслэлээр үүс

1) хуульд заасан, хуульд заагдаагүй боловч агуу. хувьд хуульд үл харшлах хэлцэл;

2) иргэний эрх зүйн харилцаа үүсгэхэд чиглэсэн хийн шийдвэр;

3) хуульд заасан бол иргэний эрх зүйн харилцаа үү хэд чиглэсэн захиргааны шийдвэр;

4) оюуны үнэт зүйл бүтээх;

5) гэм хор учруулах, үндэслэлгүйгээр эд юмс олж а эзэмших;

6) иргэний эрх зүйн харилцаа үүсгэхээр хуульд за бусад үндэслэл.

4 дүгээр зүйл. Иргэний эрх зүйн харилцааны эрх, үүргийг хэрэгжүүлэх

1. Иргэн, хуулийн этгээд нь энэ хуульд заасан э гагцхүү хууль тогтоомжийг шаардлагад нийцүүлэн өө хүсэл зоригийн дагуу хэрэгжүүлнэ.

2. Иргэн, хуулийн этгээд бусдад гэм хор учруулах б бусад хэлбэрээр эрхээ хууль бусаар ашиглаж болохгүй

3. Хуулийн этгээд өрсөлдөөнийг хязгаарлах үйл а лагаа явуулах буюу хууль ёсны давуу байдлаа хууль бу ашиглаж болохгүй.

4. Энэ зүйлийн 1, 2, 3 дахь хэсэгт заасан шаардл зөрчсөн тохиолдолд шүүх, арбитр нь иймхүү зөрчил гарг этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаала татгалзаж болно.

5 дугаар зүйл. Иргэний эрх зүйн хамгаалалт

1. Иргэний эрх зүйн хамгаалалт нь зөрчигдсөн эр сэргээх зорилготой.

2. Талууд эрхээ хамгаалуулах этгээдийг хуульд за дагуу өөрсдөө сонгон тодорхойлох эрхтэй.

3. Иргэний эрх зүйн хамгаалалтыг шүүх гагцхүү лиар тогтоосон журам аргаар хэрэгжүүлнэ.

4. Гадаад улсын иргэн, хуулийн этгээд оролцсон гэ эд хөрөнгийн шинжтэй харилцаанаас үүссэн эрхийг ар хамгаалах журам, аргыг хуулиар тогтооно

5. Шүүх, арбитр нь иргэний эрхийг дараахь аргаар хамгаална:

1) эрхийг хүлээн зөвшөөрөх;

2) эрх зөрчсөн үйлдлийг таслан зогоож, зөрчигдөхийн өмнөх байдлыг сэргээх;

3) хүлээсэн үүргийг гүйцэтгүүлэх;

4) учруулсан хохирлыг арилгуулах;

5) эд хөрөнгийн бус гэм хорыг арилгах;

6) хууль болон гэрээнд заасан анз төлүүлэх;

7) бусдын эрх зөрчсөн төрийн захиргааны байгууллагын үйлдэл болон захиргааны аливаа шийдвэрийг хүчингүй болгох;

8) иргэний эрх зүйн харилцааг өөрчлөх ба дуусгавар болгох;

9) хуулиар тогтоосон бусад арга.

6 дугаар зүйл. Иргэний хууль тогтоомжийг төсөөтэй хэрэглэх

Шүүх, арбитр нь ижил төрлийн харилцааг зохицуулсан хууль байхгүй бол ойр дүүнтэй төсөөтэй харилцааг зохицуулж байгаа хуулийг хэрэглэнэ. Тийм хууль байхгүй бол иргэний эрх зүйн агуулга, зарчимд нийцүүлэн маргааныг шийдвэрлэж болно.

7 дугаар зүйл. Нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг хамгаалах

1. Иргэн, хуулийн этгээд өөрийн нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндээ гутаагдсан гэж үзвэл уг мэдээг цаалгах, нийхүү гутаагдсанаас учирсан гэм хорыг арилгуулахыг шаардах эрхтэй.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан мэдээ тараасан этгээд үнийхээ үнэн зөвийг нотолж чадахгүй бол учирсан гэм хорыг арилгах үүрэгтэй.

3. Нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гааснаас учирсан гэм хорын хэмжээ, арилгах аргыг энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу шүүх тодорхойлно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Иргэд ба хуулийн этгээд

8 дугаар зүйл. Иргэдийн иргэний эрх зүйн эрхийн чадвар

1. Монгол Улсын иргэд нь хуульд зааснаар эд юмс,

оюуны үнэт зүйлийг өмчлөх, хэлцэл хийх, зохиогчийн
эдлэх, эд хөрөнгө, эрх өвлөх, гэрээслэх, хуулийн этгээд б
гуулах, хуулийн этгээд байгуулахгүйгээр аж ахуй эрхл
оршин суух газар, эрхлэн хийх ажил, мэргэжлээ сон
авах, хуулиар хориглоогүй бусад үйл ажиллагаа явуул
эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус амины бусад
эдэлнэ.

2. Иргэний эрх зүйн эрхийн чадвар буюу иргэний
эдлэх, үүрэгтэй байх чадварыг Монгол Улсын иргэд тэ
гаална;

3. Иргэний эрх зүйн эрхийн чадвар нь хүний төр
цагаас бий болж нас барснаар дуусгавар болно.

4. Иргэн хуулийн этгээд байгуулахгүйгээр аж ахуй э
лэх нөхцөл, журмыг хуулиар тогтооно.

9 дүгээр зүйл. Иргэдийн иргэний эрх зүйн эрхийн бүрэн чадамж

Иргэний эрх зүйн эрхийн чадамж буюу иргэн өөр
үйлдлээр өөртөө эрх олж авах, үүрэг бий болгох чад
арван найман наснаас бүрэн үүснэ.

10 дугаар зүйл. Бага насны хүмүүсийн иргэний эрх зүйн эрхийн зарим чадамж

1. Бага насны буюу арван дөрвөн насанд хүрээгүй
мүүсийн хийх хэлцлийг түүний нэрийн өмнөөс хууль ёс
төлөөлөгч-эцэг эх, асран хамгаалагч хийнэ.

2. Бага насны хүмүүс өөртөө хохиролгүй бөгөөд хийм
биелэх. ахуйн чанартай жижиг хэлцэл хийж болно.

3. Бага насны хүмүүсийн бусдад учруулсан гэм хор
энэ хуулийн 381 дүгээр зүйлд заасан журмаар арилгана

11 дүгээр зүйл. Иргэдийн иргэний эрх зүйн эрхийн хэсэгчилсэн чадамж

1. Насанд хүрээгүй буюу арван дөрвөөс арван найм х
тэлх насны хүмүүс хууль ёсны төлөөлөгч-эцэг, эх, харгалз
дэмжигчийн зөвшөөрлөөр хэлцэл хийнэ.

2. Насанд хүрээгүй хүмүүс хууль ёсны төлөөлөгчи
зөвшөөрөлгүйгээр дараахь эрхээ бие даан хэрэгжүү
болно:

1) өөрийн хөдөлмөрийн хөлс, оюутны тэтгэлэг, тэдгэ
тэй адилтгах бусад орлого, тэдэнд өөрийн үзэмжээр захир

эцуулахад нь зорилуулж шилжүүлсэн эд хөрөнгийг захиран эцуулах;

2) өөртөө хохиролгүй бөгөөд хиймэгц биелэх, ахуйн чанартай жижиг хэлцэл хийх;

3) энэ зүйлийн 2 дахь хэсгийн 1-д заасан орлогыг банкны данстай байгууллагад оруулах, түүнийг захиран зарцуулах.

3. Арван зургаагаас арван найм хүртэлх насны хүмүүс эрүүгийн хариуцлага хүлээнэ.

4. Насанд хүрээгүй хүмүүсээс бусдад учруулсан гэмт хэргийг энэ хуулийн 383 дугаар зүйлд заасан журмаар шалгана.

12 дугаар зүйл. Насанд хүрээгүй хүмүүсийг иргэний эрх зүйн эрхийн бүрэн чадамжтай гэж зарлах

1. Шүүх хүндэтгэн үзэх шалтгаан байвал арван зургаас дээш арван найм хүртэлх насны хүмүүсийг түүний хүсэлтээр эрхийн бүрэн чадамжтай гэж зарлаж болно.

2. Эрхийн бүрэн чадамжтай гэж зарлагдсан хүмүүсийн үйлдэх үүргийн талаар түүний эцэг, эх, харгалзан дэмжигч хариуцлага хүлээхгүй.

3. Эцэг, эх, харгалзан дэмжигчийн хүсэлтээр шүүх эрхийн бүрэн чадамжтай гэж зарласныг хүчингүй болгож болно.

13 дугаар зүйл. Иргэдийн иргэний эрх зүйн эрхийн чадамжийг хязгаарлах

1. Мансууруулах бодис, согтууруулах ундааны зүйлийг хэрэглэдэг этгээдийн эрхийн чадамжийг шүүх хязгаарлаж, харгалзан дэмжигчийг томилж болно.

2. Эрхийн чадамж нь хязгаарлагдсан этгээд хязгаарлагдсан чадамжийнхаа хүрээнд харгалзан дэмжигчийн зөвшөөрөлгүй аливаа хэлцэл хийнэ.

3. Эрхийн чадамжийг хязгаарлах үндэслэл болсон нөхцөл байдал арилбал тухайн этгээдэд тогтоосон хязгаарлалт шүүхийн шийдвэрээр хүчингүй болгож, харгалзан дэмжигчийг үүргээс нь чөлөөлнө.

4. Эрхийн чадамж нь хязгаарлагдсан этгээд бусдад гэм хор учруулбал эрхийн бүрэн чадамжтай иргэний адил үзэж хариуцлага хорыг арилгуулна.

14 дүгээр зүйл. Иргэний эрх зүйн эрхийн бүрэн чадамжтай иргэнийг харгалзан тусла

1. Эрүүл мэндийн байдлаас шалтгаалан эрх, үүр бичлэн хэрэгжүүлэх боломжгүй эрхийн бүрэн чадамж иргэнд өөрийнх нь хүсэлтээр хуульд заасан журмын да харгалзан туслагч томилж болно.

2. Харгалзан туслагчийг тусламж авч байгаа иргэ зөвшөөрлөөр асран хамгаалах, харгалзан дэмжих байгу лага томилно.

3. Харгалзан туслагч нь тусламж авч байгаа иргэний хөрөнгийг ашиглах, захиран зарцуулахтай холбогдсон хэ лийг гагцхүү түүний зөвшөөрлөөр хийнэ.

15 дугаар зүйл. Иргэний эрх зүйн эрхийн чадамжаа бүрэн алдах

1. Сэтгэцийн өвчний улмаас өөрийн үйлдлийн учир х богдлыг ойлгохгүй. өөрийгөө зөв удирдаж чадахгүй бол иргэнийг шүүх эрхийн бүрэн чадамжгүй гэж тооцож, түү асран хамгаалалт тогтооно.

2. Эрхийн бүрэн чадамжгүй гэж тооцогдсон иргэний рийн өмнөөс асран хамгаалагч хэлцэл хийнэ.

3. Эрхийн бүрэн чадамжгүй гэж тооцогдсон иргэ бусдад учруулсан гэм хорыг энэ хуулийн 382 дугаар зү заасан журмаар арилгана.

4. Эрхийн бүрэн чадамжгүйд тооцох үндэслэл бол нөхцөл байдал арилбал шүүх урьд гаргасан шийдвэ хүчингүй болгож, асран хамгаалагчийг үүргээс нь чөлөө

16 дугаар зүйл. Иргэний эрх зүйн эрхийн чадвар, чадамжийг хязгаарлахад чиглэсэн хэлцэл

1. Эрхийн чадвар, чадамжийг хуулиар тогтоосон ж маар гадуур хязгаарлах буюу хасаж болохгүй.

2. Эрхийн чадвар, чадамжийг хязгаарлах буюу хаса чиглэсэн хэлцэл хүчин төгөлдөр бус байна.

17 дугаар зүйл. Оршин суугаа газар

1. Иргэний оршин суугаа газрыг хуулийн дагуу түү харьяалагдан бүртгүүлсэн засаг захиргаа, нутаг дэвсгэр нэгжээр тодорхойлно.

2. Бага насны хүмүүс буюу бусдын асран хамгаалалтанд байгаа иргэний оршин суугаа газрыг тэдгээрийн эцэг, эх, асран хамгаалагчийн оршин суугаа газраар тодорхойлно.

18 дугаар зүйл. Иргэнийг сураггүй алга болсонд тооцох

1. Оршин суугаа газраасаа алга болсноос хойш хоёр жилийн хугацаанд хаана байгаа нь мэдэгдэхгүй, сураг чимээгүй болсон иргэнийг сонирхогч этгээдийн хүсэлтээр шүүх сураггүй алга болсонд тооцож болно.

2. Сураггүй алга болсон иргэний тухай сүүлийн удаа мэдээ авсан өдөр нь тодорхойгүй бол дараа сарын нэгнийг алга болсон өдөр гэж тооцно. Мэдээ авсан сар нь тодорхойгүй бол дараа жилийн нэгдүгээр сарын нэгнийг алга болсон өдөр гэж тооцно.

3. Сураггүй алга болсон иргэний эд хөрөнгөд эрхлэн хамгаалалт тогтоох бөгөөд түүний бусдыг тэжээн тэтгэх, татвар төлөх зэрэг хууль ёсоор гүйцэтгэвэл зохих үүргийг уг эд хөрөнгөөр гүйцэтгэнэ.

4. Сураггүй алга болсонд тооцогдсон иргэн эргэж ирэх буюу байгаа газар нь тогтоогдвол урьд гаргасан шийдвэрээ шүүх хүчингүй болгоно.

5. Иргэн сураггүй алга болсонд тооцогдсоноос хойш энэ зүйлийн 3 дахь хэсэгт зааснаас өөр үндэслэлээр бусдад үнэ төлбөргүй шилжсэн бөгөөд бэлэн байгаа эд хөрөнгөө буцаан авахыг уг иргэн эргэж ирсэн үедээ шаардах эрхтэй.

6. Сураггүй алга болсонд тооцогдсон иргэний эд хөрөнгийг эрхлэн хамгаалагч үрэгдүүлсэн бол шүүх тухайн нөхцөл байдлыг харгалзан уг эд хөрөнгийн үнийг бүрэн буюу хэсэгчлэн төлүүлэхээр шийдвэрлэж болно.

19 дүгээр зүйл. Иргэнийг нас барсан гэж зарлах

1. Сураггүй алга болсонд тооцогдсоноос хойш, эсхүл амь үрэгдэж болох аюултай нөхцөл байдалд алга болсноос хойш нэг жилийн турш амьд байгаа эсэх нь мэдэгдэхгүй байгаа иргэнийг сонирхогч этгээдийн хүсэлтээр шүүх нас барсан гэж зарлаж болно.

2. Иргэнийг нас барсан гэж зарласан шүүхийн шийдвэрийг үндэслэн түүнийг нас барсан тухай иргэний гэр бүлийн байдлын бүртгэлд тэмдэглэнэ.

3. Иргэнийг нас барсан гэж зарласан шүүхийн шийдвэр

хуулийн хүчин төгөлдөр болсон өдрийг түүний нас барса
өдөр гэж үзнэ.

4. Амь үрэгдэж болох аюултай нөхцөл байдалд буюу тодорхой аюул, ослын улмаас нас барсан гэж үзэх үндэстэй үед алга болсон иргэнийг нас барсан гэж зарласан бол шүү түүний нас барсан байж болох өдрийг уг иргэний нас барса өдөр гэж тооцож болно.

5. Нас барсан гэж зарлагдсан иргэний эд хөрөнгийг өв залгамжлалын журмаар бусдад шилжүүлнэ.

6. Нас барсан гэж зарлагдсан иргэний нөхөр буюу эхнэр нь гэрлэлтээ цуцлуулах тухай хүсэлтээ хуульд заасан журмын дагуу гаргаж болно.

20 дугаар зүйл. Иргэнийг нас барсан гэж зарласан шүүхийн шийдвэрийг хүчингүй болгосноос үүсэх үр дагавар

1. Нас барсан гэж зарлагдсан иргэн эргэж ирэх буюу байгаа газар нь тогтоогдвол шүүх урьд гаргасан шийдвэрээ хүчингүй болгох ба түүнийг үндэслэн иргэний гэр бүлийн байдлын бүртгэлд хийсэн тэмдэглэлийг өөрчилнө.

2. Нас барсан гэж зарлагдсан байсан иргэн өв залгамжлалын журмаар бусдад шилжсэн эд хөрөнгөө буцаан авахаар шаардах эрхтэй.

3. Нас барсан гэж зарлагдсан байсан иргэний эд хөрөнгө төрийн өмчлөлд шилжсэн бол шүүхийн шийдвэр хүчингүй болсны дараа уг эд хөрөнгийг өмчлөгчид буцааж олгоно буюу боломжгүй бол үнийг нөхөн төлнө.

4. Нас барсан гэж зарласан шүүхийн шийдвэр хүчингүй болсон нь гэрлэлт цуцалсан шүүхийн шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл болохгүй.

21 дүгээр зүйл. Хуулийн этгээд

1. Өмчлөх буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхдээ тусгайлсан эд хөрөнгөтэй; өөрийн үйл ажиллагаагаараа эрх олж, үүрэг бий болгох чадвартай; үйл ажиллагаанаасаа үүсэн гарах үүргийг эд хөрөнгөөрөө хариуцдаг шүүх, арбитрт өөрийн нэрийн өмнөөс оролцдог байгууллагыг хуулийн этгээд гэнэ.

2. Хуулийн этгээд нь ашиг олох үндсэн зорилготой бол ашгийн төлөө, хууль буюу дүрэмд заасан өөр зорилготой бол ашгийн төлөө бус байж болно.

3. Хуулийн этгээдийн тусгайлсан эд хөрөнгийн хувьд үүний үүсгэн байгуулагч буюу оролцогч нь эд хөрөнгийн эрх, үүргээ хадгалдаг буюу хадгалдаггүй байхаар хуулиар тогтоож болно.

4. Үүсгэн байгуулагч буюу оролцогч нь тусгайлсан эд хөрөнгийн тухайд эрх, үүргээ хадгалдаг хуулийн этгээдэд компани, нөхөрлөл, хоршоо, түүнчлэн өмчлөгчөөс санхүүжэг байгууллага хамаарна.

5. Үүсгэн байгуулагч буюу оролцогч нь тухайн хуулийн этгээдийн тусгайлсан эд хөрөнгийн хувьд эд хөрөнгийн эрхээ хадгалдаггүй хуулийн этгээдэд олон нийтийн, шашны байгууллага, буяны болон бусад зорилгоор байгуулагдсан нь хамаарна.

22 дугаар зүйл. Хуулийн этгээдийн иргэний эрх зүйн эрхийн чадвар

1. Хуулийн этгээд нь үүсгэн байгуулах баримт бичигт заасан үйл ажиллагааныхаа зорилгод нийцсэн эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

2. Хуулийн этгээд нь үйл ажиллагааныхаа зорилгод харшлаагүй бөгөөд хууль тогтоомжоор хориглоогүй аливаа үйл ажиллагааг явуулж болно.

3. Хуулийн этгээд нь хуульд заасан зарим үйл ажиллагаг гагцхүү эрх бүхий байгууллагын тусгай зөвшөөрлийн дсэн дээр явуулна.

4. Хуульд заасан үндэслэл, журмын дагуу хуулийн этгэдийн эрхийг хязгаарлаж болно.

23 дугаар зүйл. Хуулийн этгээд байгуулах, үүсгэн байгуулах баримт бичиг

1. Хуулийн этгээдийг иргэн, төр, түүнээс эрх олгосон байгууллага, түүнчлэн хуульд заасан бол бусад хуулийн этгээд, гадаад улсын иргэн, байгууллага, харьяалалгүй хүн хуульд заасан журмын дагуу үүсгэн байгуулж болно.

2. Хуулийн этгээдийг байгуулахад үүсгэн байгуулах баримт бичгийг бүрдүүлэх ба түүний төрөл, хэлбэр, бүрдүүлэх журмыг хуулиар тодорхойлно.

3. Хуулийн этгээдийг үүсгэн байгуулах баримт бичиг нь эрх бүхий байгууллагын шийдвэр, дүрэм, үүсгэн байгуулах тухай гэрээ байж болно.

4. Хуулийн этгээдийн дүрмийг түүний үүсгэн байгуулагч

(оролцогч), эсхүл түүнээс эрх олгогдсон байгууллага б
тална.

5. Дүрэмд хуулийн этгээдийн нэр, оршин байгаа газа
үйл ажиллагааны зорилго, хуулийн этгээдийн байгууллаг
түүний бүрэн эрх, түүнчлэн хууль тогтоомжийн дагуу тухай
төрлийн хуулийн этгээдийн хувьд зайлшгүй шаардлагата
бусад зүйлийг заана.

6. Хуульд заасан бол хуулийн этгээдийг үүсгэн байгу
лах тухай гэрээ байгуулна.

7. Хуулийн этгээдийг үүсгэн байгуулах гэрээгээр гишүү
буюу оролцогч нь үүсгэн байгуулах талаар хамтран ажи
лах журам, өөрийн эд хөрөнгийг уг хуулийн этгээдийн өм
лөл буюу өмчлөгч биш этгээдийн хувьд энэ хуулийн 88 д
гаар зүйлд заасны дагуу эзэмших, ашиглах, захиран за
цуулах эрхэд шилжүүлэх болон үйл ажиллагаанд нь оро
цох нөхцөлийг тодорхойлно. Түүнчлэн хуулийн этгээдий
үйл ажиллагааг удирдах, хуулийн этгээдийн бүрэлдэхүүнэ
гарах нөхцөл, журам, үүсгэн байгуулагчдын хамтын ажи
лагаа, ашиг, алдагдал хуваарилах зарчим болон бусад зү
лийг тусгана.

8. Хуульд заасан бол хуулийн этгээдийг улсын бүртгэл
бүртгэнэ.

9. Хууль тогтоомжийн шаардлага хангаагүй бол бүртг
байгууллага хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэхэ
татгалзана. Иймхүү татгалзсан тухай шийдвэрийг эс зө
шөөрвөл шүүхэд гомдол гаргаж болно.

10. Хуульд заасан журмын дагуу бүртгэгдвэл зохи
хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгүүлснээр, хуули
өөрөөр заагаагүй бол бусад хуулийн этгээдийг эрх бүхи
байгууллагын шийдвэр гарч, дүрэм нь батлагдсанаар ту
тус байгуулагдсанд тооцно.

11. Хуулийн этгээд байгуулагдахаас өмнөх үйл ажилла
гаанаас үүсэх үүргийг үүсгэн байгуулагч хууль тогтоомжий
дагуу хариуцна.

24 дүгээр зүйл. Хуулийн этгээдийн нэр,
оршин байгаа газар

1. Хуулийн этгээд онцгой нэртэй байна. Хуулийн этгэ
дийн нэр нь урьд улсын бүртгэлд бүртгэгдсэн хуулийн этгэ
дийн нэртэй ижил байж болохгүй.

2. Хуулийн этгээдийн нэрийг улсын нэгдсэн бүртгэлийг бүртгэх байгууллага хөтөлнө.

3. Хуулийн этгээд нь өөрийн бэлгэдэл, барааны тэмдэгтэй байж болно.

4. Хуулийн этгээдийн нэр, барааны тэмдэг, бэлгэдлийн талаар гарсан маргааныг шүүх шийдвэрлэнэ.

5. Хуулийн этгээдийн оршин байгаа газар нь түүний байгууллагын оршин байгаа газраар тодорхойлогдоно.

25 дугаар зүйл. Хуулийн этгээдийн байгууллага

1. Хуулийн этгээд нь байгууллагаараа дамжуулан иргэний эрх зүйн харилцаанд оролцоно.

2. Хуулийн этгээдийн байгууллагын эрх зүйн байдлыг хууль буюу үүсгэн байгуулах баримт бичгээр тодорхойлно.

26 дугаар зүйл. Хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газар

1. Хууль болон үүсгэн байгуулах баримт бичигт заасан бол хуулийн этгээд нь тогтоосон журмын дагуу өөрийн салбар, төлөөлөгчийн газар байгуулж болно.

2. Хуулийн этгээдийн оршин байгаа газраас өөр газар байрлаж түүний үндсэн чиг үүргийг бүхэлд нь буюу зарим нь гүйцэтгэдэг тусгай нэгжийг салбар гэнэ.

3. Хуулийн этгээдийн оршин байгаа газраас өөр газар байрлаж, түүний хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах буюу түүний нэрийн өмнөөс хэлцэл хийх зэрэг бусад эрх зүйн үйлдэл хийдэг нэгжийг төлөөлөгчийн газар гэнэ.

4. Салбар, төлөөлөгчийн газрын эрх, үүргийг тэдгээрийн дүрэмд заана.

5. Салбар, төлөөлөгчийн газрын эрх баригчид нь хуулийн этгээдээс олгосон итгэмжлэлийн үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулна.

6. Хуулийн этгээдийн салбар нь хуулийн этгээдийн эрхгэй байж болно.

27 дугаар зүйл. Хуулийн этгээдийн хариуцлага

1. Хуулийн этгээд нь өөртөө байгаа бүх эд хөрөнгөөр үүрэг хүлээж болно.

2. Хууль буюу үүсгэн байгуулах баримт бичигт өөрөөр заагаагүй бол хуулийн этгээдийг үүсгэн байгуулагч буюу түүний эд хөрөнгийг өмчлөгч нь хуулийн этгээдийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд өмчлөгч буюу үүсгэн байгуулагчийн хүлээх үүргийг хуулийн этгээд хариуцахгүй.

3. Эд хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхтэйгээр өмчлөгчөөс санхүүждэг хуулийн этгээд нь өөр байгаа мөнгөн хөрөнгөөрөө үүрэг хүлээнэ. Тэр нь үүргий биелүүлэхэд хүрэлцэхгүй бол өмчлөгч хариуцна.

4. Өмчлөгчийн хууль бус үйл ажиллагааны улмаас хуу лийн этгээд дампуурахад хүрсэн бөгөөд хуулийн этгээдий эд хөрөнгө нь нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагы хангахад хүрэлцэхгүй бол өмчлөгч хариуцна.

28 дугаар зүйл. Хуулийн этгээдийн үйл ажиллагаа дуусгавар болох

1. Хуулийн этгээдийн үйл ажиллагаа нь энэ хуульд заас наар өөрчлөн байгуулагдсан буюу татан буугдсанаар дуус гавар болно.

2. Хуулийн этгээдийг хуульд заагаагүй үндэслэл, жур маар өөрчлөн байгуулах, татан буулгах талаар бусад эт гээдтэй хийсэн хэлцэл хүчин төгөлдөр бус байна.

29 дүгээр зүйл. Хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах

1. Хуулийн этгээдийн эд хөрөнгийг өмчлөгч буюу түү нээс эрх олгосон байгууллага, түүнчлэн үүсгэн байгуула баримт бичгээр эрх олгосон байгууллагын шийдвэрээр хуу лийн этгээдийг өөрчлөн байгуулж (нэгдэх, нийлэх, хуваах тусгаарлах, өөрчлөх) болно.

2. Хуулийн этгээдийг өөрчлөн байгуулахад энэ хуулий 31 дүгээр зүйлийн зохих заалтад заасан журмыг баримтална

30 дугаар зүйл. Хуулийн этгээдийг өөрчлөн байгуулснаас үүсэх үр дагавар

1. Хуулийн этгээдийг нийлүүлэх, тусгаарлах буюу өөрч лөхөд түүний эрх, үүрэг нийхүү нийлүүлсэн, тусгаарласан өөрчилсний эцэст бий болсон хуулийн этгээдэд шилжинэ.

2. Хуулийн этгээд өөр хуулийн этгээдтэй нэгдвэл эрх үүрэг нь нийхүү нэгдэж бий болсон хуулийн этгээдэ шилжинэ.

3. Хуулийн этгээд хуваагдвал эрх, үүрэг нь хуульь өөрөөр заагаагүй бол шинээр бий болсон хуулийн этгээдүү дэд хувь тэнцэн шилжинэ.

31 дүгээр зүйл. Хуулийн этгээдийг татан буулгах

1. Хуулийн этгээд нь дараахь үндэслэлээр татан буугдана:

1) өмчлөгч буюу түүний эрх олгосон байгууллагын шийдвэр, түүнчлэн хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичгээр эрх олгосон байгууллагын шийдвэр гарсан;

2) дампуурлыг зарласан, хуулийг удаа дараа буюу ноцтойгоор зөрчсөнөөс татан буулгах тухай шүүхийн шийдвэр гарсан;

3) үйл ажиллагаагаа явуулах хугацаа дууссан буюу байгуулагдсан зорилгодоо хүрсэн учраас цаашид үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх шаардлагагүй гэсэн өөрийнх нь шийдвэр гарсан;

4) хуульд заасан бусад үндэслэл.

2. Татан буулгах тухай шийдвэр гаргасан байгууллагаас томилсон татан буулгах комисс татан буулгах ажлыг эрхлэн гүйцэтгэнэ.

3. Татан буулгах комисс нь хуулийн этгээд татан буугдсан тухай нийтэд мэдээлнэ.

4. Татан буулгах комиссоос нэхэмжлэгчдийн өргөдөл хүлээн авах хугацаа нь хуулийн этгээдийг татан буугдсан тухай нийтэд мэдээлснээс хойш хоёр сараас багагүй, зургаан сараас ихгүй байна.

5. Татан буугдаж байгаа хуулийн этгээдэд холбогдох нэхэмжлэлийг дараахь дарааллаар хангана:

1) бусдын амь нас, эрүүл мэндэд учруулсан гэм хорыг арилгуулахаар уг хуулийн этгээдээс гаргуулж байсан төлөөрийг гаргуулах;

2) хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсдад хөдөлмөрийн төлсийг төлөх;

3) татвар, нийгмийн даатгалын шимтгэл төлөх;

4) хууль тогтоомжид заасны дагуу бусад нэхэмжлэгчдэй тооцоо хийх.

6. Татан буугдаж байгаа хуулийн этгээдийн эд хөрөнгө төлбөр төлөхөд хүрэлцэхгүй бол түүний байгаа эд хөрөнгийг төлбөл зохих төлбөрийн хэмжээнд хувь тэнцүүлэн зохих дарааллын дагуу нэхэмжлэгчдэд хуваарилна.

7. Хуулийн этгээдэд байгаа мөнгөн хөрөнгө нь нэхэмжлэгчдийн шаардлагыг хангахад хүрэлцэхгүй бол татан

буулгах комисс түүний бусад эд хөрөнгийг хуульд зааса журмын дагуу худалдаж, төлбөрийг барагдуулж болно.

8. Нэхэмжлэгчдийн шаардлагыг хангасны дараа үлдсэ эд хөрөнгийг хууль ёсны өмчлөгч (үүсгэн байгуулагч)-ид хуульд тусгайлан заасан бол эрх бүхий этгээдэд шилжүүлнэ

9. Татан буугдаж байгаа хуулийн этгээдийн эд хөрөн гийг хүлээж авах этгээд байхгүй бол төрийн өмчлөлд шил жүүлнэ.

10. Хуульд зааснаар улсын бүртгэлд бүртгэгдвэл зохи хуулийн этгээдийг татан буугдсан тухай улсын бүртгэл бүртгэснээр, бусад хуулийн этгээдийг татан буулгах туха шийдвэр гарснаас түүний үйл ажиллагаа дуусгавар болсон тооцогдоно.

32 дугаар зүйл. Компани

1. Гишүүд (хувьцаа эзэмшигчид)-ийн оруулсан хув хөрөнгөөс бүрдэх дүрмийн сантай, хүлээсэн үүргээ дүрмий сангийнхаа хэмжээгээр хариуцдаг, гишүүн нь гагцхүү дү мийн санд оруулсан хөрөнгийнхөө хэмжээгээр хариуцлаг хүлээдэг хуулийн этгээдийг компани гэнэ.

2. Компани нь ганц гишүүнтэй байж болно.

3. Дүрмийн сан нь үүсгэн байгуулах баримт бичиг дурдсан хэмжээний ногдол хувьд хуваагддаг, гишүүн н бусад гишүүний ногдол хувь эзэмших эрхийг тэргүүн ээл жинд худалдан авах давуу эрхтэй компанийг хязгаарлагд мал хариуцлагатай компани гэнэ. Гишүүнд ногдол хув эзэмших эрхийн гэрчилгээ олгоно.

4. Дүрмийн сан нь нэг бүрийн тэнцүү үнэлгээ бүхий то дорхой тооны хувьцаанд хуваагддаг, хувьцаа эзэмшигчи нь хувьцаагаа нийтэд чөлөөтэй худалддаг, эсхүл хувьца эзэмшигч нь бусад хувьцаа эзэмшигчдийн хувьцааг тэргүү ээлжинд худалдан авах давуу эрхтэй компанийг хувьцаа компани гэнэ.

5. Компанийн эрх зүйн байдлыг хуулиар тогтооно.

33 дугаар зүйл. Нөхөрлөл

1. Гишүүдийн оруулсан хувь хөрөнгөөс бүрдэх эд хөрөн гөтэй, хүлээсэн үүргээ энэхүү эд хөрөнгө болон гишүүдий хувийн өмчийн эд хөрөнгөөр хуульд заасны дагуу хариуцда хуулийн этгээдийг нөхөрлөл гэнэ.

2. Нөхөрлөлийн эд хөрөнгө хүрэлцэхгүй тохиолдолд бү гишүүд нь хувийн өмчийн эд хөрөнгөөр нөхөрлөлийн хүлэ

н үүргийг хамтран хариуцдаг нөхөрлөлийг бүрэн хариуцатай нөхөрлөл гэнэ.

3. Нөхөрлөлийн эд хөрөнгө хүрэлцэхгүй тохиолдолд наад х нь нэг гишүүн хувийн өмчийн эд хөрөнгөөр нөхөрлөлийн лээсэн үүргийг бүрэн (бүрэн хариуцлагатай гишүүн) хаүцдаг нөхөрлөлийг бүрэн хариуцлагатай нөхөрлөл гэнэ. эхөрлөлийн бусад гишүүд нь бүрэн бус хариуцлагатай йна.

4. Нөхөрлөлийн өөр хэлбэрийг хуулиар тодорхойлж лно.

5. Нөхөрлөлийн эрх зүйн байдлыг хуулиар тогтооно.

34 дүгээр зүйл. Хоршоо

1. Хөдөлмөр, эд хөрөнгөө нэгтгэх замаар гишүүдийнхээ рэгцээг хангахад чиглэгдсэн үйл ажиллагаа явуулж, ршооны эд хөрөнгө хүрэлцэхгүй тохиолдолд түүний үүрйг гишүүд нь нөхөх хариуцлагын журмаар хариуцдаг хуулийн этгээдийг хоршоо гэнэ.

2. Хариуцлагын хэмжээ болон олсон орлогыг гишүүдэд ваарилах журмыг үүсгэн байгуулах баримт бичигт заана.

3 Хоршооны эрх зүйн байдлыг хуулиар тогтооно.

35 дугаар зүйл. Хуулийн этгээдийн нэгдэл

1. Хуульд өөрөөр заагаагүй бол компани, нөхөрлөл хороо нь үйл ажиллагаагаа зохицуулах зорилгоор нэгдэж лно.

2. Нэгдлийг ашгийн төлөө, эсхүл ашгийн төлөө бус байгуллагын хэлбэрээр байгуулна.

3. Олон нийтийн болон шашны байгууллага, сан нь гцхүү ашгийн төлөө бус байгууллагын хэлбэрээр нэгдэл йгуулж болно.

4. Нэгдлийн оролцогчид хуулийн этгээдийн эрхээ хадлна.

36 дугаар зүйл. Олон нийтийн болон шашны байгууллага, сан

1. Оюуны материаллаг болон материаллаг бус бусад иг сонирхлоо хамгаалах зорилгоор сайн дурын үндсэн эр нэгдсэн иргэд, хуулийн этгээдийн нэгдлийг олон ниййн байгууллага гэнэ.

2. Сүсэгтэн олны шашны зан үйл, хурал ном, болов
лын хэрэгцээг ханган зорилго бүхий байгууллагыг ша
байгууллага гэнэ.

3. Нийгэм, соёл, боловсрол, буяны болон нийтэд ту
бусад зорилгоор сайн дурын хандив, тусламж төвлөрүү
гагцхүү дүрэмдээ заасан зориулалтын дагуу захиран
цуулах эрх бүхий сайн дурын, гишүүнчлэлгүй байгуулл
сан гэнэ.

4. Олон нийтийн болон шашны байгууллага, сан нь
гийн төлөө бус байна.

5. Олон нийтийн болон шашны байгууллага, сангийн
зүйн байдлыг хуулиар тодорхойлно.

37 дугаар зүйл. Төр болон аймаг, нийслэл, сум, дүүрэг иргэний эрх зүйн харилцаанд оролцох

Төрийн хувьд төрийн эрх барих дээд байгууллага; маг, нийслэл, сум, дүүргийн хувьд тэдгээрийн иргэдийн лөөлөгчдийн Хурал нь энэ хуульд заасан иргэний үүргийг хэрэгжүүлнэ. Хууль буюу гэрээнд зааснаар тэд нь иргэний эрх, үүргээ хэрэгжүүлэх эрхийг бусдад ш жүүлж болно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Хэлцэл

38 дугаар зүйл. Хэлцэл, түүний төрөл

1. Иргэний эрх, үүргийг бий болгох, өөрчлөх, шилж лэх, дуусгавар болгоход чиглэсэн иргэн, хуулийн этгээд үйлдлийг хэлцэл гэнэ.

2. Хэлцэл нэг талын буюу хоёр, эсхүл олон талын б болно.

3. Хууль зааснаар буюу талуудын тохиролцсоноор тал хүсэл зоригоо илэрхийлснээр хийгдэх хэлцлийг талын хэлцэл гэнэ.

4. Хууль буюу хэлцлийн шинж чанарт харшлахгүй нэг талын хэлцэлд үүргийн болон гэрээний тухай нийт үндэслэл хамаарна.

5. Хоёр, эсхүл түүнээс дээш тал хүсэл зоригоо илэрхи нээр хийгдэх хэлцлийг хоёр талын буюу олон талын хэл гэнэ.

39 дүгээр зүйл. Хэлцлийн хэлбэр

1. Хуульд бичгээр хийхээр зааснаас бусад хэлцлийг маар хийж болно.

2. Талууд гол нөхцөлийн хувьд өөрийн хүслээ илэрхий эх бодит үйлдлээр хэлцэл хийж болно.

3. Хууль буюу гэрээнд заасан тохиолдолд хэлцэл хийх ухай санал харин өгөхгүй байгааг хэлцэл хийхээр зөв-өөрсөн гэж үзэж болно.

4. Хэлцлийг бичгээр хийхдээ талууд баримт бичиг арын үсгээ зурна. Өвчний болон хүндэтгэн үзэх бусад алтгааны улмаас нийхүү гарын үсэг зурж чадахгүй бол үүний даалгавраар өөр этгээд төлөөлөн зурж болох ба энэ ухай баримт бичиг тусгайлан тэмдэглэнэ.

5. Иргэд хоорондын хиймэгц биелэх хэлцлээс бусад элцлийг хуульд өөрөөр заагаагүй бол бичгээр хийнэ.

6. Хуульд өөрөөр заагаагүй бол хуулийн этгээдийн хийх элцлийг бичгээр хийнэ.

7. Бичгээр хийх хуулийн шаардлагыг биелүүлээгүй хэл-эл хүчин төгөлдөр бус байхаар хуульд заасан бол уг хэл-эл хүчин төгөлдөр бус байна. Энэ тохиолдолд талууд нь элцлээр авсан бүх зүйлээ харилцан буцааж өгнө.

8. Бичгээр хийх хуулийн шаардлагыг зөрчсөн хэлцлийн лаар талууд маргасан тохиолдолд энэ хуульд өөрөөр заа-агүй бол тэдгээр нь гэрчээр нотлох эрхээ алдах боловч отолгооны бусад хэрэгслээр нотолж болно.

40 дүгээр зүйл. Хэлцэл хийсэн гэж үзэх

1. Амаар хийх хэлцлийг дор дурдсанаар хийгдсэн гэж ин:

1) хэлцлийн гол нөхцөлийн талаар талууд хэлэлцэн то-ролцсон;

2) хэлцэл хийснийг нотолсон пайз, тасалбар зэрэг хэрэг-ж заншсан зүйлийг олгосон;

3) хууль буюу гэрээнд зааснаар хэлцэл хийх тухай са-лд харин өгөөгүй бөгөөд нийхүү харин өгөх тогтоосон гацаа буюу ердийн боломжит хугацаа өнгөрсөн.

2. Бичгээр хийх хэлцлийг дор дурдсанаар хийгдсэн гэж ин:

1) талууд хүсэл зоригоо илэрхийлсэн баримт бичиг үйл-ж, гарын үсэг зурсан;

2) хэлцэл хийх тухай санал (гэрээний төсөл)-ыг зөв-

шөөрсөн талын хүсэл зоригийг илэрхийлсэн захидал, хилгаан, албан бичиг (телекс, телефакс зэрэг) тэдгээр адилтгах бусад баримт бичгийг нөгөө тал хүлээн авсан;

3) хуульд зааснаар бүртгүүлэх буюу нотариатаар гэ лүүлбэл зохих хэлцлийг ийнхүү бүртгүүлсэн буюу гэ лүүлсэн.

3. Нэг талын хүсэл зоригийн илэрхийлэл болсон нөх лийг нөгөө тал хүлээн авснаа өөрийн тодорхой үйлдл илэрхийлсэн бол уг хэлцлийг бодит үйлдлээр хийгдсэн үзнэ.

41 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрөл авах, бүртгүүлэх хэлцэл

1. Хуульд тусгайлан заасан бол талууд хэлцэл хийх эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авах буюу бүртгүү үүрэгтэй.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан шаардлагыг биел лээгүй хэлцэл хүчин төгөлдөр бус байна. Энэ тохиолд энэ хуулийн 39 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт заасан дагавар бий болно.

42 дугаар зүйл. Хэлцлийг нотариатаар гэрчлүүлэх

1. Талуудын аль нэг нь хүсвэл хэлцлийг нотариат заа гэрчлэнэ.

2. Хэлцлийг нотариатаар гэрчлүүлэхээр хуульд заа бол талууд уг шаардлагыг биелүүлэх үүрэгтэй. Энэ үүргээ биелүүлээгүй бол хэлцэл хүчин төгөлдөр бус бай Энэ тохиолдолд энэ хуулийн 39 дүгээр зүйлийн 7 д хэсэгт үр дагавар бий болно.

3. Нотариатаар гэрчлүүлбэл зохих хэлцлийг гэрчлээ байхад талуудын аль нэг нь үүргээ бүрэн буюу ихэнх биелүүлсний дараа нөгөө тал биелэлтийг зөвшөөрөн хү сэн боловч хэлцлийг нотариатаар гэрчлүүлэхээс татгалз үүргээ гүйцэтгэсэн талын нэхэмжлэлээр шүүх уг хэлцл хийгдсэнд тооцож болно. Хэлцлийг ийнхүү хийгдсэнд то сон бол нотариатаар гэрчлүүлэх шаардлагагүй.

43 дугаар зүйл. Хүчин төгөлдөр бус хэлцэл

1. Дор дурдсан хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж үз

1) утга агуулгаараа хууль зөрчсөн буюу төр, нийгм ашиг сонирхолд илтэд харшилсан хэлцэл;

2) хуулийн этгээдээс дүрэмд заасан үйл ажиллагааны зорилгыг зөрчиж хийсэн хэлцэл;

3) бага насны хүмүүсийн хийсэн хэлцэл;

4) эрхийн бүрэн чадамжгүй иргэний хийсэн хэлцэл;

5) хууль ёсны үр дүн гаргахын тулд биш, зөвхөн дүр үүлэн хийсэн (хуурамч) хэлцэл;

6) хүчин төгөлдөр бус өөр хэлцлийг халхавчлах зорилгоор хийсэн хэлцэл.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн 3-т заасан заалт нь бага насны хүмүүст хохиролгүй, хиймэгц биелэх, ахуйн шинжтэй бяжиг хэлцэлд хамаарахгүй.

3. Хүчин төгөлдөр бус хэлцлээс үүссэн үр дагаврыг илгуулахыг аливаа сонирхогч этгээд шаардаж болно. үүнчлэн шүүх өөрийн санаачлагаар тэрхүү үр дагаврыг илгах тухай шийдвэр гаргах эрхтэй.

44 дүгээр зүйл. Сонирхогч этгээдийн нэхэмжлэлээр хүчин төгөлдөр бус гэж тооцож болох хэлцэл

1. Шүүх дор дурдсан хэлцлийг сонирхогч этгээдийн нэхэмжлэлээр хүчин төгөлдөр бус гэж тооцож болно:

1) иоцтой төөрөгдлийн улмаас хийсэн хэлцэл;

2) хууран мэхлэх ,хүч хэрэглэх, айлган сүрдүүлэх аргаар хийсэн хэлцэл. түүнчлэн аргагүй гачигдсанаас буюу нөлөөнд орсонаас болж өөртөө үзтэл хохиролтойгоор хийсэн хэлцэл;

3) иргэн, хуулийн этгээдийг төлөөлсөн этгээд төлөөлж байгаа этгээддээ санаатайгаар хохирол учруулан хийсэн хэлцэл, түүнчлэн бүрэн эрх олгогдоогүй этгээдийн хийсэн буюу бүрэн эрхээ хэтрүүлж хийсэн хэлцлийг төлөөлүүлэгч зөвшөөрөөгүй бол уг хэлцэл;

4) насанд хүрээгүй хүмүүсээс эцэг, эх, харгалзан дэмжигчийн зөвшөөрөлгүй хийсэн бөгөөд зөвшөөрөл шаардагдагүйгээс бусад хэлцэл;

5) эрхийн бүрэн чадамжтай боловч хэлцэл хийх үед хийн үйлдлийн учир холбогдлыг ойлгохгүй, өөрийгөө зөв шаардаж чадахгүй байсан иргэний хийсэн хэлцэл.

2. Энэ зүйлд заасан үндэслэлээр хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж тооцуулах тухай нэхэмжлэлийг гагцхүү өөрт хохирол учирсан гэж үзэж байгаа этгээд, эсхүл түүний эрх ёсны төлөөлөгч гаргаж болно.

45 дугаар зүйл. Хууль буюу хуулийн этгээдээс дүрэм заасан зорилгоо зөрчиж хийсэн, эсхүл төр, нийгмийн ашиг сонирхолд илтэд харшилсан хүчин төгөлдөр бус хэлцлээс үүсэх үр дагавар

1. Үүгээ агуулгаараа хууль зөрчсөн болон хуулийн этгээдэс дүрэмд заасан үйл ажиллагааныхаа зорилгыг зөрчсөн хэлцэл (43 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2) зүйлийн 2 дахь хэсэгт заасан шинжгүй бол талууд нь хэлцлээр авсан бүх зүйлийг харилцан буцааж өгнө. Буцаж өгөх боломжгүй бол үнийг төлнө.

2. Төр, нийгмийн ашиг сонирхолд илтэд харшилсан хэлцлийг санаатай хийсэн бол уг хэлцлээр авсан бүх зүйлийг, эсхүл үнийг улсын орлогод хураана. Энэ хэлцлээр хүлээсэн үүргээ талуудын аль нэг нь биелүүлсэн байвал хэлцэл ёсоор нөгөө этгээдийн авсан болон түүний хариу шаардлагаар зохих зүйлийг улсын орлогод хураана. Нэг талын уг хэлцлийг санаатай хийсэн бол түүнгүй авсан бүх зүйлийг боломжгүй бол үнийг нөгөө этгээдэд буцаан өгч, буруутай этгээдийн авсан бүх зүйлийг улсын орлогод хураана.

46 дугаар зүйл. Бага насны хүмүүстэй хийсэн хүчин төгөлдөр бус хэлцлээс үүсэх үр дагавар

1. Бага насны хүмүүстэй хийсэн биелэх, үг этгээдэл хохиролгүй, ахуйн шинжтэй жижиг хэлцлээс бусад хэлцэл (43 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3) хийсэн бол талууд хэлцлээр авсан бүх зүйлээ харилцан буцааж өгөх, боломжгүй бол үнийг төлөх үүрэгтэй.

2. Эрхийн бүрэн чадамжтай ирсэн нь нөгөө этгээдийг бага насны болохыг мэдэж байсан буюу мэдэх ёстой байсан бол түүнд учирсан хохирлыг төлөх үүрэгтэй.

47 дугаар зүйл. Эрхийн бүрэн чадамжгүй ирэнтэй хийсэн хүчин төгөлдөр бус хэлцлээс үүсэх үр дагавар

1. Эрхийн бүрэн чадамжгүй ирэнтэй хэлцэл (43 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4) хийвэл талууд уг хэлцлээр авсан бүх зүйлээ харилцан буцааж өгөх, боломжгүй бол үнийг төлөх үүрэгтэй.

2. Эрхийн бүрэн чадамжтай ирген нь нөгөө этгээдийн эрхийн бүрэн чадамжгүй болохыг мэдэж байсан буюу мэдэх ёстой байсан бол түүнд учирсан хохирлыг төлөх үүрэгтэй.

48 дугаар зүйл. Хүчин төгөлдөр бус хэлцлийг хэлцлээс үүсэх үр дагавар

1. Талууд хүчин төгөлдөр бус хэлцлийг хэлхавчилж саналтайгаар хэлцэл (43 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6) хийсэн бол тэдгээрийн хэлцэл ёсоор авсан бүх зүйлийг улсын орлогод хураана.

2. Талуудын аль нэг нь үг хэлцлийг санаатайгаар хийсэн бол түүний авсан бүх зүйлийг, боломжгүй бол үнийг нөгөө этгээдэд буцаан өгч, бурууг үй этгээдийн авсан бүх зүйлийг улсын орлогод хураана.

49 дүгээр зүйл. Ноцтой төөрөгдлөөс болж хийсэн хэлцэл хүчин төгөлдөр бус гэж тооцогдсоноос үүсэх үр дагавар

Ноцтой төөрөгдлөөс болж хийсэн хэлцэл (44 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1) хүчин төгөлдөр бус гэж тооцогдвол талууд авсан бүх зүйлээ харилцан буцааж өгөх, боломжгүй бол үнийг төлөх үүрэгтэй.

50 дугаар зүйл. Хууран мэхлэх, хүч хэрэглэх, айлган сүрдүүлэх аргаар хийсэн, аргагүй гачигдсанаас буюу нөлөөнд автсанаас болж өөртөө үзтэл хохиролтойгоор хийсэн, төлөөлүүлэгч этгээдлээ санаатайгаар хохирол учруулан хийсэн хэлцэл, бүрэн эрх олгогдоогүй этгээд хийсэн буюу бүрэн эрхээ хэтрүүлж хийснийг төлөөлүүлэгч нь зөвшөөрөөгүй хэлцэл хүчин төгөлдөр бус гэж тооцогдсоноос үүсэх үр дагавар

1. Хууран мэхлэх, хүч хэрэглэх, айлган сүрдүүлэх аргаар хийсэн, аргагүй гачигдсанаас буюу нөлөөнд автсанаас болж өөртөө үзтэл хохиролтойгоор хийсэн, төлөөлж байгаа этгээд төлөөлүүлж байгаа этгээддээ санаатайгаар хохирол учруулан хийсэн хэлцэл, бүрэн эрх олгогдоогүй этгээд хийсэн буюу бүрэн эрхээ хэтрүүлж хийснийг төлөөлүүлэгч нь

зөвшөөрөөгүй хэлцэл (44 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 2, 3) хүчин төгөлдөр бус гэж тооцогдвол хохирогч нь дор дурдсан шаардлагыг нөгөө этгээдэд тавих эрхтэй:

1) хэлцэл ёсоор авсан бүх зүйлийг буцаан өгөх, боломжгүй бол үнийг төлөх;

2) хохирлыг төлүүлэх.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хэлцэл хүчин төгөлдөр бус гэж тооцогдсон бол буруутай этгээдээс хохирогчийн авсан бүх зүйлийг улсын орлогод хураана.

51 дүгээр зүйл. Насанд хүрээгүй хүмүүсийн хийсэн хэлцэл хүчин төгөлдөр бус гэж тооцогдсоноос үүсэх үр дагавар

1. Насанд хүрээгүй хүмүүс эцэг, эх, харгалзан дэмжигчийн зөвшөөрөлгүй хийсэн хэлцэл (44 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4) хүчин төгөлдөр бус гэж тооцогдвол талууд нь авсан бүх зүйлээ харилцан буцааж өгөх, боломжгүй бол үнийг төлөх үүрэгтэй.

2. Насанд хүрээгүй хүмүүстэй хэлцэл хийсэн этгээд уг хэлцлийг эцэг, эх, харгалзан дэмжигчийн зөвшөөрөлгүй хийж болохгүй гэдгийг мэдсэн буюу мэдэх ёстой байсан бол учирсан хохирлыг уг этгээдэд төлөх үүрэгтэй.

3. Энэ зүйлийн заалт нь эрхийн бүрэн чадамжтай гэж зарлагдсан этгээдэд хамаарахгүй.

52 дугаар зүйл. Эрхийн бүрэн чадамжтай боловч хэлцэл хийх үед өөрийн үйлдлийн учир холбогдлыг ойлгохгүй, өөрийгөө зөв хийсэн хэлцэл хүчин төгөлдөр бус удирдаж чадахгүй байсан нөхцөлд гэж тооцогдсоноос үүсэх үр дагавар

1. Эрхийн бүрэн чадамжтай боловч хэлцэл хийх үед өөрийн үйлдлийн учир холбогдлыг ойлгохгүй, өөрийгөө зөв удирдаж чадахгүй байсан нөхцөлд хийсэн хэлцэл (44 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 5) хүчин төгөлдөр бус гэж тооцогдвол талууд авсан бүх зүйлээ харилцан буцааж өгөх, боломжгүй бол үнийг төлөх үүрэгтэй.

2. Хэлцэл хийсэн этгээд нь өөрөө этгээд өөрийн үйлдлийн учир холбогдлыг ойлгохгүй, өөрийгөө зөв удирдаж чадахгүй байгааг мэдэж байсан буюу мэдэх ёстой байсан бол түүнд учирсан хохирлыг төлөх үүрэгтэй.

53 дугаар зүйл. Хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж тооцох цаг

Хүчин төгөлдөр бус гэж тооцогдсон хэлцлийг хийсэн цагаас нь эхлэн хүчин төгөлдөр бус гэж үзнэ.

54 дүгээр зүйл. Хэлцлийн зарим хэсэг хүчин төгөлдөр бус болох

Хэлцлийн зарим хэсэг, хүчин төгөлдөр бус гэж тооцогдсон боловч үлдсэн хэсэг нь уг хэлцлийн зорилтыг хангаж чадахуйц байвал хэлцэл хүчин төгөлдөр хэвээр үлдэнэ.

55 дугаар зүйл. Болзол тавьж хийсэн хэлцэл

1. Болох эсэх нь мэдэгдээгүй байгаа ямар нэгэн үйл явдлаас шалтгаалан эрх, үүрэг үүсгэхээр хэлцэлд заасан бол хойшлуулах болзлоор хийсэн хэлцэл гэнэ.

2. Болох эсэх нь мэдэгдээгүй байгаа ямар нэгэн үйл явдлаас шалтгаалан эрх, үүргийг дуусгавар болгохоор хэлцэлд заасан бол өөрчлөгдөх болзлоор хийсэн хэлцэл гэнэ.

3. Тогтоосон болзол бий болохыг санаатайгаар саатуулбал уг болзол бий болсонд тооцно. Тогтоосон болзол бий болохыг санаатайгаар түргэтгэвэл уг болзол бий болоогүйд тооцно.

56 дугаар зүйл. Биржийн хэлцэл

1. Биржийн гүйлгээнд оруулах эд хөрөнгө буюу эд хөрөнгийн эрх (эд хөрөнгө, үнэт цаас гэх мэт)-ээ харилцан шилжүүлэх тухай хэлцлийг хууль тогтоомжид заасан журмын дагуу байгуулж, биржид бүртгүүлнэ.

2. Хууль, тухайн төрлийн хэлцлийн шинж байдалд харшлахгүй бол биржийн хэлцэлд түүний агуулгад нийцүүлж зохих гэрээ (худалдах-худалдан авах, комиссийн зэрэг)-ний журмыг хэрэглэж болно.

3. Талуудын худалдааны нууцыг агуулсан бөгөөд тэдний зөвшөөрөлгүйгээр мэдээлж болохгүй нөхцөлүүдийг биржийн тухай хууль тогтоомжоор тодорхойлж болно.

4. Биржийн хэлцлийг байгуулахтай холбогдсон маргааныг биржийн эрх бүхий байгууллага хянан хэлэлцэж болох бөгөөд тэрхүү шийдвэрийн талаар талууд шүүхэд гомдол гаргаж болно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Төлөөлөл ба итгэмжлэл

57 дугаар зүйл. Төлөөлөл

Иргэн ба хуулийн этгээд нь өөрийн эрх, үүргийг бусад этгээдээр төлөөлүүлэн хэрэгжүүлж болно. Ийнхүү хэрэгжүүлэх журмыг хууль буюу гэрээгээр тодорхойлно.

58 дугаар зүйл. Төлөөлөгч

1. Иргэн ба хуулийн этгээд өөрөө биечлэн хийхээр хуульд зааснаас бусад хэлцлийг төлөөлөгчөөр дамжуулан хийж болно.

2. Эрхийн бүрэн чадамжгүй, зарим болон хэсэгчилсэн чадамжтай иргэний нэрийн өмнөөс тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч-эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хэлцэл хийнэ.

3. Бусдын ашиг сонирхлын үүднээс боловч өөрийн нэрийн өмнөөс ажиллаж байгаа этгээд (үнэ хаялцуулах ажилладаагүй, дампуурлын үе дэх хэрэг гүйцэтгэгч, зууч-лагч, гэрээслэл биелүүлэгч зэрэг), түүнчлэн ирээдүйд хийдэх хэлцлийн талаар хэлэлцээ хийх эрх олгогдсон этгээдийг төлөөлөгч гэж үзэхгүй.

59 дүгээр зүйл. Төлөөлөгчийн бүрэн эрх

1. Төлөөлөгчийн бүрэн эрх нь хууль, захиргааны шийдвэр буюу итгэмжлэлд үндэслэсэн байна.

2. Төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс олгосон бүрэн эрхийг хэтрүүлж болохгүй.

3. Төлөөлүүлэгчийн нэрийн өмнөөс төлөөлөгч бүрэн эрхийнхээ хүрээнд хийсэн хэлцэл нь төлөөлүүлэгчийн эрх, үүргийг бий болгох, өөрчлөх буюу дуусгавар болгоно.

4. Төлөөлөх эрхгүй этгээдээс хийсэн буюу төлөөлөгч бүрэн эрхээ хэтрүүлэн хийсэн хэлцлийг төлөөлүүлэгч хүлээн зөвшөөрвөл хүчин төгөлдөр байна. Энэхүү хэлцлийг ийнхүү хүлээн зөвшөөрсөн үеэс эхлэн хүчин төгөлдөр гэж үзнэ.

60 дугаар зүйл. Итгэмжлэл

Нэг этгээд (итгэмжлэгч) өөрийн нэрийн өмнөөс хууль ёсны тодорхой үйл ажиллагаа гүйцэтгүүлэх бүрэн эрхийг нөгөө этгээд (итгэмжлэгдэгч)-эд олгосноо бичгээр тодорхойлсныг итгэмжлэл гэнэ.

61 дүгээр зүйл. Итгэмжлэлийн хэлбэр

1. Нотариатаар гэрчлүүлэхээр хуульд заасан хэлцэлтэй холбогдсон итгэмжлэлийг нотариатаар гэрчлүүлнэ.

2. Хөдөлмөрийн хөлс, оюуны үнэт зүйлийн үнэ, тэтгэвэр, тусламж, мөнгө шилжүүлэх, илгээлт, үнэ бүхий захидал, банкны хадгаламжаас мөнгө авах эрх олгох тухай итгэмжлэлийг итгэмжлэгчийн оршин суугаа нутгийн захиргааны болон ажиллаж, суралцаж, эмчлүүлж байгаа байгууллагын захиргаагаар гэрчлүүлж болно.

3. Цэргийн албан хаагчийн итгэмжлэлийг түүний алба хааж байгаа анги, байгууллагын захирагч (дарга), улсын асрамжийн буюу хорих газар байгаа иргэний итгэмжлэлийг эдгээр байгууллагын захиргаа гэрчилж болно.

4. Энэ зүйлд заасан шаардлагыг хангаагүй итгэмжлэл хүчин төгөлдөр бус байна.

62 дугаар зүйл. Хуулийн этгээдийн итгэмжлэл

1. Хуулийн этгээдийн итгэмжлэл ут байгууллагын эрх бариҥдын гарын үсэг, тамга (тэмдэг)-тай байна.

2. Хуулийн этгээдийн эд хөрөнгийг хүлээн авах, бусдад шилжүүлэх, захиран зарцуулах эрх олгох тухай итгэмжлэл ут байгууллагын эрх бариҥдаас гадна нягтлан бодогч буюу түүний үүрэг гүйцэтгэгч гарын үсэг зурна.

3. Банкны гүйлгээ, гадаад худалдааны гэрээ хийх эрх олгох тухай итгэмжлэлийн хэлбэр, түүнийг олгох журмыг хуулиар тогтоно.

63 дугаар зүйл. Итгэмжлэлийн хугацаа

1. Итгэмжлэлийг гурван жилээс дээшгүй хугацаагаар олгоно.

2. Хугацаа заагаагүй итгэмжлэл олгосон өдрөөс хойш нэг жилийн дотор хүчин төгөлдөр байна.

3. Олгосон он, сар, өдрийг заагаагүй итгэмжлэл хүчин төгөлдөр бус байна.

64 дүгээр зүйл. Итгэмжлэл шилжих

1. Итгэмжлэгдэгч эрх олгосон үйл ажиллагааг биечлэн үйлдэх үүрэгтэй. Итгэмжлэлд ут үйл ажиллагааг бусдаар үйлдэтгүүлж болох тухай заасан буюу эсхүл итгэмжлэгчийн нэр сонирхлын үүднээс зайлшгүй шаардлагатай байвал итгэмжлэлийг шилжүүлж болно.

2. Нотариатаар гэрчлүүлэхээр хууль буюу гэрээнд заасан хэлцлийн итгэмжлэгдэгч эрхээ бусдад шилжүүлэх бол энэ тухай итгэмжлэлийг нотариатаар гэрчлүүлнэ.

3. Шилжүүлсэн итгэмжлэлийн хугацаа үндсэн итгэмжлэлийн хугацаанаас их байж болохгүй. Үндсэн итгэмжлэл дуусгавар болбол шилжүүлсэн итгэмжлэл нэг адил дуусгавар болно.

4. Итгэмжлэгдэгч эрхээ бусдад шилжүүлсэн тухайгаа болон итгэмжлэлийг шилжүүлэн авсан этгээдийн талаар итгэмжлэгчид мэдэгдэх үүрэгтэй. Энэ үүргээ биелүүлээгүй итгэмжлэгдэгч эрх шилжүүлэн авсан этгээдийн үйл ажиллагаанаас бий болох үр дагаврыг өөрийн үйл ажиллагааны нэг адил хариуцна.

65 дугаар зүйл. Итгэмжлэл дуусгавар болох

1. Итгэмжлэл нь дор дурдсан тохиолдолд дуусгавар болно:

1) итгэмжлэлийн хугацаа дууссан;

2) итгэмжлэгч итгэмжлэлээ цуцалсан;

3) итгэмжлэл олгосон хуулийн этгээдийн үйл ажиллагаа дуусгавар болсон;

4) итгэмжлэгч, итгэмжлэгдэгч нас барсан, эсхүл нас барсан гэж зарлагдсан буюу сураггүй алга болсонд тооцогдсон;

5) итгэмжлэгч, итгэмжлэгдэгч эрхийн бүрэн чадамжгүй гэж тооцогдсон буюу эрхийн чадамж нь хязгаарлагдсан;

6) итгэмжлэгдэгч итгэмжлэлээс татгалзсан.

2. Хэдийд ч итгэмжлэгч итгэмжлэлээ цуцлах, итгэмжлэгдэгч итгэмжлэлээс татгалзах эрхтэй. Энэ эрхийг эдлэхгүй гэж тохирсон хэлцэл хүчин төгөлдөр бус байна.

3. Итгэмжлэгч нь итгэмжлэлээ цуцалсан тухайгаа итгэмжлэгдэгч болон итгэмжлэгдэгчтэй хэлцэл хийх ёстой этгээдэд мэдэгдэх үүрэгтэй.

4. Итгэмжлэл олгосон хуулийн этгээдийн үйл ажиллагаа дуусгавар болсноос, түүнчлэн итгэмжлэгч нас барсан буюу нас барсан гэж зарлагдсанаас итгэмжлэл дуусгавар болбол түүний эрх залгамжлагч буюу ев залгамжлагч нь нэхүү итгэмжлэл дуусгавар болсон тухай итгэмжлэгдэгч болон түүнтэй хэлцэл хийх ёстой этгээдэд мэдэгдэх үүрэгтэй.

5. Итгэмжлэл дуусгавар болмогц итгэмжлэгдэгч болон түүнээс итгэмжлэл шилжүүлэн авсан этгээд уг итгэмжлэлийг итгэмжлэгчид нэн даруй буцааж өгөх үүрэгтэй.

6. Итгэмжлэл дуусгавар болсныг мэдээгүй буюу мэдэх боломжгүй байхдаа итгэмжлэгдэгчээс бусад этгээдтэй хийсэн хэлцэл хүчин төгөлдөр хэвээр үлдэнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ

Иргэний эрх зүй дэх хугацаа

66 дугаар зүйл. Хугацаа тодорхойлох

1. Хууль, хэлцлээр буюу шүүхээс тогтоосон хугацааг хуанлийн он, сар, өдрөөр буюу жил, хагас жил, улирал, сар, арав хоног, долоо хоног, хоног, цагаар тодорхойлно.

2. Хугацааг зайлшгүй бий болох үйл явдлаар тодорхойлж болно.

67 дугаар зүйл. Жил, хагас жил, улирал, сар, арав хоног, долоо хоног, өдөр, цагаар тогтоосон хугацааг тоолох

1. Жилээр тогтоосон хугацаа нь уг хугацаа дуусах жилийн мөн сар, өдөр дуусна.

2. Хагас жилээр тогтоосон хугацаа нь уг хугацаа дуусвал зохих сарын мөн өдөр дуусна.

3. Улирлаар тогтоосон хугацаа нь уг хугацаа дуусвал зохих сарын мөн өдөр дуусна.

4. Сараар тогтоосон хугацаа нь уг хугацаа дуусах сарын мөн өдөр дуусна. Жил, улирал, сараар тогтоосон хугацааны дуусвал зохих сарын эцсийн өдөр байхгүй бол уг хугацаа нь тухайн сарын эцсийн өдөр дуусна.

5. Тогтоосон хугацааг тоолохдоо хагас жилийг зургаан сараар, улирлыг гурван сараар тооцно.

6. Арав хоногоор тогтоосон хугацаа нь уг хугацаа дуусах арав хоногийн мөн өдөр дуусна.

7. Долоо хоногоор тогтоосон хугацаа нь уг хугацаа дуусах долоо хоногийн мөн өдөр дуусна.

8. Хоногоор тогтоосон хугацаа нь уг хугацаа дуусах хоногийн мөн цагт дуусна.

9. Өдрөөр тогтоосон хугацаа нь уг хугацаа дуусах өдрийн мөн цагт дуусна.

10. Цагаар тогтоосон хугацаа нь уг хугацаа дуусах цагийн мөн минутад дуусна.

68 дугаар зүйл. Хугацаа тоолох ерөнхий журам

1. Хугацааг хуанлийн он, сар, өдрөөр буюу ямар нэгэн үйл явдал бий болсноос эхэлж тоолох ёстой байвал уг тогтоосон он, сар, өдөр буюу жил, улирал, сар, арав хоног долоо хоног, өдөр, цагаас, эсхүл үйл явдал болж өнгөрсний дараахь өдрөөс эхлэн тоолно.

2. Тоолох хугацааны эцсийн өдөр ажлын бус өдөр байвал түүний дараагийн ажлын өдөр уг хугацаа дуусна.

3. Хугацааг ямар нэгэн үүрэг гүйцэтгэхийн тулд тогтоосон бөгөөд хэлцэлд өөрөөр заагаагүй бол хугацааны эцсийн өдрийн хорин дөрвөн цагийн дотор уг үүргийг гүйцэтгэсэн байна.

4. Үүргийг ямар нэгэн байгууллагад гүйцэтгэх ёстой байсан бол зохих журмаар тогтоосон уг байгууллагын ажлын өдөр буюу үйлдвэрлэлийн ажиллагаа дуусах эцсийн цагийн дотор гүйцэтгэнэ.

5. Аливаа баримт бичгийг тогтоосон хугацааны эцсийн өдрийн хорин дөрвөн цагийн дотор шуудан, харилцаа холбооны байгууллагад шилжүүлсэн бол түүнийг зохих хугацаанд нь өгсөн гэж үзнэ.

69 дүгээр зүйл. Хөөн хэлэлцэх хугацаа

1. Зөрчигдсөн эрхийг хамгаалахын тулд нэхэмжлэл гаргах хөөн хэлэлцэх ерөнхий хугацаа гурван жил байна.

2. Үүргийн тусгай төрлийн хувьд энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас өөр богиносгосон хөөн хэлэлцэх хугацааг хуулиар тогтоож болно.

3. Хөөн хэлэлцэх хугацааг нэхэмжлэл гаргах эрх үүссэн өдрөөс эхлэн тоолно.

4. Хууль өөрөөр заагаагүй бол нэхэмжлэл гаргах эрх нь эрх зөрчигдсөн өдрөөс буюу эрх зөрчигдсөнийг хожим мэдсэн, эсхүл мэдэх ёстой байсан, түүнчлэн баталгаат буюу гомдлын шаардлага гаргах хугацаа тогтоосон бол гомдлын шаардлагын харилцаа авсан буюу эдгээр хугацаа дууссан өдрөөс эхлэн үүснэ.

5. Сөрөг үүргийн хөөн хэлэлцэх хугацааг үндсэн үүргийг гүйцэтгэсэн үеэс эхлэн тоолно.

6. Үндсэн үүргийн хөөн хэлэлцэх хугацаа дуусснаар нэмэгдэл үүрэг (анз, барьцаа, дэнчин, батлан даалт, баталгаа зэрэг)-ийн хөөн хэлэлцэх хугацаа нэг адил дуусна.

70 дугаар зүйл. Хөөн хэлэлцэх хугацааг хэрэглэх журам

1. Шүүх, арбитр талуудын хүсэлтийг харгалзахгүйгээр хөөн хэлэлцэх хугацааг хэрэглэнэ.

2. Шүүх, арбитр хөөн хэлэлцэх хугацаа өнгөрснийг хүндэтгэн үзэх шалтгаантай гэж үзвэл уг хугацааг сэргээж, зөрчигдсөн эрхийг хамгаалж болно.

71 дүгээр зүйл. Хөөн хэлэлцэх хугацаанд хамаарахгүй шаардлага

Дор дурдсан шаардлага хөөн хэлэлцэх хугацаанд хамаарахгүй:

1) банкинд хадгалуулсан зүйлээ буцааж авах тухай;

2) эд хөрөнгийн бус амины эрх зөрчсөнөөс учирсан хохирлыг арилгуулах тухай;

3) иргэдийн амь нас, эрүүл мэндэд гэм хор учруулсан хохирлыг арилгуулах тухай;

4) хуульд заасан бусад шаардлага.

72 дугаар зүйл. Хөөн хэлэлцэх хугацаа түр зогсох

1. Дор дурдсан тохиолдолд хөөн хэлэлцэх хугацаа түр зогсоно:

1) нэхэмжлэл гаргахад гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал (газар хөдлөх, галт уул дэлбэрэх, усны үер, ой, хээрийн түймэр зэрэг байгалийн гамшиг тохиолдох, гэх халдварт өвчин зэрэгт хорио цээр тогтоох гэх мэт) саад болсон;

2) нэхэмжлэгч, хариуцагчийн аль нэг нь дайн бүхий байдал, онц болон дайны байдал зарласан үед цэргийн албаа хааж байгаа;

3) Засгийн газраас гаргасан шийдвэр нь үүргийн хугацааг хойшлуулахад хүргэсэн.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан нөхцөл байдал нь хөөн хэлэлцэх хугацааны сүүлчийн зургаан сарын дотор гарсан байвал хөөн хэлэлцэх хугацаа түр зогсоно.

3. Түр зогссон шалтгаан арилсан өдрөөс эхлэн хөөн хэлэлцэх хугацаа үргэлжилнэ. Үлдсэн хугацаа нь зургаан сараас доош байвал уг хугацааг зургаан сар хүртэл сунгана. Хөөн хэлэлцэх хугацаа нь зургаан сараас доош байвал үлдсэн хугацаа нь хөөн хэлэлцэх хугацаатайгаа адил байна.

73 дугаар зүйл. Хөөн хэлэлцэх хугацаа тасалдах

1. Тогтоосон журмаар нэхэмжлэл гаргасан бол хөөн хэлэлцэх хугацаа тасалдана.

2. Үүрэг хүлээсэн этгээд уг үүргийг зөвшөөрөн хүлээвэл хөөн хэлэлцэх хугацаа нэг адил тасалдана.

3. Хөөн хэлэлцэх хугацаа тасалдсаны дараа уг хугацааг дахин шинээр эхлэн тоолно.

II хэсэг

ӨМЧИЙН ЭРХ ЗҮЙ

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

74 дүгээр зүйл. Өмчийн төрөл, хэлбэр

1. Монгол Улсад хувийн, нийтийн өмч байна.

2. Төр өмчийн бүх төрөл, хэлбэр чөлөөтэй хөгжих нөхцөлийг бүрдүүлж, тэдгээрийн халдашгүй байдлыг хуулиар хамгаална.

75 дугаар зүйл. Өмчлөгч

1. Монгол Улсад төр, иргэн, хуулийн этгээд өмчлөгч байж болно.

2. Гадаад улс, түүний иргэн, хуулийн этгээд, түүнчлэн олон улсын байгууллага, харьяалалгүй хүн Монгол Улсын хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол өмчлөгч байж болно.

3. Өмчлөгч нь өөрийн эрхээ бусдад шилжүүлж болох бөгөөд тэр нь эд юмсыг өмчлөгчөөс өгсөн зориулалт, өөрийн үйл ажиллагааны зорилго, дүрмийн дагуу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхтэй.

76 дугаар зүйл. Өмчлөлийн зүйл

Эд юмс, оюуны үнэт зүйл, хуулиар зөвшөөрөгдсөн нөхцөлд эд хөрөнгийн зарим эрх өмчлөлийн зүйл байж болно.

77 дугаар зүйл. Үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө

1. Эд юмсыг өмчлөлийн зүйл болохынх нь хувьд үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө гэж ангилна.

2. Үл хөдлөх эд хөрөнгөд газар, түүнээс салган хэрэглэж үл болох зүйл хамаарна.

3. Үл хөдлөх эд хөрөнгийг түүний байгаа газарт орших төрийн эрх бүхий байгууллага хуульд заасны дагуу бүртгэнэ.

4. Үл хөдлөхөөс бусад эд хөрөнгө нь хөдлөх эд хөрөнгө байна.

78 дугаар зүйл. Үнэт цаас

1. Тодорхой хэмжээний мөнгийг эргүүлж төлөхийг шаардах, хувьцаат компанид хөрөнгө оруулж, түүнийг үндэслэн ногдол ашиг авах, түүнчлэн эд хөрөнгө хүлээн авах, түүнийг захиран зарцуулах болон хуульд заасан эд хөрөнгийн бусад эрхийг гэрчилж байгаа баримтыг үнэт цаас гэнэ.

2. Үнэт цаас гаргах эрх олгох, түүнийг гүйлгээнд оруулах журам, үнэт цаасны гүйлгээнд оролцогчдын эрх, үүрэг; үнэт цаас гаргах үйл ажиллагаа болон түүний гүйлгээнд хяналт тавих байгууллагын эрх, үүргийг хуулиар тогтооно.

79 дүгээр зүйл. Үнэт цаасны талаар тавих шаардлага

1. Үнэт цаас нь хууль болон эрх бүхий байгууллагаас тогтоосон бүрдүүлбэр, хэлбэртэй байна.

2. Үнэт цаасыг эрх бүхий байгууллагын зөвшөөрлөөр, тогтоосон журмын дагуу үйлдвэрлэнэ.

80 дугаар зүйл. Үнэт цаасны хэлбэр

1. Үнэт цаас нь биет ба биет бус хэлбэртэй байна.

2. Тогтоосон журмын дагуу хэвлэсэн үнэт цаасыг биет; тусгайлан хэвлээгүй, бүрдүүлбэр нь тусгай бүртгэл (ердийн ба тооцоолох машины)-д байгаа үнэт цаасыг биет бус үнэт цаас гэнэ.

81 дүгээр зүйл. Үнэт цаасны төрөл

1. Үнэт цаас нь мэдүүлгийн, зөвшөөрлийн, эсхүл нэрийн гэсэн төрөлтэй байна.

2. Тодорхой этгээдээс зарим төрлийн үнэт цаас гаргахыг хуулиар хязгаарлаж болно.

82 дугаар зүйл. Үнэт цаасаар гэрчлэгдсэн эрх эдлэх этгээд (өмчлөгч)

1. Үнэт цаасаар гэрчлэгдсэн эрхийг дараахь этгээд эдэлнэ:

1) мэдүүлгийн үнэт цаасаар гэрчлэгдсэн эрхийг уг үнэ цаасыг хууль ёсоор олж авсан этгээд;

2) нэрийн үнэт цаасаар гэрчлэгдсэн эрхийг гаргахү түүнд нэр заагдсан этгээд;

3) зөвшөөрлийн үнэт цаасаар гэрчлэгдсэн эрхийг у үнэт цаасыг өмчлөгч буюу түүнээс уг эрхийг шилжүүлж авахаар өөрийн нэр дээр холбогдох бичилт хийлгэсэн этгээд.

2. Үнэт цаасаар гэрчлэгдсэн эрхийг эдлэгч нь үнэт цаас ны өмчлөгч байна.

83 дугаар зүйл. Үнэт цаасаар гэрчлэгдсэн эрхийг шилжүүлэх

1. Үнэт цаасыг шилжүүлснээр түүгээр гэрчлэгдэж байга эрх бүхэлдээ шилжинэ.

2. Мэдүүлгийн үнэт цаасаар гэрчлэгдсэн эрхийг уг үнэ цаасыг бусдад гардуулах замаар шилжүүлнэ.

3. Нэрийн үнэт цаасаар гэрчлэгдсэн эрхийг шилжүүлэх дээ шаардах эрх шилжүүлэх талаархи журмыг баримтална

4. Нэрийн үнэт цаасаар гэрчлэгдсэн эрхийг бусда шилжүүлэх үед нэр бүхий үнэт цаас хүчингүй болж, шин эзэмшигчийн нэр дээр өөр үнэт цаас олгоно.

5. Зөвшөөрлийн үнэт цаасаар гэрчлэгдсэн эрхийг тухай үнэт цаасанд зохих бичилт хийх замаар шилжүүлнэ. Бичил тийг гаргахүү эрх хэрэгжүүлэх даалгаврын журмаар хийх болно. Энэ тохиолдолд даалгавар гүйцэтгэгч нь үнэт цаа өмчлөгчийн төлөөлөгч байна.

84 дүгээр зүйл. Үнэт цаасыг шилжүүлэх

1. Нэрийн үнэт цаасыг шилжүүлэгч нь түүний хүчин төгөлдөр байдлыг хариуцна. Харин эрх хэрэгжүүлэх явдлы хариуцахгүй.

2. Зөвшөөрлийн үнэт цаасыг шилжүүлж байгаа этгээ нь түүний хүчин төгөлдөр байдлыг төдийгүй эрх хэрэгжүү лэх явдлыг хариуцна.

85 дугаар зүйл. Үнэт цаасаар гэрчлэгдсэн алдагдсан эрхийг сэргээх

Мэдүүлгийн ба зөвшөөрлийн үнэт цаасаар гэрчлэгдсэн алдагдсан эрхийг хуульд заасан журмын дагуу шүүх сэр гээнэ.

86 дугаар зүйл. Оюуны үнэт зүйл

1. Оюуны үнэт зүйлд нээлт, шинэ бүтээл, оновчтой санал, зохиогчийн эрхэд хамаарах бүтээл, бүтээгдэхүүний загвар, барааны тэмдэг хамаарна.

2. Шинжлэх ухаанд урьд өмнө мэдэгдээгүй байсан материаллаг ертөнцийн зүй тогтол, үзэгдэл, шинж чанарыг илрүүлэн тогтоож, туршилт сорилтоор нотолсон оюуны үнэт зүйлийг нээлт гэнэ. Газар зүй, эртний судлал, эртний амьтны судлалын олдвор, илрүүлэн олсон ашигт малтмал, түүнчлэн нийгмийн шинжлэх ухааны бүтээл нь нээлтэд хамаарахгүй.

3. Байгалийн хуульд тулгуурлан анх сэдэж, үндэслэлийг нь нээн илрүүлсэн үйлдвэрлэх арга, ажиллагаа болон бүтээгдэхүүнд хамаарах цоо шинэ шийдлийг шинэ бүтээл гэнэ.

4. Тухайн байгууллагад шинэ үйлдвэрлэх арга ажиллагаа болон бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн зохион байгуулалтад хамаарах оновчтой шийдлийг оновчтой санал гэнэ.

5. Зохиогчийн эрхэд хамаарах бүтээлд:

1) шинжлэх ухаан, уран зохиолын зэрэг утга зохиолын аман буюу бичмэл бүх төрлийн бүтээл;

2) хөгжмийн урлагийн бүх төрлийн бүтээл;

3) дүрслэх урлагийн болон хавсарга урлагийн бүх төрлийн бүтээл;

4) архитектурын бүтээл, барилга байгууламжийн зураг, төсөл;

5) бүжгийн урлагийн бүх төрлийн бүтээл, уран нугаралт, пантомим;

6) жүжгийн бүх төрлийн бүтээл;

7) кино урлагийн болон түүнтэй төсөөтэй аргаар туурвисан бүх төрлийн бүтээл;

8) гэрэл зургийн болон түүнтэй төсөөтэй аргаар туурвисан бүх төрлийн бүтээл;

9) шинжлэх ухаан, техникийн холбогдолтой төсөл, зураг, бүдүүвч, загвар;

10) цахим тооцоолуурын хөтөлбөр;

11) дуу, авиа, дүрс бичлэгийн бүтээл;

12) урьд туурвисан бүтээлийг ашиглан түүний үндсэн дээр бий болгосон үүсмэл бүтээл;

13) зохиогчийн оюуны бүтээлч үйл ажиллагааг илэрхийлж чадахуйц бусад бүтээл.

6. Үйлдвэрлэлийн аргаар хийх боломжтой бүтээгдэхүү-

ний хэлбэр, хийцэд хамаарах өвөрмөц цоо шинэ шийдлийг бүтээгдэхүүний загвар гэнэ.

7. Хуулийн этгээд, хувараа аж ахуй эрхлэгч иргэн өөрийн бараа, үйлчилгээг бусдынхаас ялгах зорилгоор хэрэглэх тэмдгийг барааны тэмдэг гэнэ. Хуулийн этгээдийн нэгдлийн гишүүд тухайн нэгдлийн хяналтын дор тэдгээрийн нэгдмэл шинж чанартай бараа, үйлчилгээнд хэрэглэх барааны тэмдгийг хамтын тэмдэг гэнэ.

87 дугаар зүйл. Өмчлөх эрх

1. Өмчлөгч нь өмчлөлийн зүйлээ хуулийн хүрээнд бүрэн мэдэж эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхтэй.

2. Хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол өмчлөгч нь эзэмшилдээ байгаа эд хөрөнгийг хадгалан хамгаална.

3. Өмчлөгч нь өмчлөх эрхээ хэрэгжүүлэхдээ хууль тогтоомж, бусад өмчлөгч, эзэмшигчдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчиж болохгүй.

4. Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн өмчлөлд байна.

5. Бэлчээр, нийтийн эдэлбэрийн ба улсын тусгай хэрэгцээнийхээс бусад газрыг зөвхөн Монгол Улсын иргэнд өмчлүүлж болно. Энэ нь газрын хэвлийг өмчлөхөд хамаарахгүй.

6. Оюуны үнэт зүйлийг өмчлөх эрх нь тухайн бүтээлийн зохиогчийн эрхтэй салшгүй холбоотой хэрэгжинэ. Оюуны үнэт зүйлийн зохиогчийн эрхийг хамгаалах асуудал хуулиар зохицуулагдана. Тухайн харилцааны агуулгад харшлахгүй бол оюуны үнэт зүйлийг өмчлөх эрхийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцаанд энэ хуулийн зохих заалт хэрэглэгдэнэ.

88 дугаар зүйл. Өмчлөгч биш этгээдийн эрх

1. Өмчлөгч биш этгээд нь эд хөрөнгө, оюуны үнэт зүйл, эрхийг хууль буюу гэрээгээр тодорхойлсон өмчлөгчөөс олгосон бүрэн эрхийн хүрээнд үйл ажиллагааныхаа чиглэлийн дагуу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхтэй.

2. Хуульд өөрөөр заагаагүй бол оюуны үнэт зүйлийг гагцхүү өмчлөгчийн буюу эрх эзэмшигчийн зөвшөөрлөөр бусад этгээд ашиглана.

89 дүгээр зүйл. Эд хөрөнгийг дундаа өмчлөх

1. Хоёр буюу түүнээс дээш этгээд эд хөрөнгийг дундаа

хэсгээр буюу хамтран өмчилж болох ба тэдгээр нь өмчлөх эрхээ бие даан хамгаалуулах эрхтэй.

2. Эд хөрөнгийг дундаа өмчлөгчийн хариуцлагыг зохих үүргийн дагуу гаргуулах төлбөрийг тухайн өмчлөгчид оногдох эд хөрөнгөөс гаргуулна.

3. Эд хөрөнгийг дундаа өмчлөхтэй холбогдсон маргааныг шүүх шийдвэрлэнэ.

4. Эд хөрөнгийг дундаа өмчлөх тухай энэ хуулийн заалтыг оюуны үнэт зүйлийг дундаа өмчлөхтэй холбоотой харилцаанд хэрэглэж болно.

90 дүгээр зүйл. Эд хөрөнгийг дундаа хэсгээр өмчлөх

1. Өмчлөгчид дундаа хэсгээр өмчлөх эд хөрөнгөө хооронд харилцан тохиролцсоны дагуу эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулна. Үүнтэй холбогдсон маргааныг шүүх шийдвэрлэнэ.

2. Эд хөрөнгийг дундаа хэсгээр өмчилж байгаа өмчлөгч бүр оногдох хэсгээ бусдын өмчлөлд шилжүүлэх буюу өөр байдлаар захиран зарцуулах эрхтэй.

91 дүгээр зүйл. Дундаа хэсгээр өмчлөх эд хөрөнгөөс оногдох хэсгээ худалдах, түрээслэх

1. Эд хөрөнгийг дундаа хэсгээр өмчлөгчдийн аль нэг нь өөрт оногдох хэсгээ худалдах, түрээслэх тохиолдолд энэ тухай бусдадаа мэдэгдэх үүрэгтэй бөгөөд тэдгээр нь уг хэсгийг тэргүүн ээлжинд худалдан авах буюу түрээслэн авах эрхтэй. Иймхүү худалдах, түрээслэх тухай мэдэгдсэн өдрөөс хойш нэг сарын дотор тэд хариу өгөөгүй бол тухайн өмчлөгч оногдсон хэсгээ өөр этгээдэд худалдах, түрээслэх эрхтэй.

2. Эд хөрөнгийг дундаа хэсгээр өмчлөгчдийн аль нэг нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасныг зөрчиж, дундаа хэсгээр өмчилж байгаа эд хөрөнгөөс өөрт оногдох хэсгээ худалдсан буюу түрээсэлсэн бол бусад өмчлөгчид нь худалдан авагч, түрээслэгчийн эрх, үүргийг өөрт шилжүүлэхийг шаардаж, зургаан сарын дотор шүүхэд нэхэмжлэл гаргаж болно.

92 дугаар зүйл. Дундаа хэсгээр өмчлөх эд хөрөнгөөс оногдох хэсгээ салгах

1. Эд хөрөнгийг дундаа хэсгээр өмчлөгчид нь уг эд хөрөнгөөс өөрт оногдох хэсгийг салгаж авахыг шаардах эрхтэй.

2. Дундаа хэсгээр өмчилж байгаа эд хөрөнгөөс өөрт оногдох хэсгийг салгаж авах талаар бусадтайгаа харилцан тохиролцоогүй бөгөөд оногдох хэсгийг нийхүү салгахад уг эд хөрөнгийн зорилалт, шинж чанар алдагдахгүй бол тухайн өмчлөгчийн хүсэлтээр эд хөрөнгөөс түүнд оногдох хэсгийг шүүх салгаж өгнө. Салгах боломжгүй бол оногдох хэсгийнх нь үнийг өмчлөгчид олгуулахаар шийдвэрлэж болно.

3. Дундаа хэсгээр өмчилж байгаа эд хөрөнгийг ашигласнаас олсон орлого, үр шим, үр төл нь дундын эд хөрөнгө болно. Дундаа хэсгээр өмчлөгчид хоорондоо өөрөөр тохиролцоогүй бол орлого, үр шим, үр төлийг хожим хуваахдаа тэдгээрт зайлшгүй оногдох хэсэгт хувь тэнцүүлэн хуваана.

93 дугаар зүйл. Дундаа хэсгээр өмчилж байгаа эд хөрөнгийн талаар гарсан зардлыг хуваарилах

Эд хөрөнгийг дундаа хэсгээр өмчлөгчид нь дундын эд хөрөнгөд оногдох татвар, эд хөрөнгийг арчилж хамгаалахад гарсан болон уг харилцаанаас үүссэн үүрэгтэй холбоотой бусад зардлыг өөрт оногдох хэсэгт хувь тэнцүүлэн хариуцна.

94 дүгээр зүйл. Эд хөрөнгийг дундаа хамтран өмчлөх

1. Дундаа хамтран өмчлөх эд хөрөнгийн нэг хэлбэр нь гэр бүлийн эд хөрөнгө байна.

2. Эд хөрөнгийг дундаа хамтран өмчлөх өөр хэлбэрийг хуулиар тогтоож болно.

95 дугаар зүйл. Гэр бүлийн эд хөрөнгийг дундаа хамтран өмчлөх

1. Гэрлэгчдийн хуваарьт эд хөрөнгөөс бусад гэр бүлийн эд хөрөнгө гэр бүлийн гишүүдийн дундаа хамтран өмчлөх өмчлөлд байна.

2. Гэр бүлийн эд хөрөнгийг гэрлэгчид болон гэр бүлийн бусад гишүүн дундаа хамтран өмчлөх эрхтэй.

3. Гэрлэгчид, гэр бүлийн бусад гишүүн нь дундаа хамтран өмчлөх эд хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах адил тэгш эрх эдэлнэ. Гэрлэгчид, гэр бүлийн бусад гишүүн нь уг эрхээ хэрэгжүүлэхдээ гэр бүлийн насанд хүрсэн бүх гишүүнтэй тохиролцох ба үл хөдлөх эд хөрөнгийг захиран зарцуулахдаа тэдгээрийн зөвшөөрлийг бичгээр

авна. Энэ шаардлагыг биелүүлээгүй хэлцэл хүчин төгөлдөр бус байна.

4. Гэр бүлийн гишүүн нь үүргээ гэр бүлийн эд хөрөнгөөс өөрт оногдох хэсгээр хариуцна.

96 дугаар зүйл. Гэрлэгчдийн хуваарьт эд хөрөнгө

1. Гэрлэгчдээс дундын өмчлөлд шилжүүлэхээр тохиролцоогүй бол дараахь эд хөрөнгө хуваарьт эд хөрөнгөд хамаарна:

1) гэрлэгчдээс гэрлэхийн өмнө олж авсан эд хөрөнгө, мөнгөн хуримтлал, эд хөрөнгийн эрх;

2) гэрлэгчид өв залгамжлал, бэлэглэлийн журмаар шилжүүлэн авсан мөнгөн хуримтлал, эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх, тэдгээрийг худалдаж, арилжсаны үр дүнд олж авсан эд хөрөнгө, мөнгө;

3) гэрлэгчдийн хувийн хэрэгцээг хангахад зориулагдсан эд хөрөнгө;

4) оюуны өмчлөлийн зүйлийн үнэ буюу зохиогчийн шагнал;

5) хувийн авьяас, чадвар, ололт амжилтыг сайшаан шагнасны орлого;

6) гэрлэгчид хуваарьт эд хөрөнгөөрөө олж авсан бөгөөд тэдгээрээс мэргэжлийн үйл ажиллагаагаа явуулахад шаардагдах эд хөрөнгө.

2. Гэрлэгчид хуваарьт эд хөрөнгөө өөрийн үзэмжээр эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулах эрхтэй.

3. Гэрлэгчид өөрөөр тохиролцоогүй бол тэдгээр нь хувийн үйл ажиллагаатайгаа холбогдсон үүргийг хуваарьт эд хөрөнгөөрөө хариуцна.

97 дугаар зүйл. Гэр бүлийн гишүүдийн дундаа хамтран өмчлөх эд хөрөнгө

1. Гэр бүлийн гишүүдийн дундаа хамтран өмчлөх эд хөрөнгөд дараахь эд хөрөнгө хамаарна:

1) энэ хуулийн 96 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас бусад эд хөрөнгө, мөнгөн хуримтлал;

2) хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол гэрлэснээс хойш гэрлэгчид, гэр бүлийн бусад гишүүний хөдөлмөр ажлын үйл ажиллагаанаас бүй болсон эд хөрөнгө, мөнгөн хуримтлал;

3) гэр бүлийн гишүүн өөрийн хуваарьт эд хөрөнгөө дундаа хамтран өмчлөхөд зориулж шилжүүлсэн эд хөрөнгө мөнгөн хуримтлал;

4) гэр бүлийн гишүүдийн хамтын хөдөлмөрийн үр дүн олсон ашиг, орлого, үр төл, шинээр бий болсон эд хөрөнгө

5) гэр бүлийн гишүүдийн ахуйн хэрэгцээг хангахад зайлшгүй шаардагдах бусад эд хөрөнгө.

2. Гэрлэгчдийн хуваарьт эд хөрөнгийг гэр бүлийн гишүүн чанаржуулснаас үнэ нь үлэмж нэмэгдсэн бол дундаа хамтран өмчлөх эд хөрөнгө болгон тогтоож болно.

98 дугаар зүйл. Гэр бүлийн дундаа хамтран өмчлөх эд хөрөнгөөс гишүүнд оногдох хэсгийг тодорхойлох

1. Гэр бүлийн дундаа хамтран өмчлөх эд хөрөнгөөс гишүүнд оногдох хэсгийг дараахь тохиолдолд тодорхойлно:

1) гэр бүлийн гишүүн гэр бүлийн бүрэлдэхүүнээс гарахад оногдох хэсгийн талаар маргавал;

2) гэрлэгчдээс төлбөр гаргуулахад тэдгээрийн хуваарьт эд хөрөнгө хүрэлцэхгүй бол;

3) гэр бүлийн бусад гишүүнээс төлбөр гаргуулбал;

4) гэр бүлийн гишүүн нас барснаар өв нээгдсэн бол.

2. Гэр бүлийн нэг гишүүнд оногдох эд хөрөнгийн хэмжээ нь насанд хүрээгүй, хөдөлмөрийн чадваргүй бүх гишүүнийг оролцуулан нийт гишүүдэд адил байна.

3. Гэрлэлт цуцалсан буюу гэрлэлтийг хүчингүйд тооцсоноос гэр бүлийн нэг гишүүнд оногдох эд хөрөнгийн хэсгийг тодорхойлохдоо гэрлэгчдийн эрүүл мэндийн байдал, хүүхдийн ашиг сонирхлыг харгалзан шүүх өөрөөр тогтоож болно.

4. Энэ зүйлийн 3 дахь хэсэгт зааснаас бусад гэр бүлийн хөдөлмөрийн чадвартай гишүүнд оногдох эд хөрөнгийн хэсгийг тодорхойлохдоо гэр бүлийн дундаа хамтран өмчлөх эд хөрөнгө бүрэлдэхэд оруулсан түүний хөдөлмөрийн оролцоо, хөрөнгийн хэмжээг харгалзан багасгах, эсхүл олгохгүй байхаар шүүх шийдвэрлэж болно.

5. Хөдөлмөрийн чадвартай гэр бүлийн гишүүн нь цэргийн жинхэнэ алба хаах, сургуульд суралцах, удаан хугацаагаар өвчлөх зэрэг хүндэтгэн үзэх шалтгаанаар дундаа хамтран өмчлөх эд хөрөнгө бүрэлдэхэд хөдөлмөрөөр буюу хөрөнгөөрөө оролцож чадаагүй бол энэ зүйлийн 4 дэх хэсгийн заалт хамаарахгүй.

6. Гэр бүлийн дундаа хамтран өмчлөх эд хөрөнгөөс гишүүнд оногдох хэсгийг тодорхойлох талаар гарсан маргааныг шүүх шийдвэрлэнэ.

99 дүгээр зүйл. Гэр бүлийн гишүүн гэр бүлийн бүрэлдэхүүнээс гарах

1. Гэр бүлийнх нэг буюу хэд хэдэн гишүүн гэр бүлийн бүрэлдэхүүнээс гарвал дундын эд хөрөнгөөс оногдох хэсгээ авах боловч гэр бүлийн аж ахуйг цаашид явуулахад зайлшгүй шаардагдах эд хөрөнгийг авах эрхгүй.

2. Оногдох хэсгийг эд хөрөнгөөр өгөх боломжгүй бол үнийг нь төлнө.

ДОЛДУГААР БҮЛЭГ

Газар өмчлөх болон газартай холбогдсон эд хөрөнгийн бусад эрх

100 дугаар зүйл. Газар өмчлөх

1. Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар төрийн өмчлөлд байна.

2. Газар өмчлөгч нь эрхээ хэрэгжүүлэхдээ хүрээлэн буй орчинд хохирол учруулах болон бусад этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчиж болохгүй.

3. Газар өмчлөгч нь өмчлөлийн газраа бусдад ашиглуулахдаа түүний зориулалтыг заана. Ийнхүү тодорхой зориулалтаар олгосон газрыг өөр зориулалтаар ашиглахыг хориглоно.

4. Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх журмыг хуулиар тогтоох хүртэл энэ бүлэгт заасан «газар өмчлөгч» гэснийг «төр» гэж ойлгоно.

101 дүгээр зүйл. Газрыг нийтээр ашиглах

Иргэд нь төрийн өмчлөлд байгаа нийтээр ашиглаж болохоор тогтоосон газарт ямар нэгэн зөвшөөрөлгүйгээр нэвтрэх, уг газарт байгаа байгалийн зүйлсийг хуулиар зөвшөөрсөн хүрээнд ашиглах эрхтэй.

102 дугаар зүйл. Газар өмчлөгч биш этгээдийн эрх

Газар өмчлөгч биш этгээд нь хууль буюу өмчлөгчтэй байгуулсан гэрээгээр тогтоосон нөхцөл, журмын дагуу газрыг эзэмшиж, ашиглана.

103 дугаар зүйл. Газрыг насаараа эзэмших эрх, уг эрхээ өвлүүлэх

1. Иргэн төрийн өмчийн газрыг хуульд заасан үндэслэл, журмын дагуу насаараа эзэмших, ийнхүү эзэмших эрхээ өвлүүлэх эрхийг олж авч болно.

2. Газрыг насаараа эзэмших, ийнхүү эзэмших эрхийг өвлөх эрх бүхий иргэн уг газрыг өөртөө шилжүүлэн авах үеийн зориулалт, нөхцөлийн дагуу эзэмшиж, ашиглана.

3. Хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол газрыг насаараа эзэмших, ийнхүү эзэмших эрхээ өвлүүлэх эрх бүхий иргэн уг газраа түүний зориулалт, нөхцөлийн дагуу бусдад ашиглуулж болно.

104 дүгээр зүйл. Газрыг тодорхой бус хугацаагаар ашиглах эрх

1. Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчийн газрыг тодорхой бус хугацаагаар ашиглах эрхийг хуулийн этгээдэд олгож болно.

2. Энэ хуулийн 105 дугаар зүйлд заасан барилга, байгууламж, бусад үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгч нь газрыг тодорхой бус хугацаагаар ашиглах эрх олж авч болно.

3. Хуулийн этгээд өөрчлөн байгуулагдахад газрыг тодорхой бус хугацаагаар ашиглах эрх нь эрх залгамжлах журмаар шилжинэ.

4. Газрыг тодорхой бус хугацаагаар ашиглах эрх бүхий этгээд уг газрыг зориулалтаар нь ашиглах, хууль буюу газар олгох тухай шийдвэрт өөрөөр заагаагүй бол барилга, байгууламж, бусад үл хөдлөх эд хөрөнгө барьж байгуулах эрхтэй. Уг этгээд нь өөртөө зориулан барьж байгуулсан барилга, байгууламж, бусад үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгч байна.

5. Газрыг тодорхой бус хугацаагаар ашиглах эрх бүхий этгээд нь гагцхүү өмчлөгчийн зөвшөөрөлтэйгээр уг газрыг үнэ төлбөртэй буюу төлбөргүйгээр, хугацаатайгаар бусдад ашиглуулах эрхтэй.

105 дугаар зүйл. Бусдын газар дээрх үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгч дэвсгэр газрыг ашиглах эрх

1. Бусдын газар дээрх үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгч нь тэрхүү газрыг ашиглах эрхтэй.

2. Хууль, газар олгох тухай шийдвэр, гэрээнд өөрөөр заагаагүй бол үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгч нь дэвсгэр газрыг тодорхой бус хугацаагаар ашиглах эрхтэй.

3. Үл хөдлөх эд хөрөнгийг өмчлөх эрх шилжихэд түүний дэвсгэр газрыг ашиглах эрх өмнөх өмчлөгчийн ашиглах эрхийн хэмжээгээр шилжинэ.

4. Хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол газар өмчлөх эрх шилжих нь үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгчийн дэвсгэр газар ашиглах эрх дуусгавар болох үндэслэл болохгүй.

5. Тухайн газрыг ашиглах талаар хууль буюу гэрээнд заасан нөхцөлд харшлахгүй бол үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгч нь уг эд хөрөнгөө өөрийн үзэмжээр эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхтэй.

106 дугаар зүйл. Бусдын газар дээрх үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгч дэвсгэр газрыг ашиглах эрхгүй болсны үр дагавар

1. Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгчийн дэвсгэр газрыг ашиглах эрх дуусгавар болоход тухайн эд хөрөнгийн эрхийг газар өмчлөгч болон эд хөрөнгө өмчлөгчийн хооронд тэрээгээр тодорхойлно. Талууд өөрсдөө тодорхойлж чадахгүй бол аль нэг талын хүсэлтээр шүүх шийдвэрлэнэ. Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгчийн дэвсгэр газар ашиглах эрх дуусгавар болсны дараа газар өмчлөгч нь уг газрыг чөлөөлөх буюу анхны байдалд нь сэргээлгэх шаардах эрхтэй.

2. Уг дэвсгэр газар дээрх барилга байгууламж (орон сууцны байшин, түүх, соёлын дурсгалт зүйлс зэрэг)-ийг буулгахыг хуулиар хориглосон тохиолдолд талуудын хүсэлтээр шүүх дараахь байдлаар шийдвэрлэж болно:

1) газар өмчлөгчид уг газар дээр байгаа үл хөдлөх эд хөрөнгийг өмчлөх эрх олгох;

2) үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгчид дэвсгэр газрыг цаашид ашиглах эрх олгож, түүний хугацаа, нөхцөлийг тогтоох.

107 дугаар зүйл. Барилга байгууламж, орон сууцны байшин зэрэг үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрх шилжихэд газар эзэмших, ашиглах эрх шилжих

1. Газар өмчлөгчийн өмчлөлд байсан барилга байгууламж, орон сууцны байшин зэрэг үл хөдлөх эд хөрөнгийг өмчлөх эрх өөр этгээдэд шилжвэл түүний дэвсгэр газрыг

эзэмших, ашиглах эрх шилжих эсэхийг талуудын тохиролцсоноор шийдвэрлэнэ.

2. Барилга байгууламж, орон сууцны байшин зэрэг үл хөдлөх эд хөрөнгийг буулгаж авахад энэ зүйлийн 1 дэх хэсгийн заалт хамаарахгүй.

108 дугаар зүйл. Газрыг хязгаартай ашиглах эрх (сервитут)

1. Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгч нь эрхээ хэрэгжүүлэх, эд хөрөнгөө ашиглах, хамгаалах нөхцөлийг бүрдүүлэхийн тулд газар өмчлөгч, эзэмшигчээс хуульд заасан журмын дагуу газар олгохыг шаардах эрхтэй.

2. Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгч бусдын газрыг хязгаартай ашиглах эрхгүйгээр өмчлөх эрхээ хэрэгжүүлэх боломжгүй бол түүнд бусдын газраар дайран өнгөрөх зам, цахилгаан, холбооны болон инженерийн шугам тавих, гарц гаргах болон бусад зорилгоор бусдын газрыг хязгаартайгаар ашиглах эрх олгож болно.

3. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу бусдын газрыг хязгаартай ашиглах эрх олгосон явдал нь газар өмчлөгч, эзэмшигчээс өмчлөх, эзэмших эрхээ хэрэгжүүлэхэд саад учруулж болохгүй.

4. Газрыг хязгаартай ашиглах нөхцөл, журмын талаар тохиролцоонд хүрээгүй бол уг маргааныг шүүх шийдвэрлэнэ.

5. Газрыг насаараа эзэмших, нийнхүү эзэмших эрхээ өвлүүлэх эрх бүхий болон тодорхой бус хугацаагаар газар ашиглах эрх бүхий этгээдэд бусдын газрыг хязгаартай ашиглах эрх олгож болно.

6. Хуульд өөрөөр заагаагүй бол өөрийн газрыг хязгаартай ашиглуулж байгаа өмчлөгч нь ашиглагчаас газар ашигласны хөлс шаардах эрхтэй.

109 дүгээр зүйл. Газрын эрх шилжихэд газрыг хязгаартай ашиглах эрх хадгалагдах

1. Газрын эрх бусдад шилжихэд уг газрыг хязгаартай ашиглах эрх хадгалагдана.

2. Газрыг хязгаартай ашиглах эрхийг гагцхүү уг эрхийг олж авах үндэслэл болсон тухайн газар дээрх үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгчид шилжүүлж болно.

110 дугаар зүйл. Газрыг хязгаартай ашиглах эрх дуусгавар болох

1. Хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол газрыг хязгаартай ашиглах эрх олгогдсон үндэслэл арилсан үед уг эрх дуусгавар болно.

2. Иргэн ба хуулийн этгээдийн эзэмшилд байгаа газрыг бусдад хязгаартай ашиглуулснаар уг газрыг зорилалтын дагуу ашиглах боломжгүй болбол өмчлөгч газрыг хязгаартай ашиглах гэрээг цуцлахаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.

111 дүгээр зүйл. Барилга, байгууламж, бусад үл хөдлөх эд хөрөнгийг хязгаартай ашиглах эрх

Газар ашиглахтай холбоогүйгээр барилга байгууламж, бусад үл хөдлөх эд хөрөнгийг хязгаартай ашиглаж болно. Энэ тохиолдолд энэ хуулийн 108, 109, 110 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

112 дугаар зүйл. Улсын тусгай хэрэгцээг үндэслэн газрыг эргүүлэн авах

1. Улсын тусгай хэрэгцээг үндэслэн газрыг нөхөх олговортойгоор эргүүлэн авч болно.

2. Газрыг эргүүлэн авах шийдвэрийг Засгийн газар гаргана.

3. Засгийн газар ийнхүү эргүүлэн авах тухайгаа өмчлөгч, эзэмшигчид нэг жилийн өмнө мэдэгдэнэ. Энэ хугацаа дуусахаас өмнө газрыг эргүүлэн авах явдлыг гагцхүү өмчлөгч, эзэмшигчийн зөвшөөрөлтэйгээр гүйцэтгэнэ.

113 дугаар зүйл. Газрыг эргүүлэн авах үеийн нөхөх олговор

1. Газрыг эргүүлэн авахад олгох нөхөх олговор, хугацаа, бусад нөхцөлийг гэрээгээр тодорхойлно.

2. Газрыг эргүүлэн авахад олгох нөхөх олговорт газар, хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол түүн дээр байгаа үл хөдлөх эд хөрөнгийн үнэ, газрыг эргүүлэн авснаас гарсан бусад зардлыг оруулан тооцно.

3. Талууд тохиролцвол эргүүлэн авах газрыг өөр газраар сольж, шинээр өгсөн газрын үнийг нөхөх олговорт оруулан тооцож болно.

4. Газрыг эргүүлэн авахад олгох нөхөх олговрын талаар маргаан гарвал шүүх шийдвэрлэнэ.

114 дүгээр зүйл. Зориулалтын дагуу ашиглаагүйгээс газрыг эргүүлэн авах

1. Хөдөө аж ахуйн болон орон сууц, бусад барилга байгууламж барих зориулалтаар олгосон газрыг гурван жилийн хугацаанд зохих зориулалтаар нь ашиглаагүй бөгөөд хуулиар өөр хугацаа тогтоогоогүй бол өмчлөгч, эзэмшигчээс эргүүлэн авч болно.

2. Газар ашиглах бэлтгэлийг хангах, байгалийн гамшиг тохиолдох зэрэг хүндэтгэн үзэх бусад шалтгааны улмаас газрыг зориулалтаар нь ашиглаж чадаагүй бол нийхүү ашиглаагүй хугацаа нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацаанд хамаарахгүй.

115 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчин ашиглаж байгаа газрыг хураан авах

Хүн амын эрүүл мэнд, экологийн болон үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд харшаар ашиглаж, хууль тогтоомжийг ноцтой зөрчсөн өмчлөгч, эзэмшигчийн газрыг хураан авч болно.

116 дугаар зүйл. Газрыг хураан авах журам

Засгийн газар нь энэ хуулийн 115 дугаар зүйлд заасан зөрчил гаргасан өмчлөгч, эзэмшигчид тухайн зөрчлөө арилгах хугацаа тогтоон өгч, уг хугацаанд зөрчлөө арилгахгүй бол газрыг хураан авахыг урьдчилан сануулна. Тогтоосон хугацаанд зөрчлийг арилгаагүй бол газрыг хураан авах тухай шийдвэр гаргана. Өмчлөгч, эзэмшигч уг шийдвэрийн талаар шүүхэд гомдол гаргаж болно.

117 дугаар зүйл. Өмчлөгч биш этгээдийн газар эзэмших, ашиглах эрх дуусгавар болох

Өмчлөгч биш этгээд (энэ хуулийн 88 дугаар зүйл)-ийн газар эзэмших, ашиглах эрх нь хуульд заасан үндэслэл, журмын дагуу дуусгавар болно.

НАЙМДУГААР БҮЛЭГ

Орон сууц өмчлөх болон орон сууцтай холбогдсон эд хөрөнгийн бусад эрх

118 дугаар зүйл. Нийтийн зориулалттай хэд хэдэн сууц бүхий орон сууцны байшин, түүний хэсэг болон нийтийн байрны барилга өмчлөх

1. Нийтийн зориулалттай хэд хэдэн сууц бүхий орон сууцны байшин, түүний хэсэг болон нийтийн байрны барилга өмчлөгч нь уг байшин, барилгыг гагцхүү зориулалтын дагуу эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулна.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан байшин, барилга өмчлөгч нь түүний зориулалтыг өөрчлөхгүйгээр орон сууцны бус зориулалтаар ашиглаж болохгүй. Зориулалтыг өөрчлөх журмыг хуулиар тогтооно.

3. Хөлслөгчийн хууль ёсны ашиг сонирхолд харшлахгүй бол энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан байшин, барилгын доорх хэнгилын талбайг өмчлөгч нь түүнийг өөрийн үзэмжээр захиран зарцуулах эрхтэй.

119 дүгээр зүйл. Нийтийн зориулалттай хэд хэдэн сууц бүхий орон сууцны байшинд сууц өмчлөх

1. Нийтийн зориулалттай хэд хэдэн сууц бүхий орон сууцны байшинд сууц өмчлөгч нь түүний доторх салган хэрэглэж үл болох эд хөрөнгийг нэг адил өмчилнө.

2. Хуульд өөрөөр заагаагүй бол нийтийн зориулалттай хэд хэдэн сууц бүхий орон сууцны байшинд сууц өмчлөгч нь энэ хуулийн 249 дүгээр зүйлд заасан дундын ашиглалтын талбайг гэрээний дагуу эзэмшиж, ашиглах буюу дундаа хамтран өмчилнө.

120 дугаар зүйл. Хувийн зориулалттай орон сууцны байшин өмчлөх

1. Хувийн зориулалттай орон сууцны байшин өмчлөгч нь түүнийг үзэмжээрээ эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулах эрхтэй.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан орон сууцны байшин

өмчлөгч нь түүнийг захиран зарцуулахдаа гэр бүлийн насанд хүрсэн бүх гишүүний зөвшөөрлийг бичгээр авна.

121 дүгээр зүйл. Сууц буюу хувийн зориулалттай орон сууцны байшин өмчлөгчийн гэр бүлийн гишүүний эрх

1. Сууц буюу хувийн зориулалттай орон сууцны байшин өмчлөгчийн гэр бүлийн гишүүн нь уг сууц буюу байшинг өмчлөгчийн нэг адил эзэмшиж, ашиглах эрхтэй.

2. Сууц буюу хувийн зориулалттай орон сууцны байшин өмчлөгчийн гэр бүлийн гишүүн нь орон сууцны эрхээ зөрчигдсөн гэж үзвэл уг зөрчлийг арилгуулахаар шаардах эрхтэй

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

Өмчлөх эрх үүсэх, дуусгавар болох

122 дугаар зүйл. Гэрээний дагуу олж авсан эд хөрөнгийг өмчлөх эрх үүсэх

1. Гэрээний дагуу олж авсан эд хөрөнгийг өмчлөх эрх, өмчлөгч биш этгээдийн хувьд энэ хуулийн 88 дугаар зүйлд заасны дагуу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрх нь хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол уг эд хөрөнгийг шилжүүлсэн үеэс эхлэн үүснэ.

2. Хуульд эд хөрөнгө шилжүүлэх гэрээг зохих байгууллагаар гэрчлүүлэх буюу бүртгүүлэхээр заасан бол иймхүү гэрчлүүлсэн буюу бүртгүүлсэн үеэс уг эд хөрөнгийг өмчлөх эрх үүснэ.

123 дугаар зүйл. Эд хөрөнгө шилжүүлсэнд тооцох

Дор дурдсан тохиолдолд эд хөрөнгийг шилжүүлсэнд тооцно:

1) эд хөрөнгийг авах этгээдэд гардуулан өгсөн;

2) эд хөрөнгийг хүргэж өгөх үүрэг хүлээсэн этгээдэд хүлээлгэн өгсөн;

3) эд хөрөнгийг хүлээн авах шилжүүлэх тухай дагалдах бичиг баримтыг хүлээлгэн өгсөн.

124 дүгээр зүйл. Орлого, үр шим, үр төлийг өмчлөх эрх

Хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол эд хөрөнгөөс олж байгаа орлого, үр шим; мал, амьтны үр төл нь уг эд

хөрөнгө, мал, амьтан өмчлөгчийн өмчлөлд байна.

125 дугаар зүйл. Эзэнгүй эд хөрөнгө

1. Эзэнгүй буюу эзэн нь мэдэгдэхгүй байгаа эд хөрөнгийг олсон этгээд түүнийг зохих нутгийн захиргааны байгууллагад өгнө.

2. Эзэнгүй буюу эзэн нь мэдэгдэхгүй байгаа эд хөрөнгийг нутгийн захиргааны байгууллага буртгэж, хамгаалалтад авна.

3. Бүртгэн авч, нийтэд мэдээлснээс хойш зургаан сарын дотор эзэн нь тогтоогдохгүй буюу эзэн нь авахаас татгалзсан бол уг эд хөрөнгийг төрийн өмчлөлд шилжүүлнэ.

126 дугаар зүйл. Гээгдэл эд хөрөнгө

1. Гээгдсэн эд хөрөнгийг олсон этгээд эзэнд нь даруй мэдэгдэж буцаан өгөх, эзэн нь мэдэгдэхгүй бол зохих нутгийн захиргааны буюу цагдаагийн байгууллагад өгнө.

2. Байгууллага, нийтийн тээврийн хэрэгслээс олдсон эд хөрөнгийг тухайн байгууллагын захиргаанд өгнө. Иймхүү өгснөөс хойш нэг сарын дотор эзэн нь тогтоогдоогүй бол байгууллагын захиргаа уг эд хөрөнгийг зохих нутгийн захиргааны буюу цагдаагийн байгууллагад шилжүүлнэ.

3. Энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан байгууллага нь гээгдсэн эд хөрөнгийн тухай нийтэд мэдээлэх, эзнийг тогтоох арга хэмжээ авах үүрэгтэй.

4. Гээгдсэн эд хөрөнгийн эзэн нь нэг жилийн дотор тогтоогдоогүй бол уг эд хөрөнгийг төрийн өмчлөлд шилжүүлнэ.

5. Гээгдсэн эд хөрөнгийг олсон этгээд уг эд хөрөнгийн эзнээс, төрийн өмчлөлд шилжүүлсэн бол төрийн зохих байгууллагаас шагнал авах эрхтэй.

6. Шагналыг эд хөрөнгө өмчлөгч болон олсон этгээдийн хооронд тохиролцсон хэмжээгээр, тохиролцохгүй бол уг эд хөрөнгийн үнийн арван хувиар олгоно.

127 дугаар зүйл. Алдуул мал, тэжээвэр амьтан (цаашид алдуул мал гэх)

1. Алдуул мал олсон этгээд эзэнд нь даруй мэдэгдэж буцаан өгөх, эзэн нь мэдэгдэхгүй бол зохих нутгийн захиргааны буюу цагдаагийн байгууллагад нэг сарын дотор мэдэгдэх үүрэгтэй.

2. Нутгийн захиргааны буюу цагдаагийн байгууллага

малын эзнийг тогтоох, эзэн нь тогтоогдтол малыг бололцоо той байгууллага буюу иргэнд шилжүүлж маллуулах арга хэмжээ авна.

3. Алдуул малын талаар нийтэд мэдээлснээс хойш нэ жилийн дотор эзэн нь тогтоогдвол малыг төлийн хамт бу цааж өгнө. Дурдсан хугацаанд эзэн нь тогтоогдоогүй бол у малыг төрийн өмчлөлд шилжүүлнэ.

4. Алдуул мал олсон этгээд таргасан зардлаа уг малын эзнээс, төрийн өмчлөлд шилжсэн бол төрийн зохих бай гууллагаас төлүүлж авахаас гадна шагнал авах эрхтэй Шагналын хэмжээг энэ хуулийн 126 дугаар зүйлийн 6 дах хэсэгт зааснаар тогтооно.

128 дугаар зүйл. Дарагдмал мөнгө, үнэт зүйл

1. Газарт булсан буюу бусад байдлаар дарагдаж орхигд сон бөгөөд эзэн нь мэдэгдэхгүй байгаа дарагдмал мөнгө үнэт зүйл төрийн өмчлөлд байна.

2. Дарагдмал мөнгө, үнэт зүйлийг илрүүлсэн этгээд эн тухай зохих нутгийн захиргааны буюу цагдаагийн байгуул лагад даруй мэдэгдэж шилжүүлэн өгөх үүрэгтэй.

3. Дарагдмал мөнгө, үнэт зүйлийг илрүүлж, зохих бай гууллагад шилжүүлсэн этгээд төрийн зохих байгууллагаа шагнал авах эрхтэй. Шагналын хэмжээг энэ хуулийн 12 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт зааснаар тогтооно.

4. Хайгуул, малталт хийх албан үүрэг бүхий этгээд у үүргээ гүйцэтгэх явцдаа дарагдмал мөнгө, үнэт зүйлий илрүүлсэн бол энэ зүйлд заасан шагнал олгохгүй.

129 дүгээр зүйл. Түүх, соёлын дурсгалт зүйлд хайр гамгүй хандах

1. Өмчлөгч өөртөө байгаа бөгөөд улсын бүртгэлд авагд сан түүх, соёлын дурсгалт зүйлийг эвдэж, гэмтээх зэргээр хайр гамгүй эзэмшиж байвал нутгийн захиргааны байгуул лагаас уг этгээдэд урьдчилан сануулж, дээрх байдлаа зас ахыг хугацаа тогтоон шаардах, эсхүл төрд худалдахыг санал болгоно.

2. Өмчлөгч худалдах саналыг хүлээж аваагүй буюу эн зүйлийн 1 дэх хэсэгт заасан шаардлагыг тогтоосон хуга цаанд биелүүлэхгүй бол зохих нутгийн захиргааны байгуул лагын нэхэмжлэлийг үндэслэн уг эд хөрөнгийг шүүхийн шийдвэрээр дайчлан авч, төрийн өмчлөлд шилжүүлж болно.

3. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар эд хөрөнгийг дайчлан авахдаа өмчлөгчид нөхөх олговор олгох ба түүний хэмжээг өмчлөгчийн саналыг харгалзан шүүх тогтооно.

4. Түүх, соёлын дурсгалт зүйлийн ач холбогдол, түүнийг хайр гамгүй эзэмшиж байгаа зөрчлийн шинж байдлыг харгалзан төрийн зохих байгууллагын нэхэмжлэлийг үндэслэн, шүүхийн шийдвэрээр түүнийг үнэ төлбөргүй хураан авч, төрийн өмчлөлд шилжүүлж болно.

130 дугаар зүйл. Бусдын эд хөрөнгийг засаж сайжруулах буюу дахин боловсруулах

Хууль буюу гэрээний дагуу бусдын эд хөрөнгийг засаж сайжруулах, дахин боловруулах замаар шинэ зүйл бий болгосон буюу зориулалтыг нь өөрчилсөн этгээд өмчлөгчийн зөвшөөрснөөр уг эд хөрөнгийн үнийг төлж, өөртөө авах, эсхүл засаж сайжруулах буюу дахин боловсруулахад гаргасан зардлаа авч, уг эд хөрөнгийг өмчлөгчид буцаан өгөх эрхтэй.

131 дүгээр зүйл. Эд хөрөнгө нийлэх буюу холилдох

1. Хэд хэдэн өмчлөгчийн эд хөрөнгө нийлэх буюу холилдсоноос түүнийг салгаж авах боломжгүй болсон, эсхүл салгаж авсны улмаас өмчлөгчдөд хохирол учрахаар байвал түүнийг дундаа хамтран өмчилнө.

2. Аль нэг өмчлөгч дундаа өмчлөхөөс татгалзвал эд хөрөнгө нийлэх буюу холилдохоос өмнө хамгийн их хэсгийг өмчилж байсан этгээд бусдадаа үнийг төлж, уг эд хөрөнгийг авах, эсхүл өөрт оногдох хэсгийн үнийг авч, эд хөрөнгөө бусдадаа шилжүүлэх эрхтэй.

132 дугаар зүйл. Гэрээний дагуу өмчлөх эрх шилжих үед эд хөрөнгө гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй байдлаас устах буюу гэмтэх

1. Эд хөрөнгө шилжихээс өмнө гэрээний дагуу өмчлөх эрх шилжсэн байхад гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлаас уг эд хөрөнгө устсан буюу гэмтсэн тохиолдолд гэрээнд өөрөөр заагаагүй бол үр дагаврыг өмчлөгч хариуцна.

2. Эд хөрөнгө шилжүүлэх буюу хүлээн авах хугацааг хожимдуулсан бол гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлаас учирсан хохирлыг хугацаа хожимдуулсан этгээд хариуцна.

3. Эд хөрөнгийг энэ хуулийн 88 дугаар зүйлд заасны дагуу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрх бүхий этгээдэд шилжүүлэх үед уг эд хөрөнгө гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлаас устах буюу гэмтэхэд энэ зүйлд заасан журмыг баримтална.

133 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөлтэйгээр олж авах эд юмс

1. Галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх зүйл, мансууруулах бодис, хүчтэй нөлөөлөх хор зэрэг эд юмсыг гагцхүү тусгай зөвшөөрөлтэйгээр олж авна.

2. Тусгай зөвшөөрөлтэй олж авах эд юмсын жагсаалт, зөвшөөрөл олгох журмыг Засгийн газар тогтооно.

134 дүгээр зүйл. Эд хөрөнгийг дайчлан авах, хураах

Гагцхүү хуульд заасан үндэслэл, журмын дагуу нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн бусдын эд хөрөнгийн үнийг төлж, төрийн өмчлөлд дайчлан авах, эсхүл эрх зүйн зөрчил гаргасан этгээдийн эд хөрөнгийг үнэ төлбөргүй хурааж болно.

135 дугаар зүйл. Эд хөрөнгийг өмчийн нэг төрөл хэлбэрээс нөгөөд шилжүүлэх

1. Хууль буюу гэрээгээр өмчлөлийн аливаа төрөл, хэлбэрийг өөрчилж, өмчлөх эрх үүсгэж болно.

2. Төрийн өмчийн эд хөрөнгийг өмчлөлийн өөр төрөлд шилжүүлэх нөхцөл, журмыг хуулиар тогтооно.

136 дугаар зүйл. Оюуны үнэт зүйл өмчлөх эрх үүсэх

1. Хуульд өөрөөр заагаагүй бол оюуны үнэт зүйл бүтээсэн этгээдийн өмчлөх эрх нь уг зүйлийг бүтээсэн үеэс үүснэ.

2. Өмчлөгч нь оюуны үнэт зүйл бүтээснээ тухайн үед нь баталгаажуулах үүрэгтэй. Иймхүү баталгаажуулсан нь зайлшгүй шаардлагатай үед уг зүйлийг бүтээснээ нотлох үүргээс өмчлөгчийг чөлөөлөхгүй.

3. Оюуны үнэт зүйлийн өмчлөгч болохыг хуульд заасан журмын дагуу бүртгэсэн бүртгэлээр тодорхойлно.

137 дугаар зүйл. Нээлт гаргагчийн эрх

1. Нээлт гаргагчийн эрх нь түүнд олгосон нээлтийн дипломоор баталгаажна.

2. Нээлт гаргагчийн талаар гарсан маргааныг шүүх шийдвэрлэнэ.

3. Нээлт гаргагч нь нээлтийн диплом авснаар бүтээлээ өмчлөх, нээлт гарсантай холбогдсон эд хөрөнгийн ба эд хөрөнгийн бус амины эрх эдэлнэ.

4. Нээлтийг бүртгэх, диплом олгох, нээлт гаргагчид шагнал, урамшил олгох, хөнгөлөлт үзүүлэх журам, эдгээрийг эрхлэн хариуцах байгууллагыг Засгийн газар тогтооно.

138 дугаар зүйл. Хамтран нээлт гаргах

1. Нээлтийг хоёр буюу хэд хэдэн иргэн хамтран гаргасан бол нээлт гаргагч бүр өөрийн нэр заагдсан диплом авах эрхтэй.

2. Нээлт гаргахад зөвхөн техникийн туслалцаа үзүүлсэн иргэн хамтран нээлт гаргагчид тооцогдохгүй.

139 дүгээр зүйл. Өмчлөх эрх дуусгавар болох

Өмчлөгчийн өмчлөх эрх дараахь үндэслэлээр дуусгавар болно:

1) өөрийн өмчлөлийн зүйл болох эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхээ хууль буюу гэрээгээр бусдад шилжүүлэх;

2) өмчлөх эрхээсээ татгалзах;

3) өмчлөлийн зүйл болох эд хөрөнгө нь устах;

4) хуульд заасан үндэслэлээр өмчлөх эрхээ алдах;

5) өмчлөгч болох иргэн нас барах, нас барсан гэж зарлагдах;

6) өмчлөгч болох хуулийн этгээд татан буугдах;

7) хуульд заасан бусад үндэслэл

АРАВДУГААР БҮЛЭГ

Монгол Улсын иргэний хувийн өмч

140 дүгээр зүйл. Монгол Улсын иргэний хувийн өмчийн эрх

Монгол Улсын иргэн хувийн өмчтэй байх эрхтэй.

141 дүгээр зүйл. Монгол Улсын иргэний хувийн өмчлөлийн зүйлс

1. Монгол Улсын иргэн өмчлөлд нь байж болохыг хуу-

лиар хориглосноос бусад үл хөдлөх ба хөдлөх эд хөрөнгө оюуны үнэт зүйл, эрхийг хувьдаа өмчилж болно.

2. Газрыг хувьд өмчлөх журмыг хуулиар тогтооно.

142 дугаар зүйл. Иргэдээс өмчлөх эрхээ хэрэгжүүлэх бусад хэлбэр

Хуульд өөрөөр заагаагүй бол иргэн хувийн өмчийн эд хөрөнгөөрөө буюу түүнийгээ нийлүүлэх замаар байгуулсан хуулийн этгээдийн эд хөрөнгийг өмчлөх эрхээ өөрсдөө буюу төлөөлөх этгээдээрээ дамжуулан хэрэгжүүлнэ.

АРВАННЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтийн өмч

143 дугаар зүйл. Төрийн өмч

1. Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, ой, ус, ургамал, амьтан, байгалийн бусад баялаг төрийн өмчлөлд байна. Түүнчлэн үл хөдлөх ба хөдлөх бусад эд хөрөнгө, оюуны үнэт зүйл, эрх төрийн өмчлөлд байж болно.

2. Төрийн өмчлөлийн зүйлсийг Монгол Улсын төрийн эрх барих дээд байгууллага, түүний эрх олгосон байгууллага хууль тогтоомжид заасан эрх хэмжээнийхээ дотор эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулна.

3. Төрийн өмчид үндэслэсэн хуулийн этгээд нь өөрт олгогдсон эд хөрөнгийг үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн хуулиар тогтоосон хэмжээ, хязгаарын дотор эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхтэй.

4. Төрийн өмчийн хуулийн этгээдэд шилжүүлснээс бусад эд хөрөнгө, төсвийн зохих хөрөнгө нь төрийн санг бүрдүүлнэ.

5. Төрийн санг эзэмших, ашиглах, захиран зарцуулах журмыг хуулиар тогтооно.

144 дүгээр зүйл. Орон нутгийн өмч

Аймаг, нийслэл, сум, дүүргийн өмчлөлд дараахь эд хөрөнгө байж болно:

1) төрийн өмчөөс хууль тогтоомжийн дагуу хуваарилж шилжүүлсэн өмчлөлийн зүйлс;

2) өөрийн хөрөнгөөр байгуулсан хуулийн этгээдийн эд хөрөнгө, түүнээс авах ногдол ашиг;

3) орон нутгийн төсөв, санхүүгийн дэмжлэг, хуульд заасан бусад эх үүсвэрээр бий болсон эд хөрөнгө.

145 дугаар зүйл. Олон нийтийн байгууллага, сангийн өмч

1. Олон нийтийн байгууллага нь гишүүд, дэмжигчдийн татвар, хандив, дүрэмдээ нийцсэн үйл ажиллагааныхаа үр дүнд олсон бусад орлогоос бүрдсэн өөрийн өмчлөлийн эд хөрөнгөтэй байж болох бөгөөд түүнийгээ гагцхүү дүрмээр тодорхойлсон зорилго, үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхийн тулд эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхтэй.

2. Олон нийтийн байгууллагын өмчлөх эрхийг түүний удирдах байгууллага хууль, дүрэмд заасан эрх хэмжээний дагуу хэрэгжүүлнэ.

3. Санд шилжүүлсэн эд хөрөнгө нь түүний өмчлөлд байна. Үүсгэн байгуулагч нь сангийн үүргийг, сан нь үүсгэн байгуулагчийн үүргийг хариуцахгүй. Сангийн эд хөрөнгийг гагцхүү түүний дүрэмд заасан зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зарцуулна.

4. Сангийн эд хөрөнгийн зарцуулалтад төрийн эрх бүхий байгууллага болон үүсгэн байгуулагч хяналт тавина.

5. Олон нийтийн байгууллага, сан татан буугдсан нөхцөлд үлдсэн эд хөрөнгийг хэрхэх талаар тэдгээрийн дүрэмд заах бөгөөд ийнхүү заагаагүй бол төрийн өмчлөлд шилжүүлнэ. Олон нийтийн байгууллага татан буугдвал эд хөрөнгийг нь адил зорилго бүхий байгууллагад, сан татан буугдвал эд хөрөнгийг нь гагцхүү нийгэм, соёл, буяны болон нийтэд тустай бусад зорилгоор ажиллаж байгаа хуулийн этгээдэд шилжүүлэхээр тэдгээрийн дүрэмд заана.

146 дугаар зүйл. Шашны байгууллагын өмч

1. Шашны байгууллага барилга, шүтээн, буян үйлдэх зүйл, сүсэгтний өргөл барьц, өөрийн хөрөнгөөр бий болгосон, эсхүл байгууллага, иргэний хандивласан болон бусад эд хөрөнгө, түүнчлэн оюуны үнэт зүйлийг өмчлөх эрхтэй.

2. Шашны байгууллагын өмчлөх эрхийг түүний өөрийн удирдлагын байгууллага хууль, дүрэмд заасан эрх хэмжээнийхээ дагуу хэрэгжүүлнэ.

3. Шашны байгууллага татан буугдвал үлдсэн эд хөрөнгийг хэрхэх талаар түүний дүрэмд заах бөгөөд ийнхүү заагаагүй бол төрийн өмчлөлд шилжүүлнэ. Шашны байгууллага татан буугдвал үлдэх эд хөрөнгөө адил зорилго бүхий байгууллагад шилжүүлэхээр дүрэмд заана.

147 дугаар зүйл. Хандивласан эд хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах

Төрийн өмчийн байгууллагад хандив өгөх, хандивласан эд хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах журмыг хуульд өөрөөр заагаагүй бол Засгийн газар тогтооно.

148 дугаар зүйл. Төр, олон нийт, шашны байгууллага, сангийн эд хөрөнгөөс төлбөр гаргуулах

Төр, олон нийт, шашны байгууллага, сангийн, хуульд хориглон зааснаас бусад эд хөрөнгөөс төлбөр гаргуулж болно.

АРВАНХОЁРДУГААР БҮЛЭГ

Гадаад улсын иргэн, хуулийн этгээд, гадаад улс болон олон улсын байгууллагын өмч

149 дүгээр зүйл. Гадаад улсын иргэний өмч

1. Гадаад улсын иргэн нь Монгол Улсын хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын нутаг дэвсгэр дээр өмчлөлийн зүйлсийг тус улсын иргэний нэг адил өмчлөх эрхтэй.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн заалт харьяалалгүй хүнд нэг адил хамаарна.

150 дугаар зүйл. Гадаад улсын хуулийн этгээдийн өмч

Гадаад улсын хуулийн этгээд нь Монгол Улсын хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд заасан нөхцөл, журмын дагуу тус улсад зөвшөөрөгдсөн үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх зорилгоор өмчлөлийн зүйлсийг Монгол Улсын нутаг дэвсгэр дээр өмчлөх эрхтэй.

151 дүгээр зүйл Олон улсын байгууллагын өмч

Олон улсын байгууллага нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаагаа явуулахад шаардагдах өмчлөлийн зүйлсийг Монгол Улсын хууль, Монгол Улсын олон улсын гэрээний дагуу өмчлөх эрх эдэлнэ.

152 дугаар зүйл. Гадаад улсын иргэн, хуулийн этгээд, олон улсын байгууллагын эд хөрөнгөөс төлбөр гаргуулах

1. Гадаад улсын иргэн, хуулийн этгээд, олон улсын байгууллагын эд хөрөнгөөс төлбөр гаргуулах журмыг Монгол Улсын хууль, Монгол Улсын олон улсын гэрээгээр тодорхойлно.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн заалт харьяалалгүй хүнд нэг адил хамаарна.

АРВАНГУРАВДУГААР БҮЛЭГ

Өмчлөх эрхийн баталгаа, иргэний эрх зүйн хамгаалалт

153 дугаар зүйл. Өмчлөх эрхийн баталгаа, иргэний эрх зүйн хамгаалалтын үндэс

1. Төр нь өмчийн төрөл, хэлбэрийн ялгааг харгалзахгүйгээр өмчлөх эрхийг хамгаалах хууль зүй, эдийн засгийн болон бусад адил нөхцөлийг бүрдүүлж, уг эрхийг баталгаажуулна.

2. Өмчлөгчийн өмчлөх эрхийг бусад бүх этгээд зөрчихгүй байх үүрэгтэй.

154 дүгээр зүйл. Бусдын хууль бус эзэмшлээс эд хөрөнгөө шаардан нэхэмжлэх

1. Өмчлөгч эд хөрөнгөө бусдын хууль бус эзэмшлээс шаардан нэхэмжлэх эрхтэй.

2. Эд хөрөнгийг хууль бус эзэмшигч нь эзэмшлээ хууль бус болохыг мэдээгүй бөгөөд мэдэх боломжгүй байсан, эд хөрөнгийг түүнд өгсөн этгээдийн уг эд хөрөнгийг бусдад эгөх эрхгүй болохыг мэдээгүй бөгөөд мэдэх боломжгүй байсан бол түүнийг шударга эзэмшигч гэж үзнэ.

3. Өмчлөгч буюу хууль ёсоор эзэмшигч нь эд хөрөнгөө эрийн хүсэл зоригоос гадуур алдсан байвал уг эд хөрөнгийг үнэ төлбөртэй олж авсан шударга эзэмшигчээс шаардан нэхэмжлэх эрхтэй. Энэ тохиолдолд эд хөрөнгийг үнэ төлбөртэй олж авсан шударга эзэмшигч нь эд хөрөнгийг шилжүүлж өгсөн этгээдээс учирсан хохирлоо арилгуулахаар шаардах эрхтэй.

4. Шударга эзэмшигч эд хөрөнгийг үнэ төлбөргүй авсан бол өмчлөгч хэдийд ч шаардан нэхэмжлэх эрхтэй

5. Мөнгө, үнэт цаасыг шударга эзэмшигчээс шаардан нэхэмжилж болохгүй.

155 дугаар зүйл. Хууль бус эзэмшигчээр орлого, хохирлыг төлүүлэх

1. Өмчлөгч нь бусдын хууль бус эзэмшлээс эд хөрөнгөө шаардан нэхэмжлэхдээ шударга бус эзэмшигчээс уг эд хөрөнгийг эзэмших хугацаандаа авсан буюу зайлшгүй авах ёстой байсан орлогыг шаардах эрхтэй.

2. Шударга эзэмшигчээс уг эд хөрөнгийг хууль бус эзэмшиж байгаагаа мэдсэн буюу мэдэх ёстой байсан үеэс, эсхүл өмчлөгчийн эд хөрөнгөө буцаан нэхэмжилсэн шаардлагыг хүлээн авснаас хойшхи хугацаанд уг эд хөрөнгөөс авсан буюу зайлшгүй авах ёстой байсан орлогыг өмчлөгч шаардах эрхтэй.

3. Шударга эзэмшигч нь эд хөрөнгийн орлогыг өмчлөгчид шилжүүлэх болсон үеэс хойш уг эд хөрөнгөд зарцуулсан зайлшгүй зардлыг өмчлөгчөөс шаардах эрхтэй.

4. Эд хөрөнгө хууль бусаар эзэмшигч нь хийсэн засварынхаа зүйлийг уг эд хөрөнгөд гэмтэл учруулахгүй бол салгаж өөртөө үлдээх эрхтэй.

5. Эд хөрөнгө шударгаар эзэмшигч нь хийсэн засварынхаа зүйлийг уг эд хөрөнгөд гэмтэл учруулахгүйгээр салгаж авах боломжгүй бол засварын үнийг засвар хийсний үр дүнд нэмэгдсэн эд хөрөнгийн үнээс хэтрүүлэхгүй хэмжээгээр нэхэмжилж болно.

156 дугаар зүйл. Өмчлөх эрх зөрчсөн зөрчлийг арилгуулах

Өмчлөгч нь эд хөрөнгөө эзэмшихтэй холбоогүй боловч өмчлөх эрх нь ямар нэгэн хэлбэрээр зөрчигдсөн гэж үзвэл уг зөрчлийг арилгуулахыг шаардах эрхтэй.

157 дугаар зүйл. Өмчлөх эрх хэрэгжүүлэхэд саад болж байгаа үйлдлийг зогсоохыг шаардах

Өмчлөх эрхээ хэрэгжүүлэхэд саад болж байгаа аливаа үйлдлийг зогсоохыг өмчлөгч шаардах эрхтэй.

158 дугаар зүйл. Эд хөрөнгө хууль ёсоор эзэмшигчийн эрхийг хамгаалах

Эд хөрөнгийг хууль, гэрээний дагуу эзэмшиж байгаа өмчлөгч биш этгээдэд энэ хуулийн 154-өөс 157 дугаар зүйлийн заалт нэг адил хамаарна.

159 дүгээр зүйл. Оюуны үнэт зүйлийг өмчлөх эрхийн баталгаа, хамгаалалт

1. Оюуны үнэт зүйлийг өмчлөх эрхийн баталгаа, хамгаалалтыг хуулиар тогтооно.

2. Хуульд өөрөөр заагаагүй бол оюуны үнэт зүйлийг өмчлөх эрхийн баталгаа, хамгаалалтыг энэ хуулиар зохицуулна.

III ХЭСЭГ

ҮҮРГИЙН ТУХАЙ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ АРВАНДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Үүрэг үүсэх түүнийг гүйцэтгэх

160 дугаар зүйл. Үүрэг, түүнийг гүйцэтгэх

1. Иргэний гүйлгээнд оролцогч нэг этгээд-үүрэг хүлээгч нь эд хөрөнгө шилжүүлэх, ажил гүйцэтгэх, туслалцаа үзүүлэх, мөнгө төлөх зэрэг ямар нэгэн тодорхой үйлдэл хийх, эсхүл тодорхой үйлдэл хийхээс татгалзах үүргийг нөгөө этгээд-үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө хүлээх бөгөөд үүрэг гүйцэтгүүлэгч нь түүнээс үг үүргээ гүйцэтгэхийг шаардах эрхтэй.

2. Үүрэг нь энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан үндэслэлээр үүснэ.

3. Үүрэг хүлээгч нь үүрэг үүсэх үндэслэл болсон хууль, гэрээний заалтын дагуу хүлээсэн үүргээ гүйцэтгэнэ. Хууль, гэрээнд тийм заалт байхгүй бол ердийн шаардлагад нийцүүлэн гүйцэтгэнэ.

4. Хууль буюу гэрээнд зааснаас бусад тохиолдолд үүрэг гүйцэтгэхээс дангаараа татгалзах буюу гэрээний нөхцөлийг дангаараа өөрчилж болохгүй.

5. Хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй, түүнчлэн үүргийн байдлаас шаардагдахгүй бол үүрэг гүйцэтгүүлэгч үүргийн гүйцэтгэлийг хэсэгчлэн хүлээн авах эрхгүй.

161 дүгээр зүйл. Гэрээ байгуулах

1. Гэрээний гол нөхцөлийн талаар талууд харилцан тохиролцож хуульд заасан буюу хэлэлцэн тохирсон хэлбэрээр гэрээ хийсэн бол уг гэрээг байгуулсан гэж үзнэ.

2. Хуульд заасан буюу гэрээнд зайлшгүй тусгавал зохих, түүнчлэн нэг талын хүсэлтийн дагуу нөгөө тал нь зөвшөөрсөн нөхцөлийг гэрээний гол нөхцөл гэнэ.

3. Эд хөрөнгө шилжүүлснээр гэрээ байгуулахаар хуульд заасан бол гэрээний гол нөхцөлийн талаар талууд тохиролцож, тухайн эд хөрөнгийг шилжүүлсэн үеэс гэрээ байгуулсанд тооцно.

4. Тухайн төрлийн гэрээний хэлбэрийг хуульд заагаагүй нөхцөлд гэрээг тодорхой хэлбэрээр, байгуулахаар талууд тохиролцсон бол түүнийг тухайн хэлбэрээр хийсэн үеэс байгуулсанд тооцно.

5. Хуульд зааснаар буюу талууд тохиролцсоноор гэрээг бичгээр байгуулах ёстой бол талууд баримт бичиг үйлдэж, гарын үсэг зурах буюу гэрээний төслийг зөвшөөрснөө илэрхийлсэн талын гарын үсэг зурагдсан захидал, цахилгаан, албан бичиг (телекс, телефакс зэрэг) бусад баримт бичгийг нөгөө тал хүлээн авснаар байгуулсанд тооцно.

6. Нэг буюу хэд хэдэн тодорхой этгээдэд хандсан талын хүсэл зоригийг бодитойгоор илэрхийлж, түүнийг зөвшөөрсөн этгээдтэй эрх, үүргийн хувьд холбогдоно гэж үзэж илгээсэн, гэрээ байгуулах тухай хангалттай тодорхой саналыг гэрээний төсөл гэнэ. Гэрээний гол нөхцөл буюу түүнийг тодорхойлох журмыг заасан саналыг хангалттай тодорхой гэж үзнэ.

7. Тодорхой бус этгээдүүдэд хандаж гаргасан санал нь өөртөө шууд өөр заалт агуулаагүй бол гэрээний төсөл ирүүлэх дуудлага гэж тооцогдоно.

8. Гэрээний төслийг хариу ирүүлэх хугацаатайгаар илгээсэн бөгөөд дурдсан хугацаанд нөгөө талаас төслийг зөвшөөрсөн тухай хариу авсан бол гэрээ байгуулагдсанд тооцно.

9. Гэрээний төслийг хариу ирүүлэх хугацаа заалгүйгээр амаар мэдэгдсэн бөгөөд нөгөө тал уг төслийг зөвшөөрснөө нэн даруй мэдэгдсэн бол гэрээ байгуулагдсанд тооцно.

10. Гэрээний төслийг хариу ирүүлэх хугацаа заалгүй бичгээр илгээсэн бөгөөд түүнийг зөвшөөрсөн тухай харуг ердийн боломжит хугацаанд хүлээн авсан бол гэрээ байгуулагдсанд тооцно.

11. Гэрээний төсөл илгээсэн тал зааган хугацаанд, хугацаа заагаагүй бол харин хүлээн авах ердийн боломжит хугацааны дотор төслөөсөө татгалзах эрхгүй.

12. Гэрээний төслийг зөвшөөрсөн тухай хожимдож ирсэн харинаас үзвэл харинг хугацаанд нь илгээсэн болох нь тодорхой бөгөөд төсөл илгээсэн тал харинг хугацаа хожимдуулж хүлээн авсан учраас гэрээ байгуулахгүй гэж нөгөө талд нэн даруй мэдэгдээгүй бол гэрээг байгуулагдсанд тооцно. Төсөл илгээсэн тал харинг хугацаа хожимдуулж авсан тухай нөгөө талд мэдэгдсэн тохиолдолд хугацаа хожимдож авсан харинг гэрээний шинэ төсөл гэж үзнэ.

13. Гэрээний төслөөс өөр нөхцөлөөр гэрээ байгуулахыг зөвшөөрсөн харинг гэрээний шинэ төсөл гэж үзнэ.

14. Хууль буюу гэрээнд заасан бол гэрээ байгуулах явцад гарсан маргааныг шүүх, арбитрын журмаар шийдвэрлүүлж болно.

162 дугаар зүйл. Үнэ хаялцуулах ажиллагаа

1. Үнэ хаялцуулах замаар гэрээ байгуулж болно. Хуульд өөрөөр заагаагүй бол гэрээг үнэ хаялцаж ялсан этгээдтэй байгуулна.

2. Үнэ хаялцуулах ажиллагааг зохион байгуулагч нь өмчлөгч буюу эрх эзэмшигч, эсхүл эрх олгогдсон байгууллага байж болно. Эрх олгогдсон байгууллага нь өмчлөгч буюу эрх эзэмшигчтэй байгуулсан гэрээний үндсэн дээр тэдгээрийн нэрийн өмнөөс буюу өөрийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулна.

3. Эд юмс буюу эд хөрөнгийн эрхийг худалдах гэрээг гагцхүү үнэ хаялцуулах замаар байгуулахаар хуульд заасан бол ийнхүү байгуулна.

4. Үнэ хаялцуулах ажиллагаа нь дуудлагын худалдаа буюу уралдааны хэлбэрээр явагдана. Дуудлагын худалдаагаар үнэ хаялцан ялагч нь хамгийн өндөр үнэ санал болгосон этгээд байна. Уралдаанд ялагч нь уралдааныг зохион байгуулах комиссоос урьдчилан тодорхойлсноор хамгийн сайн нөхцөлийг хангасан этгээд байна. Хуульд өөрөөр заагаагүй бол үнэ хаялцуулах ажиллагааны хэлбэрийг уг эд хөрөнгийн өмчлөгч буюу эд хөрөнгийн эрх эзэмшигч тогтооно.

5. Дуудлагын худалдаа буюу уралдаанд нэг этгээд оролцсон бол худалдаа буюу уралдаан явагдаагүй гэж үзнэ.

6. Энэ зүйлд заасан журам нь хуульд өөрөөр заагаагүй бол шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн журмаар явагдах дуудлагын худалдаанд нэг адил хамаарна.

7. Дуудлагын худалдаа ба уралдаан нь нээлттэй буюу хаалттай байж болно. Нээлттэй дуудлагын худалдаа ба уралдаанд ямар ч этгээд оролцож болно. Хаалттай дуудлагын худалдаа ба уралдаанд гагцхүү энэ зорилгоор тусгайлан уригдсан этгээд оролцоно.

8. Хуульд өөрөөр заагаагүй бол зохион байгуулагч нь зарыг үнэ хаялцуулах ажиллагаа явуулахаас 30-аас доошгүй хоногийн өмнө гаргах үүрэгтэй. Зар нь ажиллагаа явуулах хэлбэр, газар, цаг, хугацаа, гэрээний зүйл, анхны үнэ, оролцогчдыг бүртгэх, ялсан этгээдийг тогтоох зэрэг журам болон бусад мэдээллийг агуулсан байна. Гэрээний зүйл нь гэрээ байгуулах эрх байвал үнэ хаялцуулах ажиллагаа явуулах тухай зард гэрээ байгуулах хугацааг заана.

9. Хууль буюу зард өөрөөр заагаагүй бол нээлттэй худалдаа ба уралдаан зохион байгуулагч нь тэдгээрийг хийхээс татгалзах эрхтэй боловч худалдаа хийхээр зарласан өдрөөс 3-аас доошгүй хоногийн, уралдаан явуулахаар зарласан өдрөөс 30-аас доошгүй хоногийн өмнө ийнхүү татгалзаж болно. Дээрх хугацааг зөрчиж худалдаа хийх буюу уралдаан явуулахаас татгалзсан зохион байгуулагч нь оролцогчдод учирсан хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй. Хаалттай дуудлагын худалдаа ба уралдаан зохион байгуулагч нь түүнд уригдсан оролцогчдод учирсан хохирлыг ямар хугацаанд худалдаа, уралдаан явуулахаас татгалзсанаас үл хамааран төлөх үүрэгтэй.

10. Үнэ хаялцуулах ажиллагаанд оролцогчид нь зард заасан хэмжээ, журмаар, заасан хугацаанд дэнчин тавина. Үнэ хаялцуулах ажиллагаа явагдаагүй буюу түүнд оролцоогүй, эсхүл оролцсон боловч ялаагүй этгээдэд дэнчинг буцаан олгоно. Ялсан этгээдтэй гэрээ байгуулахдаа дэнчинг гэрээний үүргийн гүйцэтгэлд оруулан тооцно.

11. Үнэ хаялцуулах ажиллагаанд ялсан этгээд болон ажиллагаа зохион байгуулагч нь дуудлагын худалдаа ба уралдааны үр дүнгийн тухай тэмдэглэлд явуулсан өдөрт нь гарын үсэг зурах бөгөөд энэ тэмдэглэл нь гэрээний адил хүчинтэй байна. Ялсан этгээд нь тэмдэглэлд гарын үсэг зурахаас зайлсхийвэл оруулсан дэнчингээ алдана. Ажиллагаа зохион байгуулагч нь тэмдэглэлд гарын үсэг зурахаас зайлс-

хийвэл нөгөө талын тавьсан дэнчинг хоёр нугалж өгөхийн зэрэгцээ ажиллагаанд оролцоноос учирсан хохирлыг дэнчингээс давсан хэмжээнд нь нөхөн төлөх үүрэгтэй.

12. Гэрээ байгуулах эрх олж авах нөхцөлтэйгээр үнэ хаялцуулах ажиллагаа явагдсан бол ажиллагаа явагдаж дуусаад тэмдэглэл үйлдсэнээс хойш 20 хоногийн дотор, эсхүл зард дурдсан хугацаанд талууд гэрээнд гарын үсэг зурна. Талуудын аль нэг нь гэрээ байгуулахаас зайлсхийвэл нөгөө тал нь гэрээг байгуулсанд тооцож, үүргийн гүйцэтгэлийг хангуулах, учирсан хохирлоо төлүүлэхээр шаардах эрхтэй.

13. Хуулиар тогтоосон журам зөрчиж явуулсан үнэ хаялцуулах ажиллагаа хүчин төгөлдөр бус байна.

14. Хүчин төгөлдөр бус үнэ хаялцуулах ажиллагаагаар ялсан этгээдтэй байгуулсан гэрээ хүчин төгөлдөр бус байна.

163 дугаар зүйл. Нийтийн гэрээ

1. Иргэд, хуулийн этгээд өөрийн үйл ажиллагааныхаа шинжээс хамааран, нийтэд хандаж, хуульд заасан буюу өөрөө зарласан нөхцөлөөр, түүнийг хүлээн зөвшөөрсөн аливаа этгээдийн өмнө тодорхой үүрэг хүлээх (эд хөрөнгө худалдах, ажил гүйцэтгэх, туслалцаа үзүүлэх гэх мэт)-ээр байгуулсан гэрээг нийтийн гэрээ гэнэ.

2. Хуульд зааснаас бусад тохиолдолд харну төлбөртэй нийтийн гэрээнд эд хөрөнгө, ажил, туслалцааны үнэ болон бусад нөхцөл гэрээ байгуулахыг зөвшөөрсөн бүх этгээдэд адил тогтоогдоно.

3. Санал гаргагч тал нь зохих эд хөрөнгийг шилжүүлэх, ажил гүйцэтгэх, туслалцаа үзүүлэх боломжтой бол санал хүлээн авагчтай нийтийн гэрээ байгуулахаас татгалзах эрхгүй. Санал гаргагч гэрээ байгуулахаас үндэслэлгүй татгалзвал энэ хуулийн 164 дүгээр зүйлд заасан журмаар зохицуулна.

164 дүгээр зүйл. Гэрээ заавал байгуулах

1. Талуудын аль нэг нь гэрээ заавал байгуулахаар хуульд заасан бол тэр тал нь нөгөө талдаа гэрээний төслийг зөвшөөрсөн буюу татгалзсан харнуг, эсхүл гэрээний шинэ төсөл (гэрээг өөр нөхцөлөөр байгуулах тухай харну)-ийг хууль буюу гэрээнд өөр хугацаа тогтоогоогүй бол гэрээний төсөл хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор илгээх үүрэгтэй.

2. Хууль буюу гэрээнд өөр хугацаа тогтоогоогүй бол гэрээ заавал байгуулах үүрэг бүхий талаас гэрээний шинэ төсөл хүлээн авсан тал нь хариу хүлээн авсан, эсхүл хариу ирүүлэх хугацаа өнгөрснөөс хойш 30 хоногийн дотор гэрээ байгуулах явцад гарсан маргааныг шийдвэрлүүлэхээр шүүхэд мэдүүлэх эрхтэй.

3. Гэрээ заавал байгуулах үүрэг бүхий талаас илгээсэн гэрээний шинэ төслийг 30 хоногийн дотор хүлээн авсан бол тэр тал нь уг төслийг зөвшөөрсөн, эсхүл татгалзсан тухайгаа түүнийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор хариу мэдэгдэх үүрэгтэй. Хууль буюу гэрээнд өөрөөр тогтоогоогүй бол гэрээний шинэ төслийг зөвшөөрөөгүй, эсхүл заасан хугацаанд хариу ирүүлээгүй тохиолдолд гэрээний шинэ төслийг илгээгч нь маргааныг шийдвэрлүүлэхээр шүүхэд мэдүүлэх эрхтэй.

4. Хуульд заасны дагуу гэрээ заавал байгуулах үүрэг бүхий тал гэрээ байгуулахаас зайлхийвэл нөгөө тал нь гэрээг байгуулсанд тооцож, үүргийн гүйцэтгэлийг хангуулах, учирсан хохирлыг төлүүлэхээр шүүхэд мэдүүлэх эрхтэй.

165 дугаар зүйл. Гэрээ ба хууль

1. Гэрээ нь уг гэрээг байгуулах үед хүчин төгөлдөр байсан хуулиар тогтоосон журамд нийцсэн байна.

2. Гэрээ байгуулагдах үед үйлчилж байсан журмаас өөр журам тогтоосон хууль гэрээ байгуулсны дараа батлагдсан бөгөөд шинээр тогтоосон журам нь гэрээний аль нэг буюу хоёр талын эрх, хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулахаар байвал уг гэрээний нөхцөл хүчин төгөлдөр хэвээр байна.

166 дугаар зүйл. Гэрээ тайлбарлах

1. Шүүх гэрээг тайлбарлахдаа түүний үгийн шууд утгыг анхаарна. Гэрээний аль нэг нөхцөлийн утга нь ойлгомжгүй бол шүүх түүний агуулгыг бусад нөхцөл болон гэрээний ерөнхий агуулгатай харьцуулах замаар тодорхойлно.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан журмаар гэрээний агуулгыг тодорхойлох боломжгүй бол гэрээний зорилтыг харгалзан талуудын жинхэнэ нэгдмэл санаар тодруулна. Үүний тулд гэрээ байгуулахаас өмнө хийсэн хэлэлцээ, харилцан илгээсэн баримт бичиг, талуудын хооронд тогтсон практик, ажил хэргийн заншил зэрэг холбогдох нөхцөл байдлыг харгалзан үзэж болно.

167 дугаар зүйл. Урьдчилсан гэрээ

1. Урьдчилсан гэрээгээр түүнд заасан нөхцөлийн дагуу ад хөрөнгө шилжүүлэх, ажил гүйцэтгэх, туслалцаа үзүүлэх ухай зэрэг гэрээг ирээдүйд байгуулахаар талууд үүрэг үлээнэ. Хуулиар тогтоогоогүй бөгөөд урьдчилсан гэрээнд заагаагүй ирээдүйн гэрээний гол нөхцөлүүдийг тохиролцох курмыг талууд урьдчилсан гэрээгээр тодорхойлно.

2. Урьдчилсан гэрээг бичгээр байгуулна.

3. Урьдчилсан гэрээний нэг тал нь түүгээр тохиролцсон эрээг байгуулахаас татгалзвал нөгөө тал нь энэ хуулийн 64 дүгээр зүйлд заасан журмын дагуу шүүхэд мэдүүлэх рхтэй. Хуульд өөрөөр заагаагүй бол урьдчилсан гэрээгээр охиролцсон гэрээг байгуулахаас үндэслэлгүйгээр зайлсийсэн тал нь гэрээ байгуулах хугацаа хожимдсоны улмаас өгөө талд учирсан хохирлыг төлнө.

168 дугаар зүйл. Эвлэрлийн гэрээ

1. Талууд хоорондын маргааныа харилцан буулт хийх амаар шийдвэрлэхээр эвлэрлийн гэрээг байгуулж болно.

2. Талууд өөрсдийн захиран зарцуулах эрхэд хамаарахгүй эд хөрөнгө, эрхийн талаар эвлэрлийн гэрээ байгуулж олохгүй.

3. Гэрээний үр дүн бодит байдлаас зөрүүтэй байж болоыг мэдсээр байж талууд эвлэрлийн гэрээ байгуулсан бол аргаан гарахын өмнөх байдал зөв байсан нь тогтоогдсон ч эр нь уг гэрээг хүчин төгөлдөр бус гэж тооцох үндэслэл олохгүй. Харин маргаан гарахын өмнөх байдал зөв байсыг нотлох баримт хожим илэрвэл гэрээг хүчин төгөлдөр ус гэж тооцохоор эвлэрлийн гэрээнд заасан бөгөөд тийм аримт илэрвэл уг гэрээ хүчин төгөлдөр бус болно.

169 дүгээр зүйл. Нэрлэгдээгүй гэрээ

1. Энэ хуулиар тусгайлан зохицуулагдаагүй бөгөөд шууд эрлэгдээгүй боловч гэрээний үндсэн шинж, хэлбэрийг лэрхийлсэн өвөрмөц ангуулга бүхий гэрээг нэрлэгдээгүй эрээ гэнэ.

2. Нэрлэгдээгүй гэрээнд энэ хуулийн үүргийн тухай ийтлэг үндэслэл хамаарна.

170 дугаар зүйл. Гуравдагч этгээдэд ашигтай гэрээ

1. Гуравдагч этгээдэд ашигтай гэрээгээр талууд гэрээнд

оролцоогүй гуравдагч этгээдийн тусын тулд үүрэг гүйцэ гүүлэхээр тохиролцоно.

2. Хууль, гэрээнд өөрөөр заагаагүй бөгөөд үүргийн шинж чанарт харшлахгүй бол үүрэг гүйцэтгүүлэгч болон гэрээнд гүйцэтгэл ашигтай байх гуравдагч этгээд нь уг гэрээний гүйцэтгэлийг шаардах эрхтэй.

3. Гуравдагч этгээд гэрээгээр олгогдсон эрхээсээ татгалзсан бөгөөд хууль, гэрээ, үүргийн шинж чанарт харшлахгүй бол гэрээ байгуулсан этгээд гуравдагч этгээдийн эдлэх байсан эрхийг олж авч болно.

171 дүгээр зүйл. Гуравдагч этгээдээр үүрэг гүйцэтгүүлэ

1. Хууль буюу гэрээнд заасан, түүнчлэн гэрээний алнэг талтай гуравдагч этгээд зохих гэрээ хийсэн бол үүргийн бүхэлд нь буюу зарим хэсгийг гуравдагч этгээдээр гүйцэтгүүлж болно.

2. Хууль, гэрээ, үүргийн байдлаас үүрэг хүлээгч уг үүргийг биечлэн гүйцэтгэх шаардлагагүй бол гуравдагч этгээдийн гүйцэтгэлийг үүрэг гүйцэтгүүлэгч хүлээн авах үүрэгтэй.

3. Гуравдагч этгээд хариуцлага хүлээхээр хууль заагаагүй бол түүний гүйцэтгээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүй үүргийн хариуцлагыг үндсэн үүрэг гүйцэтгэгч хариуцна.

172 дугаар зүйл. Үүрэг гүйцэтгэх хугацаа

1. Үүргийг хууль, гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэнэ.

2. Үүрэг хүлээгч үүрэг гүйцэтгүүлэгчийн зөвшөөрөлгүйгээр үүргээ хугацаанаас өмнө гүйцэтгэх эрхгүй.

3. Үүрэг гүйцэтгэх хугацаа, болзол тогтоогоогүй бол үүрэг гүйцэтгүүлэгч хэдийд ч үүргийн гүйцэтгэлийг шаардах эрхтэй ба үүрэг хүлээгч гүйцэтгэх үүрэгтэй. Хууль, гэрээнд өөрөөр заагаагүй буюу үүргийн байдлаас шаардагдахгүй бол үүрэг хүлээгч нь үүрэг гүйцэтгүүлэгч шаардсанаас хойш 10 хоногийн дотор түүнийг гүйцэтгэх үүрэгтэй.

4. Хууль буюу гэрээнд заасан бол талуудын тохиролцсоноор үүрэг гүйцэтгэх хугацааг сунгаж болно. Үүрэг гүйцэтгэх хугацаа сунгах асуудлыг үүргийн үндсэн хугацаа дууссахаас өмнө талууд шийдвэрлэсэн байвал зохино.

173 дугаар зүйл. Үүрэг гүйцэтгэх газар

1. Хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол үүрэг гүйцэтгэх газрыг дараахь байдлаар тодорхойлно:

1) үл хөдлөх эд хөрөнгө шилжүүлэх үүргийг үг эд хөрөнгийн байгаа газар;

2) эд хөрөнгө тээвэрлүүлэх үүргийн үед түүнийг үүрэг гүйцэтгүүлэгч буюу эрх бүхий этгээдэд хүргүүлэхээр анхны тээвэрлэгчид хүлээлгэн өгч байгаа газар;

3) мөнгөн төлбөрийн үүргийг үүрэг гүйцэтгүүлэгчийн оршин суугаа (оршин байгаа) газар, харин үүрэг гүйцэтгүүлэгч оршин суугаа (оршин байгаа) газраа өөрчилсөн бөгөөд энэ тухай үүрэг хүлээгчид мэдэгдсэн бол түүний шинээр оршин суугаа (оршин байгаа) газар гүйцэтгэх боловч үүнтэй холбогдон гарсан зардлыг үүрэг гүйцэтгүүлэгч хариуцна.

4) бусад бүх үүргийг үүрэг хүлээгчийн оршин суугаа (оршин байгаа) газар.

2. Гэрээнд заасан бол тухайн эд хөрөнгийг үйлдвэрлэсэн (бэлтгэсэн) буюу хадгалж байсан газар үүргийг гүйцэтгэж болно.

174 дүгээр зүйл. Гэрээний үнэ

1. Хариу төлбөртэй гэрээний үнийг талууд тохиролцон тогтооно.

2. Хууль буюу гэрээнд заасан бол гэрээ байгуулснаас хойш гэрээний үнийг өөрчилж болно.

3. Хууль буюу гэрээнд заасан бол талууд гэрээний үнийг үүрэг гүйцэтгэх үеийн зах зээлийн ханшаар тооцох, эсхүл хожим тохиролцож болно.

175 дугаар зүйл. Мөнгөн төлбөрийн үүрэг

1. Мөнгөн төлбөрийн үүргийг Монгол Улсын мөнгөн тэмдэгт-төгрөгөөр гүйцэтгэнэ.

2. Гадаад валют, гадаад валютаар илэрхийлэгдэх төлбөрийн баримтаар Монгол Улсын нутаг дэвсгэр дээр мөнгөн төлбөрийн үүрэг гүйцэтгэхдээ тогтоосон журмыг баримтлана.

3. Үүрэг гүйцэтгүүлэгч байхгүй, эсхүл үүрэг гүйцэтгүүлэгч үүргийн гүйцэтгэлийг хүлээн авахаас татгалзсан буюу хугацаа хожимдуулсан бол үүрэг хүлээгч нь төлөх мөнгө, шилжүүлэх үнэт цаасаа нотариатад хадгалуулах ба нотариат энэ тухай үүрэг гүйцэтгүүлэгчид мэдэгдэнэ.

4. Мөнгө, үнэт цаасыг нотариатад хадгалуулсныг үүрэг гүйцэтгэсэнд тооцно.

5. Мөнгөн төлбөрийн үүрэг гүйцэтгэх хугацааг хожим-

дуулсан бөгөөд талууд гэрээнд заасан бол үүрэг гүйцэтгүүлэгч анз төлүүлэхээр шаардах эрхтэй.

176 дугаар зүйл. Үнэт цаасаар гэрчлэгдэж байгаа үүргийг гүйцэтгэх нөхцөл

1. Үнэт цаасыг гаргасан, үнэт цаасаар гэрчлэгдсэн эрхийг болон үнэт цаасыг шилжүүлсэн бүх этгээд үнэт цаас өмчлөгчийн өмнө хууль тогтоомжид заасны дагуу хамтын хариуцлага хүлээнэ.

2. Хуурамч буюу засвартай болохыг нь илрүүлсэн үнэт цаас өмчлөгч нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан этгээдийн хэн алинаас нь үүргээ зохих ёсоор гүйцэтгэх, учирсан хохирлыг төлөхийг шаардах эрхтэй.

177 дугаар зүйл. Хэд хэдэн үүрэг гүйцэтгүүлэгч буюу хэд хэдэн үүрэг хүлээгч оролцсон үүргийн гүйцэтгэл

1. Хэд хэдэн үүрэг гүйцэтгүүлэгч буюу хэд хэдэн үүрэг хүлээгч оролцсон үүргийг хууль буюу гэрээнд заасны дагуу хэсэгчлэн буюу хамтран гүйцэтгэх, эсхүл гүйцэтгэлийг хэсэгчлэн буюу хамтран шаардана.

2. Хэд хэдэн үүрэг хүлээгч үүргийг хэсэгчлэн гүйцэтгэх бол үүрэг хүлээгч тус бүр өөрт ногдох үүргийг үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө хариуцна. Өөрт ногдох үүргийг гүйцэтгэснээр түүний үүрэг дуусгавар болно.

3. Хэд хэдэн үүрэг гүйцэтгүүлэгч оролцсон бол тэд өөрт ногдох үүргийн гүйцэтгэлийг үүрэг хүлээгчээс шаардах эрхтэй.

4. Гэрээнд өөрөөр заагаагүй бол хэд хэдэн үүрэг гүйцэтгүүлэгч оролцсон үүргийн үед тэдгээрийн тус бүрийнх нь үүргийн гүйцэтгэлийг шаардах эрх, түүнчлэн хэд хэдэн үүрэг хүлээгч оролцсон үүргийн үед тэдгээрийн тус бүрийнх нь гүйцэтгэх үүргийн хэмжээг тус тус тэнцүү гэж үзнэ.

5. Хууль буюу гэрээнд зааснаар үүргийн зүйл нь үл хуваагдах шинжтэй байвал үүргийг хамтран гүйцэтгэх буюу гүйцэтгэлийг хамтран шаардана.

6. Үүргийг хамтран гүйцэтгэх бол үүрэг гүйцэтгүүлэгч үүргийн гүйцэтгэлийг бүх үүрэг хүлээгчээс буюу тэдгээрийн аль нэгнээс бүхэлд нь шаардах эрхтэй. Хамтран үүрэг хүлээгчдийн аль нэг нь үүргийг дутуу гүйцэтгэсэн бол үлдсэн

...цэтгүүлэгч бусад үүрэг хү-

хэсгийн гүйцэтгэлийг үү
лээгчээс шаардах эрхтэй.

7. Хамтран үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө үүрэг гүйцэт-
гүйцэтгэсэн үүрэг хүлээгчид чөлөөлөгдөнө.
гэхээс бусад үүрэг гүйцэтгүүлэгчид бүтдээрээ буюу тэд-

8. Аль нэг нь үүргийг бүрэн гүйцэтгэхийг үүрэг хүлээгчээс
шаардах эрхтэй.

9. Үүрэг хүлээгч нь хамтран үүрэг гүйцэтгүүлэгчдийн
аль нэгэнд үүргийг бүрэн гүйцэтгэсэн бол бусад үүрэг гүй-
цэтгүүлэгчдийн өмнө үүрэг гүйцэтгэхээс чөлөөлөгдөнө.

178 дугаар зүйл. Гэрээг өөрчлөх ба цуцлах

1. Хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол гэрээг
талуудын хэлэлцэн тохиролцсоноор өөрчлөх ба цуцлж
болно.

2. Гагцхүү дараахь тохиолдолд нэг талын санаачилгын
дагуу шүүхийн шийдвэрээр гэрээг өөрчлөж, цуцалж болно:

1) нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн бол;

2) хууль буюу гэрээнд заасан бусад тохиолдолд.

3. Нэг талын санаачлагаар гэрээг бүрэн буюу хэсэгчлэн
шелүүлэхээс татгалзахыг хууль буюу гэрээгээр өөрчөөрсөн
тохиолдолд ийнхүү татгалзсанаар гэрээ нь өөрчлөгдсөн,
эсхүл цуцлагдсанд тооцогдоно.

4. Хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол гэрээг
өөрчлөх ба цуцлах тухай тохиролцоог үндсэн гэрээтэй адил
аргаар хийнэ.

5. Гэрээг өөрчлөх ба цуцлах тухай талуудын аль нэгний
саналлыг нөгөө тал эс зөвшөөрсөн, саналд дурдсан буюу
хууль, гэрээгээр тогтоосон хугацаанд хариу ирүүлээгүй,
эсхүл ийм хугацаа тогтоогоогүй тохиолдолд 30 хоногийн
дотор хариу ирүүлээгүй бол гэрээг цуцлах тухай хүсэлтээ
үүнд гаргах эрхтэй.

6. Гэрээг цуцалснаар талуудын үүрэг дуусгавар болно.

7 Гэрээг өөрчилсөн бол талуудын үүрэг өөрчилсөн байд-
гаар үргэлжилнэ.

8. Талуудын тохиролцсоноор буюу гэрээний шинж ча-
арт харшлахгүй бол гэдгээрийн эрх, үүрэг нь гэрээг өөрч-
өх ба цуцлах тухай тохиролцсон үеэс, эсхүл энэ тухай
үүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс
лэн өөрчлөгдөх ба дуусгавар болно.

9. Хууль буюу талуудын тохи
гоогүй бол гэрээг өөрчлөх ба цуцлаха ноор өөрөөр тогтоо
үүргийн бислэлтийг бүцаан шаардах эрхтэ гүйцэтгэгдсэн
10. Талуудын аль нэг нь гэрээг ноцтой зөрч
түүнийг өөрчлөх ба цуцлахад хүргэсэн бол ийнхүү улмаас
сөн, цуцалснаас өөрт учирсан хохирлыг нөгөө тал шаардл
эрхтэй.

АРВАНТАВДУГААР БҮЛЭГ

Үүргийн гүйцэтгэлийг хангах

179 дүгээр зүйл. Үүргийн гүйцэтгэлийг хангах арга

1. Хууль болон гэрээнд зааснаар бол үүргийн гүйцэтгэ
нь анз, барьцаа, дэнчин, батлан даалт, баталгаагаар хан
гадана.
2. Үүргийн гүйцэтгэлийг хангах тухай гэрээ хүчин т
өлдөр бус болох нь үндсэн үүрэг хүчин төгөлдөр бус боло
үндэслэл болохгүй.
3. Үндсэн үүрэг хүчин төгөлдөр бус болсноор түүни
гүйцэтгэлийг хангах тухай гэрээ хүчин төгөлдөр бус болно

180 дугаар зүйл. Анз

1. Хүлээсэн үүргээ гүйцэтгээгүй буюу зохих ёсоор гүй
цэтгээгүй тал хууль болон гэрээнд зааснаар нөгөө талда
төлөх ёстой мөнгөн төлбөрийг анз гэнэ.
2. Үндсэн үүргийн гэрээний хэлбэрээс үл хамааран анзы
тухай гэрээг бичгээр байгуулна. Энэ шаардлагыг хангаагү
гэрээ хүчин төгөлдөр бус байна.
3. Анз нь торгууль, алданги гэсэн төрөлтэй байна.
4. Үүргээ гүйцэтгээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгү
үүрэг хүлээгчээс үүрэг гүйцэтгүүлэгчид төлөхөөр хууль
болон гэрээнд урьдчилан тодорхой хэмжээгээр, эсхүл гүй
цэтгээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүй үүргийн үний
дүнгийн тодорхой хувиар тогтоосон анзыг торгууль гэнэ.
5. Хууль болон гэрээнд заасан, хугацаа хэтрүүлсэн хоно
тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн тодорхой ху
виар тооцож, үүрэг хүлээгчээс үүрэг гүйцэтгүүлэгчид төлө
анзыг алданги гэнэ. Үүрэг гүйцэтгэх хугацаа хожимдуулса
хоног тутамд төлөх алдангийн хэмжээг гүйцэтгээгүй үүргий
үнийн дүнгийн 0,5 хүртэл хувиар тогтоож болно.

6. Анзын нийт дүн гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 хувиас хэтэрч болохгүй.

7. Анз төлөхөөр гэрээ байгуулсан бол үүргээ гүйцэтгээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүйгээс учирсан хохирлыг анзаас илүү гарсан хэмжээгээр, эсхүл үүрэг гүйцэтгүүлэгчийн сонгосноор анз буюу хохирлын аль нэгийг төлүүлж болно. Харин хууль болон гэрээнд заасан бол хохирлыг анзын хамт бүрэн төлүүлнэ.

8. Үүрэг хүлээгч үүргээ гүйцэтгээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүйн төлөө харилцлага хүлээхээргүй байвал (энэ хуулийн 191 дүгээр зүйл) үүрэг гүйцэтгүүлэгч анз төлүүлэхээр шаардах эрхгүй.

9. Гэрээгээр тогтоосон анзын хэмжээ үүрэг гүйцэтгүүлэгчид учирсан хохирлоос их байвал шүүх, арбитр анзын хэмжээг багасгах эрхтэй.

181 дүгээр зүйл. Барьцаа

1. Хуульд өөрөөр заагаагүй бол эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх барьцааны зүйл байж болно.

2. Орон сууц, барилга, бусад үл хөдлөх эд хөрөнгийг барьцаалах журмыг хуулиар тогтооно.

3. Үүрэг хүлээгч барьцаагаар хангагдсан үүргийг хууль буюу гэрээнд заасны дагуу гүйцэтгээгүй бол барьцаалагч-үүрэг гүйцэтгүүлэгч нь бусад үүрэг гүйцэтгүүлэгчдээс тэргүүн ээлжинд барьцаалсан эд хөрөнгийн үнээс хохирлоо арилгуулах эрхтэй.

4. Барьцаалуулагч нь үүрэг хүлээгч буюу бусад этгээд байж болно.

5. Барьцаалуулагч нь барьцаанд барьцаалсан эд хөрөнгийг өмчлөгч байна.

6. Гэрээнд өөрөөр заагаагүй бол барьцаалсан эд хөрөнгөөр үүргийг гүйцэтгэх ба барьцаалагчид төлбөл зохих хохирол, анзыг төлж болно.

7. Барьцааны гэрээнд талуудын нэр, оршин суугаа (оршин байгаа) газар, барьцаагаар хангагдсан үүрэг, түүний хэмжээ, гүйцэтгэх хугацаа, барьцаанд барьцаалсан эд хөрөнгийн жагсаалт, үнэ, байгаа газрыг заана.

8. Барьцааны гэрээг бичгээр хийнэ. Үл хөдлөх эд хөрөнгийг барьцаалсан тухай гэрээг үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн газарт бүртгүүлнэ. Энэ зүйлд заасан журмыг зөрчсөн барьцааны гэрээ хүчин төгөлдөр бус байна.

9. Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалсан бол гэрээг бүртгүүлсэн цагаас, бусад эд хөрөнгө барьцаалсан бол түүнийг барьцаалагчид шилжүүлсэн цагаас барьцааны эрх үүснэ. Эд хөрөнгийг барьцаалагчид шилжүүлэхгүй гэж гэрээнд заасан бол барьцааны эрх нь гэрээ байгуулагдсан цагаас үүснэ.

10. Хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол барьцаалсан хөдлөх эд хөрөнгө барьцаалагчид шилжинэ. Барьцаалсан эд хөрөнгийг шилжүүлэн авсан барьцаалагч уг эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах үүрэгтэй.

11. Барьцаалагчаас буюу хадгалж байсан үүрэг хүлээгчийн хадгалалтаас гарсан барьцаалагдсан эд хөрөнгийг барьцаалагч нэхэмжлэх эрхтэй.

12. Барьцаалсан эд хөрөнгийг өмчлөх эрх барьцаалуулагчаас өөр этгээдэд шилжвэл барьцааны эрх хүчин төгөлдөр хэвээр үлдэнэ.

13. Хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол барьцаалагч уг эд хөрөнгийг ашиглах эрхгүй.

14. Барьцаалагч түүнд шилжсэн эд хөрөнгө устсан, алга болсон, гэмтсэн явдал өөрийн нь буруугаас болоогүй гэдгийг нотолж чадахгүй бол хариуцлага хүлээнэ.

15. Хуульд өөрөөр заагаагүй бол барьцаалсан эд хөрөнгийн үнээс үүрэг гүйцэтгүүлэгчийн нэхэмжлэлийн шаардлагыг шүүхийн шийдвэрээр хангана.

16. Барьцаалсан бөгөөд даатгалтай эд хөрөнгө устгагдсан бол барьцаалагч даатгалын төлбөрөөс тэргүүн ээлжинд хохирлоо арилгуулах эрхтэй.

17. Барьцаалсан эд хөрөнгийг худалдсан үнэ нь барьцаалагчийн нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн хангаагүй бөгөөд хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол барьцаалагч үлдсэн хохирлоо үүрэг хүлээгчийн бусад эд хөрөнгөөс гаргуулах эрхтэй. Энэ тохиолдолд барьцааны эрх нь бусад үүрэг гүйцэтгүүлэгчдээс тэргүүн ээлжинд хохирлоо арилгуулах үндэс болохгүй.

18. Барьцааны эрх дараахь тохиолдолд дуусгавар болно:

1) барьцаагаар хангагдсан үүрэг дуусгавар болбол;
2) барьцаалсан эд хөрөнгө устгагдвал;
3) барьцаалсан эд хөрөнгийг барьцаалагч өмчлөн авбал;
4) барьцаалсан эд хөрөнгийг албадан худалдвал.

182 дугаар зүйл. Банк ба барьцаалан зээлдэх газраас барьцаатай зээл олгох

Банк ба барьцаалан зээлдэх газраас барьцаатай зээл олгохыг хууль буюу түүнд нийцүүлэн талуудын хооронд бичгээр байгуулсан гэрээгээр зохицуулна.

183 дугаар зүйл. Дэнчин

1. Хуульд өөрөөр заагаагүй бол гэрээнд оролцогч нэг этгээд нь гэрээ хийснийг нотолгоо, түүнийг гүйцэтгэх баталгаа болгон нөгөө этгээддээ төлбөл зохих төлбөрт оролцуулан өгсөн эд хөрөнгө, мөнгийг дэнчин гэнэ.

2. Үүрэг гүйцэтгээгүйгээс хариуцлага хүлээгч нь дэнчин тавьсан этгээд байвал уг дэнчин нөгөө этгээддээ үлдэнэ. Үүрэг гүйцэтгээгүйгээс хариуцлага хүлээгч нь дэнчин авсан этгээд байвал дэнчинг нөгөө этгээддээ хоёр нугалан төлөх үүрэгтэй.

3. Үүрэг гүйцэтгээгүйгээс хариуцлага хүлээгч нь гэрээнд өөрөөр заагаагүй бол нөгөө этгээдэд учирсан хохирлыг төлөхдөө дэнчинг оролцуулан тооцно.

184 дүгээр зүйл. Батлан даалт

1. Батлан даагч нь үүрэг хүлээгч өөрийн үүргийг бүрэн буюу заримыг гүйцэтгэж чадна гэдгийг үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө баталж, гүйцэтгэхгүй бол өөрөө хариуцахаар батлан даах гэрээ байгуулна.

2. Батлан даах гэрээг бичгээр байгуулна. Энэ шаардлагыг хангаагүй гэрээ хүчин төгөлдөр бус байна.

3. Гэрээнд өөрөөр заагаагүй бол батлан даагч нь нэг талын санаачилгаар батлан даалтаа цуцлах эрхгүй.

4. Гэрээнд өөрөөр заагаагүй бол үүрэг гүйцэтгүүлэгч нь батлан даалтын талаархи шаардах эрхээ бусдад шилжүүлж болохгүй.

5. Гэрээнд өөрөөр заагаагүй бол үүрэг гүйцэтгээгүйн хариуцлагыг үүрэг хүлээгч болон батлан даагч хамтран хариуцна. Гэрээнд өөрөөр заагаагүй бол батлан даалтыг хамтран гаргагчид нь хариуцлагыг хамтран хүлээнэ.

6. Үүрэг гүйцэтгэсэн батлан даагчид энэхүү үүргийн талаархи үүрэг гүйцэтгүүлэгчийн бүх эрх шилжинэ. Үүрэг гүйцэтгүүлэгч нь үүрэг хүлээгчээс шаардах шаардлагын баримт бичиг, эдгээр шаардлагыг хангах эрхийг үүрэг гүйцэтгэсэн батлан даагчид шилжүүлэн өгөх үүрэгтэй.

7. Үүрэг гүйцэтгүүлэгчээс батлан даагчид нэхэмжлэл гаргавал үүрэг хүлээгчээс үүрэг гүйцэтгүүлэгчийн эсрэг гаргаж болох бүх татгалзлыг батлан даагч гаргах эрхтэй.

8. Үүрэг гүйцэтгүүлэгчээс батлан даагчид нэхэмжлэл гаргавал уг хэргийг шийдвэрлэхэд үүрэг хүлээгчийг татан оролцуулна. Иймхүү татан оролцуулаагүй бол үүрэг хүлээгч нь үүрэг гүйцэтгүүлэгчийн эсрэг гаргаж болох байсан бүх татгалзлыг үүрэг гүйцэтгэсэн батлан даагчийн нэхэмжлэлийн эсрэг гаргах эрхтэй.

9. Батлан даагч шаардсаар байтал уг хэргийг шийдвэрлэхэд оролцоогүй үүрэг хүлээгч энэ зүйлийн 8 дахь хэсэгт заасан эрхээ алдана.

10. Үүрэг хүлээгч үүргээ бүрэн буюу хэсэгчлэн биелүүлээгүй тохиолдолд батлан даагч үүрэг хариуцах хугацаа эхэлснээс хойш нэг жилийн дотор үүрэг гүйцэтгүүлэгч нь батлан даагчид нэхэмжлэл гаргаагүй бол батлан даалт дуусгавар болно.

11. Батлан даах гэрээг тодорхой хугацаа заалгүй буюу болзол тавилгүй хийсэн бол батлан даах гэрээ байгуулснаас хойш гурван жилийн дараа батлан даалт дуусгавар болно.

185 дугаар зүйл. Баталгаа

1. Үүрэг хүлээгч нь гүйцэтгэсэн ажил, шилжүүлсэн эд хөрөнгийн чанарын талаар тодорхой хугацаатайгаар баталгаа гаргаж болно. Энэ талаар үүрэг гүйцэтгүүлэгчид бичгээр мэдэгдэнэ.

2. Үүрэг гүйцэтгүүлэгч нь тухайн эд хөрөнгийг хэвийн байдлаар ашиглахад саад болж байгаа чанарын дутагдлын талаар баталгаанд заасан хугацааны дотор гомдлын шаардлага гаргах эрхтэй. Энэ тохиолдолд үүрэг гүйцэтгүүлэгч нь эд хөрөнгийн чанарын дутагдлыг үнэ төлбөргүй арилгах буюу зохих чанарын эд хөрөнгөөр солих, эсхүл уг эд хөрөнгийг эгүүлэн өгч, төлсөн үнээ буцааж авах, учирсан хохирлоо төлүүлэхээр шаардах эрхтэй.

АРВАНЗУРГАДУГААР БҮЛЭГ

Эрх, үүрэг шилжих

186 дугаар зүйл. Шаардах эрхээ шилжүүлэх

1. Хууль буюу гэрээнд харшлаагүй, эсхүл үүрэг гүйцэтгүүлэгчийн хувийн байдалтай салшгүй холбоотойгоос бусад

тохиолдолд үүрэг гүйцэтгүүлэгч шаардах эрхээ өөр этгээдэд шилжүүлж болно.

2. Шинэ үүрэг гүйцэтгүүлэгчид шилжүүлсэн шаардах эрхийн хүчин төгөлдөр байдлыг анхны үүрэг гүйцэтгүүлэгч хариуцна. Харин анхны үүрэг гүйцэтгүүлэгч шинэ үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө өөрөө батлан даалт гаргаснаас бусад үүргийн гүйцэтгэлийг хариуцахгүй.

3. Шаардах эрхээ шилжүүлсэн үүрэг гүйцэтгүүлэгч энэ тухайгаа үүрэг хүлээгчид бичгээр мэдэгдэнэ. Ийнхүү мэдэгцэгүй бол үүрэг хүлээгч хүлээсэн үүргээ анхны үүрэг гүйцэтгүүлэгчид гүйцэтгэснээр үг үүрэг дуусгавар болно.

4. Үүргийн өмнө гүйцэтгэснээр үг үүрэг дуусгавар болно. мэдэгдэл авсан үүрэг хүлээгч нь шаардлага тавих эрх шилжсэн тухай сан бүх тайлбар, үед анхны үүрэг гүйцэтгүүлэгчид гаргах байцэтгэлийг хангуулах эрх нэг... шилжинэ. Шаардах эрх шинэ үүрэг гүйцэтгүүлэгчид гаргах эрх

187 дугаар зүйл. Үүрэг шилжих

1. Үүрэг хүлээгч нь гагцхүү үүрэг гүйцэтгүүлэ... зөвшөөрөлтэйгээр үүргээ бусдад шилжүүлж болно.

2. Шинэ үүрэг хүлээгч нь үүрэг гүйцэтгүүлэгч, анхны үүрэг хүлээгч хоёрын хоорондын харилцаан дээр үндэслэн гарсан бүх шаардлагыг үүрэг гүйцэтгүүлэгчид тавьж болно.

3. Батлан даагч буюу барьцаалагч шинэ үүрэг хүлээгчийн өмнөөс хариуцлага хүлээхийг зөвшөөрөөгүй бол батлан даалт буюу гуравдагч этгээдээс бариулсан барьцаа нь үүрэг шилжихийн хамт дуусгавар болно.

188 дугаар зүйл. Шаардах эрх ба үүрэг шилжих хэлбэр

Бичгээр байгуулах, тусгай зөвшөөрөл авах, бүртгүүлэх буюу гэрчлүүлэх хэлцэлд үндэслэсэн эрх, үүргийг шилжүүлэхдээ үг хэлцэл байгуулсан хэлбэрээр хийнэ.

АРВАНДОЛДУГААР БҮЛЭГ

Үүрэг гүйцэтгээгүйгээс үүсэх хариуцлага

189 дүгээр зүйл. Үүрэг гүйцэтгэхийг шаардах эрх

1. Талуудын аль нэг нь үүргээ гүйцэтгээгүй бол нөгөө тал нь үг үүргийг гүйцэтгэхийг шаардах эрхтэй.

2. Талуудын аль нэг нь эд хөрөнгийг бусдын өмчлөл буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрх (энэ хуулийн 88 дугаар зүйлд заасан)-эд шилжүүлэх үүргээ гүйцэтгээгүй бол уг эд хөрөнгийг өөртөө шилжүүлэхийг нөгөө тал шаардах эрхтэй. Эд хөрөнгийг нэгэн адил эрх бүхий өөр этгээдэд шилжүүлсэн бол дээрх эрх алдагдана.

Эд хөрөнгийг шилжүүлээгүй байсан бол уг эд хөрөнгө нь урдаар шилжвэл зохих байсан этгээдэд шилжинэ. Хууль буюу гэрээнд зааснаар урдаар шилжвэл зохихоос бусад этгээдүүдийн хувьд хэн түрүүлж нэхэмжилсэн этгээдэд шилжүүлнэ.

3. Тодорхой ажил гүйцэтгэх, туслалцаа үзүүлэх үүргийг гүйцэтгээгүй бол хууль буюу гэрээнд зааснаар үүлэх эрхийг гүйцэтгэвэл зохих талын зардлаар гүйцэтгүүлэх нөгөө тал эдэлнэ.

190 дугаар зүйл. Үүрэг зохих ёсоор гүйцэтгээгүйн хариуцлага

1. Үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүйн улмаас үүрэг гүйцэтгүүлэгчид учирсан бүх хохирлыг үүрэг хүлээгч төлөх үүрэгтэй.

2. Үүрэг гүйцэтгүүлэгчээс гарсан зардал, эд хөрөнгийн алдагдал буюу гэмтэл, үүрэг хүлээгч үүргээ гүйцэтгэсэн бол үүрэг гүйцэтгүүлэгчид зайлшгүй орох байсан орлогыг хохиролд тооцно.

3. Үүрэг хүлээгч үүргээ гүйцэтгээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүйгээс анз төлөхөөр хууль болон гэрээнд заасан бол энэ хуулийн 180 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт заасны дагуу анз, хохирлыг төлүүлнэ.

4. Үүрэг хүлээгч нь тодорхой эд хөрөнгийг үүрэг гүйцэтгүүлэгчийн өмчлөл буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрх (энэ хуулийн 88 дугаар зүйлд заасан)-эд шилжүүлэх үүргээ гүцэтгээгүй бол үүрэг гүйцэтгүүлэгч нь уг эд хөрөнгийг өөртөө шилжүүлэх, хохирлоо арилгахыг шаардах эрхтэй.

5. Тодорхой ажил гүйцэтгэх, туслалцаа үзүүлэх үүргээ үүрэг хүлээгч гүйцэтгээгүй бөгөөд хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол үүрэг гүйцэтгүүлэгч уг үүргийг өөрөө гүйцэтгэх буюу гуравдагч этгээдээр гүйцэтгүүлж, учирсан хохирлыг арилгахыг шаардах эрхтэй.

191 дүгээр зүйл. Хариуцлага хүлээх үндэслэл

1. Хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол үүрэг хүлээгч нь үүргээ гүйцэтгээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүйн хариуцлагыг гагцхүү гэм буруутай нөхцөлд хүлээнэ.

2. Хуульд өөрөөр заагаагүй бол хүлээсэн үүргээ гүйцэтгээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүй үүрэг хүлээгч гэм буруугүй болохоо өөрөө нотолно. Үүргээ зохих ёсоор гүйцэтгэхийн тулд өөрөөс хамаарах бүх арга хэмжээ авсан гэдгээ нотолж чадвал үүрэг хүлээгч гэм буруугүйд тооцогдоно.

3. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас үүргээ гүйцэтгээгүй буюу зохих ёсоор гүйцэтгэх боломжгүй байснаа үүрэг хүлээгч нотлоогүй бол хариуцлага хүлээнэ.

4. Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан онцгой нөхцөл байдалд үүрэг хүлээгчийн хамтран ажиллагч нараас үүргээ гүйцэтгээгүй, үүрэг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай көрөнгө хүрэлцээгүй зэрэг нөхцөл байдал хамаарахгүй.

192 дугаар зүйл. Хугацаа хожимдуулсан, хугацаанаас өмнө үүрэг гүйцэтгэснээс үүсэх хариуцлага

1. Үүрэг гүйцэтгэх хугацаа хожимдуулсан үүрэг хүлээгч нь хугацаа хожимдуулснаас үүрэг гүйцэтгэх боломжгүй болсны хариуцлагыг үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө хүлээнэ.

2. Хугацаа хожимдуулснаас уг үүргийн гүйцэтгэл нь үүрэг гүйцэтгүүлэгчид хэрэгцээгүй болбол үүрэг гүйцэтгүүлэгч нь уг үүргийн гүйцэтгэлийг хүлээн авахаас татгалзаж, хохирол төлөхийг шаардах эрхтэй.

3. Зохих ёсоор гүйцэтгэсэн үүргийн гүйцэтгэлийг үүрэг гүйцэтгүүлэгч хүлээн авахаас татгалзсан, эсхүл үүрэг хүлээгч үүргээ гүйцэтгэхээс өмнө үүрэг гүйцэтгүүлэгч гүйцэтгэвэл зохих үүргээ гүйцэтгээгүйгээс түүнийг гүйцэтгэх боломжгүй болсон буюу үүрэг гүйцэтгэхгүй байхаар тохирсон бол үүрэг гүйцэтгүүлэгч хугацаа хожимдуулсан гэж үзнэ.

4. Үүрэг гүйцэтгүүлэгч хугацаа хожимдуулсны улмаас учирсан хохирлыг үүрэг хүлээгчид төлнө. Үүрэг гүйцэтгүүлэгч хугацаа хожимдуулснаас төлөх анзыг хууль болон гэрээгээр тогтоож болно.

5. Үүрэг гүйцэтгүүлэгчийн хожимдуулсан хугацаанд үүрэг хүлээгч анз төлөхгүй.

6. Үүрэг гүйцэтгүүлэгч ийнхүү хугацаа хожимдуулсан, өөрөө болон үүргийн гүйцэтгэлийг хүлээн авбал зохих этгээд гэм буруугүй болохыг нотолж чадвал хугацаа хожимдуулсаны хариуцлагаас чөлөөлөгдөнө.

7. Үүрэг гүйцэтгүүлэгч нь түүний зөвшөөрөлгүйгээр үүрэг хүлээгч хугацаанаас өмнө үүргээ гүйцэтгэснээс учирсан хохирлыг шаардах эрхтэй.

193 дугаар зүйл. Үүрэг гүйцэтгүүлэгчийн гэм буруу үүрэг хүлээгчийн хариуцлагад нөлөөлөх

1. Үүрэг гүйцэтгүүлэгчийн санаатай буюу болгоомжгүй үйлдэл, эс үйлдэл нь үүрэг хүлээгчээс үүргээ гүйцэтгэх буюу зохих ёсоор гүйцэтгэхэд болон түүнээс учрах хохирлын хэмжээг нэмэгдүүлэхэд нөлөөлсөн, эсхүл үүрэг гүйцэтгээгүйгээс улмаас гарах хохирлыг багасгах арга хэмжээг үүрэг гүйцэтгүүлэгч аваагүй бол шүүх эдгээр нөхцөл байдлыг харгалзан үүрэг хүлээгчийн төлбөрийн хэмжээг хорогдуулах эрхтэй.

2. Хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол үүрэг гүйцэтгүүлэгчийн гэм бурууг аас болж үүргийг гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд үүрэг хүлээгч хариуцлагаас чөлөөлөгдөнө.

194 дүгээр зүйл. Төрийн захиргааны байгууллага үүрэг хүлээх

1. Төрийн захиргааны байгууллага шийдвэр гаргахдаа буюу түүний албан тушаалтан үйл ажиллагаагаа явуулахдаа гэрээ байгуулсан талуудад хохирол учруулахгүй байх арга хэмжээ авах үүрэгтэй.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үүргээ төрийн захиргааны байгууллага түүний албан тушаалтан бүрэлдүүлээгүйгээс гэрээний талд хохирол учирсан бол талуудын шаардсанаар уг байгууллага хохирлыг нөхөн төлнө.

АРВАННАЙМДУГААР БҮЛЭГ

Үүрэг дуусгавар болох

195 дугаар зүйл. Үүрэг гүйцэтгэснээр дуусгавар болох

1. Үүргийг зохих ёсоор гүйцэтгэсэн бол дуусгавар болно.

2. Үүрэг гүйцэтгүүлэгч үүргийн гүйцэтгэлийг хүлээн авахын хамт үүрэг хүлээгчийн шаардсанаар гарын үсэг өгөх үүрэгтэй.

3. Үүрэг хүлээгч үүргээ баталж, үүрэг гүйцэтгүүлэгчид үүргийн хуудас өгсөн бол үүрэг гүйцэтгүүлэгч үүргийн гүйцэтгэлийг хүлээн авмагц уг хуудсыг буцаан өгнө. Үүргийн хуудсыг үрэгдүүлэх зэргээр буцаан өгөх боломжгүй болсон бол энэ талаар зохих баримтад тэмдэглэнэ.

4. Үүрэг гүйцэтгүүлэгч үүргийн гүйцэтгэлийг хүлээн авсан тухай гарын үсэг өгөх буюу үүргийн хуудсыг буцаан өгөхөөс татгалзвал үүрэг хүлээгч үүргийн гүйцэтгэлийг саатуулах эрхтэй.

196 дугаар зүйл. Үүргийг гүйцэтгэсэнд тооцож дуусгавар болгох

1. Үүрэг гүйцэтгэх хугацаа нэгэнт болсон, эсхүл гүйцэтгэх хугацаа заагаагүй буюу шаардах болзол тогтоогоогүй бол аль нэг талын хүсэлтээр талуудын нэг төрлийн үүргүүдийг хооронд нь тооцож, уг үүргийг дуусгавар болгож болно. Ийнхүү үүргийг тооцож дуусгавар болгох явдал гагцхүү хөөн хэлэлцэх хугацаа дуусаагүй шаардлагад хамаарна.

2. Шаардах эрх шилжсэн тухай мэдэгдэл авах үед үүрэг тооцох боломжтой байсан бол үүрэг хүлээгч нь шинээр үүрэг гүйцэтгүүлэгчид үүргийн гүйцэтгэлийг хүлээлгэн өгөхөөс татгалзаж, түрүүчийн үүрэг гүйцэтгүүлэгчтэй уг үүргийг тооцох эрхтэй.

3. Бусдын амь нас, эрүүл мэндэд гэм хор учруулсны улмаас үүссэн хохирлыг арилгах үүргийг тооцох журмаар дуусгавар болгож болохгүй.

197 дугаар зүйл. Үүргийг талуудын тохиролцоогоор дуусгавар болгох

Талуудын тохиролцоогоор нэг үүргийг нөгөөгөөр солих замаар зохицуулан дуусгавар болгож болно.

198 дугаар зүйл. Захиргааны шийдвэрээр үүргийг өөрчлөх ба дуусгавар болгох

1. Талууд заавал биелүүлбэл зохих захиргааны шийдвэрээр үүссэн үүргийг уг байгууллагын шийдвэрээр өөрчлөх ба дуусгавар болгож болно.

2. Захиргааны шийдвэрээр үүрэг өөрчлөгдсөн ба дуусгавар болсон бол түүн дээр үндэслэн үүссэн бөгөөд талууд заавал биелүүлбэл зохих бусад үүрэг нэг адил өөрчлөгдөх ба дуусгавар болно.

199 дүгээр зүйл. Гүйцэтгэх боломжгүйгээс үүрэг дуусгавар болох

Үүрэг хүлээгчээс үл хамаарах шалтгаанаар үүргийг гүйцэтгэх боломжгүй болсон бол түүнийг дуусгавар болгоно.

200 дугаар зүйл. Талууд нас барснаас үүргийг дуусгавар болгох

1. Үүрэг хүлээгчийн хувийн байдалтай салшгүй холбоотой үүрэг түүний нас барснаар дуусгавар болно.

2. Үүрэг гүйцэтгүүлэгч нас барвал түүний эрүүл мэндэд гэм хор учруулснаас үүссэн, түүнчлэн гүйцэтгэх явдал өөртэй нь шууд холбогдсон бусад үүрэг нэг адил дуусгавар болно.

201 дүгээр зүйл. Үүрэг дуусгавар болох бусад үндэслэл

Үүрэг дуусгавар болох бусад үндэслэлийг хууль буюу гэрээгээр тодорхойлж болно.

IV ХЭСЭГ

ГЭРЭЭНИЙ ҮҮРЭГ

I ДЭД ХЭСЭГ

ЭД ХӨРӨНГӨ, ОЮУНЫ ҮНЭТ ЗҮЙЛ, ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙГ БУСДЫН ӨМЧЛӨЛД ШИЛЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДСОН ГЭРЭЭНИЙ ҮҮРЭГ

АРВАНЕСДҮГЭЭР БҮЛЭГ

Худалдах-худалдан авах

202 дугаар зүйл. Худалдах-худалдан авах гэрээ

1. Худалдах-худалдан авах гэрээгээр худалдагч нь гэрээний зүйл (эд хөрөнгө, оюуны үнэт зүйл, эд хөрөнгийн

эрх)-ийг худалдан авагчийн өмчлөл буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрх (энэ хуулийн 88 дугаар зүйл)-эд шилжүүлэх; худалдан авагч нь тэдгээрийг хүлээн авч, тогтоосон үнийг төлөх үүрэг тус тус хүлээнэ.

2. Хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол биржийн худалдаа болон дуудлагын худалдаанд худалдах-худалдан авах гэрээний нийтлэг журмыг хэрэглэнэ.

203 дугаар зүйл. Худалдах-худалдан авах гэрээний хэлбэр

1. Худалдах-худалдан авах гэрээний хэлбэр нь энэ хуулийн 39, 40, 41, 42 дугаар зүйлд заасан журмаар тодорхойлогдоно.

2. Худалдах-худалдан авах гэрээний өөр хэлбэрийг хууль буюу гэрээгээр тогтоож болно.

3. Үл хөдлөх эд хөрөнгө худалдах-худалдан авах гэрээг үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн газарт бүртгүүлнэ.

204 дүгээр зүйл. Худалдах-худалдан авах гэрээний үнэ

1. Талууд үнийг тохиролцон тогтооно.

2. Үнийг үндэсний мөнгөн тэмдэгт-төгрөгөөр буюу бусад орны мөнгөн тэмдэгтээр тогтоож болохоос гадна түүнийг тогтоох өөр аргыг талууд харилцан тохиролцож болно.

3. Хуульд зааснаар буюу гэрээний онцлогоос хамаарч тодорхой хугацааны дараа, эсхүл урьдчилан төлөхөөс бусад тохиолдолд гэрээний зүйлийг шилжүүлсний дараа үнийг шууд төлнө.

4. Энэ хуульд зааснаас өөр журмыг хуулиар тогтоож болно.

205 дугаар зүйл. Эд хөрөнгийг шилжүүлэх үүргээ гүйцэтгээгүй худалдагчийн хариуцлага

Худалдагч нь эд хөрөнгийг худалдан авагчид шилжүүлээгүй буюу шилжүүлсэн эд хөрөнгө нь гэрээний нөхцөлд тохирохгүй бол худалдан авагч нь гэрээнд заасан буюу гэрээний нөхцөлд тохирсон эд хөрөнгө шилжүүлэх, гэрээний биелэлтийг саатуулснаас учирсан хохирлыг төлүүлэх, эсхүл гэрээг цуцалж, иймхүү цуцалснаас учирсан хохирлыг төлүүлэхээр шаардах эрхтэй.

206 дугаар зүйл. Худалдан авагч эд хөрөнгө хүлээн авах буюу үнэ төлөхөөс татгалзах

Худалдан авагч худалдан авсан зүйлээ хүлээн авах буюу түүний үнийг төлөхөөс татгалзвал худалдагч нь гэрээг биелүүлэх түүний биелэлтийг саатуулснаас учирсан хохирлыг төлүүлэх, эсхүл гэрээг цуцалж, иймхүү цуцалснаас учирсан хохирлыг төлүүлэхээр шаардах эрхтэй.

207 дугаар зүйл. Худалдсан эд хөрөнгийг хадгалах

Эд хөрөнгө шилжихээс өмнө өмчлөх эрх шилжсэн үед уг эд хөрөнгийг худалдан авагчид шилжих хүртэл худалдагч зохих ёсоор хадгалах үүрэгтэй. Иймхүү хадгалахад худалдагчаас гарсан зайлшгүй зардлыг гэрээнд заасан бол худалдан авагч төлөх үүрэгтэй.

208 дугаар зүйл. Худалдаж байгаа эд хөрөнгийн талаар мэдээлэл өгөх худалдагчийн үүрэг

1. Худалдагч нь худалдаж байгаа эд хөрөнгийн зориулалт, хэрэглээний шинж чанар, хадгалах, хэрэглэх, тээвэрлэх нөхцөл, журам, баталгаат болон эдэлгээний хугацаа, үйлдвэрлэгчтэй холбогдсон үнэн зөв, бүрэн мэдээллийг худалдан авагчид өгөх үүрэгтэй.

2. Энэ зүйлийн 1-д заасан үүргийг худалдагч биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүйгээс учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр худалдан авагч шаардах эрхтэй.

209 дүгээр зүйл. Худалдаж байгаа эд хөрөнгийн чанар

1. Худалдаж байгаа эд хөрөнгийн чанар нь гэрээний нөхцөлд тохирсон байна. Гэрээнд тийм нөхцөл заагаагүй бол худалдагч нь өөрт мэдэгдэж байгаа буюу гэрээнд заасан тодорхой зориулалтад нийцсэн бөгөөд ердийн шаардлагад тохирсон чанар бүхий эд хөрөнгийг худалдан авагчид шилжүүлэх үүрэгтэй. Худалдагч худалдаж байгаа эд хөрөнгийн тодорхой зориулалтын талаар мэдэх үүрэггүй байсан бол уг эд хөрөнгө нь иймэрхүү төрлийн эд хөрөнгийн ийнхүү зориулалтад нийцсэн байна.

2. Худалдаж байгаа эд хөрөнгийн стандарт, техникийн нөхцөлийг гэрээгээр тодорхойлсон бол түүний чанар уг нөхцөлд нийцсэн байна.

210 дугаар зүйл. Зохих чанарын бус эд хөрөнгө худалдсанаас үүсэх худалдан авагчийн эрх ба худалдагчийн хариуцлага

1. Худалдагч эд хөрөнгийн чанарын доголдол, согог, эмтэл (цаашид чанарын дутагдал гэх)-нйн талаар урьдчи-ан мэдэгдээгүй бол худалдан авагч дараахь шаардлагын ль нэгийг түүнд тавьж гомдлын шаардлага гаргах эрхтэй:

1) тухайн эд хөрөнгийг зохих чанарын тийм эд хөрөн-өөр солих;

2) эд хөрөнгийн чанарын дутагдлыг үнэ төлбөргүй рилгах;

3) эд хөрөнгийн чанарын дутагдлыг арилгахад гаргасан ардлыг төлүүлэх;

4) үнийг зохих хэмжээгээр хорогдуулах, эсхүл төлбөр ийхээс бүрэн буюу тодорхой хугацаагаар хэсэгчлэн тат-алзах.

2. Худалдан авагч энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан шаардлага тавилгүйгээр гэрээг цуцалж, зохих чанарын бус д хөрөнгийг худалдагчид буцаан өгч, төлсөн мөнгөө эргүүлж вахыг шаардах эрхтэй.

3. Худалдан авагчийн энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт заа-ан шаардлага нь түүнд учирсан хохирлыг арилгахад хүрэл-эхгүй бол тэрээр учирсан хохирлоо бүрэн арилгахыг шаар-ах эрхтэй.

4. Хууль буюу гэрээнд өөр урт хугацаа заагаагүй бөгөөд удалдан авагч тухайн эд хөрөнгийг өмчлөх эрхийг шилжүү-эн авснаас хойш зургаан сарын дотор эд хөрөнгийн чана-ын дутагдлыг илрүүлсэн бол энэ зүйлд заасан эрхээ хэрэг-күүлж болно. Дээрхээс урт баталгаат хугацаа тогтоогдсон охиолдолд уг хугацааны дотор энэхүү эрхээ хэрэгжүүлж олно.

5. Хэрэглэх хугацаа тогтоогдсон эд хөрөнгийн тухайд нэ зүйлд заасан эрхийг хэрэглэх хугацааны дотор хэрэг-күүлж болно.

6. Тухайн эд хөрөнгийн чанарын дутагдал нь худалдан авагч түүнийг тээвэрлэх, хадгалах, ашиглах журам зөрчсө-өөс, эсхүл гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас үүссэн гэдгийг худалдагч отолбол худалдан авагчийн энэ зүйлд заасан шаардлагыг ангахаас татгалзаж болно.

7. Хуульд өөрөөр заагаагүй бөгөөд худалдаж авсан эд хөрөнгийн чанарын дутагдлыг энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасан хугацаа өнгөрснөөс хойш боловч түүнийг хэрэглэх хугацааны дотор илрүүлсэн худалдан авагч нь уг дутагдал эд хөрөнгийг худалдан авахаас өмнө үүссэн гэдгийг нотолбол тэрээр энэ зүйлд заасан эрхээ хэрэгжүүлж болно.

211 дүгээр зүйл. Баталгаат хугацаатай худалдсан эд хөрөнгийн чанарын дутагдлыг хариуцах

1. Худалдаж байгаа эд хөрөнгийн чанарын талаар хууль буюу гэрээнд баталгаат хугацаа тогтоосон бол эд хөрөнгө худалдсан өдрөөс эхлэн уг хугацааг тоолно.

2. Худалдан авагч нь эд хөрөнгийг хэвийн байдлаар ашиглах, хэрэглэхэд саад болсон чанарын дутагдлын талаар худалдагчид баталгаат хугацааны дотор гомдлын шаардлага гаргаж болно.

3. Энэ зүйлийн 1. 2 дахь хэсэгт заасны дагуу гомдлын шаардлага гарсан бөгөөд уг дутагдал нь худалдан авагч эд хөрөнгийг тээвэрлэх, хадгалах, ашиглах, хэрэглэх журмыг зөрчсөнөөс бий болсныг худалдагч нотолж чадахгүй бол тэрээр эд хөрөнгийн дутагдлыг өөрийн зардлаар арилгах буюу зохих чанарын эд хөрөнгөөр солих, эсхүл үнийг төлөх үүрэгтэй.

212 дугаар зүйл. Эд хөрөнгийг савлах, баглах, тэмдэглэх

1. Эд хөрөнгийг сав, баглаа, тэмдэглэгээтэйгээр шилжүүлэхээр хууль буюу гэрээнд заасан бол тэдгээрийг хууль буюу гэрээний шаардлагад нийцүүлэн бэлтгэнэ. Сав, баглаа, тэмдэглэгээ нь уг эд хөрөнгийн байдалд бүрэн тохирсон, түүнийг тээвэрлэх, хадгалах үед тоо, чанарыг нь алдагдуулахгүй байхад зохицсон байна. Сав, баглаатай эд хөрөнгө бүр дээр зохих тэмдэглэгээ хийнэ.

2. Хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол худалдан авагч сав, баглааны үнийг тухайн эд хөрөнгийн үнэ дээр нэмж төлнө.

3. Сав, баглааг буцааж өгөхөөр гэрээнд зааж болно.

213 дугаар зүйл. Иж бүрэн эд хөрөнгө

1. Хууль буюу гэрээнд заасан бол худалдагч нь эд хөрөнгийг стандарт, техникийн нөхцөл буюу үнийн жагсаал-

тын дагуу холбогдох бүх эд юмс, сэлбэг, хэсгийн хамтаар иж бүрэн нийлүүлэх үүрэгтэй. Эд хөрөнгийн иж бүрэн байдлыг стандарт, техникийн нөхцөл буюу үнийн жагсаалт, эсхүл гэрээгээр тодорхойлж болно.

2. Иж бүрэн бус эд хөрөнгө шилжүүлбэл түүнийг нөхөн бүрдүүлэх буюу өөр иж бүрэн эд хөрөнгөөр сольж өгөхийг худалдан авагч шаардах эрхтэй. Эд хөрөнгийг нөхөн бүрдүүлэх буюу солихтой холбогдсон зардлыг худалдан авагч төлөхгүй, ийнхүү төлсөн бол буцааж авахыг шаардах эрхтэй.

3. Худалдагч иж бүрэн бус эд хөрөнгийг тохиролцсон хугацаанд бүрдүүлж өгөхгүй бол худалдан авагч нь эд хөрөнгийг хүлээн авахаас татгалзаж, түүнээс учирсан хохирлоо төлүүлэхийг шаардах эрхтэй.

214 дүгээр зүйл. Худалдсан эд хөрөнгийн чанарын дутагдлын талаар гаргасан нэхэмжлэлийн хөөн хэлэлцэх хугацаа

Худалдан авагчийн гомдлын шаардлагыг худалдагч хангаагүй бол эд хөрөнгийн чанарын дутагдлын талаар худалдан авагч нь гомдлын шаардлагын хариу авсан өдрөөс эхлэн зургаан сарын дотор шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй. Гомдлын шаардлага таргасан буюу түүний хариуг авсан өдрийг тогтоох боломжгүй, эсхүл хариу аваагүй бол хөөн хэлэлцэх хугацааг гомдлын шаардлага гаргах хугацаа дууссан өдрөөс эхлэн тооло.

215 дугаар зүйл. Худалдаж байгаа эд хөрөнгийн талаар гуравдагч этгээдийн эрх

Худалдагч гэрээ хийхдээ худалдаж байгаа эд хөрөнгийн талаар гуравдагч этгээд (хөлслөгч, барьцаалагч зэрэг)-ийн эдлэх бүх эрхийн талаар худалдан авагчид урьдчилан мэдэгдэх үүрэгтэй. Худалдагч энэ үүргээ биелүүлээгүй бол худалдан авагч гэрээгээ цуцалж ийнхүү цуцалснаас учирсан хохирлыг төлүүлэх, эсхүл худалдан авсан үнийг зохих хэмжээгээр хорогдуулахыг шаардах эрхтэй.

216 дугаар зүйл. Худалдсан эд хөрөнгийг худалдан авагчаас шүүхийн журмаар гаргуулахад худалдагчийн хүлээх хариуцлага

1. Эд хөрөнгийг худалдахаас өмнө үүссэн худалдагчийн

үүрэгтэй холбоотойгоор гуравдагч этгээд уг эд хөрөнгий гаргуулан авахаар худалдан авагчид холбогдуулан шүүхэ нэхэмжлэл гаргавал энэ хэргийг шийдвэрлэхэд худалдаг авагч худалдагчийг татан оролцуулах үүрэгтэй. Худалдаг энэ хэрэгт худалдан авагчийн талд оролцох үүрэгтэй.

2. Эд хөрөнгийг гаргуулан авахаар худалдан авагчид холбогдуулан гуравдагч этгээдээс гаргасан нэхэмжлэлий шаардлага хангагдвал худалдан авагчид учирсан хохирлы худалдагч төлөх үүрэгтэй. Харин худалдан авагч нь эн хэргийг шийдвэрлэхэд худалдагчийг татан оролцуулаагүй бөгөөд хэрэв оролцуулсан бол уг эд хөрөнгийг худалдаг авагчид үлдээж чадах байснаа худалдагч нотолбол эн үүргээс чөлөөлөгдөнө.

217 дугаар зүйл. Эд хөрөнгийг зээлээр худалдах-худалдан авах

1. Хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол эд хөрөнгийн үнийг төлөх хугацаа тогтоож, зээлээр худалдаж болно.

2. Хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол зээлээр худалдах эд хөрөнгийн үнийг худалдаа хийсэн өдөр талуудын тохиролцсон үнээр тогтоох бөгөөд түүнээс хойш худалдагч үнийг өөрчлөх эрхгүй.

3. Зээлээр худалдсан эд хөрөнгийг худалдан авагчид шилжүүлсэн үеэс эхлэн түүнийг өмчлөх эрх шилжинэ.

218 дугаар зүйл. Бэлтгэн нийлүүлэх аргаар эд хөрөнгө худалдах-худалдан авах (бэлтгэн нийлүүлэх гэрээ)

1. Бэлтгэн нийлүүлэх гэрээгээр бэлтгэн нийлүүлэгч нь аж ахуй эрхлэх зориулалт бүхий эд хөрөнгийг худалдан авагчийн өмчлөл буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрх (энэ хуулийн 88 дугаар зүйл)-эд тохиролцсон хугацаанд шилжүүлэх; худалдан авагч уг эд хөрөнгийг хүлээн авч, үнийг төлөх үүрэг тус тус хүлээнэ.

2. Хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол бэлтгэн нийлүүлэх гэрээнд худалдах-худалдан авах гэрээний журмыг хэрэглэнэ.

3. Тодорхой төрлийн эд хөрөнгө бэлтгэн нийлүүлэх өөр нөхцөлийг хууль буюу гэрээгээр тогтоож болно.

219 дүгээр зүйл. Бэлтгэн нийлүүлэх хугацаа

1. Нэг төрлийн эд хөрөнгийг хэсэгчлэн бэлтгэн нийлүү.

лэхээр гэрээнд заасан бөгөөд талууд өөрөөр тохиролцоогүй бол заасан хугацааны дотор тэнцүү хэмжээгээр нийлүүлнэ.

2. Машин, тоног төхөөрөмж, бусад эд хөрөнгийн иж бүрдлийг бэлтгэн нийлүүлэх тухай гэрээнд түүний хэсгүүдийг нийлүүлэх хугацаа заагаагүй бол иж бүрдлийн сүүлчийн хэсгийг нийлүүлсэн өдрөөр гүйцэтгэлийг тооцно.

3. Бэлтгэн нийлүүлэх хугацаа хэтрүүлсэн, эсхүл худалдан авагчийн зөвшөөрөлгүйгээр хугацаанаас өмнө нийлүүлсэн тохиолдолд гэрээнд өөрөөр заагаагүй бол худалдан авагч түүнээс учирсан хохирлыг арилгахыг шаардах буюу бэлтгэн нийлүүлэгчид урьдчилан мэдэгдэж, эд хөрөнгийг хүлээн авахаас татгалзах эрхтэй. Худалдан авагчийн мэдэгдлийг хүлээж авахаас өмнө бэлтгэн нийлүүлэгчээс илгээсэн эд хөрөнгийг худалдан авагч хүлээн авч үнийг төлөх үүрэгтэй.

220 дугаар зүйл. Бэлтгэн нийлүүлэх гэрээний үүргийг гүйцэтгэхээс нэг тал татгалзах

1. Талуудын аль нэг нь гэрээг ноцтой зөрчсөн тохиолдолд гэрээнд өөрөөр заагаагүй бол нөгөө тал бэлтгэн нийлүүлэх гэрээгээр хүлээсэн үүргээ бүгдийг буюу заримыг гүйцэтгэхээс татгалзаж болно.

2. Бэлтгэн нийлүүлэгч зохих чанарын бус эд хөрөнгийг удаа дараа нийлүүлсэн буюу гэрээнд заасан бэлтгэн нийлүүлэх хугацааг удаа дараа хэтрүүлсэн, эсхүл худалдан авагч нь бэлтгэн нийлүүлсэн эд хөрөнгийн төлбөрийг гэрээнд заасан хугацаанаас байнга буюу их хэмжээгээр хожимдуулсан, түүнчлэн төлбөрийн чадваргүй гэж зарлагдсан бол гэрээг ноцтой зөрчсөн гэж үзнэ.

221 дүгээр зүйл. Оюуны үнэт зүйл, эд хөрөнгийн эрхийг худалдах, арилжих, бэлэглэх

Хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол оюуны үнэт зүйл, эд хөрөнгийн эрхийг худалдах, арилжих, бэлэглэхэд энэ бүлгийн болон хорь хориннэгдүгээр бүлгийн холбогдох заалтыг хэрэглэнэ.

ХОРЬДУГААР БҮЛЭГ

Арилжаа

222 дугаар зүйл. Арилжааны гэрээ

1. Арилжааны гэрээгээр талууд нь тодорхой эд хөрөнгийг солилцох журмаар өмчлөл буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрх (энэ хуулийн 88 дугээр зүйл)-эд харилцан шилжүүлэх үүрэг хүлээнэ.

2. Төрийн өмчлөлийн мөнгө, үнэт цаасаар арилжаа хийх журмыг хуулиар тогтооно.

3. Арилжааны гэрээгээр үнэт цаас солилцохдоо шилжүүлэх эрхээ үнэлж болно.

223 дугаар зүйл. Арилжааны гэрээнд худалдах-худалдан авах гэрээний журмыг баримтлах

Хуульд өөрөөр заагаагүй бол арилжааны гэрээнд талууд худалдах-худалдан авах харилцааг зохицуулж байгаа журмыг баримтална. Арилжааны гэрээ хийхээр гэрээний төсөл илгээгчийг худалдагч, түүнийг зөвшөөрсөн талыг худалдан авагч гэж үзнэ.

ХОРИННЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Бэлэглэл

224 дүгээр зүйл. Бэлэглэл

1. Бэлэглэлээр нэг тал нь эд хөрөнгийг нөгөө талын өмчлөл буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрх (энэ хуулийн 88 дугаар зүйл)-эд үнэ төлбөргүй шилжүүлэн өгөх ба нөгөө тал нь уг эд хөрөнгийг хүлээн авна.

2. Хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол бэлэглэлийг эд хөрөнгө шилжүүлэн өгснөөр, үл хөдлөх эд хөрөнгө бэлэглэсэн бол үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн газарт бүртгүүлснээр байгуулсанд тооцно.

225 дугаар зүйл. Хандивын гэрээ

1. Тодорхой эд хөрөнгийг тусгай зориулалтаар хандивын журмаар бэлэглэж болно .

2. Хандив хүлээн авагч нь хандивын эд хөрөнгийг зориулалтын дагуу эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулна.

Хандив хүлээн авагч энэ үүргээ гүйцэтгээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүй бол бэлэглэгч хандивласан хөрөнгийг буруутай этгээдээс гаргуулан зориулалтын дагуу эзэмшиж ашиглаж, захиран зарцуулахыг шаардах эрхтэй.

ХОРИНХОЁРДУГААР БҮЛЭГ

Эрчим хүч, бусад нөөцөөр хангах

226 дугаар зүйл. Эрчим хүч, бусад нөөцөөр хангах гэрээ

1. Холбогдсон сүлжээгээр дамжуулан эрчим хүч, бусад нөөцөөр хангах гэрээгээр хангагч нь тогтоогдсон техникийн шаардлага, гэрээний нөхцөлд нийцсэн тоо, чанарын эрчим хүч, бусад нөөцөөр зохих хугацаанд хангах; хэрэглэгч нь хүлээн авсан эрчим хүч, бусад нөөцийн үнийг төлөх үүрэг тус тус хүлээнэ.

2. Эрчим хүч, бусад нөөцийг дамжуулах шугам сүлжээний эзэмшлийн зааг, түүнчлэн шугам сүлжээ, тоног төхөөрөмж, барилга байгууламжийн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангах талаар талуудын хүлээх үүрэг, хариуцлагыг гэрээнд заана.

3. Тодорхой төрлийн эрчим хүч, бусад нөөцөөр хангах гэрээний онцлогийг хуулиар тогтоож болно.

227 дугаар зүйл. Эрчим хүч, бусад нөөц хэрэглэгчийн үүрэг

1. Эрчим хүч, бусад нөөцийг хэрэглэгч дор дурдсан үүрэг хүлээнэ:

1) хэрэглэсэн эрчим хүч, бусад нөөцийн үнийг гэрээнд заасан хугацаанд төлөх;

2) эрчим хүч, бусад нөөцийг ашиглах, дахин боловсруулахад зориулсан тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, хэвийн ажиллагааг хангах, энэ талаар тогтоосон журмыг биелүүлэх;

3) эрчим хүч, бусад нөөцийг хэрэглэх талаар гэрээнд заасан журмыг хэрэглэгч биелүүлэх үүрэгтэй.

4) хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол эрчим хүч, бусад нөөцийг ашиглах, дахин боловсруулахад зориулсан тоног төхөөрөмжид зайлшгүй шаардагдах, өөрөө хийж болох

засварыг цаг тухайд нь хийх, мэргэжлийн хувьд зайлшгүй хийх ёстой засварыг хангагч хийсэн бол үнэ, хөлсийг төлөх

5) эрчим хүч, бусад нөөц, тэдгээрийн зарцуулалтыг тоо цоолох систем, нөөцийг ашиглах, дахин боловсруулахад зориулсан тоног төхөөрөмжийг гэрээнд заасан зориулалтын дагуу хэвийн байдлаар ашиглахтай холбогдсон хангагчийн шаардлагыг биелүүлэх;

6) хууль буюу гэрээнд заасан бусад үүрэг.

2. Хэрэглэгч нь эрчим хүч, бусад нөөцийг ашиглах, дахин боловсруулахад зориулсан тоног төхөөрөмжид эвдрэл гэмтэл учруулсан бол шаардагдах засварыг өөрөө, болон цоогүй бол хангагчаар хийлгэх эрхтэй. Хэрэглэгч уг эвдрэл гэмтлийг засуулах шаардлагатай арга хэмжээ авахгүй бол хангагч өөрөө засварыг хийж, гарсан зардлыг хэрэглэгчээс шаардан авна.

3. Эрчим хүч, бусад нөөцийг хэрэглэгч нь энэ зүйлд заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд хуульд өөрөөр заагаагүй бол хангагч учирсан хохирлоо төлүүлэхийг шаардах. эрчим хүч, бусад нөөцөөр хангахаас татгалзах эрхтэй. Эрчим хүч, бусад нөөц хэрэглэсний үнийг хугацаанд нь төлөөгүй бол хэрэглэгч хуульболон гэрээнд заасан хэмжээгээр алданги төлнө.

4. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн 2-т заасан үүрэг биелэгдээгүй явдалд өөрийн гэм буруугүй гэдгээ нотолбол хэрэглэгчийг хариуцлагаас чөлөөлнө.

228 дугаар зүйл. Эрчим хүч, бусад нөөцөөр хангагчийн үүрэг

1. Эрчим хүч, бусад нөөцөөр хангагч дор дурдсан үүрэг хүлээнэ:

1) гэрээний нөхцөлд тохирсон тоо, хэмжээ, чанарын эрчим хүч, бусад нөөцөөр зохих хугацаанд хангах;

2) хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол эрчим хүч, бусад нөөцийг ашиглах дахин боловсруулахад зориулсан зохих тоног төхөөрөмжийг суурилуулж, хэрэглэгчийн эзэмшилд шилжүүлэх;

3) хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол эрчим хүч, бусад нөөцийг ашиглах, дахин боловсруулахад зориулсан тоног төхөөрөмжид өөрийн зардлаар технологийн шаардлагын дагуу үйлчилгээ хийх;

4) зайлшгүй шаардлагатай үед эрчим хүч, бусад нөөцийг ашиглах, дахин боловсруулахад зориулсан тоног төхөөрөмжид засвар хийх. Энэ тохиолдолд засварын үнэ, хөлсийг төлөх журмыг энэ хуулийн 227 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3-т зааснаар тодорхойлно.

5) хуульд заасан бусад үүрэг.

3. Хангагч нь хэрэглэгчийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцохгүйгээр нөөцийн зарцуулалтыг тооцоолох систем, нөөцийг ашиглах дахин боловсруулахад зориулсан тоног төхөөрөмжийн техникийн байдлыг шалгах эрхтэй.

4. Хангагч нь энэ зүйлд заасан үүргээ гүйцэтгээгүй буюу зохих ёссор гүйцэтгээгүй тохиолдолд хуульд өөрөөр заагаагүй бол хэрэглэгч учирсан хохирлоо төлүүлэхээр шаардах, эрчим хүч, бусад нөөцийн үнийг бүрэн буюу заримыг төлөхөөс татгалзах эрхтэй.

ХОРИНГУРАВДУГААР БҮЛЭГ

Зээл

229 дүгээр зүйл. Зээлийн гэрээ

1. Зээлийн гэрээгээр зээлдүүлэгч нь мөнгө, бусад эд хөрөнгийн зээлдэгчийн өмчлөл буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрх (энэ хуулийн 88 дугаар зүйл)-эд шилжүүлэх; зээлдэгч нь авсан мөнгө буюу иж бүрэл төрөл, чанар, хэмжээний эд хөрөнгийг зээлдүүлэгчид буцаан өгөх үүрэг тус тус хүлээнэ.

2. Мөнгөн зээлийн гэрээгээр зээлдэгч нь мөнгөний ханшийн өөрчлөлтийг харгалзахгүйгээр зээлдүүлэгчид анх авсан хэмжээний мөнгийг эргүүлэн өгнө.

3. Зээлийн гэрээний үүргийг хангах арга, түүнийг хэрэгжүүлэх журмыг талууд тохиролцон тодорхойлно.

4. Зээлийн гэрээг тодорхой бус хугацаагаар байгуулсан бол зээлдүүлэгчийн шаардсан цагт зээлдэгч зээлийн гэрээний зүйлийг буцаан өгөх үүрэгтэй.

5. Зээлийн гэрээг тодорхой хугацаатай байгуулсан бөгөөд зээлдэгч үүргээ гүйцэтгээгүй бол зээлийн гэрээний зүйлийг эргүүлэн авах, хууль болон гэрээнд заасан бол гэрээний хугацаа хэтэрсний алданги төлүүлэхийг зээлдүүлэгч шаардах эрхтэй.

II ДЭД ХЭСЭГ

ЭД ХӨРӨНГӨ, ОЮУНЫ ҮНЭТ ЗҮЙЛИЙГ БУСДЫН ЭЗЭМШИЛ, АШИГЛАЛТАД ШИЛЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДСОН ГЭРЭЭНИЙ ҮҮРЭГ ХОРИНДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Эд хөрөнгө хөлслөх

230 дугаар зүйл. Эд хөрөнгө хөлслөх гэрээ

Эд хөрөнгө хөлслөх гэрээгээр хөлслүүлэгч нь хөлслөгчид эд хөрөнгийг түр хугацаагаар ашиглуулах, хөлслөгч үг эд хөрөнгө ашигласны хөлсийг төлөх үүрэг тус тус хүлээнэ.

231 дүгээр зүйл. Эд хөрөнгө хөлслөх гэрээний хэлбэр

1. Хуульд өөрөөр заагаагүй бол иргэд хоорондын нэг жилээс дээш хугацаагаар эд хөрөнгө хөлслөх гэрээг бичгээр хийнэ.

2. Талуудын аль нэг нь хуулийн этгээд байвал эд хөрөнгө хөлслөх гэрээг хугацаа харгалзахгүйгээр бичгээр хийнэ.

3. Орон сууцнаас бусад үл хөдлөх эд хөрөнгө хөлслөх гэрээг үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн газарт бүртгүүлнэ.

4. Хуульд өөрөөр заагаагүй бол тодорхой төрлийн эд хөрөнгө хөлслөхөд өөр журам тогтоож болно.

232 дугаар зүйл. Эд хөрөнгө ашигласны хөлс

1. Эд хөрөнгө ашигласны хөлсний хэмжээ, төлөх аргыг талууд харилцан тохиролцож тодорхойлно.

2. Хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол хөлслөгч эд хөрөнгө ашигласны хөлсийг хөлслүүлэгчид тогтмол хугацаанд төлөх үүрэгтэй.

233 дугаар зүйл. Эд хөрөнгө хөлслөх гэрээний хугацаа

1. Эд хөрөнгө хөлслөх гэрээг тодорхой буюу тодорхой бус хугацаагаар байгуулна. Тодорхой хугацаатай гэрээг арван жилээс дээшгүй хугацаагаар байгуулна.

2. Эд хөрөнгө хөлслөх гэрээний хугацаа дууссан боловч хөлслүүлэгч татгалзаагүй бөгөөд хөлслөгч уг эд хөрөнгийг үргэлжлэн ашигласаар байвал гэрээг тодорхой бус хугацаагаар тухайн нөхцөлөөр сунгасанд тооцно.

3. Эд хөрөнгө хөлслөх гэрээнд хугацаа заагаагүй бол уг гэрээг тодорхой бус хугацаагаар байгуулсан гэж үзнэ.

4. Хугацаа заагаагүй хийсэн гэрээний талууд уг гэрээг хэдийд ч дуусгавар болгох эрхтэй боловч үл хөдлөх эд хөрөнгө хөлслөх гэрээг дуусгавар болгох тухайгаа нөгөө талдаа гурван сараас доошгүй хугацааны өмнө мэдэгдэх үүрэгтэй.

234 дүгээр зүйл. Эд хөрөнгө хөлслөгчийн давуу эрх

Эд хөрөнгө хөлслөх гэрээний үүргээ зохих ёсоор гүйцэтгэдэг хөлслөгч нь уг гэрээний хугацаа дуусахад дээрх эд хөрөнгийг хөлслөн авах шинэ гэрээг тэргүүн ээлжинд байгуулах давуу эрхтэй. Энэ заалтыг зөрчиж өөр этгээдтэй эд хөрөнгө хөлслөх гэрээ байгуулсан байвал хуучин хөлслөгч нь шинэ хөлслөгчийн эрх, үүргийг өөртөө шилжүүлэн авахыг шаардах эрхтэй.

235 дугаар зүйл. Хөлслүүлэгчийн үүрэг

1. Эд хөрөнгө хөлслүүлэгч гэрээний нөхцөлд тохирсон эд хөрөнгийг хөлслөгчид шилжүүлэх, хуульд өөрөөр заагаагүй бөгөөд гэрээгээр тохиролцсон бол хөлслөн өгсөн эд хөрөнгөд засвар хийх үүрэгтэй.

2. Гэрээ байгуулж байх үед хөлслөгч мэдсэн буюу мэдэх боломжтой байсан эд хөрөнгийн чанарын дутагдлыг хөлслүүлэгч харицуахгүй.

236 дугаар зүйл. Хөлслүүлэгч үүргээ гүйцэтгээгүйгээс үүсэх үр дагавар

1. Хөлслүүлэгч эд хөрөнгөө шилжүүлэхгүй байвал хөлслөгч нь түүнийг шаардан авч, учирсан хохирлоо нөхөн төлүүлэх, эсхүл гэрээг цуцалж, учирсан хохирлоо төлүүлэхээр шаардах эрхтэй.

2. Хөлслүүлэгч эд хөрөнгөд засвар хийх тухай хууль буюу гэрээнд заасан үүргээ гүйцэтгээгүй бол хөлслөгч нь зайлшгүй шаардагдах засварыг хийж, түүний үнийг төлүүлэх буюу төлбөл зохих хөлсөндөө тооцох, эсхүл гэрээг цуцалж, учирсан хохирлыг төлүүлэхээр шаардах эрхтэй.

237 дугаар зүйл. Хөлслөгчийн үүрэг

Хөлслөгч дор дурдсан үүрэг хүлээнэ:

1) эд хөрөнгийг гэрээний нөхцөлийн дагуу ашиглах;

2) эд хөрөнгийг ердийн элэгдлээс гадуур гэмтээж муутгахгүй байх;

3) эд хөрөнгө ашигласны хөлсийг хугацаанд нь төлөх; Хөлслөн авсан эд хөрөнгийг ашиглах боломж өөрөөс нь хамаарахгүй шалтгаанаар эрс багасвал хөлсийг түүнд зохицуулан хорогдуулахыг хөлслүүлэгчээс шаардаж болно.

4) хууль буюу гэрээнд заасан бол эд хөрөнгөнд засвар хийх;

5) гэрээ дуусгавар болсны дараа ердийн буюу гэрээгээр тохиролцсон элэгдлийг тооцож, уг эд хөрөнгийг хөлслүүлэгчид буцааж өгөх.

238 дугаар зүйл. Хөлслөгч үүргээ гүйцэтгээгүйгээс үүсэх үр дагавар

1. Хөлслөгч эд хөрөнгийг гэрээний нөхцөлийн дагуу ашиглаагүй эсхүл ашиглах явцдаа чанарыг нь саналтай буюу болгоомжгүйгээр муутгах, хөлсийг хугацаанд нь байнга төлөхгүй байх зэрэг зөрчил гаргасныг хөлслүүлэгчээс сануулсаар байхад түүнийг зогсоохгүй бол хөлслүүлэгч гэрээг цуцалж, учирсан хохирлыг төлүүлэхээр шаардах эрхтэй.

2. Хөлслүүлэгч шаардсаар байхад хууль буюу гэрээгээр хүлээсэн засвар хийх үүргээ хөлслөгч гүйцэтгээгүй бол хөлслүүлэгч уг засварыг хөлслөгчийн зардлаар хийлгэх буюу гэрээг цуцалж, учирсан хохирлыг төлүүлэхээр шаардах эрхтэй.

3. Гэрээ дуусгавар болсны дараа хөлслөгч эд хөрөнгийг буцааж өгөхдөө хууль буюу гэрээнд зааснаас муутгасан бөгөөд үүнд өөрийн гэм буруугүй болохоо нотолж чадахгүй бол хөлслүүлэгч нь учирсан хохирлыг төлүүлэхээр шаардах эрхтэй.

4. Эд хөрөнгө хөлслөх гэрээний хугацаа дууссаны дараа уг эд хөрөнгийг хөлслөгч буцааж өгөхгүй бол хөлслүүлэгч нь эд хөрөнгөө буцаан авах, хэтрүүлсэн хугацаанд оногдох хөлс болон учирсан хохирлыг төлүүлэхээр шаардах эрхтэй.

239 дүгээр зүйл. Хөлслөн өгсөн эд хөрөнгө өөр өмчлөгчид шилжих

Хөлслөн өгсөн эд хөрөнгийг өмчлөх буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрх (энэ хуулийн 88 дугаар

зүйл) хөлслүүлэгчээс өөр этгээдэд шилжвэл эд хөрөнгө хөлслөх гэрээ хүчин төгөлдөр хэвээр үлдэнэ.

240 дүгээр зүйл. Дамжуулан хөлслөх

Хөлслөн авсан эд хөрөнгийг гагцхүү хөлслүүлэгчийн зөвшөөрөлтэйгээр бусдад дамжуулан хөлсөлж болно.

241 дүгээр зүйл. Хөлслөн авсан эд хөрөнгийг ашиглах нөхцөлгүй болсноос гэрээг цуцлах

Хөлслөн авсан эд хөрөнгийг ашиглах боломжгүй болсон нь өөрийнх нь буруугаас болоогүй бол хөлслөгч гэрээг цуцлахыг шаардах эрхтэй.

242 дугаар зүйл. Эд хөрөнгийг засаж сайжруулсан хөлслөгчийн эрх

1. Хөлслөгч нь хөлсөлж авсан эд хөрөнгөө хөлслүүлэгчийн зөвшөөрөлтэйгээр өөрийн зардлаар засаж сайжруулсан бөгөөд талууд өөрөөр хэлэлцэн тохиролцоогүй бол гээд дууставар болсны дараа түүнд оруулсан зайлшгүй зардлаа төлүүлэхээр шаардах эрхтэй.

2. Өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр эд хөрөнгөнд хийсэн сайжруулалтын үнийг хөлслүүлэгч төлөхөөс татгалзвал хөлслөгч уг сайжруулалтаа салган авч болно. Уг сайжруулалтыг эд хөрөнгөөс салган авах боломжгүй бөгөөд гэрээнд өөрөөр заагаагүй бол хөлслүүлэгч өөрийнх нь зөвшөөрөлгүй хийсэн сайжруулалтын үнийг төлөхгүй.

ХОРИНТАВДУГААР БҮЛЭГ

Орон сууц хөлслөх

243 дугаар зүйл. Орон сууц хөлслөх гэрээ

1. Орон сууц хөлслөх гэрээгээр хөлслүүлэгч нь өмчлөөө буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрх (энэ уулийн 88 дугаар зүйл)-дээ байгаа, аж төрөх шаардлага ангасан орон сууцны байшин нийтийн байр, сууц, өрөө, р (цаашид орон сууц гэх)-ийг хөлслөн авагч болон түүний р бүлийн гишүүдийн эзэмшил, ашиглалтад шилжүүлэх; элслөгч нь уг орон сууцыг зориулалтын дагуу ашиглах, рэн бүтэн байдлыг хангах, орон сууц ашигласны хөлс

(цаашид орон сууцны хөлс гэх)-ийг хугацаанд нь төлөх үүргийг тус тус хүлээнэ.

2. Хуульд өөрөөр заагаагүй бол орон сууц эзэмших ашиглах журмыг талуудын хоорондын гэрээгээр тодорхойлно.

244 дүгээр зүйл. Орон сууц хөлслөх гэрээний хэлбэр

Орон сууц хөлслөх гэрээг бичгээр байгуулна. Энэ шаардлагыг хангаагүй гэрээ хүчин төгөлдөр бус байна.

245 дугаар зүйл. Орон сууц хөлслүүлэгчийн үүрэг

1. Хөлслүүлэгч нь гэрээний нөхцөлд тохирсон орон сууцыг хөлслөгчийн эзэмшил, ашиглалтанд хугацаанд нь шилжүүлэх хууль буюу гэрээнд заасан бол шаардагдах засварыг хийх үүрэгтэй.

2. Хөлслүүлэгч гэрээний нөхцөлийг зөрчсөн бол хөлслөгч хөлсийг бууруулах буюу учирсан хохирлыг төлүүлэхээр шаардах эрхтэй.

246 дугаар зүйл. Орон сууц хөлслөгчийн үүрэг

1. Орон сууц хөлслөгч дор дурдсан үүрэгтэй:

1) орон сууцны хөлсийг гэрээнд заасан хугацаанд төлөх;

2) орон сууц болон дундын ашиглалтын талбайг зориулалтын дагуу ашиглах, түүний бүрэн бүтэн байдал, ашиглалтын шаардлагыг хангах;

3) хууль буюу гэрээнд заасан бол орон сууцанд зайлшгүй шаардагдах засварыг тухай бүр нь хийх;

4) орон сууц ашиглалтын бусад журмыг сахин биелүүлэх.

2. Хөлслөгч буюу түүний гэр бүлийн гишүүд орон сууцанд эвдрэл, гэмтэл учруулсан бол шаардагдах засварыг өөрөө даруй хийх үүрэгтэй. Хөлслүүлэгч шаардсаар байхад уг засварыг хөлслөгч хийхгүй бол хөлслүүлэгч өөрөө хийж, түүнтэй холбогдон гарсан зайлшгүй зардлыг хөлслөгчөөс шаардах эрхтэй.

247 дугаар зүйл. Орон сууц хөлслөх гэрээний хугацаа, уг гэрээг шинэчлэн байгуулах эрх

1. Орон сууц хөлслөх гэрээг тодорхой буюу тодорхой бус хугацаагаар байгуулж болно.

2. Орон сууцыг иргэн насаараа эзэмшиж, ашиглах буюу уг эрхээ өв залгамжуулж болно.

3. Орон сууц хөлслөх гэрээнд хугацаа заагаагүй бол уг гэрээг тодорхой биш хугацаагаар байгуулсан гэж үзнэ.

4. Орон сууц хөлслөх гэрээний хугацаа дууссан боловч хөлслүүлэгч татгалзаагүй бөгөөд хөлслөгч уг орон сууцыг үргэлжлүүлэн ашигласаар байвал гэрээг тодорхой бус хугацаагаар, тухайн нөхцөлөөр сунгасанд тооцно.

5. Орон сууц хөлслөх гэрээний үүргээ зохих ёсоор гүйцэтгэдэг хөлслөгч нь уг гэрээний хугацаа дуусахад дээрх орон сууцыг хөлслөн авах шинэ гэрээг тэргүүн ээлжинд байгуулах эрхтэй. Хөлслүүлэгч энэ заалтыг зөрчиж, өөр этгээдтэй гэрээ байгуулсан бол хуучин хөлслөгч нь шинэ хөлслөгчийн эрх, үүргийг өөртөө шилжүүлэн авахыг шаардах эрхтэй.

248 дугаар зүйл. Орон сууцны хөлс

1. Орон сууцны хөлсний хэмжээ, төлөх хугацаа, аргыг талууд харилцан тохиролцож тодорхойлно.

2. Хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол хөлслөгч орон сууцны хөлсийг хөлслүүлэгчид тогтмол хугацаанд төлөх үүрэгтэй.

249 дүгээр зүйл. Орон сууцны дундын ашиглалтын талбайг ашиглах

Хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол орон сууцны дундын ашиглалтын талбай (гал тогооны болон ариун цэвийн өрөө, байшингийн орц, шат зэрэг)-г уг орон сууцанд ууж байгаа хөлслөгчид адил тэгш ашиглах эрхтэй бөгөөд дээр талбай нь орон сууц хөлслөх гэрээний бие даасан үйл болохгүй.

250 дугаар зүйл. Хөлслөгчийн гэр бүлийн гишүүн

1. Хөлслөгчтэй хамт аж төрж байгаа нөхөр буюу эхнэр, үүхэд, эцэг, эхийг түүний гэр бүлийн гишүүн гэж үзнэ.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэр бүлийн гишүүний өрөл садангийн бусад хүмүүс, түүнчлэн түүний асрамжид айгаа хөдөлмөрийн чадваргүй нэг жилээс доошгүй хугаагаар хамт аж төрж, хамтын аж ахуйтай байгаа тэтгүүлэгч хүмүүсийг хөлслөгчийн гэр бүлийн гишүүнд тооцож олно.

3. Гэр бүлийн гишүүний талаархи маргааныг шүү
шийдвэрлэнэ.

251 дүгээр зүйл. Хөлслөгчийн гэр бүлийн гишүүдийн эрх

1. Орон сууц хөлслөгчтэй хамт аж төрж байгаа гэ
бүлийн гишүүд нь хууль буюу орон сууц хөлслөх гэрээгээ
тогтоогдсон хөлслөгчийн бүх эрхийг эдэлж, үүрэг хүлээнэ.

2. Орон сууц хөлслөгч буюу түүний гэр бүлийн гишүү
ний хүсэлтээр орон сууц хөлслөх гэрээг гэр бүлийн гишүү
дийн аль нэгтэй нь байгуулж болно.

3. Орон сууц хөлслөгч нас барсан, эсхүл уг орон сууц
наас гарсан тохиолдолд орон сууц хөлслөх гэрээг түүний
гэр бүлийн гишүүдийн аль нэгтэй нь байгуулна.

4. Гэр бүлийн насанд хүрсэн гишүүн гэр бүлийн бүрэ
дэхүүнээс гарахад орон сууц эзэмших, ашиглах эрхий
талаар гарсан маргааныг орон сууц хөлслөх гэрээг хэ
хийснийг харгалзахгүйгээр шүүхийн журмаар шийдвэрлэнэ

252 дугаар зүйл. Хөлслөгч түр явах үе дэх орон сууц эзэмших, ашиглах эрх

Хөлслөгч түр явахад орон сууц эзэмших, ашиглах эр
хэрхэхийг дор дурдсан тохиолдолд дараахь журмаар шийд
вэрлэнэ:

1) цэргийн жинхэнэ албанд татагдсан иргэний орон сууц
эзэмших, ашиглах эрх нь цэргийн алба хааж байгаа хуга
цаанд болон түүнийг дуусснаас хойш зургаан сарын дото
хэвээр үлдэнэ. Цэргийн жинхэнэ албанд татагдсан иргэни
орон сууцанд түүний гэр бүлийн гишүүн үлдээгүй бол тү
нийг цэргийн албанд явсан өдрөөс эхлэн хөлслүүлэгч нь у
орон сууцыг өөр этгээдэд хөлслөн өгч болно. Шинэ хөлслөг
нь өмнөх хөлслөгчийг буцаж ирмэгц түүний анхны шаардла
гаар уг орон сууцыг чөлөөлөх үүрэгтэй. Чөлөөлөхөөс та
галзвал өөр орон сууц олгосон эсэхийг харгалзахгүйгээ
шүүхийн журмаар нүүлгэн гаргана;

2) асрамжийн газарт шилжиж байгаа иргэний орон сууц
эзэмшихх, ашиглах эрх асаргааны хугацаанд хэвээр үлдэнэ
Тухайн этгээдийн орон сууцанд түүний гэр бүлийн гишүү
үлдээгүй бол асрамжийн газарт шилжсэн өдрөөс нь эхлэ
хөлслүүлэгч уг орон сууцыг өөр этгээдэд хөлслөн өгч болно
Шинэ хөлслөгч нь асрамжийн газраас буцаж ирсэн хөл

лөгч буюу түүний асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн анхны шаардлагаар орон сууцыг чөлөөлөх үүрэгтэй. Чөлөөлөхөөс татгалзвал өөр орон сууц олгосон эсэхийг харгалзахгүйгээр түүнийг шүүхийн журмаар нүүлгэн гаргана;

3) хуульд өөрөөр заагаагүй бол хөлслөгч гадаадад буюу өөр орон нутагт гэр бүлийн гишүүдийн хамт түр явсан бол түүний орон сууц эзэмших, ашиглах эрх хэвээр үлдэх эсэхийг талууд тохиролцон шийдвэрлэнэ;

4) цагдан хоригдож байгаа буюу хорих ял шийтгүүлсэн хөлслөгчийн орон сууцанд түүний гэр бүлийн гишүүн үлдээгүй бол орон сууц эзэмших, ашиглах эрхийг энэ зүйлийн 3-т заасны дагуу шийдвэрлэнэ.

253 дугаар зүйл. Орон сууцны зориулалт өөрчлөгдсөнөөс гэрээний нөхцөл өөрчлөгдөх

Хөлслөн өгсөн орон сууцны зориулалтыг өөрчилсөн тохиолдолд хөлслөгчид өөр орон сууц олгох эсэх асуудлыг талууд тохиролцон шийдвэрлэнэ.

254 дүгээр зүйл. Орон сууцыг дамжуулан хөлслөх

1. Хөлслөгч нь эзэмшиж байгаа орон сууцаа бүхэлд нь буюу түүний хэсгийг хөлслөгчийн зөвшөөрөлтэйгээр өөр этгээдэд дамжуулан хөлслөх эрхтэй бөгөөд тэрээр үндсэн гэрээгээр хүлээсэн үүргээ хөлслүүлэгчийн өмнө бүрэн хариуцна.

2. Дамжуулан хөлслөх гэрээний хугацааг талууд тохиролцон тогтоох боловч орон сууц хөлслөх үндсэн гэрээний үлдсэн хугацаанаас хэтэрч болохгүй. Дамжуулан хөлслөгч нь гэрээний хугацаа сунгахыг шаардах эрхгүй.

3. Дамжуулан хөлслөгч гэрээний хугацаа дуусмагц орон сууцыг чөлөөлөх үүрэгтэй ба энэ үүргээ биелүүлэхгүй бол үндсэн хөлслөгчийн шаардсанаар өөр орон сууц олгосон эсэхийг харгалзахгүйгээр түүнийг шүүхийн журмаар нүүлгэн гаргана.

4. Дамжуулан хөлслөх гэрээг тодорхой бус хугацаагаар байгуулж болно. Энэ үед талууд гэрээг хэдийд ч цуцлах эрхтэй боловч энэ тухай нэг сараас доошгүй хугацааны өмнө нөгөө талдаа мэдэгдэх үүрэгтэй.

5. Орон сууц дамжуулан хөлсөлсний хөлсийг талууд тохиролцон тогтоох боловч үндсэн гэрээгээр тогтоогдсон хөлслөгчийн төлбөл зохих хөлсний хэмжээнээс хэтэрч болохгүй.

255 дугаар зүйл. Түр суугч

Хөлслөгч өөрийн эзэмшиж байгаа орон сууцдаа гэрээ ба хөлсгүйгээр түр суугчийг суулгаж болно. Түр суугч нь хөлслөгчийн анхны шаардлагаар уг орон сууцыг чөлөөлөх үүрэгтэй бөгөөд чөлөөлөхөөс татгалзвал түүнийг хуульд заасны дагуу нүүлгэн гаргана.

256 дугаар зүйл. Орон сууц хөлслөх гэрээ дуусгавар болоход дамжуулан хөлслөгч, түр суугчийг гаргах

Орон сууц хөлслөх гэрээ дуусгавар болоход дамжуулан хөлслөгч ба түр суугчийг өөр орон сууц олгосон эсэхийг харгалзахгүйгээр хуульд заасан журмаар нүүлгэн гаргана.

257 дугаар зүйл. Орон сууц солилцох

1. Орон сууц хөлслөгчид нь хөлслүүлэгчийн зөвшөөрөлтэйгээр өөрсдийн эзэмшиж байгаа орон сууцаа солилцох эрхтэй.

2. Ийнхүү солилцохын тулд хөлслөгчид нь гэр бүлийнхээ насанд хүрсэн бүх гишүүний зөвшөөрлийг бичгээр авсан байх үүрэгтэй. Энэ шаардлагыг биелүүлээгүй гэрээ хүчин төгөлдөр бус байна.

258 дугаар зүйл. Орон сууц өмчлөх эрх өөр өмчлөгчид шилжих

Бусдад хөлслүүлсэн орон сууцны өмчлөх эрх өөр өмчлөгч буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрх бүхий этгээд (энэ хуулийн 88 дугаар зүйл)-эд шилжихэд орон сууц хөлслөх гэрээ хүчин төгөлдөр хэвээр үлдэнэ.

259 дүгээр зүйл. Орон сууц хөлслөх хугацаатай гэрээг цуцлах

1. Орон сууц хөлслөгчийн санаачилгаар орон сууц хөлслөх хугацаатай гэрээг хэдийд ч цуцлах эрхтэй. Ийнхүү цуцлах тухайгаа хөлслөгч нэг сараас доошгүй хугацааны өмнө хөлслүүлэгчид мэдэгдэх үүрэгтэй.

2. Орон сууц хөлслүүлэгчийн санаачилгаар орон сууц хөлслөх хугацаатай гэрээг цуцлах талаар талууд харилцан тохиролцохгүй бол түүнийг гагцхүү шүүхийн шийдвэрээр хугацаанаас өмнө цуцлах болно

260 дугаар зүйл. Орон сууц хөлслөх хугацаагүй гэрээг цуцлах

1. Нийтийн зориулалттай орон сууцыг хугацаагүй хөлсөлсөн бөгөөд хөлслөгч нь гэрээний үүргээ зохих ёсоор гүйцэтгэдэг бол талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээг цуцлана. Талууд ийнхүү тохиролцохгүй бол шүүхийн журмаар гэрээг цуцалж болно.

2. Хувийн зориулалттай орон сууц хөлслөх гэрээг хугацаагүй байгуулсан бол талуудын аль нэг нь гэрээг хэдийд ч цуцлах эрхтэй боловч энэ тухай гурван сараас доошгүй хугацааны өмнө нөгөө талдаа мэдэгдэх үүрэгтэй.

261 дүгээр зүйл. Орон сууцны байшинг буулгахад орон сууц хөлслөх гэрээ дуусгавар болох

1. Эрх бүхий байгууллагын шийдвэрээр орон сууцны байшинг буулгахад орон сууц хөлслөх гэрээ дуусгавар болно.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар гэрээ дуусгавар болсон тохиолдолд хөлслөгчид өөр орон сууц олгох буюу боломжгүй бол гарсан зардлыг уг байгууллагаас нөхөн төлнө.

3. Ашиглалтын шаардлага хангахгүй болсноос орон сууцны байшинг буулгахад энэ зүйлийн заалт хамаарахгүй.

262 дугаар зүйл. Хөлслөгчийг орон сууцнаас шүүхийн журмаар нүүлгэн гаргах

Орон сууц хөлслөгчийг дараахь тохиолдолд өөр орон сууц олгохгүйгээр шүүхийн журмаар нүүлгэн гаргана:

1) хөлслөгч буюу түүний гэр бүлийн гишүүн орон сууц хөлслөх гэрээний үүргээ байнга зөрчиж, хөлслүүлэгчээс урьдчилан удаа дараа сануулсаар байтал уг зөрчлөө арилгаагүй;

2) иргэд орон сууцанд хууль бусаар орж суусан;

3) түр буюу улирлын чанартай ажил гүйцэтгэх, сургуульд суралцахтай холбогдуулан олгосон нийтийн байрыг ажил, сургуулиа төгссөний дараа сайн дураар чөлөөлөөгүй;

4) хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байхдаа гэрээгээр тохиролцсоны дагуу аж төрж байсан орон сууцаа уг гэрээнд заасан хугацаа дуусахад чөлөөлөөгүй;

5) өөр орон сууц олгохоор хуульд зааснаас бусад тохиолдолд албан тушаалын байдал, түүнчлэн хөнгөлөлт эдлэх эрхтэй нь холбогдуулж, тодорхой хугацаагаар, хуульд заасны дагуу олгосон орон сууцыг хугацаа дууссаны дараа сайн дураар чөлөөлөөгүй;

263 дугаар зүйл. Хөлслөгчийг зочид буудлаас шүүхийн журмаар нүүлгэн гаргах

Зочид буудалд хугацаа хэтрүүлэн суух буюу зочид буудлын дотоод журмыг удаа дараа зөрчсөн хөлслөгчийг шүүхийн журмаар нүүлгэн гаргана.

264 дүгээр зүйл. Нүүлгэн гаргах журам

Шүүхийн хуулийн хүчин төгөлдөр шийдвэрийг үндэслэн шүүхийн шийдвэр гүйцэтгэхийн алба дангаараа буюу цагдаагийн байгууллагатай хамтран хөлслөгчийг нүүлгэн гаргана.

ХОРИНЗУРГАДУГААР БҮЛЭГ

Эд хөрөнгө түрээслэх

265 дугаар зүйл. Эд хөрөнгө түрээслэх гэрээ

1. Эд хөрөнгө түрээслэх гэрээгээр түрээслүүлэгч өөрийн өмчлөлд буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрх (энэ хуулийн 88 дугаар зүйл)-дээ байгаа үл хөдлөх ба хөдлөх эд хөрөнгийг түрээслэгчид аж ахуйн үйл ажиллагаа явуулах болон дүрэмд заасан зорилгоо биелүүлэхэд нь зориулж зохих болзол, хугацаа, төлбөртэйгээр эзэмшүүлэх, ашиглуулахаар шилжүүлэх; түрээслэгч нь эд хөрөнгийг хууль буюу гэрээнд заасны дагуу эзэмших, ашиглах, төлбөрийг төлөх үүргийг тус тус хүлээнэ.

2. Эд хөрөнгийг эрх залгамжлан түрээсэлж болно.

3. Түрээсийн гэрээнд энэ хуулийн 242 дугаар зүйлийн заалт нэг адил хамаарна.

266 дугаар зүйл. Түрээсэлсэн эд хөрөнгөөс олсон орлого, үр шим, үр төлийг өмчлөх

Хуульд өөрөөр заагаагүй бол түрээсэлсэн эд хөрөнгийг эзэмшиж, ашигласны үр дүнд буй болсон орлого, үр шим,

ур төлийг өмчлөх эрхийг талуудын хоорондын гэрээгээр тодорхойлно.

267 дугаар зүйл. Түрээсийн гэрээний хэлбэр

1. Түрээсийн гэрээг бичгээр байгуулна. Үл хөдлөх эд өөрөнгө түрээслэх гэрээг үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн газарт бүртгүүлнэ.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан шаардлагыг биелүүлээгүй гэрээ хүчин төгөлдөр бус байна.

268 дугаар зүйл. Түрээсийн гэрээний хугацаа

1. Хуульд өөрөөр заагаагүй бол түрээсийн гэрээний хугацааг түрээсэлж буй эд хөрөнгийн шинж байдал, зориулалтыг харгалзан талууд тохиролцож тогтооно.

2. Түрээсийн гэрээнд энэ хуулийн 233 дугаар зүйлийн 2, 3, 4 дэх хэсгийн заалт нэг адил хамаарна.

269 дүгээр зүйл. Түрээсийн гэрээг өөрчлөх ба цуцлах

Хүндэтгэн үзэх шалтгаанаар гэрээгээр хүлээсэн үүргийг гүйцэтгэх боломжгүй болбол гэрээг өөрчлөх ба цуцлахыг талуудын аль нэг нь шаардах эрхтэй.

270 дугаар зүйл. Түрээсийн гэрээг өөрчлөхгүй ба цуцлахгүй байх

1. Талуудын үйл ажиллагаанаас үл хамаарах шалтгаанаар түрээслүүлэгч, түрээслэгч солигдох нь түрээсийн гэрээг цуцлах, гэрээний нөхцөлийг өөрчлөх үндэслэл болохгүй.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн заалт нь эрх залгамжлагчаас гэрээний нөхцөлийг өөрчлөх, гэрээг цуцлах тухай санал оргахад саад болохгүй.

271 дүгээр зүйл. Түрээсийн төлбөр

1. Хуульд өөрөөр заагаагүй бол түрээсийн төлбөрийг талууд тохиролцож тогтооно.

2. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас түрээсэлсэн эд хөрөнгийн чанар байдал алдагдвал талууд харилцан тохиролцож, түрээсийн төлбөрийн хэмжээг өөрчилж болно.

3. Гэрээнд өөрөөр заагаагүй бол түрээсийн төлбөрийг дараагийн хугацаанд төлнө.

272 дугаар зүйл. Түрээслүүлэгчийн үүрэг

1. Түрээслүүлэгч нь гэрээний нөхцөлд тохирсон эд хөрөнгийг түрээслэгчид шилжүүлэх, хуульд өөрөөр заагаагүй бөгөөд гэрээгээр тохирсон бол эд хөрөнгөнд засвар хийх үүрэгтэй. Бусад үүргийг талууд тохиролцон гэрээнд тодорхойлж болно.

2. Гэрээ байгуулах үед мэдэгдээгүй байсан бөгөөд ашиглахад саад болж байгаа эд хөрөнгийн чанарын дутагдлыг түрээслүүлэгч хариуцна.

273 дугаар зүйл. Түрээслэгчийн үүрэг

Түрээслэгч нь түрээслэн авсан эд хөрөнгийг гэрээнд заасны дагуу эзэмших, ашиглах; газрын үржил. малын ашиг шим, эд хөрөнгийн чанар байдлыг алдагдуулахгүй байх; нөхөн сэргээх; түрээсийн төлбөрийг хугацаанд нь төлөх; хуульд өөрөөр заагаагүй бөгөөд гэрээгээр тохиролцсон бол эд хөрөнгөнд засвар хийх; хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол гэрээ дуусгавар болсны дараа ердийн буюу гэрээгээр тохиролцсон элэгдлийг тооцож, эд хөрөнгийг түрээслүүлэгчид буцаан өгөх үүрэг хүлээнэ. Бусад үүргийг талууд тохиролцсон гэрээнд зааж болно.

274 дүгээр зүйл. Түрээслүүлэгч, түрээслэгчийн давуу эрх

1. Түрээслүүлэгч нь гэрээ байгуулахаар хэд хэдэн этгээд санал гаргавал түрээслэгчийг сонгож авах, түрээслэгч гэрээгээр хүлээсэн үүргээ ноцтой зөрчсөн, төлбөрийн чадваргүй, эд хөрөнгө эзэмших найдваргүй болсон тохиолдолд гэрээг цуцлах, учирсан хохирлыг төлүүлэхээр шаардах эрхтэй.

2. Хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол эд хөрөнгийг дахин түрээслэх, худалдах тохиолдолд гэрээний үүргээ зохих ёсоор гүйцэтгэдэг түрээслэгч нь түүнийг тэргүүн ээлжинд түрээслэн авах буюу худалдан авах эрхтэй. Түрээслүүлэгч энэ заалтыг зөрчиж, уг эд хөрөнгийг өөр этгээдэд түрээслэх буюу худалдах гэрээ байгуулсан байвал хуучин түрээслэгч нь шинэ түрээслэгчийн эрх, үүргийг өөртөө шилжүүлэн авахыг шаардах эрхтэй.

3. Талууд тохиролцон бусад давуу эрхийг гэрээгээр тогтоож болно.

275 дугаар зүйл. Эд хөрөнгийг дамжуулан түрээслэх

Түрээслэн авсан эд хөрөнгийг гагцхүү түрээслүүлэгчийн зөвшөөрөлтэйгээр дамжуулан түрээсэлж болно.

276 дугаар зүйл. Түрээслэх эд хөрөнгийг үнэлэх

Хуульд өөрөөр заагаагүй бол түрээсэлж байгаа эд хөрөнгийг талуудын тохиролцсоноор үнэлнэ.

277 дугаар зүйл. Түрээсэлсэн эд хөрөнгийг худалдах буюу үнэ төлбөргүй шилжүүлэх

Түрээсийн гэрээ дуусгавар болсны дараа түрээсэлсэн эд хөрөнгийг дахин үнэлж худалдах, эсхүл үнэ төлбөргүй шилжүүлэх эсэхийг талууд тохиролцох эрхтэй.

278 дугаар зүйл. Түрээсэлсэн эд хөрөнгийн даатгал

Түрээсэлсэн эд хөрөнгийг даатгуулах, даатгалын хөрөнгийг хуваарилах журмыг талууд гэрээгээр тохиролцоно.

279 дүгээр зүйл. Хамтран түрээслэх

Хэд хэдэн этгээд эд хөрөнгө хамтран түрээслэх тохиолдолд түрээслэгчдийн хоорондын харилцааг тэдгээрийн хоорондын гэрээгээр зохицуулна. Хамтран түрээсэлсэн нөхцөлд түрээслэгч бүр эрхээ хамгаалахыг бие даан шаардах эрхтэй.

280 дугаар зүйл. Түрээсийн гэрээний үүрэг гүйцэтгээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүйгээс үүсэх үр дагавар

1. Түрээсийн гэрээний үүргээ гүйцэтгээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүй бол талууд хууль бусын гэрээнд заасны дагуу хариуцлага хүлээнэ.

2. Түрээсийн гэрээний үүргээ гүйцэтгээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүй талын хариуцлагыг тодорхойлоход энэ хуулийн 236, 238 дугаар зүйлийн заалт хамаарна.

281 дүгээр зүйл. Газар түрээслэх

1. Газар түрээслэх эрх нь газрын хэвлийг эзэмших, ашиглахад хамаарахгүй.

2. Газар түрээслэх журмыг хуулиар тогтооно.

ХОРИНДОЛДУГААР БҮЛЭГ

Эд хөрөнгө үнэ төлбөргүй ашиглах

282 дугаар зүйл. Эд хөрөнгө үнэ төлбөргүй ашиглах гэрээ

1. Эд хөрөнгө үнэ төлбөргүй ашиглах гэрээгээр нэг тал нь эд хөрөнгийг түр хугацаанд нөгөө талдаа үнэ төлбөргүй ашиглуулахаар шилжүүлнэ.

2. Эд хөрөнгө үнэ төлбөргүй ашиглах гэрээнд энэ хуулийн 231, 233, 242 дугаар зүйлийн заалт нэг адил хамаарна.

283 дугаар зүйл. Эд хөрөнгө үнэ төлбөргүй ашиглаж байгаа талын үүрэг

1. Хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол бусдын эд хөрөнгийг үнэ төлбөргүй ашиглаж байгаа тал түүнийг гэрээнд заасны дагуу ашиглах, ердийн элэгдлээс өөрөөр гэмтээж, муудуулахгүй байх, засвар хийх. уг эд хөрөнгийг хэвийн байдалд байлгахын тулд зохих зардал гаргах үүрэгтэй. Эд хөрөнгийг үнэ төлбөргүй ашиглахаар авсан тал гэрээ дуусгавар болоход уг эд хөрөнгийг ердийн буюу гэрээгээр тохиролцсон элэгдлийг тооцож буцааж өгөх үүрэгтэй.

2. Эд хөрөнгө үнэ төлбөргүй ашиглахаар авсан тал энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан заалтыг зөрчсөн бөгөөд эд хөрөнгө өгсөн тал санууллсаар байхад дээрх зөрчлийг үргэлжлүүлсээр байвал эд хөрөнгө өгсөн тал нь гэрээг цуцлахыг шаардах, гаргасан зардал буюу эд хөрөнгө гэмтэж муудсанаас учирсан хохирлыг төлүүлэхээр шаардах эрхтэй.

3. Эд хөрөнгө үнэ төлбөргүй ашиглахаар авсан тал түүнийг өгсөн талын зөвшөөрөлгүйгээр өөр этгээдэд шилжүүлэх эрхгүй. Зөвшөөрөл авч эд хөрөнгийг бусдад шилжүүлсэн этгээд нь эд хөрөнгө өгсөн талын өмнө хүлээх хариуцлагаас чөлөөлөгдөхгүй.

284 дүгээр зүйл. Үнэ төлбөргүй ашиглуулахаар өгсөн эд хөрөнгийг өмчлөх эрх шилжих

Үнэ төлбөргүй ашиглуулахаар өгсөн эд хөрөнгийг өмчлөх эрх өөр этгээдэд шилжихэд эд хөрөнгө үнэ төлбөргүй ашиглах гэрээ хүчин төгөлдөр хэвээр үлдэнэ. Харин гэрээг тодорхой бус хугацаагаар байгуулсан бол шинэ өмчлөгч нь гэрээ цуцлахыг шаардах эрхтэй.

ХОРИННАЙМДУГААР БҮЛЭГ

Оюуны үнэт зүйлийг ашиглах

285 дугаар зүйл. Оюуны үнэт зүйлийг ашиглах гэрээ

1. Оюуны үнэт зүйлийг ашиглах гэрээгээр оюуны үнэт зүйлийг өмчлөгч буюу патент эзэмшигч нь сонирхогч этгээд (иргэн, хуулийн этгээд, төр)-эд оюуны үнэт зүйлийг тодорхой зориулалтаар, шагналтай ашиглуулахаар шилжүүлэх үүрэг хүлээнэ.

2. Оюуны үнэт зүйлийг ашиглах гэрээний зүйл болох бүтээлтэй холбогдсон зохиогчийн амины эрхийн хувьд сонирхогч этгээд аливаа эрх эдлэхгүй.

3. Хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол оюуны үнэт зүйлийг ашиглах гэрээнд энэ хуулийн зохих заалт хамаарна.

286 дугаар зүйл. Оюуны үнэт зүйлийг ашиглах гэрээний хэлбэр

Оюуны үнэт зүйлийг ашиглах гэрээг бичгээр хийх ба хуульд тусгайлан заасан бол эрх бүхий байгууллагад бүртгүүлнэ.

287 дугаар зүйл. Оюуны үнэт зүйлийг ашиглах гэрээний зүйл, үнэ, агуулга

1. Оюуны үнэт зүйлийг ашиглах гэрээний зүйл нь хуулиар тогтоосон журмаар хэлбэржиж, бүртгэгдэж, тооцогдон нээлт, шинэ бүтээл, оновчтой санал, бүтээгдэхүүний загвар, барааны тэмдэг болон зохиогчийн эрхэд хамаарах бүтээл байна.

2. Оюуны үнэт зүйлийг ашигласны хөлс, шагналыг хуульд өөрөөр заагаагүй бол гэрээний талууд тохиролцон тогтооно.

3. Оюуны үнэт зүйлийг ашиглах гэрээнд оюуны үнэт зүйлийг ашиглах арга, хэлбэр, хэмжээ, хүрээ, хугацаа, талуудын эрх, үүрэг, хариуцлага, хуульд заасан бусад нөхцөлийг заана.

288 дугаар зүйл. Оюуны үнэт зүйлийг ашиглах гэрээ зөрчсөнөөс үүсэх хариуцлага

Гэрээний үүргээ гүйцэтгээгүй буюу зохих ёсоор гүйцэт-

гээгүй тал нь хууль буюу гэрээнд заасан хэмжээ, нөхцөлийн дагуу хариуцлага хүлээнэ.

III ДЭД ХЭСЭГ

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭНИЙ ҮҮРЭГ ХОРИНЕСДҮГЭЭР БҮЛЭГ

Ажил гүйцэтгэх

289 дүгээр зүйл. Ажил гүйцэтгэх гэрээ

1. Ажил гүйцэтгэх гэрээгээр ажил гүйцэтгэгч захиалагчийн даалгаврын дагуу түүний буюу өөрийн эд хөрөнгөөр тодорхой ажил гүйцэтгэх; захиалагч уг ажлыг хүлээн авч хөлс төлөх үүргийг тус тус хүлээнэ,

2. Гэрээнд заасан ажлыг гүйцэтгэхдээ төсөв боловсруулж болно. Төсвийг өөрчлөх арга, журмын талаар болон түүнийг зөрчсөнөөс үүсэх хариуцлагыг талууд гэрээгээр тодорхойлно.

3. Захиалагч нь ажил гүйцэтгэгчийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцохгүйгээр хэдийд ч ажлын явц, чанарыг шалгах эрхтэй.

4. Гүйцэтгэсэн ажлыг хүлээлгэн өгөх гэрээнд заасан хугацаа болохоос өмнө гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлаас устсан буюу гэмтсэн эд хөрөнгийн талаархи хариуцлагыг тухайн эд хөрөнгийн өмчлөгч буюу эзэмшигч, уг хугацаа болсноос хойш үүссэн хариуцлагыг хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол хугацаа хожимдуулсан тал хүлээнэ.

5. Ажил гүйцэтгэх гэрээний зүйлийг захиалагчид хүлээлгэн өгөхөөс өмнө гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлаас устсан буюу гэмтсэн, эсхүл захиалагчийн буруугаас болж ажлыг дуусгах боломжгүй болсон бол ажил гүйцэтгэгч ажлын хөлсийг шаардах эрхтэй. Гэрээнд заасан ажил гүйцэтгэх боломжгүй болсон нь захиалагчийн эд хөрөнгө буюу ажил гүйцэтгэх тухай заавар учир дутагдалтайгаас болсон бөгөөд ажил гүйцэтгэгч нь эд хөрөнгийг солих, өгсөн зааврaa өөрчлөх явдал чухал болохыг захиалагчид цаг тухайд нь мэдэгдсэн бол ажил гүйцэтгэгч ажлын хөлс авах эрхээ алдахгүй. Түүнчлэн ажил гүйцэтгэхэд хэрэглэгдэх зүйл үрэгдсэн явдал ажил гүйцэтгэгчийн

буруугаас болоогүй бөгөөд ажил хүлээн авах хугацааг захиалагч хожимдуулснаас хойш тохиолдсон бол ажил гүйцэтгэгч хөлс авах эрхээ нэг адил алдахгүй.

6. Хуульд өөрөөр заагаагүй бол ажил гүйцэтгэх гэрээг бичгээр хийнэ.

290 дугаар зүйл. Ерөнхий ба туслан гүйцэтгэгч

1. Ажил гүйцэтгэгч нь гэрээнд заасан ажлыг гүйцэтгэхэд бусад этгээд (туслан гүйцэтгэгч)-ийг оролцуулж болно.

2. Хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол ажил гүйцэтгэгч нь туслан гүйцэтгэгчийн ажлын үр дүнг захиалагчийн өмнө хариуцна. Энэ тохиолдолд ажил гүйцэтгэгч нь захиалагчийн хувьд ерөнхий ажил гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгчийн хувьд захиалагч болно.

291 дүгээр зүйл. Ажил гүйцэтгэх гэрээний хугацаа

1. Хуульд өөрөөр заагаагүй бол ажил гүйцэтгэх гэрээний хугацааг талууд тохиролцон тодорхойлно. Ажлын онцлогийг харгалзан завсрын буюу тусгай хугацаа тогтоож болно.

2. Хуульд өөрөөр заагаагүй бол завсрын буюу тусгай хугацааг зөрчсөнөөс үүсэх хариуцлагыг талууд тохиролцон тодорхойлж болох боловч тэр нь үндсэн хугацааг зөрчсөнөөс үүсэх хариуцлагаас илүү байж болохгүй.

292 дугаар зүйл. Ажлын хөлс

Хуульд өөрөөр заагаагүй бол ажил гүйцэтгэсний хөлсний хэмжээ, хөлс төлөх арга, журам, хугацааг талууд тохиролцон тодорхойлно.

293 дугаар зүйл. Ажлын чанар

Ажлын чанарыг талууд тохиролцон тодорхойлно.

294 дүгээр зүйл. Ажил гүйцэтгэгчийн үүрэг

1. Ажил гүйцэтгэгч нь гэрээнд дурдсан ажлыг тогтоосон хугацаанд зохих ёсоор гүйцэтгэх үүрэгтэй.

2. Гэрээнд өөрөөр заагаагүй бол ажил гүйцэтгэгч уг ажлыг өөрийн эд хөрөнгө, багаж, техник хэрэгслээр гүйцэтгэнэ.

3. Захиалагчийн нийлүүлсэн эд хөрөнгө нь гэрээгээр гүйцэтгэх ажлын шаардлагад тэнцэхгүй буюу чанар муутай

байвал ажил гүйцэтгэгч нь захиалагчид цаг тухайд нь мэдэгдэх үүрэгтэй.

4. Ажил гүйцэтгэх аргын талаар захиалагчийн өгсөн заавар уг ажлын чанар, үр дүнд мууташр нөлөөлөхүйц байх буюу ажил гүйцэтгэгчээс үл хамаарах бусад шалтгаан байвал ажил гүйцэтгэгч зохих цагт нь захиалагчид мэдэгдэх үүрэгтэй.

5. Ажил гүйцэтгэгч захиалагчаас олгосон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах арга хэмжээ авах үүрэгтэй бөгөөд устсан буюу гэмтсэнээс үүсэх хариуцлагыг хүлээнэ.

295 дугаар зүйл. Ажил гүйцэтгэгч гэрээ зөрчсөнөөс үүсэх захиалагчийн эрх

1. Ажил гүйцэтгэгч нь гэрээний нөхцөлийг зөрчсөн буюу гүйцэтгэсэн ажилд ямар нэгэн дутагдал байвал захиалагч дор дурдсан шаардлагын аль нэгийг тавих эрхтэй:

1) буруу буюу дутуу гүйцэтгэсэн ажлыг тогтоосон хугацаанд өөрийн зардлаар засах буюу гүйцээх;

2) ажлын хөлсийг зохих хэмжээгээр хорогдуулах;

3) ажлын дутагдлыг захиалагч өөрийн хөрөнгөөр засахад гарсан зайлшгүй зардлыг төлүүлэх.

2 Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхдээ гэрээг ноцтой зөрчсөн буюу бусад ноцтой дутагдал гаргасан байвал захиалагч нь гэрээг цуцалж, учирсан хохирлыг төлүүлэхээр шаардах эрхтэй.

296 дугаар зүйл. Ажил гүйцэтгэгчийн хариуцлагын талаар гомдлын шаардлага гаргах хугацаа

1. Ажил гүйцэтгэгч гэрээний нөхцөлийг зөрчсөн буюу гүйцэтгэсэн ажилд ямар нэг дутагдал байвал захиалагч энэ тухай гомдлын шаардлагыг хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол ажил хүлээн авснаас хойш зургаан сарын дотор, хэвийн байдлаар хүлээн авах үед илрүүлэх боломжгүй дутагдлын тухай гомдлын шаардлагыг ажил хүлээн авснаас хойш нэг жилийн дотор гаргана. Барилга, байшинтийн ийм дутагдлын талаар ажил хүлээн авснаас хойш гурван жилийн дотор гомдлын шаардлага гаргаж болно.

2. Хууль буюу гэрээнд баталгаат хугацаа заасан бөгөөд уг хугацааны дотор ажлын дутагдлыг илрүүлсэн бол гомдлын шаардлага гаргах хугацааг дутагдал илрүүлсэн өдрөөс эхлэн тоолно.

3. Энэ зүйлд заасан гомдлын шаардлага гаргах хугацаа дууссан өдрөөс эхлэн хөөн хэлэлцэх хугацааг тоолно.

297 дугаар зүйл. Захиалагчийн үүрэг

1. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэсэн ажлыг хүлээн авч, зохих хөлсийг төлөх үүрэгтэй. Гэрээнд өөрөөр заагаагүй бол ажлын хөлсийг бүх ажлыг гүйцэтгэсний дараа төлнө.

2. Гэрээнд заасан бол захиалагч нь ажил гүйцэтгэхэд зайлшгүй шаардагдах эд хөрөнгийг бүрэн буюу түүний заримыг ажил гүйцэтгэгчид шилжүүлэн өгөх үүрэгтэй.

3. Захиалагч нь ажил гүйцэтгэгчээс зохих хугацаанд тавьсан шаардлагын дагуу түүнд өгсөн чанар муутай буюу хэрэгцээгүй эд хөрөнгийг солих, ажил гүйцэтгэх аргын талаар өгсөн зааврaа өөрчлөх, түүнчлэн ажлын чанарт муугаар нөлөөлөх өөрөөс хамаарах бусад нөхцөлийг арилгах үүрэгтэй.

298 дугаар зүйл. Захиалагч гүйцэтгүүлсэн ажлаа хүлээн аваагүйгээс үүсэх үр дагавар

1. Захиалагч гүйцэтгэсэн ажлыг хүлээн аваагүй бөгөөд хууль буюу гэрээгээр өөр журам тогтоогоогүй бол ажил гүйцэтгэгч гурван сарын дотор хоёроос доошгүй удаа бичгээр урьдчилан мэдэгдсэний дараа уг зүйлийг дуудлагын буюу комиссийн худалдаагаар худалдах эрхтэй.

2. Худалдсан үнээс ажил гүйцэтгэгч төлүүлэн авбал зохих бүх төлбөрөө суутган авч, илүү гарсныг захиалагчид олгоно. Захиалагчид олгох боломжгүй бол улсын орлогод оруулна.

3. Худалдсан үнэ нь ажил гүйцэтгэгчид төлбөл зохих төлбөрийг төлөхөд хүрэлцэхгүй бол зөрүүг захиалагчаас шаардах эрхтэй.

4. Гүйцэтгэгчийн эд хөрөнгөөр гүйцэтгэсэн ажлыг захиалагч хүлээн аваагүйгээс үүсэх үр дагаврыг энэ зүйлийн 1, 2, 3 дахь хэсэгт зааснаар зохицуулна.

299 дүгээр зүйл. Захиалагчийн шаардлагаар ажил гүйцэтгэх гэрээг цуцлах

1. Ажил гүйцэтгэгч гэрээнд заасан хугацаанд ажил эхлээгүй буюу удаан хийснээс түүнийг хугацаанд нь дуусгах

боломжгүй болсон бол захиалагч гэрээг цуцалж, учирсан хохирлыг төлүүлэхээр шаардах эрхтэй.

2. Ажил гүйцэтгэгч гэрээнд заасан ажлыг зохих ёсоор гүйцэтгэж чадахгүй нь илэрхий болсон буюу ажлын дутагдлыг тогтоосон хугацаанд арилгаагүй бөгөөд гэрээнд заасан бол захиалагч нь гэрээг цуцлахгүйгээр, ажил гүйцэтгэгчийн зардлаар уг ажлын дутагдлыг засаж цаашид үргэлжлүүлэхийг өөр этгээдэд даалгаж болно.

3. Хүндэтгэн үзэх шалтгаан байвал захиалагч нь нэгэнт гүйцэтгэсэн ажлын хөлсийг төлөхийн хамт гэрээ цуцалсны улмаас ажил гүйцэтгэгчид учирсан хохирлыг гүйцэтгэсэн ажлын байдлыг харгалзан төлж. ажил дуусахаас өмнөх аль ч үед гэрээг цуцлах эрхтэй.

300 дугаар зүйл. Ажил гүйцэтгэгчийн шаардлагаар ажил гүйцэтгэх гэрээг цуцлах

Ажил гүйцэтгэхэд тэнцэхгүй буюу чанар муутай эд хөрөнгийг сольж өгөх, эсхүл ажил гүйцэтгэх талаар өгсөн үндэслэлгүй зааврааө өөрчлөх тухай зохих хугацаанд өгсөн шаардлагыг захиалагч хүлээж аваагүй бол ажил гүйцэтгэгч гэрээг цуцалж, учирсан хохирлоо төлүүлэхээр шаардах эрхтэй.

301 дүгээр зүйл. Ажил гүйцэтгэх зарим төрлийн гэрээний зохицуулалт

1. Ажил гүйцэтгэх гэрээний тодорхой төрлүүдэд энэ хуулийн 289-өөс 300 дугаар зүйлд заасан нийтлэг журам хамаарна.

2. Ажил гүйцэтгэх зарим төрлийн гэрээний онцлог зохицуулалтыг хуулиар тогтоож болно.

ГУЧДУГААР БҮЛЭГ

Барилгын ажил гүйцэтгэх

302 дугаар зүйл. Барилгын ажил гүйцэтгэх гэрээ

Барилгын ажил гүйцэтгэх гэрээгээр ажил гүйцэтгэгч нь өөрийн буюу захиалагчийн эд хөрөнгөөр зохих зураг, төслийн дагуу барилга барих буюу барилгын ажил гүйцэтгэх, гэрээнд заасан хугацаанд захиалагчид шилжүүлэн өгөх; захиалагч нь ажил гүйцэтгэгчид барилга барих талбай, ажлын байр

гаргаж өгөх, зураг, төсөл, төсвийг шилжүүлэх, гүйцэтгэсэн ажлыг хүлээн авах. хөлсийг төлөх үүргийг тус тус хүлээнэ.

2. Хуульд өөрөөр заагаагүй бол материал техник, зураг, төслөөр хангах үүргийг аль тал гүйцэтгэхийг гэрээгээр тодорхойлно.

3. Хуульд өөрөөр заагаагүй бол барилгын ажил гүйцэтгэсний хөлсний хэмжээ, хөлс төлөх арга, журам, хугацааг талууд тохиролцон тодорхойлно.

4. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас барьж байгаа барилга түүнийг хүлээлгэн өгөх хугацаанаас өмнө нурсан буюу гэмтсэн бөгөөд гэрээнд өөрөөр заагаагүй бол захиалагч нь гүйцэтгэсэн болон сэргээн босголтын ажлын хөлсийг төлөх үүрэгтэй.

5. Талуудаас үл хамаарах нөхцөл байдлын улмаас барилгын ажлыг дараа үргэлжлүүлэн гүйцэтгэхээр түр зогсоох шаардлага гарвал захиалагч нь түр зогсоохоос өмнө гүйцэтгэсэн ажлын хөлс болон түр зогсоохтой холбогдож гарах зардлыг ажил гүйцэтгэгчид төлнө.

303 дугаар зүйл. Барилгын ажлын гүйцэтгэлийг шалгах

1. Хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол гүйцэтгэж байгаа ажил нь хугацаа, хэмжээ, төсөв, чанарын талаар гэрээ болон зураг төсөлдөө нийцэж байгаа эсэхэд захиалагч зохих журмын дагуу шалгалт хийж, хяналт тавина.

2. Ажил гүйцэтгэгч нь барилга болон барилгын тодорхой төрлийн ажлыг хийж дуусмагц дараагийн ажлыг гүйцэтгэхэд захиалагчийн зүгээс шаардагдах ажлуудыг тодорхойлсон бичиг баримт үйлдэж, захиалагчид шилжүүлэх үүрэгтэй.

ГУЧИННЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Төсөл зохиох ажил гүйцэтгэх

304 дүгээр зүйл. Төсөл зохиох ажил гүйцэтгэх гэрээ

1. Тодорхой төсөл зохиох ажил гүйцэтгэх гэрээгээр ажил гүйцэтгэгч нь захиалагчийн захиалгаар төслийн баримт бичгийг боловсруулах; захиалагч түүнийг хүлээн авч. хөлс төлөх үүргийг тус тус хүлээнэ.

2. Төслийг хүлээн авах, хэрэгжүүлэх явцад дутагдал илэрвэл ажил гүйцэтгэгч нь түүнийг дахин үнэ төлбөргүй

хийх, хууль буюу гэрээнд өөр хариуцлага тогтоогоогүй бо. төслийн дутагдлаас болж захиалагчид учирсан хохирлы нөхөн төлөх үүрэгтэй.

3. Захиалагч нь төслийн зориулалт, бусад зайлшгү шаардлагатай мэдээллээр ажил гүйцэтгэгчийг хангах үүрэ тэй ба түүнийг биелүүлээгүй бол ажил гүйцэтгэгч нь гэрээ цуцалж, учирсан хохирлыг төлүүлэхээр шаардах эрхтэй.

ГУЧИНХОЁРДУГААР БҮЛЭГ

Судалгаа шинжилгээний ба туршилт, зохион бүтээх ажил гүйцэтгэх

305 дугаар зүйл. Судалгаа шинжилгээний ба туршилт. зохион бүтээх ажил гүйцэтгэх гэрээ

1. Судалгаа шинжилгээний ба туршилт, зохион бүтээ ажил гүйцэтгэх гэрээгээр гүйцэтгэгч нь захиалгад заасан судалгаа шинжилгээний ажил хийх, шинэ бүтээгдэхүүни загвар, түүнийг зохион бүтээх бичиг баримтыг боловсруу лах, үйлдвэрлэлийн шинэ технологи буюу үйлдвэрлэлд ши нэлэг бусад зүйлийг зохион бүтээх, туршилт явуулах захиалагч нь ажлын үр дүнг хүлээн авч. хөлс төлөх үүрэ тус тус хүлээнэ.

2. Гүйцэтгэгчтэй хийх гэрээ нь судалгаа шинжилгээни ба туршилт, зохион бүтээх ажлыг бүхэлд нь болон тэдгээ рийн тодорхой үе шатыг хамарч болно.

3. Судалгаа шинжилгээний ба туршилт зохион бүтээ ажлыг гүйцэтгэх явцад гэрээнд заасан үр дүнд хүрэх бо ломжгүй болох нь илэрвэл захиалагч тэр хүртэлх хугацаанд гүйцэтгэсэн ажилд тохирох хөлс, гүйцэтгэгчээс гарсан зард лыг төлөх үүрэгтэй.

4. Гүйцэтгэгч нь судалгаа шинжилгээний ба туршил зохион бүтээх ажил гүйцэтгэх явцдаа зохиогчийн эрхэ хамаарах ююуны үнэт зүйл бүтээсэн бол уг бүтээлтэй хол богдсон зохиогчийн амины эрхийн хувьд захиалагч алива эрх эдлэхгүй.

ГУЧИНГУРАВДУГААР БҮЛЭГ

Зохиол бүтээл туурвих ажил гүйцэтгэх

306 дугаар зүйл. Зохиол бүтээл туурвих ажил гүйцэтгэх гэрээ

1. Зохиол бүтээл туурвих ажил гүйцэтгэх гэрээгээр гүйцэтгэгч нь шинжлэх ухаан, техникийн болон урлаг, утга зохиолын ямар нэгэн төрөл, хэлбэрийн бүтээлийг захиалгын дагуу тогтоосон хугацаанд туурвиж, захиалагчид шилжүүлэх; захиалагч нь уг бүтээлийг хүлээн авч, зохих хөлс, шагналыг төлөх үүрэг тус тус хүлээнэ.

2. Хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол зохиол бүтээл туурвих ажил гүйцэтгэх гэрээнд энэ хуулийн 304 дүгээр зүйлийн 2, 3, 305 дугаар зүйлийн 2, 3, 4 дэх хэсгийн заалт нэг адил хамаарна.

ГУЧИНДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Хөдөлмөрлөх

307 дугаар зүйл. Хөдөлмөрийн гэрээ

1. Иргэд нь хуулийн этгээд, иргэдтэй хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж болно.

2. Хөдөлмөрийн гэрээ байгуулах нөхцөл, журмыг хуулиар тогтооно.

3. Хуульд өөрөөр заагаагүй бол уг гэрээнд энэ хуулийн ёронхий үндэслэлийг хэрэглэнэ.

ГУЧИНТАВДУГААР БҮЛЭГ

Хөлсөөр ажиллах

308 дугаар зүйл. Хөлсөөр ажиллах гэрээ

Хөлсөөр ажиллах гэрээгээр ажиллагч өөрийн өндөр эдлэг, онцгой авьяас чадвараа ашиглан тодорхой хугацаанаар ажиллах, ажиллуулагч хөлсийг төлөх үүрэг тус тус үлээнэ.

309 дүгээр зүйл. Хөлсөөр ажиллах гэрээний хугацаа

1. Хуульд өөрөөр заагаагүй бол хөлсөөр ажиллах гэрээний хугацааг талууд тохиролцон тодорхойлно.

2. Ажлын онцлогийг харгалзан завсрын хугацаа то тоож болно.

3. Хуульд өөрөөр заагаагүй бол завсрын хугацааг зөр сөнөөс үүсэх хариуцлагыг талууд тохиролцож тодорхойлс боловч энэ нь тухайн ажил гүйцэтгэх гэрээний хугац зөрчсөнөөс үүсэх хариуцлагаас их байж болохгүй.

310 дугаар зүйл. Хөлсөөр ажиллах гэрээний хөлс

1. Хуульд өөрөөр заагаагүй бол хөлсөөр ажиллах гэрэ ний хөлсний хэмжээ, хөлс төлөх арга, журам, хугац талууд тохиролцон тодорхойлно.

2. Хуульд өөрөөр заагаагүй бол ажиллах үүргийг гү цэтгэхтэй холбоотой бусад эрх, үүргийг талууд гэрээнд тодорхойлж болно.

311 дүгээр зүйл. Ажиллагчийн үүрэг

1. Ажиллагч дараахь үүргийг хүлээнэ:

1) гэрээнд заасан ажлыг биечлэн гүйцэтгэх, ажла гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэхгүй байх;

2) гэрээний хугацаанд ажиллуулагчийн зөвшөөрөлгүй гээр гүйцэтгэж буй үүрэгтэйгээ холбоотой буюу ижил үү гийг бусад этгээдийн өмнө гүйцэтгэхгүй байх;

3) гэрээнд заасан үүрэгтэй холбоотой бусад үүрэ гүйцэтгэх.

Ажиллагч энэ зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасан үү гээ зөрчвөл гэрээг цуцалж, учирсан хохирлоо төлүүлэх; 3-т заасан үүргээ зөрчвөл гэрээг цуцалж, учирсан хохиро болон гэрээнд заасан анз төлүүлэхээр ажиллуулагч шаарда эрхтэй.

312 дугаар зүйл. Ажиллуулагчийн үүрэг

1. Ажиллуулагч дараахь үүрэг хүлээнэ:

1) гэрээгээр тодорхойлсон хөлсийг төлөх;

2) гэрээнд заасан бол эд хөрөнгийн дэмжлэг үзүүлэх;

3) хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол ажиллаг гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх явцдаа нас барсан үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчнөө өвчилсний улмаас учирсан хохирлыг арилгах.

2. Хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол ажиллуу лагч нь үүргийн гүйцэтгэлийг шаардах эрхээ ажиллагчий зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд шилжүүлэх эрхгүй.

3. Ажиллуулагч хууль буюу гэрээгээр хүлээсэн үүргээ өөрчвөл ажиллагч нь учирсан хохирол, зардлыг төлүүлэх, өсхүл гэрээг цуцалж, учирсан хохирол, зардлыг төлүүлэхээр шаардах эрхтэй.

IV ДЭД ХЭСЭГ

ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДСОН ГЭРЭЭНИЙ ҮҮРЭГ

ГУЧИНЗУРГАДУГААР БҮЛЭГ

Тээвэрлэлт

313 дугаар зүйл. Тээвэрлэлтийн гэрээ

1. Ачаа тээвэрлэлтийн гэрээгээр тээвэрлэгч нь ачаа тээвэрлүүлэгчээс итгэмжлэн өгсөн ачааг дурдсан газар хүргэж, эх бүхий этгээдэд хүлээлгэн өгөх; гэрээнд өөрөөр заагаагүй бол ачаа тээвэрлүүлэгч нь тогтоосон хөлсийг төлөх үүрэг тус тус хүлээнэ.

2. Зорчигч тээвэрлэх гэрээгээр тээвэрлэгч нь зорчигчийг үрвэл зохих газар нь маршрутын дагуу тээвэрлэн хүргэх, өрөв зорчигч тээш өгсөн бол түүнийг дурдсан газар хүргэж, орчигч буюу зохих эрх бүхий этгээдэд хүлээлгэн өгөх; рээнд өөрөөр заагаагүй бол зорчигч нь тээвэрлэлтийн хөлийг төлөх үүргийг тус тус хүлээнэ.

3. Ачаа, зорчигч, тээшийг тээвэрлэх нөхцөл, тээвэрлэлийн талаар талуудын хүлээх хариуцлага нь хууль, хуульд ийцсэн тодорхой төрлийн тээврийн дүрэм ба тогтоосон үрмаар батлагдсан бусад дүрмээр тодорхойлогдоно.

4. Хуульд өөрөөр заагаагүй бол тээвэрлэгч нь тээвэрлэлийн талаархи; тээвэрлүүлэгч нь ачаа, тээшийн талаархи дээллийг харилцан солилцоно.

314 дүгээр зүйл. Тээвэрлэлтийн гэрээний хэлбэр

Тээвэрлэлтийн гэрээ нь энэ хуулийн 39 дүгээр зүйлд асан хэлбэртэй байна.

315 дугаар зүйл. Тээвэрлэлтийн хөлс

1. Тээвэрлэлтийн хөлсийг талууд тохиролцон тогтооно.

2. Тээвэрлүүлэгчийн тээвэрлүүлэхээр өгсөн ачааг тээлэгч тээвэрлэлтийн хөлс болон бусад төлбөрийн барьанд барьж болно.

316 дугаар зүйл. Тээвэрлэлтийн хугацаа, түүнийг зөрчсөний хариуцлага

1. Хуульд өөрөөр заагаагүй бол тээвэрлэгч үүргээ гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэх үүрэгтэй.

2. Тээвэрлэгч хугацаа зөрчсөн бол хууль буюу гэрээнд заасан хариуцлага хүлээнэ.

3. Хугацаа хожимдуулсан нь өөрийнх нь буруугаас болоогүй бол тээвэрлэгч хариуцлагаас чөлөөлөгдөнө.

4. Тээвэрлэгч маршрут зөрчсөн бөгөөд гэрээнд заасан бол хариуцлага хүлээнэ.

317 дугаар зүйл. Зорчигчийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд гэм хор учруулсан хариуцлага

Зорчигчийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд гэм хор учруулснаас тээвэрлэгчийн хүлээх хариуцлага нь бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд гэм хор учруулснаас үүсэх үүргийн тухай хэм хэмжээгээр тодорхойлогдоно.

318 дугаар зүйл. Ачаа буюу тээшийг алдаж дутагдуулсан, гэмтээснээс үүсэх хариуцлага

Хуульд өөрөөр заагаагүй бол тээвэрлэгч тээвэрлэхээр хүлээн авсан ачаа, тээшийг алдсан, дутагдуулсан бол үнийг хоёр нугалж; гэмтээсэн бол гэмтээсэн ачаа, тээшийн үнийг төлүүлэхээр тээвэрлүүлэгч шаардах эрхтэй.

319 дүгээр зүйл. Тээвэрлэлтийн талаар гаргах гомдлын шаардлага, нэхэмжлэл

1. Тээвэрлүүлэгч нь тээвэрлэлтийн талаар шүүхэд нэхэмжлэл гаргахын өмнө тээвэрлэгчид гомдлын шаардлага гаргана.

2. Гомдлын шаардлагыг түүнийг гаргах эрх үүссэн өдрөөс эхлэн зургаан сарын дотор гаргана. Хууль болон гэрээнд анз төлөхөөр заасан бол энэ тухай гомдлын шаардлагыг дөчин тав хоногийн дотор гаргана.

3. Тээвэрлэгч нь гомдлын шаардлагыг хүлээн авч, түүнийг хангах буюу няцаах тухай хариуг гурван сарын дотор тээвэрлүүлэгчид мэдэгдэнэ. Харин хэд хэдэн төрлийн тээвэрийг нэг бичиг баримт бичгээр гүйцэтгэж байгаа тээвэрлэлтийн талаар гаргасан гомдлын шаардлагад зургаан сарын

дотор, анз төлүүлэх тухай гомдлын шаардлагад дөчин тав хоногийн дотор хариу мэдэгдэх үүрэгтэй.

4. Гомдлын шаардлагыг няцаасан, эсхүл энэ зүйлд заасан хугацаанд хариу өгөөгүй бол тээвэрлүүлэгч хариу авсан буюу гомдлын шаардлага гаргах хугацаа дууссан өдрөөс эхлэн нэг жилийн дотор шүүхэд нэхэмжлэл гаргана.

5. Тээвэрлэгч нь ачаа тээвэрлүүлэгч, хүлээн авагч, зорчигчдод тээвэрлэлттэй холбогдуулан гаргах гомдлын шаардлага, нэхэмжлэлд энэ зүйлийн заалт хамаарна.

320 дугаар зүйл. Тээвэрлэлтийг зохион байгуулах тухай гэрээ

1. Ачааг байнга тээвэрлэх шаардлагатай бол тээвэрлэгч, тээвэрлүүлэгчийн хооронд тээвэрлэлтийг байнга буюу тодорхой хугацаанд зохион байгуулах тухай гэрээ байгуулж болно.

2. Тээвэрлэлтийг зохион байгуулах гэрээнд тээврийн хэрэгсэл олгох, тээвэрлүүлэх ачааг шилжүүлэх хугацаа, ачааны хэмжээ болон бусад нөхцөлүүд, түүнчлэн тодорхой төрлийн тээврийн дүрэм, журамд заагаагүй тээвэрлэлтийг зохион байгуулах бусад нөхцөлийг заана.

3. Тээвэрлэлтийг зохион байгуулах тухай гэрээнд энэ хуулийн 314-өөс 319 дүгээр зүйлийн заалт нэг адил хамаарна.

ГУЧИНДОЛДУГААР БҮЛЭГ

Даалгавар

321 дүгээр зүйл. Даалгаврын гэрээ

1. Даалгаврын гэрээгээр даалгавар гүйцэтгэгч нь даалгавар өгөгчийн нэрийн өмнөөс, түүний зардлаар тодорхой үйлдэл хийх; хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол даалгавар өгөгч нь хөлс төлөх үүрэг тус тус хүлээнэ.

2. Хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол даалгавар гүйцэтгэгч даалгаврыг биечлэн гүйцэтгэх үүрэгтэй. Ямар ч үед даалгавар өгөгч даалгавраа цуцлах, даалгавар гүйцэтгэгч даалгавраас татгалзах эрхтэй. Энэ эрхийг хязгаарлах гэрээ хүчин төгөлдөр бус байна.

3. Даалгавар өгөгч өөрийн ашиг сонирхлыг өөрөөр хамгаалах боломжоо алдсан үед даалгавраас татгалзсан даалгавар

гүйцэтгэгч ийнхүү татгалзсанаас учирсан хохирлыг даалгавар өгөгчид төлөх үүрэгтэй.

322 дугаар зүйл. Даалгавар гүйцэтгэгчийн үүрэг

1. Даалгавар гүйцэтгэгч даалгаврыг даалгавар өгөгчийн зааврын дагуу гүйцэтгэх үүрэгтэй. Даалгавар өгөгчийн ашиг сонирхлын үүднээс түүний өгсөн зааврыг өөрчлөх зайлшгүй шаардлагатай бөгөөд энэ талаар урьдчилан мэдэгдэх боломжгүй байсан, эсхүл мэдэгдсэн боловч зохих хугацаанд хариу аваагүй бол даалгавар гүйцэтгэгч уг зааврыг өөрчлөх эрхтэй.

2. Даалгавар гүйцэтгэгч нь даалгавар өгөгчийн шаардлагаар гүйцэтгэж байгаа ажлын явцын талаар мэдээлэх, даалгавар гүйцэтгэхтэй холбогдуулан хүлээж авсан бүх зүйлийг даалгавар өгөгчид нэн даруй шилжүүлэх үүрэгтэй.

323 дугаар зүйл. Даалгавар өгөгчийн үүрэг

Даалгавар өгөгч нь өгсөн даалгаврынхаа гүйцэтгэлийг хүлээн авах үүрэгтэй. Түүнчлэн гэрээнд өөрөөр заагаагүй бол даалгавар гүйцэтгэхэд зайлшгүй шаардагдах зүйлийг даалгавар гүйцэтгэгчид олгох, даалгавар гүйцэтгэхтэй холбогдон гарсан зайлшгүй зардлыг даалгавар гүйцэтгэгчид төлөх үүрэгтэй.

324 дүгээр зүйл. Даалгавар өөрчлөгдөх

Даалгавар бүрэн гүйцэтгэгдээгүй байхад даалгавар өгөгч нь түүнийг өөрчилбөл даалгавар гүйцэтгэгчид учирсан хохирлыг төлөх ба хөлс өгөхөөр тохиролцсон байсан бол гүйцэтгэсэн даалгаврын хэмжээгээр түүнийг төлөх үүрэгтэй.

325 дугаар зүйл. Даалгавар гүйцэтгэгч нь даалгавар гүйцэтгэхээс татгалзах

Даалгавар гүйцэтгэгч нь өгсөн даалгаврыг гүйцэтгэхээс татгалзвал түүнийг гүйцэтгэхтэй холбогдуулан авсан зүйлийг гүйцэтгээгүй даалгаврын хэмжээгээр даалгавар өгөгчид буцааж өгөх үүрэгтэй.

326 дугаар зүйл. Даалгавар гүйцэтгэгч нас барах буюу хуулийн этгээд татан буугдах

1. Даалгавар гүйцэтгэгч иргэн нас барвал түүний өв залгамжлагч нь гэрээ дуусгавар болсон тухай даалгавар

өгөгчид мэдэгдэж, түүний эд хөрөнгийг хамгаалах арга хэмжээ авах үүрэгтэй.

2. Даалгавар гүйцэтгэгч хуулийн этгээд татан буугдвал энэ үүргийг татан буулгах комисс, эсхүл татан буулгах ажлыг эрхлэн явуулж байгаа этгээд энэ тухай даалгавар өгөгчид мэдэгдэж, түүний эд хөрөнгийг хамгаалах арга хэмжээ авах үүрэгтэй.

327 дугаар зүйл. Даалгаврыг өөр этгээдэд шилжүүлэх

1. Гэрээнд заасан буюу даалгавар өгөгч эрх олгосон, эсхүл даалгаврыг биечлэн гүйцэтгэх боломжгүй болсон үед түүнийг өөр этгээдээр гүйцэтгүүлэх нь даалгавар өгөгчийн ашиг сонирхолд нийцэж байвал даалгавар гүйцэтгэгч нь түүнийг гүйцэтгүүлэхээр өөр этгээд (орлон гүйцэтгэгч)-эд шилжүүлж болно.

2. Даалгаврыг бүрэн буюу түүний зарим хэсгийг орлон гүйцэтгэгчид шилжүүлсэн даалгавар гүйцэтгэгч энэ тухай даалгавар өгөгчид даруй мэдэгдэх ба орлон гүйцэтгэгчийн талаар даалгавар өгөгчийг мэдээллээр хангах үүрэгтэй.

3. Даалгавар гүйцэтгэгч даалгаврыг гүйцэтгэх шаардлага хангахгүй этгээдийг орлон гүйцэтгэгчээр сонгон авснаас уг даалгавар гүйцэтгэгдээгүй буюу зохих ёсоор гүйцэтгэгдээгүй байвал хариуцлагыг өөрөө хүлээнэ.

4. Даалгавар гүйцэтгэгч нь энэ зүйлийн 1, 2 дахь хэсгийн заалтыг зөрчсөн бол орлон гүйцэтгэгчийн гүйцэтгэвэл зохих үүргийг өөрийн үүргийн нэгэн адил хариуцна.

5. Даалгавар өгөгч нь даалгавар гүйцэтгэгчийн сонгон авсан орлон гүйцэтгэгчийг хэдийд ч өөрчлөх эрхтэй.

328 дугаар зүйл. Даалгаврын гэрээ дуусгавар болох

Даалгаврын гэрээ энэ хуулийн 195. 197-гоос 201 дүгээр зүйлд зааснаас гадна дор дурдсан үндэслэлээр дуусгавар болно:

1) даалгавар өгөгч даалгавраа өөрчилсөн;

2) даалгавар гүйцэтгэгч нь даалгавар биелүүлэхээс татгалзсан;

3) талуудын аль нэг нь болох иргэн эрхийн бүрэн адамжгүйд, эсхүл сураггүй алга болсонд тооцогдсон, үүнчлэн нас барсан, нас барсан гэж зарлагдсан;

4) талуудын аль нэг нь болох хуулийн этгээд татан буугдсан.

329 дүгээр зүйл. Бусдын үүргийг даалгаваргүйгээр гүйцэтгэх

1. Зохих бүрэн эрхгүй атлаа өөр этгээдийн ашиг сонирхлын үүднээс хэлцэл хийсэн этгээдийн үйл ажиллагааг тухайн этгээд хожим хүлээн зөвшөөрвөл уг хэлцлийг хийхэд гарсан бүх зардлыг төлөх үүрэгтэй. Иймхүү хүлээн зөвшөөрөөгүй бол ашиг сонирхлынх нь үүднээс хэлцэл хийгдсэн этгээд уг хэлцэл хийснээс олсон ашгийн хэмжээнд зайлшгүй зардлыг төлнө.

2. Бусдын эд хөрөнгөнд хохирол учирч болзошгүй бодитой аюулын тухай өмчлөгч буюу эзэмшигчид нь урьдчилан мэдэгдэх боломжгүй нөхцөлд уг аюулыг зайлуулсан зохих бүрэн эрхгүй этгээд зардал, хохирлоо төлүүлэхийг өмчлөгч буюу эзэмшигчээс шаардах эрхтэй. Иймхүү төлөх хохирлын хэмжээ нь учрах байсан хохирлын хэмжээнээс хэтэрч болохгүй.

ГУЧИННАЙМДУГААР БҮЛЭГ

Зуучлал

330 дугаар зүйл. Зуучлалын гэрээ

Зуучлалын гэрээгээр зууч нь зуучлуулагчаас олгосон бүрэн эрхийн дагуу, түүний ашиг сонирхлын төлөө хэлцэл хийх этгээдтэй холбож өгөх; зуучлуулагч нь гэрээнд өөрөөр заагаагүй бол хөлс төлөх үүргийг тус тус хүлээнэ.

331 дүгээр зүйл. Зуучлалын гэрээний хэлбэр

Хуульд өөрөөр заагаагүй бол зуучлалын гэрээг байгуулахад энэ хуулийн 39 дүгээр зүйлийг баримтална.

332 дугаар зүйл. Зуучийн үүрэг

1. Зууч нь зуучлуулагчийг гуравдагч этгээдтэй гэрээ хийлгэхээр тохиролцож, түүнийгээ тодорхой хэлбэрээр нотлох үүрэгтэй. Хуульд өөрөөр заагаагүй бол ийнхүү нотлох хэлбэрийг гэрээгээр тодорхойлно. Ийнхүү нотолж чадаагүй бол зуучийг үүргээ гүйцэтгээгүй гэж үзнэ.

2. Зууч нь зуучлуулагчийн итгэмжлэн өгсөн мэдээллийн нууцыг хадгалах, түүний ашиг сонирхолд харш мэдээллийг

ашиглахгүй байх үүрэгтэй ба энэ үүргээ зөрчвөл зуучлуулагч нь гэрээг цуцалж, учирсан хохирлыг төлүүлэхээр шаардах эрхтэй.

3. Зууч нь зуучлалтай холбогдуулж зуучлуулагчийн өгсөн зааврыг биелүүлнэ. Энэ заавар нь хууль зөрчсөн буюу зуучлалын үйл ажиллагаа явуулах боломжгүйд хүргэвэл зууч нь гэрээг цуцалж, учирсан хохирлыг төлүүлэхээр шаардах эрхтэй. Ийнхүү буруу зааварласнаас үүсэх хариуцлагыг зууч гуравдагч этгээдийн өмнө хүлээхгүй.

4. Зууч үүргээ гүйцэтгэхээс үндэсгүйгээр татгалзвал зуучлуулагч гэрээг цуцлах, хөлс төлөхөөс татгалзах эрхтэй.

5. Зууч нь гуравдагч этгээдэд гэрээгээр шилжүүлэхээр зуучлуулагчаас олгосон эд хөрөнгийг өөрөө худалдаж авах эрхгүй. Зууч энэ заалтыг зөрчвөл уг эд хөрөнгө (боломжгүй бол түүний үнэ)-ийг зуучлуулагчид буцаан өгч, зууч орлого олсон бол түүнийг улсын орлогод хураана.

6. Зууч нь гагцхүү зуучлуулагчийн ашиг сонирхлын төлөө ажиллах ба гэрээ байгуулагч гуравдагч этгээдийн зуучийн үүргийг давхар гүйцэтгэж болохгүй. Энэ заалтыг зөрчвөл зуучлуулагч нь гэрээг цуцалж, учирсан хохирлоо төлүүлэх эрхтэй ба гуравдагч этгээдээс зуучийн авсан хөлсийг улсын орлогод хураана.

7. Энэ зүйлд зааснаас өөр үүргийг гэрээгээр тодорхойлж болно.

333 дугаар зүйл. Зуучлуулагчийн үүрэг

1. Зуучлуулагч нь зуучийг үүргээ биелүүлэхэд зайлшгүй шаардлагатай мэдээлэл, бусад нөхцөлөөр хангах үүрэгтэй ба энэ үүргээ биелүүлэхгүй бол зуучлагч нь гэрээг цуцлах эрхтэй.

2. Зуучлуулагч нь хууль буюу гэрээнд заасны дагуу хөлсийг тогтоосон хугацаанд төлөх бөгөөд энэ үүргээ биелүүлэхгүй бол зууч учирсан хохирлыг төлүүлэхээр шаардах эрхтэй.

334 дүгээр зүйл. Зуучлах үүргийг өөр этгээдэд шилжүүлэх

Зуучлах үүргийг өөр этгээдэд шилжүүлэхэд энэ хуулийн 187 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

ГУЧИНЕСДҮГЭЭР БҮЛЭГ

Комисс

335 дугаар зүйл. Комиссын гэрээ

1. Комиссын гэрээгээр комисс нь үйлчлүүлэгчийн даалгавар, зардлаар өөрийн нэрийн өмнөөс нэг ба хэд хэдэн хэлцэл хийх; үйлчлүүлэгч нь хөлс төлөх үүрэг тус тус хүлээнэ.

2. Үйлчлүүлэгчээс шалтгаалж комиссын гэрээ биелэгдээгүй бол комисс нь зохих хөлс авах, гарсан зардлыг нөхөн төлүүлэхээр шаардах эрхтэй.

3. Комиссын гэрээг бичгээр хийнэ.

336 дугаар зүйл. Комисс даалгавар гүйцэтгэх

1. Комисс нь даалгаврыг үйлчлүүлэгчийн зааврын дагуу түүнд аль болох ашигтайгаар гүйцэтгэх үүрэгтэй.

2. Үйлчлүүлэгчид илэрхий ашигтай бөгөөд энэ тухай түүнд урьдчилан мэдэгдэх боломжгүй, эсхүл хариуг зохих хугацаанд авааагүй бол комисс нь үйлчлүүлэгчийн зааврыг өөрчлөх эрхтэй.

3. Үйлчлүүлэгчийн даалгаснаас илүү ашигтай нөхцөлөөр хэлцэл хийсэн бөгөөд гэрээнд өөрөөр заагаагүй бол олсон ашгийг талууд тэнцүү хуваах авна.

337 дугаар зүйл. Үйлчлүүлэгчийн эд хөрөнгийн талаар комиссын гүйцэтгэх үүрэг

1. Үйлчлүүлэгчээс ирүүлсэн, эсхүл үйлчлүүлэгчид зориулан ирүүлсэн эд хөрөнгийг комисс хүлээн авах үед уг эд хөрөнгөд байсан чанарын дутагдал ердийн үзлэгээр илэрсэн бол комисс энэ тухай үйлчлүүлэгчид даруй мэдэгдэнэ.

2. Бусад этгээд үйлчлүүлэгчийн эд хөрөнгөд хохирол учруулсан бол комисс нь үйлчлүүлэгчийн эрхийг хамгаалах арга хэмжээ авч, энэ тухай холбогдох баримт цуглуулж, үйлчлүүлэгчид даруй мэдэгдэнэ.

3. Энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан үүргээ гүйцэтгээгүй бол үүнтэй холбогдон гарсан хохирлыг комисс нь үйлчлүүлэгчид төлнө.

4. Үйлчлүүлэгчийн эд хөрөнгө алдагдсан буюу гэмтсэн нь өөрийнх нь буруугаас болоогүй гэдгийг нотолж чадахгүй бол комисс үйлчлүүлэгчийн өмнө хариуцлага хүлээнэ.

5. Тухайн эд хөрөнгийг заавал даатгуулах тухай хуулийн заалт, эсхүл энэ талаар өгсөн үйлчлүүлэгчийн зааврыг биелүүлээгүй комисс нь үүнээс үүсэх хариуцлагыг үйлчлүүлэгчийн өмнө хүлээнэ.

338 дугаар зүйл. Үйлчлүүлэгч иргэн нас барсан, нас барсан гэж зарлагдсан, сураггүй алга болсонд буюу иргэний эрх зүйн эрхийн бүрэн чадамжгүйд тооцогдсон, хуулийн этгээдийн үйл ажиллагаа зогссон үед комиссын хүлээх үүрэг

Үйлчлүүлэгч иргэн нас барсан, нас барсан гэж зарлагдсан, сураггүй алга болсонд буюу эрхийн бүрэн чадамжгүйд тооцогдсон, түүнчлэн хуулийн этгээдийн үйл ажиллагаа зогссон үед үйлчлүүлэгчийн эрх залгамжлагч буюу түүний төлөөлөгчөөс зохих заавар иртэл комисс даалгаврыг үргэлжлүүлэн гүйцэтгэж байх үүрэгтэй.

339 дүгээр зүйл. Гуравдагч этгээд үүргээ гүйцэтгээгүйгээс үүсэх хариуцлага

1. Даалгаврыг гүйцэтгэхийн тулд комиссоос гуравдагч этгээдтэй хийсэн хэлцлээр хүлээсэн үүргээ уг этгээд гүйцэтгээгүй бол комисс энэ тухай үйлчлүүлэгчид даруй мэдэгдэж шаардагдах баримт, мэдээллийг цуглуулж, түүнд шилжүүлэх үүрэгтэй. Мэдээллийг хүлээн авсан үйлчлүүлэгч дурдсан хэлцлийн дагуу гуравдагч этгээдэд тавибал зохих шаардлагыг өөртөө шилжүүлэн авахыг комиссоос шаардах эрхтэй.

2. Гуравдагч этгээд үүргээ гүйцэтгээгүйн хариуцлагыг өөртөө хүлээхээр комисс батлан даалт гаргасан бол тэрээр уг хариуцлагыг хүлээнэ.

340 дүгээр зүйл. Комиссийн олсон зүйлийг үйлчлүүлэгч өмчлөх

1. Үйлчлүүлэгч нь комисст шилжүүлсэн өөрийн эд хөрөнгө, түүнчлэн комиссоос үйлчлүүлэгчийн зардлаар олсон зүйлийг өмчлөх эрхтэй.

2. Комисс нь өөрт төлөх төлбөрийн шаардлагаа хангуулахын тулд комиссийн гэрээний зүйлийг барьцаанд авах эрхтэй.

341 дүгээр зүйл. Үйлчлүүлэгч даалгаврын биелэлтийг хүлээн авах

1. Комисс даалгавар гүйцэтгэмэгц гүйцэтгэсэн даалгаврынхаа талаар үйлчлүүлэгчид тайлагнахын хамт олсон бүх зүйлээ түүнд шилжүүлэх үүрэгтэй.

2. Даалгаврыг гүйцэтгэхийн тулд комиссоос гуравдагч этгээдтэй хийсэн хэлцлээс үүссэн эрхийг шилжүүлэхийг үйлчлүүлэгч шаардвал комисс түүнийг биелүүлэх үүрэгтэй. Үйлчлүүлэгч нь ийнхүү эрх шилжүүлэн авбал хэлцлийн дагуу комиссийн хүлээсэн үүргийг нэг адил хүлээн авах үүрэгтэй.

3. Комиссоос шилжүүлж байгаа эд хөрөнгийг хүлээн авах үед илэрсэн дутагдлын талаар үйлчлүүлэгч комисст даруй мэдэгдэх үүрэгтэй.

4. Комиссийн тайланд дурдсан үйл ажиллагааг бүхэлд нь буюу түүний зарим хэсгийг зөвшөөрөхгүй бол үйлчлүүлэгч түүнийг хүлээн авсан өдрөөс хойш гурван сарын дотор энэ тухай комисст мэдэгдэх үүрэгтэй. Дээрх хугацаанд үйлчлүүлэгч тайлангийн талаар санал ирүүлээгүй бөгөөд гэрээнд өөрөөр заагаагүй бол түүнийг хүлээн авсан гэж үзнэ.

342 дугаар зүйл. Комиссийн хөлс, зардал

1. Комисс даалгаврыг гүйцэтгэсний дараа комиссийн хөлс, даалгавар биелүүлэхтэй холбогдон гарсан зардал төлөхийг үйлчлүүлэгчээс шаардах эрхтэй. Үйлчлүүлэгчийн эд хөрөнгийг хадгалж байсны зардлыг гэрээнд заасан бол комисст төлнө.

2. Комисс гуравдагч этгээдтэй хийсэн хэлцлийн биелэлтийг өөрөө хүлээхээр батлан даасан бол ийнхүү батлан даасны хөлсийг шаардан авах эрхтэй.

3. Комиссийн хөлс, түүнчлэн гуравдагч этгээдтэй хийсэн гэрээг комисс батлан даасны хөлсний хэмжээг талууд хэлэлцэн тогтоох ба ийнхүү тогтоогоогүй бол талуудын аль нэгний хүсэлтээр шүүх, арбитр тогтоож болно.

343 дугаар зүйл. Комисс даалгавар гүйцэтгэхээс татгалзах буюу гүйцэтгэх боломжгүй болсноос комиссийн гэрээ дуусгавар болох

1. Үйлчлүүлэгч гэрээг зөрчсөн бол комисс нь даалгавар гүйцэтгэхээс татгалзах эрхтэй.

2. Комисс даалгавар гүйцэтгэхээс татгалзаж байгаагаа үйлчлүүлэгчид бичгээр мэдэгдэх бөгөөд үйлчлүүлэгч түүнийг хүлээн авсан өдрөөс хойш хоёр долоо хоног өнгөрмөгц уг гэрээ дуусгавар болно.

3. Комисс нь даалгавар гүйцэтгэхээс татгалзсан тохиолдолд хөлс, зардлаа гүйцэтгэсэн даалгаврын хэмжээгээр үйлчлүүлэгчээс шаардах эрхтэй.

4. Даалгавар гүйцэтгэх боломжгүй болсон нь комиссийн буруугаас болоогүй бол тэрээр гаргасан зардлаа үйлчлүүлэгчээр төлүүлж, гүйцэтгэсэн даалгаврын хэмжээгээр хөлс шаардах эрхтэй.

5. Комиссийн буруугаас болж даалгавар гүйцэтгэх боломжгүй болсон бөгөөд гэрээнд өөрөөр заагаагүй бол комисс нь даалгаврын гүйцэтгэсэн хэсэгт оногдох хөлс, зардлыг тооцон, үйлчлүүлэгчид учирсан хохирлыг төлөх үүрэгтэй.

ДӨЧДҮГЭЭР БҮЛЭГ

Хадгалалт

344 дүгээр зүйл. Хадгалалтын гэрээ

Хадгалалтын гэрээгээр хадгалагч нь хадгалуулагчаас шилжүүлсэн эд хөрөнгийг хадгалах ба түүнийг хадгалуулагчид буцааж өгөх буюу эрх бүхий этгээдэд шилжүүлэн өгөх үүрэг хүлээнэ.

345 дугаар зүйл. Хадгалалтын гэрээний хэлбэр

1, Хадгалалтын гэрээг энэ хуулийн 39 дүгээр зүйлд заасан хэлбэрээр хийнэ.

2. Хуульд заасан хэлбэрээр хийгээгүй хадгалалтын гэрээний талаар талууд маргавал дараахь тохиолдолд гэрчээр нотлуулах эрхээ алдахгүй:

1) гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдалд эд хөрөнгөө хадгалуулахаар шилжүүлсэн;

2) хадгалуулахаар шилжүүлсэн эд хөрөнгө мөн эсэхийг тогтоох;

3) автомат хадгалагчид эд хөрөнгөө хадгалуулахаар шилжүүлсэн.

346 дугаар зүйл. Хадгалалтын хөлс

Хуульд өөрөөр заагаагүй бол эд хөрөнгө хадгалсны

хөлс төлөхөөр талууд тохиролцож болно. Энэ тохиолдолд хөлсний хэмжээ, төлөх арга, журам, хугацааг гэрээгээр тодорхойлно.

347 дугаар зүйл. Хадгалалтын гэрээний хугацаа

1. Хадгалалтын гэрээг тодорхой буюу тодорхой бус хугацаагаар байгуулж болно.

2. Тодорхой бус хугацаагаар байгуулсан гэрээг талууд хэдийд ч дуусгавар болгох эрхтэй боловч нөгөө талдаа үүрэг гүйцэтгэх боломжийн хугацаа олгоно.

348 дугаар зүйл. Хадгалагч, түүний үүрэг

1. Хадгалагч нь дараахь этгээд байж болно:

1) хадгалалтын үйл ажиллагаа явуулах үндсэн чиг үүрэг бүхий иргэн, хуулийн этгээд;

2) үндсэн үйл ажиллагааныхаа зэрэгцээ хадгалалтын үүрэг гүйцэтгэдэг иргэн, хуулийн этгээд;

3) бусдын эд хөрөнгийг хадгалах үүргийг гэрээгээр хүлээсэн иргэн.

2. Хуульд өөрөөр заагаагүй бол хадгалагч дор дурдсан үүрэг хүлээнэ:

1) хадгалуулахаар шилжүүлсэн эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах;

2) хадгалуулагчийн шаардсан үед эд хөрөнгийг буцааж өгөх буюу эрх бүхий этгээдэд шилжүүлэх.

3. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасан этгээд нь хадлахаар хүлээн авсан эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангахад шаардагдах бүхий л арга хэмжээг авах үүрэгтэй.

4. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн 2, 3-т заасан этгээд нь хөлсгүй хадгалахаар хүлээн авсан эд хөрөнгийг өөрийн эд хөрөнгөтэй адил нөхцөлөөр хадгалах, хэрэв хөлсөөр хадгалж байгаа бол эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах талаар өөрөөс хамаарах боломжийн бүхий л арга хэмжээг авах үүрэгтэй.

349 дүгээр зүйл. Хадгалагчийн эрх

1. Хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол хадгалагч дор дурдсан эрх эдэлнэ:

1) хадгалуулахаар шилжүүлсэн эд хөрөнгө, түүний үр шим, үр төлийг ашиглах;

2) хадгалалтын хөлсийг шаардах.

2. Хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол хадгалагч хадгалалтын зардлыг хадгалуулагчаар төлүүлэхээр шаардах эрхтэй.

350 дугаар зүйл. Хадгалуулагчийн үүрэг

Хадгалуулагч дор дурдсан үүрэг хүлээнэ:

1) хадгалуулахаар шилжүүлсэн эд хөрөнгөө тогтоосон хугацаанд нь буцаан авах;

2) хууль буюу гэрээнд заасан бол хадгалагчид хөлс төлөх;

3) хадгалалттай холбогдон гарсан зайлшгүй зардлыг хадгалагчид төлөх;

4) хадгалуулахаар шилжүүлсэн эд хөрөнгийн онцлог шинж чанар, хадгалах нөхцөл, журмын талаар хадгалагчид мэдээлэх;

5) гэрээ байгуулснаас хойш тодорхой хугацааны дараа эд хөрөнгөө хадгалалтанд шилжүүлэхээр тохиролцсон бол уг эд хөрөнгөө тогтоосон хугацаанд шилжүүлэх.

351 дүгээр зүйл. Хадгалуулагчийн эрх

Хадгалалтын гэрээний хугацаанаас үл хамааран хадгалуулагч хадгалуулахаар шилжүүлсэн эд хөрөнгөө буцааж авахаар хэдийд ч шаардах эрхтэй. Энэ тохиолдолд хадгалагчид үүргээ гүйцэтгэх боломжийн хугацаа олгоно.

352 дугаар зүйл. Хадгалалтын гэрээний талуудын харилцлага

1. Хадгалагч нь хадгалалтанд шилжүүлсэн эд хөрөнгийг алдсан, дутагдуулсан, гэмтээсэн бөгөөд гэрээнд өөрөөр заагаагүй бол хадгалуулагчид учирсан хохирлыг төлнө.

2. Эд хөрөнгийг хадгалалтад шилжүүлэх үед мэдэж байсан чанарын дутагдлын талаар хадгалуулагч нь хадгалагчид мэдэгдээгүй, эсхүл энэхүү дутагдлын талаар хадгалагч, хадгалуулагчийн хэн аль нь мэдээгүй буюу мэдэх боломжгүй байснаас шалтгаалан хадгалагчид учирсан хохирлыг хадгалуулагч төлөх үүрэгтэй.

3. Хадгалалтын болон эд хөрөнгийг хадгалуулахаар шилжүүлэх хугацааг хэтрүүлсэн тохиолдолд анз төлөхөөр тохиролцсон бол бууртай тал нь гэрээнд заасан анзыг төлнө.

4. Зочид буудал, нийтийн байр, амралт, сувиллын газар

болон түүнтэй адилтгах үйл ажиллагаа эрхэлдэг этгээд үйлчлүүлэгчид олгосон өрөө, тасалгаанд байгаа үйлчлүүлэгчийн мөнгө, үнэт эдлэлээс бусад эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах үүрэгтэй ба энэхүү үүргээ гүйцэтгээгүйгээс үйлчлүүлэгчид учирсан хохирлыг төлнө.

353 дугаар зүйл. Хадгалалтын гэрээний талуудыг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл

Хадгалагч дор дурдсан тохиолдолд хариуцлагаас чөлөөлөгдөнө:

1) энэ хуулийн 348 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасан этгээд нь хадгалуулагчийн шилжүүлсэн эд хөрөнгийг алдаж, дутагдуулж, гэмтээсэн нь гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлаас болсон гэдгийг нотолбол;

2) энэ хуулийн 348 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2, 3; 352 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан этгээд нь хадгалуулагчийн шилжүүлсэн эд хөрөнгийг алдаж, дутагдуулж, гэмтээсэнд гэм буруугүй болохоо нотолбол;

3) хадгалуулагч нь хадгалуулахаар шилжүүлсэн эд хөрөнгөө тогтоосон хугацаанд буцааж аваагүй байхад эд хөрөнгө алдагдаж, дутагдаж гэмтсэн нь хадгалагчийн санаатай буюу илтэд болгоомжгүй үйлдлээс болсон нь тогтоогдоогүй бол;

354 дүгээр зүйл. Хадгалалтад өгсөн эд хөрөнгөө буцааж аваагүйгээс үүсэх үр дагавар

1. Хадгалах хугацаа дууссан эд хөрөнгийг хадгалуулагч буцааж аваагүй бөгөөд хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол түүнийг буцааж авахыг хадгалагч гурван сарын хугацаанд хоёроос доошгүй удаа бичгээр урьдчилан мэдэгдсэний дараа уг эд хөрөнгийг дуудлагын буюу комиссийн худалдаагаар худалдах эрхтэй.

2. Худалдсан эд хөрөнгийн үнээс хадгалагч хууль буюу гэрээнд зааснаар өөрт ногдох хөлс, анз, зардлыг тооцон авч, илүү гарсныг хадгалуулагчид олгох, тийм боломжгүй бол улсын орлогод оруулна.

3. Худалдсан үнэ нь хадгалагчид төлбөл зохих төлбөрийг төлөхөд хүрэлцэхгүй бол зөрүүг хадгалуулагчаас шаардах эрхтэй.

355 дугаар зүйл. Хадгалалтын үүрэг үүсэх бусад үндэслэл

1. Дор дурдсан тохиолдолд хадгалалтын үүрэг үүсч болно:

1) энэ бүлэгт зааснаас өөр төрлийн гэрээ байгуулснаар;

2) хуульд заасан бусад үндэслэлээр

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу үүссэн хадгалалтын харилцаанд энэ бүлгийн заалт нэг адил хамаарна.

ДӨЧИННЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Асран тэтгэх

356 дугаар зүйл. Асран тэтгэх гэрээ

1. Асран тэтгэх гэрээгээр асран тэтгэгч нь асруулагчийг хоол хүнс, хувцас, орон сууцаар хангах, асрах, сувилах, эмнэлгийн туслалцааг өөрийн буюу асруулагчийн зардлаар үзүүлэх, нас барвал өөрийн зардлаар оршуулах; асруулагч нь гэрээгээр хэлэлцэн тохирсон мөнгийг асруулах хугацаанд байнга төлөх буюу эд хөрөнгийг асран тэтгэгчид өгөх үүрэг тус тус хүлээнэ.

2. Асруулагч нь өндөр нас, эрүүл мэндээс шалтгаалан бие даан амьдрах чадваргүй иргэн байна.

3. Асран тэтгэх гэрээг бичгээр хийж, нотариатаар гэрчлүүлнэ. Энэ шаардлагыг биелүүлээгүй гэрээ хүчин төгөлдөр бус байна.

4. Асран тэтгэх гэрээний биелэлтэд нутгийн захиргааны байгууллага хяналт тавина.

357 дугаар зүйл. Төрөл садангаа асран тэтгэх үүргээ шилжүүлэх

Иргэн өөрийн асрамжид байгаа төрөл садангийн хүний нэрийн өмнөөс гуравдагч этгээдтэй гэрээ байгуулж, асруулагчийн үүргийг өмчлөлдөө байгаа эд хөрөнгөөр хариуцах замаар асран тэтгэх үүргээ шилжүүлэх эрхтэй.

358 дугаар зүйл. Асран тэтгэгчийн хариуцлага

1. Асран тэтгэгч үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүйгээс асруулагчийн эрүүл мэнд муудахад хүрсэн тохиолдолд нутгийн захиргааны байгууллага асруулагчийг төлөөлөн гэрээг цуцлахаа шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.

2. Энэ үндэслэлээр гэрээг цуцлахад эд хөрөнгө, мөнгө, түүний хэсгийг асруулагчид эргүүлэн олгоно.

359 дүгээр зүйл. Асран тэтгэх гэрээ
дуусгавар болох

1. Асруулагч бие даан амьдрах чадвартай болсон, эсхүл нас барсан бол асран тэтгэх гэрээ дуусгавар болно.

2. Асран тэтгэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэхгүй байгаа буюу цаашид үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон бол асран тэтгэх гэрээг талуудын аль нэгний санаачилгаар цуцалж болно.

ДӨЧИНХОЁРДУГААР БҮЛЭГ

Даатгал

360 дугаар зүйл. Даатгалын зүйл

1. Даатгалын зүйл нь эд хөрөнгө, түүнчлэн хуульд харшлаагүй эд хөрөнгийн бус ашиг сонирхол байна.

2. Даатгалыг сайн дурын үндсэн дээр хийх бөгөөд хуульд заасан бол заавал даатгах даатгалын хэлбэртэй байж болно.

3. Даатгагч нь хуульд заасан шаардлага хангасан, даатгалын үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг эрх бүхий байгууллагаас авсан хуулийн этгээд байна.

361 дугаар зүйл. Даатгалын гэрээ

1. Даатгалын гэрээгээр даатгагч нь гэрээнд заасан даатгалын тохиолдол буй болоход даатгуулагч буюу ашиг сонирхлынх нь төлөө гэрээ байгуулагдсан этгээдэд учирсан хохирлыг бүрэн буюу зарим хэсгийг төлөх; даатгуулагч нь гэрээгээр тогтоосон даатгалын хураамжийг төлөх үүргийг тус тус хүлээнэ.

2. Эд хөрөнгийг бүрэн үнээр нь даатгуулаагүй тохиолдолд хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол хохирлыг даатгасан хэмжээгээр төлнө.

3. Гэрээнд заасан даатгалын үнэ нь даатгуулсан эд хөрөнгийн жинхэнэ үнээс өндөр байвал эд хөрөнгийн үнээс илүү гарсан хэсэгт нь гэрээ хүчин төгөлдөр бус байна.

4. Даатгагч нь гэрээнд заасан тохиолдол буй болмогц

даатгуулагч буюу эрх ашгийнх нь төлөө гэрээ байгуулагдсан этгээдэд нийгмийн даатгал, нийгмийн хангамжаас олгож байгаа мөнгөн хөрөнгөөс үл шалтгаалан гэрээнд заасан хохирлыг төлөх үүрэг хүлээнэ.

5. Хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол даатгалын хураамжийг төлөх хүртэл гэрээ хүчин төгөлдөр болохгүй.

6. Даатгалын зүйлийн онцлогтой холбоотой эрх, үүргийг хууль буюу гэрээгээр тусгайлан тодорхойлж болно.

7. Даатгалын гэрээг бичгээр байгуулна. Энэ шаардлагыг хангаагүй гэрээ хүчин төгөлдөр бус байна.

362 дугаар зүйл. Даатгалын тохиолдол бий болсноос үүсэх үр дагавар

1. Даатгалын тохиолдол бий болмогц даатгагч нь даатгуулагч буюу эрх ашгийнх нь төлөө гэрээ байгуулагдсан этгээдэд даатгалын төлбөр болон хохирлын хэмжээг багасгахын тулд гаргасан зайлшгүй зардлыг даатгалын төлбөрийн хэмжээнд нөхөн төлөх үүрэгтэй.

2. Хууль буюу гэрээнд заасан бол даатгуулагч даатгалын тохиолдол бий болсны дараа даатгасан хөрөнгийнхөө эрхээс татгалзаж, даатгалын төлбөрийг бүрэн хэмжээгээр авч болно.

3. Даатгагчаар төлбөрөө төлүүлсэн этгээдээс хохирол учруулсан этгээдэд шаардлага тавих эрх нь даатгалын төлбөрийн хэмжээгээр даатгагчид шилжинэ.

V ДЭД ХЭСЭГ

ЗӨӨЛ-ТООЦООНЫ ҮҮРЭГ

ДӨЧИНГУРАВДУГААР БҮЛЭГ

Төлбөр тооцоо

363 дугаар зүйл. Төлбөр тооцоо

1. Хуулийн этгээд, иргэд хоорондын бэлнээр хийх мөнгөн төлбөр тооцоог банкиар дамжуулан гүйцэтгэж болно.

2. Хуулийн этгээд оролцсон бэлэн бус хэлбэрээр хийх мөнгөн төлбөр тооцоог банкиар дамжуулан гүйцэтгэнэ.

3. Төлбөр хариуцагч нь төлбөрийг банкин дахь хадгаламжийн харилцах, зээлийн дансаар гүйцэтгэнэ.

4. Гэрээнд өөрөөр заагаагүй бол төлбөр хариуцагчийн

данснаас түүний зөвшөөрөлгүйгээр гүйлгээ хийхийг хориглоно. Шүүхийн шийдвэрээр хийгдэх гүйлгээнд энэ заалт хамаарахгүй.

5. Мөнгөн төлбөрийг төлбөр хариуцагчийн хадгаламжийн харилцах, зээлийн дансанд байгаа хөрөнгийн дүнд багтаан хууль ёсны бүрдэл болсон баримтыг үндэслэн гүйцэтгэнэ.

6. Банкнаар дамжуулан гүйцэтгэх төлбөр тооцооны үйл ажиллагааг хуулиар зохицуулна.

ДӨЧИНДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Мөнгөн хадгаламж

364 дүгээр зүйл. Мөнгөн хадгаламжийн гэрээ

1. Мөнгөн хадгаламжийн гэрээгээр банк нь хадгалуулагчийн мөнгийг хадгалах, түүнийг хадгалуулсан буюу эрх бүхий этгээдэд эргүүлэн өгөх, харин төлбөр (хүү) төлөх үүрэг хүлээнэ.

Мөнгөн хадгаламжийн гэрээнд хадгалалтын хугацаа, төлөх хүүгийн хувь, түүнийг тооцох журам, гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгээгүйн төлөө талуудын хүлээх хариуцлагыг заана.

3. Мөнгөн хадгаламжийн гэрээг бичгээр хийнэ.

365 дугаар зүйл. Мөнгөн хадгаламжийн гэрээний хугацаа

1. Мөнгөн хадгаламжийн гэрээг тодорхой буюу тодорхой бус хугацаагаар байгуулна.

2. Мөнгөн хадгаламжийн гэрээг тодорхой бус хугацаагаар байгуулсан бол хадгалагч нь хадгалуулагчийн хүссэн цагт түүний хадгалуулсан мөнгийг буцаан өгч, хүүг төлөх үүрэгтэй.

3. Мөнгөн хадгаламжийн гэрээг тодорхой хугацаагаар байгуулсан бол уг хугацаа дууссаны дараа хадгалуулагчийн анхны шаардлагаар хадгалагч нь мөнгийг буцаан өгч, хүүг төлөх үүрэгтэй.

4. Гэрээнд заасан хугацаа дууссан боловч хадгалуулагч хадгалуулсан мөнгөө буцаан авах шаардлага тавиагүй бол уг гэрээг цаашид тодорхой бус хугацаагаар сунгагдсанд тооцно.

5. Тодорхой хугацаагаар байгуулсан гэрээг хадгалагч

нэг талын санаачилгаар өөрчлөх ба хугацаанаас өмнө цуцлах эрхгүй.

6. Хадгалагч энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан үүргээ гүйцэтгээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүй бол хадгалуулагч учирсан хохирол, гэрээнд заасан бол анз төлүүлэхээр шаардах эрхтэй.

366 дугаар зүйл. Банкинд хадгалагдаж байгаа мөнгөн хөрөнгийг захиран зарцуулах

1. Банкинд мөнгөө хадгалуулж байгаа этгээд хуульд заасны дагуу уг мөнгөө захиран зарцуулна.

2. Хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол банк нь хадгалж байгаа мөнгөн хөрөнгийг өөрийн нэрийн өмнөөс гүйлгээнд оруулж ашиглах эрхтэй боловч хадгалуулагчаас мөнгөө захиран зарцуулах баталгааг хангах үүрэгтэй.

367 дугаар зүйл. Хадгалагч (банк)-ийн үүрэг

1. Банк нь хадгалуулагчийн нэр дээр данс нээж, мөнгөн хөрөнгийг хадгалах ба уг данснаас хадгалуулагчийн даалгаврааар гүйлгээ хийх үүрэгтэй.

2. Хуульд өөрөөр заагаагүй бол банк нь хадгалуулагчийн дансны нууцыг хадгалж, түүгээр хийсэн гүйлгээний талаархи, мэдээллийг задруулахгүй байх үүрэгтэй. Хадгалуулагч мөнгөө захиран зарцуулахад хадгалагч хяналт тавих, хөндлөнгөөс оролцох, саад хийх эрхгүй.

3. Хадгалагч энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан үүргээ гүйцэтгээгүй бол хадгалуулагч гэрээг цуцалж, учирсан хохирлыг төлүүлэхээр шаардах эрхтэй.

ДӨЧИНТАВДУГААР БҮЛЭГ

Банкнаас зээл олгох

368 дугаар зүйл. Банкнаас зээл олгох гэрээ

1. Банкнаас зээл олгох гэрээгээр банк нь өөрийн өмчлөл буюу эзэмшилд байгаа мөнгөн хөрөнгийг хуульд заасан үндэслэл, журмаар зээл авагч (иргэд, хуулийн этгээд, гөр)-ийн өмчлөл буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрх (энэ хуулийн 88 дугаар зүйл)-эд тодорхой хугацаагаар

шилжүүлэх; зээлдэгч нь тогтоосон хугацаанд уг мөнгийг буцааж өгөх үүрэг тус тус хүлээнэ.

2. Банкнаас олгох зээл нь хүүтэй буюу хүүгүй байж болно.

3. Банкнаас зээл олгох гэрээг бичгээр хийнэ. Энэ шаардлагыг биелүүлээгүй гэрээ хүчин төгөлдөр бус байна.

4. Банкнаас олгох зээлийн хүү нь гэрээний хугацаагаар тодорхойлогдоно.

5. Зээлдэгч нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацаанд авсан зээлээ эргүүлэн өгөөгүй бөгөөд энэ тохиолдолд зээлийн хүүг нэмэгдүүлэхээр гэрээнд заасан бол нэмэгдүүлсэн хүүгийн хэмжээг үндсэн хүүгийн хорин хувиас хэтрүүлэхгүйгээр тогтооно.

6. Гэрээ байгуулснаас хойш тодорхой хугацааны дараа зээлдэгчид мөнгийг шилжүүлэхээр тохиролцсон бөгөөд банк энэ үүргээ хугацаанд нь гүйцэтгээгүй бол зээлдэгч уг мөнгийг авахаар шаардах эрхтэй.

7. Банкнаас олгох зээлийн гэрээнд энэ хуулийн 180 190 дүгээр зүйл хамаарахгүй.

8. Банкны зээлийн үйл ажиллагааг хуулиар зохицуулна.

VI ДЭД ХЭСЭГ

БУСАД ГЭРЭЭНИЙ ҮҮРЭГ ДӨЧИНЗУРГАДУГААР БҮЛЭГ

Хамтран ажиллах

369 дүгээр зүйл. Хамтран ажиллах гэрээ

1. Хамтран ажиллах гэрээгээр талууд ашиг олох болон бусад тодорхой зорилгыг хэрэгжүүлэхийн тулд хамтран ажиллах үүрэг хүлээнэ.

2. Хамтран ажиллах гэрээг бичгээр үйлдэнэ.

3. Хамтран ажиллах тодорхой төрлийн гэрээний онцлогийг хуулиар тогтоож болно.

370 дугаар зүйл. Хамтран ажиллах

Гэрээнд өөрөөр заагаагүй бол хамтын үйл ажиллагаан талууд харилцан тохиролцож хэрэгжүүлнэ. Хамтын үйл ажиллагааг аль нэг оролцогч нь удирдах тухай гэрээнд заасан тохиолдолд уг этгээд тухайн үйл ажиллагааг удир-

дан гүйцэтгэнэ. Ийнхүү удирдахдаа гэрээнд оролцогчдоос олгосон итгэмжлэлийг үндэслэн үйл ажиллагаагаа явуулна.

371 дүгээр зүйл. Хамтран ажиллах гэрээнд оролцогчын дундын эд хөрөнгө

1. Хамтран ажиллахаар талуудын нэгтгэсэн мөнгөн болон бусад эд хөрөнгө, түүнчлэн хамтран ажиллаж бүтээсэн, олж авсан эд хөрөнгө нь тэдгээрийн хамтран, эсхүл хэсгээр өмчлөх дундын эд хөрөнгө байна.

2. Хамтран ажиллахад зориулан хуулийн этгээдүүдээс гаргасан эд хөрөнгийг гэрээгээр захиран зарцуулах эрх олгогдсон байгууллагад шилжүүлж болно.

3. Гэрээнд оролцогчийн хамтран ажиллах үйл ажиллагаатай холбоогүй төлбөрийг барагдуулах өөр эх үүсвэргүй бол тогтоосон журмын дагуу дундын эд хөрөнгөөс оногдох хэсгээр төлүүлж болно.

4. Дундын эд хөрөнгийг захиран зарцуулах журмыг гэрээгээр тодорхойлно.

372 дугаар зүйл. Хамтран ажиллах гэрээний бусад зохицуулалт

Хамтран ажиллах гэрээгээр олсон ашиг, алдагдал, бусад үр дагаврыг хуваарилах журмыг талууд харилцан тохиролцож тогтооно.

ДӨЧИНДОЛДУГААР БҮЛЭГ

Уралдаан

373 дугаар зүйл. Уралдаан зарлах

1. Ямар нэгэн ажлыг гүйцэтгэх тодорхой болзлыг хангавал шагнал буюу эрх олгохоор нийтэд зарласан иргэн, хуулийн этгээд нь уралдаанд зарласан болзлын ёсоор шалгарсан этгээдэд тухайн шагнал буюу эрхийг олгох үүрэг хүлээнэ.

2. Уралдааны болзолд ямар ажлыг хэдий хугацаанд гүйцэтгэх, тодорхой эрх олгох нөхцөл, шагналын тоо, хэмжээ, гүйцэтгэсэн ажил буюу төслийг шалгаруулж байр эзлүүлэх журам, хугацааг тодорхой заана. Уралдааны болзолд дээрхээс өөр нөхцөл зааж болно.

374 дүгээр зүйл. Уралдааны болзлыг өөрчлөх

1. Нэгэнт зарласан уралдааны болзлыг өөрийн хүсэл

зоригоос үл хамаарах шалтгаанаар зайлшгүй өөрчлөх шаардлагатай бол уг ажлыг гүйцэтгэн ирүүлэхээр тогтоосон хугацааны дотор өөрчилж болно.

2. Уралдаанд ирүүлбэл зохих ажлын талаар тавих шаардлага ихээхэн өөрчлөгдөхөөр байвал уг ажлыг гүйцэтгэн ирүүлэх хугацааг түүнд зохицуулан сунгана.

3. Уралдааны болзолд орсон өөрчлөлтийг уралдаан зарласан журмаар зарлана. Ийнхүү зарлаагүй бол уралдааны болзол өөрчлөгдсөн гэж үзэхгүй.

4. Уралдаан зарласан этгээд уралдаанд оролцогчоос түүнд оролцохыг зөвшөөрсөн хариу буюу холбогдох материалыг хүлээн авснаас хойш саналаасаа татгалзах эрхгүй. Ийнхүү татгалзсан тохиолдолд болзол хангасан оролцогч зарласан шагналыг авахаар шаардах эрхтэй.

5. Энэ зүйлд заасан журмыг уралдаан зарласан этгээд зөрчсөн бол түүнийг улмаас оролцогчдод учирсан хохирлыг төлөх үүрэгтэй.

375 дугаар зүйл. Уралдаанд шагнал авсан бүтээлийг ашиглах

Уралдаан зарласны дагуу зохиогчийн эрхэд хамаарах бүтээл туурвисан бөгөөд уг бүтээл нь уралдааны шагнал авсан бол уралдаан зарласан этгээд түүнийг уралдааны болзолд дурдсан аргаар ашиглах эрхтэй. Уралдааны болзолд өөрөөр заагаагүй бол энэхүү бүтээлийн зохиогч нь бүтээлээ ашиглуулсны хөлс, шагналыг авах эрхтэй.

376 дугаар зүйл. Уралдаанд ирүүлсэн ажлыг буцаан өгөх

Байр эзэлж тодорхой шагнал буюу эрх аваагүй ажил, түүнчлэн шагналд орсон буюу эрх авсан боловч дараа нь ашиглахаар болзолд зарлаагүй ажлыг уралдаан дуусмагц даруй буцаан өгнө.

V ХЭСЭГ

ГЭРЭЭНИЙ БУС ҮҮРЭГ

ДӨЧИННАЙМДУГААР БҮЛЭГ

Гэм хор учруулснаас үүсэх үүрэг

377 дугаар зүйл. Гэм хор учруулснаас хариуцлага хүлээх үндэслэл

1. Бусдын амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд,

ажил хэргийн нэр хүнд, эд хөрөнгөд гэм хор учруулсан этгээд уг гэм хорыг бүрэн хариуцаж арилгах үүрэгтэй.

2. Гэм хор учруулсан этгээд ийнхүү гэм хор учруулсан нь түүний буруугаас болоогүй гэдгийг нотолбол хуульд зааснаас бусад тохиолдолд ийнхүү гэм хор учруулсны хариуцлагыг хүлээхгүй.

3. Эрх үүргийнхээ ёсоор бусдад гэм хор учруулсан этгээд хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд уг гэм хорын хариуцлагаас чөлөөлөгдөнө.

4. Хэр хэмжээнээс хэтрээгүй бол аргагүй хамгаалалтын үед бусдад учруулсан гэм хорыг хариуцахгүй.

5. Гарцаагүй байдлын улмаас бусдад гэм хор учруулсан этгээдийг шүүх тухайн нөхцөл байдал, учирч болох байсан хохирлын хэмжээг харгалзан хариуцлагаас бүрэн буюу хэсэгчлэн чөлөөлж болно.

6. Хууль ёсны үйлдлийн улмаас учруулсан гэм хорыг хуульд тусгайлан заасан бол арилгуулж болно.

7. Гэм хорын хэмжээг гагцхүү шүүх тогтооно.

378 дугаар зүйл. Хуулийн этгээд бусдад гэм хор учруулсны хариуцлага

1. Ажиллагсдаас хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх явцад бусдад учруулсан гэм хорын хариуцлагыг түүний ажиллаж байгаа хуулийн этгээд хүлээнэ.

2. Төр, захиргааны байгууллага, түүний албан тушаалтан буруу шийдвэр гаргасан буюу өөр байдлаар албаны үйл ажиллагааг буруу явуулснаас бусдад учруулсан гэм хорыг хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 377 дугаар зүйлд заасан журмаар арилгана.

3. Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүх, прокурорын байгууллагын албан тушаалтан албаны үйл ажиллагааг буруу явуулснаас бусдад учруулсан гэм хорыг хуульд заасан үндэслэл, журмын дагуу арилгана.

379 дүгээр зүйл. Орчин тойрондоо аюул учруулж болох зүйлээс гарах хариуцлага

1. Орчин тойрондоо аюул учруулж болох зүйлийг эзэмшигч нь түүнээс учирсан гэм хорыг хариуцан арилгах үүрэгтэй.

2. Гэм хор учруулсан нь гэнэтийн буюу даваагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал, түүнчлэн хохирог-

чийн санаатай үйлдэл, эс үйлдэл, хэтэрхий болгоомжгүйгээс болсон бол орчин тойрондоо аюул учруулж болох зүйлийг эзэмшигч хариуцлагаас чөлөөлөгдөнө.

380 дугаар зүйл. Бараа, ажил, үйлчилгээний дутагдлын улмаас үүссэн гэм хорыг хариуцах

1. Бараа, гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний үр дүн нь үйлдвэрлэл, зохион бүтээлт, жор найрлагын болон бусад дутагдалтай байсны улмаас бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд гэм хор учруулсан бол түүнийг худалдсан буюу үйлдвэрлэсэн этгээд гэм хорыг арилгах үүрэгтэй.

2. Тухайн бараа (ажил, үйлчилгээ)-г ашиглах, хадгалах журам зөрчсөний улмаас гэм хор учирсан болохыг түүнийг худалдсан буюу үйлдвэрлэсэн этгээд нотолбол хариуцлагаас чөлөөлөгдөнө.

381 дүгээр зүйл. Бага насны хүмүүс гэм хор учруулсны хариуцлага

1. Бага насны хүмүүсийн учруулсан гэм хорыг тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч-эцэг, эх, асран хамгаалагч хариуцан арилгана.

2. Бага насны хүмүүс сургууль, хүүхэд хүмүүжүүлэх болон эрүүл мэндийн байгууллагын шууд хяналтын дор байхдаа бусдад учруулсан гэм хорыг эдгээр байгууллага хариуцан арилгана.

382 дугаар зүйл. Эрхийн бүрэн чадамжгүй гэж тооцогдсон этгээд гэм хор учруулсан хариуцлага

Сэтгэцийн өвчний улмаас эрхийн бүрэн чадамжгүй гэж тооцогдсон этгээд бусдад гэм хор учруулбал түүний асран хамгаалагч буюу байнгын хяналт тавих үүрэг бүхий байгууллага уг гэм хорыг хариуцан арилгана.

383 дугаар зүйл. Насанд хүрээгүй хүмүүс гэм хор учруулсны хариуцлага

1. Насанд хүрээгүй хүмүүс бусдад учруулсан гэм хорыг өөрөө хариуцан арилгана.

2. Насанд хүрээгүй хүмүүсийн бусдад учруулсан гэм хорыг арилгахад хуульд заасны дагуу түүний ажил эрхэлж

олсон цалин, хөлс, орлого, түүнчлэн хууль ёсны төлөөлөгчөөс үзэмжээрээ захиран зарцуулахад нь зориулж шилжүүлсэн тодорхой эд хөрөнгө нь хүрэлцэхгүй бол нийхүү хүрэлцэхгүй байгаа хэмжээгээр түүний эцэг, эх, харгалзан дэмжигч нөхөх хариуцлага хүлээнэ.

384 дүгээр зүйл. Үйлдлийнхээ учир холбогдлыг ойлгохгүй буюу түүнийг зөв удирдах чадваргүй байхдаа бусдад гэм хор учруулсны хариуцлага

Эрхийн бүрэн чадамжтай цргэн өөрийн үйлдлийн учир холбогдлыг ойлгохгүй буюу түүнийг зөв удирдах чадваргүй байхдаа бусдад учруулсан гэм хорыг хариуцахгүй. Харин согтууруулах буюу мансууруулах бодис хэрэглэж өөрийгөө гийм байдалд хүргэсэн этгээд хариуцлагаас чөлөөлөгдөхгүй.

385 дугаар зүйл. Гэм хорыг хамтран хариуцах

Хамтран гэм хор учруулсан бол хохирогчийн өмнө хамтын хариуцлага хүлээнэ.

386 дугаар зүйл. Эд хөрөнгөд учруулсан гэм хорыг арилгах

Бусдын эд хөрөнгөд гэм хор учруулсан этгээд уг гэм хорыг арилгахдаа гэм хор учруулахаас өмнө байсан байдалд нь сэргээх (адил нэр, төрөл, чанарын эд хөрөнгө өгөх эмтсэн эд хөрөнгийг засах зэргээр) буюу учирсан хохирлыг мөнгөөр төлнө.

387 дугаар зүйл. Бусдын эрүүл мэндэд учирсан гэм хорыг арилгах

1. Бусдын эрүүл мэндэд гэм хор учруулсан этгээд нь охирогчийн хөдөлмөрийн чадвараа алдсанаас дутуу авсан цалин, хөлс, түүнтэй адилтгах орлого, ийнхүү эрүүл мэндэд эм хор учруулсантай холбогдон гарсан (түүнийг асарч увилах, нэмэгдэл хоол өгөх, хиймэл эрхтэн хийх, эмнэлэг, увиллын газар эмчлүүлэх зэрэг) зайлшгүй бүх зардлыг охирогчид төлөх үүрэгтэй.

2. Хохирогч гэм хор учрах үед тодорхой цалин, хөлс, рлогогүй байсан бол хөдөлмөрийн чадвар алдсанаас учирсан хохирлыг хууль тогтоомжоор тогтоосон хөдөлмөрийн өлсний доод хэмжээнээс багагүй хэмжээгээр тооцож төүүлэхийг шаардах эрхтэй.

388 дугаар зүйл. Арван зургаан нас хүрээгүй хүмүүст учруулсан гэм хорыг арилгах

1. Арван зургаан нас хүрээгүй бөгөөд цалин, хөлс, орлогогүй хүмүүсийн эрүүл мэндэд гэм хор учруулсан бол гэм хор учруулсан этгээд нь ийнхүү эрүүл мэндэд гэм хор учруулсантай холбогдон гарсан зардлыг энэ хуулийн 387 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар нөхөн төлнө.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хохирогч арван зургаан нас хүрсэн боловч эрүүл мэнд нь сайжраагүй бол хөдөлмөрийн чадвар алдсанаас учирсан хохирлыг хууль тогтоомжоор тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй хэмжээгээр тооцож төлүүлэхээр түүний эцэг, эх, харгалзан дэмжигч шаардах эрхтэй.

3. Арван зургаан нас хүрээгүй хүмүүсийн эрүүл мэндэд гэм хор учруулах үед тэрээр байнгын цалин, хөлс, орлоготой байсан бол хохирлыг дутуу авсан цалин, хөлс, орлогын хэмжээгээр төлүүлнэ.

389 дүгээр зүйл. Хохирогч нас барснаас учирсан гэм хорыг арилгах

1. Хохирогч нас барсан бол түүнийг оршуулахтай холбогдсон зайлшгүй зардал болон гэм хор учруулсан төлбөрийг шаардах эрхтэй.

2. Гэм хор учруулсны төлбөрийг нас барсан хохирогчийн асрамжид байсан буюу нас барах үед түүнээс тэтгэвэр авах эрхтэй байсан хөдөлмөрийн чадваргүй этгээд, хохирогчийг нас барсны дараа төрсөн түүний хүүхэд тус тус, түүнчлэн нас барагчийн найман нас хүрээгүй хүүхэд, дүү, ачийг асран хүмүүжүүлж байнгын цалин, хөлс, орлогогүй байгаа нас барагчийн эцэг, эх, нөхөр (эхнэр)-ийн аль нэг нь авах эрхтэй.

3. Төлбөр гаргуулах хэмжээг тогтоохдоо нас барагчид өөрт нь болон түүний асрамжид байсан хөдөлмөрийн чадвартай бөгөөд төлбөр авах эрхгүй этгээдэд оногдох хэсгийг хасаад нас барагчийн сарын цалин, хөлс, орлогын дунджаар тогтооно. Түүнчлэн төлбөр авагч тус бүрт тогтоосон төлбөрийн хэмжээнээс тэжээгчээ алдагчийн хувьд авч байгаа тэтгэврийг хасна.

4. Гэм хор учруулсны төлбөрийг дор дурдсан хугацаанд нөхөн төлнө:

1) бага насны буюу насанд хүрээгүй хүмүүст арван зургаан нас хүртэл, харин суралцаж байгаа бол арван найман нас хүртэл;

2) тавин таваас дээш насны эмэгтэйчүүд, жараас дээш насны эрэгтэйчүүдэд бүх насаар нь;

3) тахир дутуу иргэнд хөдөлмөрийн чадвар алдалт тогтоогдсон хугацаанд;

4) нас барагчийн найман нас хүрээгүй хүүхэд, дүү, ачийг асран хүмүүжүүлж байгаа байнгын цалин, хөлс, орлогогүй нас барагчийн эцэг, эх, нөхөр (эхнэр)-ийн аль нэгэнд түүний нас, хөдөлмөрийн чадварыг харгалзахгүйгээр уг хүүхдийг найман нас хүртэл.

390 дүгээр зүйл. Гэм хор учруулсны төлбөрийн хэмжээ өөрчлөгдөх

1. Эрүүл мэндэд нь гэм хор учирснаас болж, хөдөлмөрийн чадвараа хагас алдсан иргэний хөдөлмөрийн чадвар нь цаашид дордох буюу авч байгаа тэтгэврийн хэмжээ багасвал гэм хор учруулсны төлбөрийг зохих хэмжээгээр нэмэгдүүлэхийг хариуцагчаас шаардах эрхтэй.

2. Хохирогчийн хөдөлмөрийн чадвар сайжирсантай холбоотойгоор авч байгаа цалин, хөлс, орлого болон тэтгэврийн хэмжээ нэмэгдвэл хариуцагч нь гэм хор учруулсны төлбөрийн хэмжээг багасгахыг шаардах эрхтэй.

391 дүгээр зүйл. Хохирогч нас барсан буюу хөдөлмөрийн чадвар алдсантай холбогдуулан төлбөр төлөх

1. Хохирогч нас барсан буюу хөдөлмөрийн чадвараа алдсантай холбогдсон төлбөрийг сар тутам төлнө.

2. Гэм хор учруулсны төлбөр төлөх үүрэг бүхий хуулийн этгээдийн үйл ажиллагаа зогссон бөгөөд түүний эрх залгамжлагч байхгүй бол хохирогч нас барсан буюу хөдөлмөрийн чадвараа алдсантай холбогдуулан уг хуулийн этгээдээс төлбөл зохих төлбөрт шаардагдах хэмжээний хөрөнгийг энэ хуулийн 31 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу тэргүүн ээлжинд хуримтлуулж, тогтоосон хугацаанд хохирогчид олгож байхын тулд нийгэм хангамжийн байгууллагад шилжүүлнэ.

3. Шүүх төлбөр авагчийн хүсэлтээр мөнгөний ханшийн өөрчлөлтийг харгалзан төлбөрийн үнийн дүнг өөрчилж болно.

392 дугаар зүйл. Эд хөрөнгийн бус гэм хорыг арилгах

1. Бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийгээ бодит байдалд нийцэж байгааг нотолж чадахгүй бол эд хөрөнгийн хохирол арилгасныг үл харгалзан эд хөрөнгийн бус гэм хорыг мөнгөн буюу бусад хэлбэрээр арилгах үүрэг хүлээнэ.

2. Шүүх эд хөрөнгийн бус гэм хорыг арилгах хэмжээг мэдээ тараасан арга, хэрэгсэл, тарсан хүрээ, хохирогчид учирсан сэтгэл санааны үр дагавар зэргийг харгалзан, нэхэмжлэгчийн шаардлагын хүрээнд мөнгөөр тооцож тогтоох ба мэдээ тараасан уг хэлбэрээр болон бусад аргаар няцаалт хийхийг гэм хор учруулсан этгээдэд үүрэг болгоно.

393 дугаар зүйл. Гэм хор учруулснаас төлсөн төлбөрийг буцаан нэхэмжлэх шаардлага

1. Бусдын амь нас, эрүүл мэндэд гэм хор учруулсантай холбогдуулан төлбөр төлсөн нийгмийн даатгал, нийгмийн хангамжийн буюу бусад байгууллага нь гэм буруутай хуулийн этгээд, иргэнээс төлбөр, тусламжаа буцаан нэхэмжлэх эрхтэй.

2. Гэм хорыг хариуцвал зохих хуулийн этгээд буюу иргэн нь буцаан нэхэмжилсэн шаардлагын дагуу уг байгууллагыг хохиролгүй болгох үүрэгтэй.

3. Гэм хор учруулсны төлбөрийн хэмжээ нь энэ хуулийн 390 дүгээр зүйлд заасан үндэслэлээр багасвал буцаан нэхэмжлэх шаардлагын дагуу хүлээх харицуцлагын хэмжээ нэгэн адил багасна.

394 дүгээр зүйл. Хохирогчийн гэм буруу, гэм хор учруулагчийн эд хөрөнгийн байдлыг харгалзан үзэх

1. Гэм хор учрах буюу түүнээс үүдэн гарах хохирлын хэмжээ нэмэгдэхэд хохирогчийн хэтэрхий болгоомжгүй үйлдэл, эс үйлдэл нөлөөлсөн бол уг нөхцөл байдлыг харгалзан харицуцах гэм хорын хэмжээг багасгаж болно.

2. Санаатай гэмт хэргийн улмаас учруулснаас бусад гэм хорыг нөхөн төлөх хэмжээг тогтоохдоо гэм хор учруулагчийн эд хөрөнгийн байдлыг харгалзан шүүх багасгаж болно.

ДӨЧИНЕСДҮГЭЭР БҮЛЭГ

Бусдын эд хөрөнгийг аварч байхад учирсан гэм хорыг арилгах

395 дугаар зүйл. Бусдын эд хөрөнгийг аварч байхад учирсан гэм хорыг арилгах

Бусдын эд хөрөнгийг учирч болох аюулаас аварсан иргэнд ийнхүү аврах үед гэм хор учирсан бол тэрээр уг эд хөрөнгийг өмчлөгч буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрх бүхий этгээд (энэ хуулийн 88 дугаар зүйл)-ээс гэм хорыг арилгуулахаар шаардах эрхтэй.

ТАВЬДУГААР БҮЛЭГ

Эд хөрөнгийг үндэслэлгүйгээр олж авсан буюу эзэмшсэнээс үүсэх үүрэг

396 дугаар зүйл. Үндэслэлгүйгээр олж авсан буюу эзэмшсэн эд хөрөнгийг буцаах үүрэг

1. Хууль буюу хэлцлээр тогтоосон үндэслэлгүйгээр бусдын эд хөрөнгийг олж авсан этгээд түүнийг өмчлөгч буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрх бүхий этгээд (энэ хуулийн 88 дугаар зүйл)-эд нь буцааж өгөх боломжгүй бол эд хөрөнгө буцааж өгөхийг шаардсан үеийн ханшаар үнийг төлөх үүрэгтэй.

2. Эд хөрөнгө олж авсан үндэслэл нь хожим хүчингүй болбол энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үүрэг нэг адил үүснэ.

3. Бусдын эд хөрөнгийг үндэслэлгүйгээр шударга бусаар олж авсан этгээд ийнхүү эд хөрөнгийг олж авсан үеэс, шударгаар олж авсан этгээд нь үндэслэлгүйгээр олж авсан гэдгээ мэдсэн буюу мэдэх ёстой байсан үеэс эхлэн уг эд хөрөнгөөс олсон буюу зайлшгүй олох ёстой байсан орлого, үр шим, үр төлийг хууль ёсны өмчлөгч, эзэмшигчид буцааж өгөх, боломжгүй бол үнийг төлөх үүрэгтэй.

4. Хууль буюу хэлцлээр тогтоосон үндэслэлгүйгээр бусдын эд хөрөнгийг ашигласан бол энэ зүйлд заасан журам нэг адил хамаарна.

5. Үндэслэлгүйгээр олж авсан эд хөрөнгийг өмчлөгч буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрх бүхий этгээд нь тодорхойгүй, эсхүл тэдгээр нь өмчлөх буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ алдсан, түүнчлэн өмчлөхөөс татгалзсан бол уг эд хөрөнгийг улсын орлогод оруулна.

397 дугаар зүйл. Эд хөрөнгийг үндэслэлгүйгээр олж авсан гэж үзэхгүй байдал

1. Нэхэмжлэл гаргах хөөн хэлэлцэх хугацаа дууссаныг мэдэлгүйгээр нэг тал нөгөөдөө үүргийн гүйцэтгэл болгон эд хөрөнгө шилжүүлсэн бол түүнийг үндэслэлгүйгээр олж авсан гэж буцаан нэхэмжилж болохгүй.

2. Дансны алдаанаас буюу хөлс, шагнал авагч хууль бус арга хэрэглэж илүү авсанаас бусад оюуны бүтээлийн хөлс, шагналыг үндэслэлгүйгээр олж авсан гэж нэхэмжилж болохгүй.

3. Хөдөлмөрийн хөлс, тэтгэвэр, тэтгэмжид илүү олгогдсон мөнгийг буцаан төлөх нөхцөл журам нь тус тусын харилцааг зохицуулж байгаа хуулиар тодорхойлогдоно. Эдгээр харилцааг зохицуулж байгаа хуульд энэ тухай заагаагүй бол энэ зүйлийн 2 дахь хэсгийн заалт нэг адил хамаарна.

VI ХЭСЭГ

ӨВЛӨХ ЭРХ

ТАВИННЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Ерөнхий зүйл

398 дугаар зүйл. Өв залгамжлах үндэслэл

1. Өвлүүлэгчийн эд хөрөнгө, эрх өв залгамжлагдана.

2. Өв залгамжлал нь хуульд зааснаар буюу гэрээслэлээр гүйцэтгэгдэнэ.

3. Хуульд заасан өв залгамжлал нь гагцхүү өвлүүлэгчийн гэрээслэлээр өөрчлөгдөнө.

4. Хууль ёсны буюу гэрээслэлээр өв залгамжлагчид нь гагцхүү өвлүүлэгчийг нас барах үед амьд байсан иргэн, түүнчлэн түүний нас барсны дараа төрсөн хүүхэд байж болно.

5. Хууль ёсны буюу гэрээслэлээр өв залгамжлагч байхгүй эсхүл тэдгээр нь өв залгамжлалаас татгалзсан буюу өв залгамжлах эрхээ алдсан бол нас барагчийн өвлөгдөл зохих эд хөрөнгө эзэнгүй эд хөрөнгийн нэг адил төрийн өмчлөлд шилжинэ.

6. Өвлүүлэгчийн эд хөрөнгийн зарим хэсэг нь гэрээслэгдсэн бөгөөд үлдсэн хэсгийг өвлөх хууль ёсны өв залгамжлагч байхгүй бол түүнийг мөн эзэнгүй эд хөрөнгийн нэг адилаар төрийн өмчлөлд шилжүүлнэ.

399 дүгээр зүйл. Оюуны үнэт зүйлийг өв залгамжлах

1. Оюуны үнэт зүйлийг өв залгамжлах эрх нь гагцхүү эд хөрөнгийн эрхэд хамаарна. Энэхүү эрхийг хуульд зааснаар буюу гэрээслэлээр олж авч болно.

2. Оюуны үнэт зүйлийг өв залгамжлах эрх нь 50 жилийн хугацаанд хадгалагдана.

3. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас бусад эрх нь хуульд заасан үндэслэлээр төрд шилжинэ.

400 дугаар зүйл. Өв залгамжлах эрхээ алдах

1. Өвлүүлэгчийг, эсхүл хууль ёсны буюу гэрээслэлээр өв залгамжлагчийг санаатайгаар алсан, түүнчлэн тэдгээрийн аль нэгний нас барах шалтгаан болсон бусад гэмт хэргийг санаатайгаар үйлдсэн нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон бол уг гэм буруутай этгээд хуульд зааснаар ба гэрээслэлээр өв залгамжлах эрхээ алдана.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийн учир мөрдөн байцаалтад шалгагдаж байгаа этгээдэд шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болох буюу хэргийг хэрэгсэхгүй болгох хүртэл эд хөрөнгийг өв залгамжлуулж болохгүй бөгөөд өвлөгдөх эд хөрөнгөөс түүнд оногдох хэсгийг энэ хуулийн 422 дугаар зүйлд заасны дагуу хамгаалах арга хэмжээ авна.

401 дүгээр зүйл. Өв нээгдэх үе

Өвлүүлэгч нас барсан өдрөөс, түүнчлэн иргэнийг нас барсан гэж зарласан бол энэ хуулийн 19 дүгээр зүйлд заасан өдрөөс өв нээгдэнэ.

402 дугаар зүйл. Өв нээгдэх газар

Өвлүүлэгчийн сүүлчийн оршин суух байсан газар, тэр

нь мэдэгдэхгүй бол өвлөгдөх эд хөрөнгө буюу түүний гол хэсэг нь байгаа газрыг өв нээгдсэн газар гэнэ.

ТАВИНХОЁРДУГААР БҮЛЭГ

Хуульд зааснаар өв залгамжлах

403 дугаар зүйл. Хууль ёсны өв залгамжлагч

1. Дор дурдсан этгээдийг хууль ёсны өв залгамжлагч гэх ба тэдгээр нь адил хэмжээгээр өв залгамжлах эрхтэй:

1) нас барагчийн нөхөр, эхнэр, төрүүлсэн ба үрчилж авсан буюу түүнийг нас барсан хойно төрсөн хүүхэд, нас барагчийн асрамжинд байсан хөдөлмөрийн чадваргүй төрүүлсэн ба үрчилсэн эцэг, эх;

2) энэ хэсгийн 1-д заасан өв залгамжлагчид байхгүй, эсхүл тэдгээр нь өв залгамжлахаас татгалзсан буюу өв залгамжлах эрхээ алдсан бол нас барагчийн төрүүлсэн ба үрчилсэн хөдөлмөрийн чадвартай эцэг, эх, өвөг эцэг, эмэг эх, ах, эгч, дүү.

2. Хуульд зааснаар өв залгамжлах эрхтэй эцэг, эх нь өв нээгдэх үед амьд байгаагүй бол өвлүүлэгчийн ач, зээ, ачинцар, зээнцэр нь эцэг, эхдээ хуульд зааснаар өвлөгдвөл зохих байсан эд хөрөнгийн хэсгийг тэгш хуваан өвлөнө.

3. Энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт дурдсан хүмүүсээс гадна өвлүүлэгч нас барахаас өмнө нэгээс доошгүй жилийн хугацаанд түүний асрамжинд байсан хөдөлмөрийн чадваргүй иргэн хууль ёсны өв залгамжлагчид тооцогдоно. Өөр өв залгамжлагч байвал ийнхүү асрамжид байсан этгээд тэдгээртэй адил хэмжээгээр өвлөнө.

4. Гэрийн эд хогшил нь ээлж дараалал, эд хөрөнгийн өвлөгдөх хэсгийн шинж байдлаас шалтгаалахгүйгээр өвлүүлэгчийг нас барах үед түүнтэй хамт амьдарч байсан хууль ёсны өв залгамжлагчид шилжинэ.

5. Гэрлэгчдийн хуваарьт эд хөрөнгийг энэ зүйлийн 1, 2, 3 дахь хэсэгт зааснаар өв залгамжилна.

6. Гэр бүлийн гишүүдийн дундаа хамтран өмчлөх эд хөрөнгийн гишүүнд оногдох хэсгийг гагцхүү энэ зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасан этгээдүүд биет байдлаар буюу мөнгөн хэлбэрээр өвлөх эрхтэй.

404 дүгээр зүйл. Гэрээслэгдээгүй үлдсэн эд хөрөнгийг өвлөх

Эд хөрөнгийн зарим хэсэг нь гэрээслэлээр өв залгамжлагчид шилжсэн бол үлдэх хэсэг нь хууль ёсны өв залгамжлагчид шилжинэ.

ТАВИНГУРАВДУГААР БҮЛЭГ

Гэрээслэлээр өвлөх

405 дугаар зүйл. Гэрээслэлийн агуулга

1. Иргэн нь хуульд зааснаар өвлөх эрхтэй буюу эрхгүй нэг ба хэд хэдэн иргэн, түүнчлэн төр буюу хуулийн этгээдэд өөрийн эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийн заримыг буюу бүгдийг үзэмжээрээ хуваарилан гэрээсэлж болно.

2. Төр буюу хуулийн этгээдэд эд хөрөнгө гэрээслэгч нь түүний зориулалтыг зааж болно.

3. Хуульд зааснаар өв залгамжлах эрхтэй нэг буюу хэд хэдэн, бүх эсхүл этгээдийн өв залгамжлах эрхийг гэрээслэгч гэрээслэлдээ нэр заан хасаж болно. Иймхүү өв залгамжлах эрхээ хасуулсан этгээдэд энэ зүйлийн 4 дэх хэсэг, 406 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалт хамаарахгүй.

4. Гэрээслэгч нь бүх эд хөрөнгөө өөр этгээдэд гэрээсэлсэн тохиолдолд өвлүүлэгчийн насанд хүрээгүй буюу хөдөлмөрийн чадваргүй, түүнчлэн түүний нас барсан хойно төрсөн хүүхэд, түүний асрамжинд байсан хөдөлмөрийн чадваргүй нөхөр (эхнэр), төрүүлсэн ба үрчилсэн эцэг, эх, хууль ёсны бусад өв залгамжлагч хуульд зааснаар өвлөгдвөл зохих хөрөнгийн гуравны хоёроос багагүй хэсгийг заавал өвлөнө. Иймхүү заавал өвлөгдвөл зохих хэсгийн хэмжээг тодорхойлохдоо өвлүүлэгчийн хуваарьт болон дундаа хамтран өмчлөх эд хөрөнгийн оногдох хэсгийг оролцуулан тооцно.

406 дугаар зүйл. Өв залгамжлагч өөрчлөгдөх

Өв нээгдэхээс өмнө гэрээслэлд заасан өв залгамжлагч нас барсан буюу өвийг хүлээн авахаас татгалзсан бол гэрээслэгч нь өөр өв залгамжлагчийг томилж болно.

407 дугаар зүйл. Гэрээслэлийн хэлбэр

1. Гэрээслэлийг бичгээр хийж үйлдсэн газар, он, сар,

өдрийг зааж, нотариатоор гэрчлүүлнэ. Гэрээслэл хийсэн газар нотариат байхгүй бол баг, сумын Засаг даргаар гэрчлүүлнэ.

2. Дор дурдсан тохиолдолд нотариатоор гэрчлүүлсний нэг адил үзнэ:

1) цэргийн албан хаагчийн гэрээслэлийг түүний алба хааж байгаа цэргийн ангийн удирдлага гэрчилсэн;

2) хорих газар хоригдож байгаа буюу ажиллаж байгаа иргэний гэрээслэлийг хорих ангийн дарга гэрчилсэн.

3. Энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан шаардлага хангаагүй гэрээслэл хүчин төгөлдөр бус байна.

408 дугаар зүйл. Гэрээслэлээр өв залгамжлагчид даалгавар үүрэг

1. Гэрээслэгч нь хууль ёсны өв залгамжлагч буюу өөр этгээдийн ашиг сонирхлын төлөө, эсхүл ямар нэг нийтэд тустай зорилгын үүднээс гэрээслэлээр өв залгамжлагчид аливаа үүрэг даалгах эрхтэй.

2. Гэрээслэлээр өв залгамжлагч нь гагцхүү түүнд өвлүүлсэн эд хөрөнгийн хэмжээнд даалгасан үүргийг гүйцэтгэнэ.

3. Гэрээслэлээр өв залгамжлагч нас барсан буюу өв залгамжлахаас татгалзсан бол түүнд даалгагдсан үүрэг уг өвийг хүлээн авсан бусад өв залгамжлагчдад шилжинэ.

409 дүгээр зүйл. Гэрээслэлийг өөрчлөх ба цуцлах

1. Гэрээслэгч нь хэдийд ч гэрээслэлээ өөрчлөх ба цуцлах эрхтэй.

2. Шинэ гэрээслэл хийсэн буюу гэрээслэлээ цуцалсан тухай зохих баримт бичиг гаргаснаар гэрээслэл өөрчлөгдөх ба цуцлагдана. Иймхүү шинээр хийсэн гэрээслэл буюу гэрээслэлээ цуцалсан тухай баримт бичгийг энэ хуулийн 407 дугаар зүйлд заасны дагуу гэрчлүүлнэ.

410 дугаар зүйл. Гэрээслэлийг биелүүлэх

1. Гэрээслэл биелүүлэхийг гэрээслэлээр томилогдсон өв залгамжлагчид даалгана.

2. Гэрээслэгч нь гэрээслэл биелүүлэгчээр өөр иргэнийг томилж болно.

3. Гэрээслэл биелүүлэгч нь даалгасан үүргийг биелүүлэхийг зөвшөөрснөө батлаж, гэрээслэлд гарын үсэг зурах

буюу энэ тухай баримт бичиг үйлдэж, гэрээслэлд хавсаргаснаар уг даалгаврыг гүйцэтгэх үүрэг хүлээнэ.

4. Гэрээслэл биелүүлэгч гэрээслэлийг биелүүлэхэд шаардагдах бүхий л арга хэмжээг авах үүрэгтэй бөгөөд түүнийг биелүлэх, өвлөгдсөн эд хөрөнгийг эрхлэн удирдах, хамгаалахад гарсан зайлшгүй зардлаа өвлөгдөх хөрөнгөөс гаргуулан авах эрхтэй.

5. Гэрээслэл биелүүлэгч түүнийг биелүүлмэгц өв залгамжлагчид тайлагнах үүрэгтэй.

ТАВИНДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Өв хүлээн авах ба татгалзах

411 дүгээр зүйл. Өв хүлээн авах

1. Өв залгамжлал нь өвлөгдөх эд хөрөнгийг хүлээн авснаар гүйцэтгэгдэнэ.

2. Өвлөгдөх эд хөрөнгийг өв залгамжлагч ямар нэг нөхцөл заах буюу болзол тавьж түр хүлээн авч болохгүй.

3. Өв залгамжлагчийн хүлээн авсан эд хөрөнгийг өв нээгдсэн өдрөөс эхлэн өв залгамжлагчид шилжсэн гэж үзнэ.

412 дугаар зүйл. Өв хүлээн авах ба түүнийг хүлээн авахаас татгалзах журам

1. Өвлүүлэгчийг нас барах хүртэл түүнтэй хамт амьдарч байсан өв залгамжлагч нь өв нээгдсэнээс хойш гурван сарын дотор өв хүлээн авахаас татгалзсан тухайгаа нотариат буюу нотариат байхгүй газар баг, сумын Засаг даргад мэдэгдээгүй бол уг өвийг хүлээн авсан гэж үзнэ.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас бусад өв залгамжлагчид нь өв нээгдсэнээс хойш нэг жилийн дотор хуульд заасны дагуу өвлөгдсөн эд хөрөнгийг эзэмдэн авсан буюу эрхлэн удирдсан, эсхүл нотариат буюу баг, сумын Засаг даргад өв хүлээн авах буюу өв залгамжлах эрхийн гэрчилгээ олгохыг хүсч, өргөдөл гаргасан байвал уг өвийг хүлээн авсан гэж үзнэ.

3. Энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан хугацаанд өв залгамжлагч өвлөгдөх эд хөрөнгийг хүлээн аваагүй буюу хүлээн авах тухай хүсэлтээ зохих байгууллага, этгээдэд гаргаагүй бол түүнийг өв залгамжлалаас татгалзсан гэж үзнэ.

4. Хүндэтгэн үзэх шалтгаан байвал өв хүлээн авах хугацааг шүүх сунгаж болно. Ийнхүү хугацаа сунгасан бол хугацаа хожимдуулсан өв залгамжлагч нь бусад өв залгамжлагчид буюу төрийн өмчлөлд шилжсэн эд хөрөнгөөс өөрт оногдох бэлэн байгаа эд хөрөнгө, эсхүл түүнийг борлуулсан үнийн зохих хэсгийг шаардан авах эрхтэй.

5. Өв залгамжлагч өвлөх эрхээ өв залгамжилбал зохих бусад иргэн, эсхүл төр, аль нэг хуулийн этгээдэд шилжүүлэхээр зааж, өв хүлээн авахаас татгалзах эрхтэй.

413 дугаар зүйл. Өвлөгдөх эд хөрөнгийг хүлээн авах эрх шилжих

1. Хууль ёсны буюу гэрээслэлээр өв залгамжлагч өв нээгдсэний дараа уг өвийг хүлээн авч чадалгүй нас барсан бол өвлөгдөх эд хөрөнгөөс түүнд оногдох хэсгийг хүлээн авах эрх түүний өв залгамжлагчид шилжинэ.

2. Ийнхүү шилжсэн эрх нь өв хүлээн авах хугацааны дотор нийтлэг журмын дагуу хэрэгжих боловч үлдсэн хугацаа нь эрх шилжих үед гурван сараас доош байсан бол гурван сарын дотор хэрэгжинэ.

414 дүгээр зүйл. Өв залгамжлагч нь бусад өв залгамжлагчдын ирэхээс өмнө өвлөгдөх эд хөрөнгийг авах

Өв залгамжлагч нь өвлөгдөх эд хөрөнгийг бусад өв залгамжлагчдын ирэхийг хүлээхгүйгээр авч болох боловч өв нээгдсэн өдрөөс хойш нэг жил өнгөрөөгүй буюу өв залгамжлах эрхийн гэрчилгээ олгох хүртэл уг эд хөрөнгийг худалдах, бэлэглэх буюу барьцаанд өгөх, гэрээслэх эрхгүй. Харин өвлөгдсөн эд хөрөнгөөс дор дурдсан зардлыг гаргах эрхтэй:

1) өвлүүлэгчийг өвчтэй байхад асрах ба түүнийг оршуулахад гарсан зардал;

2) өвлүүлэгчийн асрамжид байсан буюу өвлүүлэгчээс тэтгэвэр авах эрхтэй этгээдийг асран тэтгэсний зардал;

3) хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах бусад төлбөрийн шаардлагыг, хангах зардал;

4) өвлөгдсөн эд хөрөнгийг хамгаалахад гарсан зардал.

415 дугаар зүйл. Өв залгамжлах эрхийн гэрчилгээ олгох

1. Хууль ёсны буюу гэрээслэлээр өв залгамжлагч нь өв

залгамжлах эрхийн гэрчилгээ олгох хүсэлтийг өв нээгдсэн газрын нотариат, нотариатгүй газар баг, сумын Засаг даргад гаргаж болно. Эзэнгүй эд хөрөнгийг төрийн өмчлөлд шилжүүлсэн тухай гэрчилгээг төрийн зохих байгууллагад дээрх журмын дагуу олгоно.

2. Хууль ёсны өв залгамжлагчид өв залгамжлах эрхийн гэрчилгээг өв нээгдсэнээс хойш нэг жил өнгөрсний дараа олгоно. Гэрчилгээ олгох тухай хүсэлт гаргасан буюу өвлөгдсөн эд хөрөнгийг авсан этгээдээс өөр өв залгамжлагч байхгүй болохыг батлах лавтай баримт байвал гэрчилгээг өв нээгдсэнээс хойш нэг жилийн хугацаа өнгөрөхөөс өмнө олгож болно.

3. Энэ хуулийн 405 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан өвлөх эрх бүхий этгээд байхгүй тохиолдолд гэрээслэлээр өв залгамжлах эрхийн гэрчилгээг өв нээгдсэн өдрөөс хойш нэг жилийн дотор өв залгамжлагч гэрээслэлээ үзүүлснээр олгоно.

4. Эзэнгүй эд хөрөнгийг төрийн өмчлөлд шилжүүлсэн тухай гэрчилгээг өв нээгдсэнээс хойш нэг жилийн дараа төрийн зохих байгууллагад олгоно.

416 дугаар зүйл. Өвлөгдсөн эд хөрөнгийг хуваарилах

1. Өвлөгдсөн эд хөрөнгийг өв залгамжлалд оролцсон бүх өв залгамжлагчид хэлэлцэн зөвшөөрөлцөж, хууль ёсны буюу гэрээслэлээр өв залгамжлагч бүрт оногдвол зохих хэмжээгээр хуваарилна. Ийнхүү хуваарилах талаар маргаан гарвал шүүх шийдвэрлэнэ.

2. Өвлүүлэгчийг амьд байхад олдсон бөгөөд төрөөгүй байгаа өв залгамжлагчид оногдох хэсгийг тусгаарлан гаргана. Төрөөгүй өв залгамжлагчийн ашиг сонирхлыг хамгаалахын тулд өвлөгдөх эд хөрөнгийг хуваарилахдаа асран хамгаалах байгууллагын төлөөлөгчийг оролцуулна.

ТАВИНТАВДУГААР БҮЛЭГ

Өвлөх эд хөрөнгийн хэмжээ нэмэгдэх

417 дугаар зүйл. Хууль ёсны өв залгамжлагчийн өвлөх эд хөрөнгийн хэмжээ нэмэгдэх

1. Хууль ёсны өв залгамжлагчдын аль нэг нь өөрт оног-

дох хэсгийг хэнд олгохыг заалгүй өв залгамжлахаас татгалзсан, эсхүл өв залгамжлах эрхээ алдсан бол түүнд оногдох хэсгийг хууль ёсны бусад өв залгамжлагчдад тэгш хуваан олгоно.

2. Гэрээслэгч нь бүх эд хөрөнгөө гэрээсэлсэн тохиолдолд гэрээслэлээр өв залгамжлагчдын аль нэг нь өөрт оногдох хэсгийг хэнд олгохыг заалгүйгээр өв залгамжлахаас татгалзсан, эсхүл өв залгамжлах эрхээ алдсан бол түүнд оногдох хэсгийг энэ хуулийн 405 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан хууль ёсны өв залгамжлагчдад тэгш хуваан олгоно.

3. Гэрээслэгч нь эд хөрөнгийнхөө зарим хэсгийг гэрээсэлсэн бөгөөд гэрээслэлээр өв залгамжлагчдын аль нэг нь энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан үндэслэлээр өв залгамжлагчдын тооноос хасагдвал түүнд оногдох хэсгийг хууль ёсны өв залгамжлагчдад тэгш хуваан олгоно.

4. Энэ зүйлд заасан өвлөгдөх эд хөрөнгийн оногдох хэсгийг хүлээн авах өв залгамжлагч байхгүй бол түүнийг эзэнгүй эд хөрөнгийн нэг адил төрийн өмчлөлд шилжүүлнэ.

418 дугаар зүйл. Гэрээслэлээр өв залгамжлагчийг өөрчилсний үр дагавар

Энэ хуулийн 400 дугаар зүйлд заасан үндэслэлээр өвлөх эрхээ алдсан гэрээслэлээр өв залгамжлагчийн оронд өвлүүлэгч нь өөр өв залгамжлагчийг томилсон бол энэ хуулийн 417 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсгийн заалт хамаарахгүй.

ТАВИНЗУРГАДУГААР БҮЛЭГ

Өвлүүлэгчийн үүргийг өв залгамжлагч хариуцах

419 дүгээр зүйл. Өв залгамжлагчийн хариуцлага

Өв хүлээн авсан өв залгамжлагч буюу энэ бүлэгт заасан журмаар эд хөрөнгийг шилжүүлэн авсан төрийн байгууллага нь өвлүүлэгчийн гүйцэтгэвэл зохих үүргийг өвлөн авсан эд хөрөнгийн хэмжээнд хариуцна. Хэд хэдэн өв залгамжлагч байвал уг үүргийг тус тусын өвлөсөн эд хөрөнгийн хэмжээнд хувь тэнцүүлэн хариуцна.

420 дугаар зүйл. Өвлүүлэгчийн үүрэг гүйцэтгүүлэгч гомдлын шаардлага гаргах

Өвлүүлэгчийн гүйцэтгэвэл зохих үүргийн талаарх

гомдлын шаардлагыг түүний үүрэг гүйцэтгүүлэгч өв нээгдсэн өдрөөс хойш нэг жилийн дотор өв залгамжлагч буюу гэрээслэл биелүүлэгч, нотариат, эсхүл эд хөрөнгийг шилжүүлэн авсан төрийн байгууллагад гаргана. Иймхүү гомдлын шаардлага гаргасан бол гомдлын шаардлагын хариуг авсан, эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа дууссан өдрөөс хойш 1 жилийн дотор нэхэмжлэлээ шүүхэд гаргаж болно.

ТАВИНДОЛДУГААР БҮЛЭГ

Өвлөгдөх эд хөрөнгийг хамгаалах

421 дүгээр зүйл. Өвлөгдөх эд хөрөнгийг хамгаалах журам ба хугацаа

1. Өв нээгдсэн газрын нотариат буюу нотариатгүй газарт баг, сумын Засаг дарга шаардлагатай гэж үзвэл өв залгамжлагч, өвлүүлэгчийн үүрэг гүйцэтгүүлэгч, түүнчлэн төрийн ашиг сонирхлын үүднээс өвлөгдөх эд хөрөнгийг хамгаалах арга хэмжээ авна.

2. Өвлөгдөх эд хөрөнгийг бүх өв залгамжлагч хүлээн авах буюу төрийн өмчлөлд шилжих хүртэл хамгаална.

422 дугаар зүйл. Өвлөгдөх эд хөрөнгөд эрхлэн хамгаалалт тогтоох

Өвлүүлэгчийн үүрэг гүйцэтгүүлэгч нэхэмжлэл гаргасан буюу бусад шаардлагатай тохиолдолд нутгийн захиргааны байгууллага өвлөгдөх эд хөрөнгөд эрхлэн хамгаалалт тогтооно. Иймхүү эрхлэн хамгаалалт тогтоосонтой холбогдон гарсан зардлыг өвлөгдөх эд хөрөнгөөс гаргана.

VII ХЭСЭГ

ОЛОН УЛСЫН ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙ ТАВИННАЙМДУГААР БҮЛЭГ

Гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээдийн иргэний эрх зүйн эрхийн чадвар, гадаад улсын хууль, олон улсын гэрээ хэрэглэх

423 дугаар зүйл. Олон улсын гэрээ

Монгол Улс олон улсын гэрээ байгуулахдаа Монгол

Улсын Иргэний хуулийн нийтлэг үндэслэлийг харгалзана. Гэвч Монгол Улсын олон улсын гэрээнд Монгол Улсын Иргэний хуулийн заалтаас өөр журам тогтоосон байвал олон улсын гэрээний заалтыг хэрэглэнэ.

424 дүгээр зүйл. Гадаад улсын хуулийг хэрэглэх үндэслэл

Монгол Улсын хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд харшлаагүй гадаад улсын хууль болон олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн заншлын хэм хэмжээг иргэний эрх зүйн харилцаанд хэрэглэж болно.

425 дугаар зүйл. Гадаад улсын хуулийн агуулгыг тогтоох

1. Шүүх, арбитр гадаад улсын хуулийг хэрэглэхдээ түүний хэм хэмжээний агуулгыг тэдгээрийн албан ёсны тайлбар, хэрэглэдэг практикт нийцүүлэн тогтооно.

2. Гадаад улсын хуулийн хэм хэмжээний агуулгыг тогтоох зорилгоор шүүх, арбитр нь зохих дэмжлэг туслалцаа үзүүлэх, тайлбар хийхийг хүсч, тогтоосон журмын дагуу Монгол Улсын Хууль зүйн яам, Монгол Улсад буюу хилийн чанадад байгаа бусад эрх бүхий байгууллагад хандах буюу мэргэжилтэн урьж болно.

3. Талууд гадаад улсын хуулийн зохих хэм хэмжээний агуулгыг баталсан баримт бичгийг гаргаж өгөх эрхтэй.

4. Энэ зүйлд заасны дагуу зохих арга хэмжээ авсан боловч гадаад улсын хуулийн хэм хэмжээний агуулга тогтоогдоогүй бол Монгол Улсын хуулийг хэрэглэнэ.

426 дугаар зүйл. Гадаад улсын хууль хэрэглэхийг хязгаарлах

Гадаад улсын хуулийг хэрэглэх нь Монгол Улсын хууль, Монгол улсын олон улсын гэрээнд харшилбал түүнийг хэрэглэхгүй. Энэ тохиолдолд Монгол Улсын хуулийг хэрэглэнэ.

427 дугаар зүйл. Хөөн хэлэлцэх хугацаа

1. Хөөн хэлэлцэх хугацааны асуудлыг тухайн харилцааг зохицуулахад хэрэглэж байгаа Монгол улсын хууль, Монгол улсын олон улсын гэрээний дагуу шийдвэрлэнэ.

2. Хөөн хэлэлцэх хугацаанд хамаарахгүй байх шаардлагыг Монгол Улсын хуулиар тогтоож болно.

428 дугаар зүйл. Гадаад улсын иргэн, харьяалалгүй хүний иргэний эрх зүйн эрхийн чадвар, чадамж

1. Гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын иргэний нэгэн адил эрхийн чадвартай байна. Тэдгээрийн эрхийн чадварыг Монгол Улсын хуулиар хязгаарлаж болно.

2. Гадаад улсын иргэний эрхийн чадамжийг түүний харьяалагдаж байгаа улсын хуулиар тодорхойлно.

3. Харьяалалгүй хүний эрхийн чадамжийг түүний байнга оршин суугаа улсын хуулиар тодорхойлно.

4. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр хийсэн хэлцэл, гэм хор учруулснаас үүсэх үүргийн талаархи гадаад улсын иргэн буюу харьяалалгүй хүний эрхийн чадамж нь Монгол Улсын хуулиар тодорхойлогдоно.

5. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр аливаа этгээдийг эрхийн бүрэн чадамжгүйд тооцох буюу чадамжийг нь хязгаарлах асуудлыг Монгол Улсын хуулийн дагуу шийдвэрлэнэ.

6. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр аливаа этгээдийг сураггүй алга болсонд тооцох, нас барсан гэж зарлах асуудлыг Монгол Улсын хуулийн дагуу шийдвэрлэнэ.

429 дүгээр зүйл. Гадаад улсын хуулийн этгээдийн иргэний эрх зүйн эрхийн чадвар

1. Гадаад улсын хуулийн этгээдийн эрхийн чадварыг харьяалсан улсын хуулиар тодорхойлсныг тус улсад хүлээн өвшөөрнө.

2. Гадаад улсын хуулийн этгээд хэлцэл хийхдээ Монгол Улсын хуульд байхгүй хязгаарлалтыг үндэслэж болохгүй.

430 дугаар зүйл. Иргэний эрх зүйн эрхийн чадварыг хариу хязгаарлах

Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн эрхийн чадварын талаар тусгай хязгаарлалт тогтоосон улсын иргэн, хуулийн этгээдийн эрхийн чадварын талаар Монгол Улсын адилтгах газар хариу хязгаарлалт тогтоож болно.

431 дүгээр зүйл. Эд хөрөнгийн бус амины эрхийг хамгаалах

Эд хөрөнгийн бус амины эрхийг хамгаалахдаа нэхэмж-

лэл гаргах үндэслэл болсон үйл баримт, бусад нөхцөл байдал үүссэн улсын хууль, эсхүл нэхэмжлэгчийн оршин суугаа (оршин байгаа) улсын хуулийг түүний сонгосноор хэрэглэнэ.

432 дугаар зүйл. Өмчлөх эрх

Эд хөрөнгө өмчлөх эрхийг дор дурдсан байдлаар тодорхойлно:

1) эд хөрөнгө өмчлөх эрхийг тухайн эд хөрөнгийн байгаа улсын хуулиар;

2) бүртгэгдвэл зохих эд хөрөнгө өмчлөх эрх тухайн эд хөрөнгийг бүртгэсэн улсын хуулиар;

3) Монгол Улсын хуульд өөрөөр заагаагүй бол эд хөрөнгийг өмчлөх эрх үүсэх, дуусгавар болох асуудал нь иймхүү өмчлөх эрх үүсэх, дуусгавар болох үндэслэл болсон үйл баримт, бусад нөхцөл байдал үүсэх үед тухайн эд хөрөнгө байсан улсын хуулиар;

4) талууд өөрөөр тохиролцоогүй бол хэлцлийн зүйл болж байгаа эд хөрөнгийг өмчлөх эрх үүсэх, дуусгавар болох асуудал нь уг хэлцэлд хэрэглэгдэх хуулиар;

5) талууд өөрөөр тохиролцоогүй бол гадаад эдийн засгийн хэлцлээр замд яваа эд хөрөнгийг өмчлөх эрхийн асуудлыг уг эд хөрөнгийг илгээсэн улсын хуулиар;

6) өмчлөх эрхээ хамгаалах тухай эд хөрөнгийн шаардлага гаргасан өмчлөгчийн эрхийг түүний сонгосноор уг эд хөрөнгө байгаа буюу түүнийг бүртгэсэн улсын, эсхүл шүүхэд нь нэхэмжлэл гаргасан улсын аль нэгийх нь хуулиар.

433 дугаар зүйл Хэлцэл ба итгэмжлэл

1. Хэлцлийн хэлбэрийг түүнийг хийсэн улсын хуулиар тодорхойлно.

2. Монгол Улсын хуулийн шаардлагыг хангасан бөгөөд гадаадад хийсэн хэлцлийг зөвхөн хэлбэр зөрчсөн гэх үндэслэлээр хүчин төгөлдөр бус гэж тооцож болохгүй.

3. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байгаа үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой хэлцлийн хэлбэрийг Монгол Улсын хуулиар тодорхойлно.

4. Хэлцэл хийсэн газрыг тогтоох асуудлыг Монгол Улсын хуулиар тодорхойлно.

5. Итгэмжлэлийн хэлбэр, хугацааг түүнийг олгосон улсын хуулиар тодорхойлно. Итгэмжлэл нь Монгол Улсын хуулийн шаардлагыг хангаж байвал зөвхөн хэлбэрийн та-

лаархи шаардлага зөрчсөн гэх үндэслэлээр хүчин төгөлдөр бус гэж тооцож болохгүй.

434 дүгээр зүйл. Гадаад эдийн засгийн хэлцэлд оролцогчдын эрх, үүрэг

1. Гадаад эдийн засгийн хэлцэлд оролцогч талуудын эрх, үүргийг хэлцэл хийх үед болон түүнээс хойш хийсэн хэлэлцээрүүдээр талуудын сонгосон улсын хуулиар тодорхойлно.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар талууд хэрэглэх хуулийг сонгоогүй бол дор дурдсан талын оршин суугаа (оршин байгаа) буюу үйл ажиллагааныхаа голыг явуулдаг улсын хуулиар тодорхойлно:

1) худалдах-худалдан авах гэрээнд худалдагчийн;
2) эд хөрөнгө хөлслөх гэрээнд хөлслүүлэгчийн;
3) хадгалалтын гэрээнд хадгалагчийн;
4) комиссийн гэрээнд комиссийн;
5) даалгаврын гэрээнд даалгавар гүйцэтгэгчийн;
6) тээвэрлэлтийн гэрээнд тээвэрлэгчийн;
7) даатгалын гэрээнд даатгуулагчийн;
8) зээлийн гэрээнд зээлдүүлэгчийн;
9) бэлэглэлийн гэрээнд бэлэглэгчийн;
10) батлан даалтын гэрээнд батлан даагчийн;
11) барьцааны гэрээнд барьцаалуулагчийн.

3. Талууд өөрөөр тохиролцоогүй бол үйлдвэрлэлийн хамтын ажиллагаа явуулах, мэргэшүүлэх, хорших, их бүлгэд нэгдэх, угсрах, бусад ажил гүйцэтгэх гэрээнд нутаг дэвсгэр дээр нь уг үйл ажиллагааг явуулж байгаа буюу эрээний үр дүн бий болж байгаа улсын хуулийг хэрэглэнэ.

4. Гадаад улсын хуулийн этгээд буюу иргэн оролцсон хамтарсан үйлдвэр байгуулах тухай гэрээнд тухайн хамтарсан үйлдвэрийн оршин байгаа улсын хуулийг хэрэглэнэ.

5. Биржийн хэлцэл, үнэ хаялцуулах ажиллагааны үр дүнд байгуулагдсан гэрээнд тухайн биржийн хэлцэл хийсэн буюу үнэ хаялцуулах ажиллагаа явуулсан улсын хуулийг хэрэглэнэ.

6. Энэ зүйлийн 1, 2, 3, 4 дэх хэсэгт заагаагүй бусад гэрээний талуудын эрх, үүрэг нь тухайн гэрээний агуулгад онцлийдвэрлэх ач холбогдол бүхий үүргийг гүйцэтгэж байгаа талын оршин суугаа (оршин байгаа) буюу үйл ажиллагааныхаа голыг явуулдаг улсын хуулиар тодорхойлогдоно.

7. Талууд өөрөөр тохиролцоогүй бол үүргийн гүйцэтгэлийг хүлээн авахад хүлээн авч байгаа улсын хуулийг харгалзан үзнэ.

435 дугаар зүйл. Гэм хор учруулсны улмаас үүсэх үүрэг

1. Гэм хор учруулсны улмаас үүсэх үүргийн талуудын эрх, үүргийг нутаг дэвсгэр дээр нь гэм хор учруулсан үйл баримт буюу гэм хор арилгуулах тухай шаардлага гаргах үндэслэл болсон бусад нөхцөл байдал бий болсон улсын хуулиар тодорхойлно.

2. Гэм хор учруулсны улмаас хилийн чанадад үүссэн үүргийн талууд нь Монгол Улсын иргэн буюу хуулийн этгээд байвал тэдгээрийн эрх, үүргийг Монгол Улсын хуулиар тодорхойлно.

436 дугаар зүйл. Өв залгамжлалд хэрэглэгдэх хууль

1. Өв залгамжлах харилцааг өвлүүлэгч хамгийн сүүлд нутаг дэвсгэр дээр нь байнга амьдран сууж байсан улсын хуулиар зохицуулна.

2. Өвлүүлэгчийн иргэний эрх зүйн эрхийн чадвар, гэрээслэлийн хэлбэр, гэрээслэл хийх ба түүнийг өөрчлөх асуудал нь уг гэрээслэлийг хийх ба түүнийг өөрчлөх үед гэрээслэгчийн байнга амьдран сууж байсан улсын хуулиар тодорхойлогдоно. Харин гэрээслэл хийх ба өөрчлөх нь түүний хийгдсэн улсын хууль ба Монгол Улсын хуулийн шаардлагад тохирч байвал зөвхөн хэлбэрийг баримтлаагүй гэх үндэслэлээр гэрээслэл ба түүнийг өөрчилснийг хүчин төгөлдөр бус гэж тооцож болохгүй.

3. Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа үл хөдлөх эд хөрөнгийг өвлүүлэх явдлыг гагцхүү Монгол Улсын хуулийн дагуу гүйцэтгэнэ. Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа үл хөдлөх эд хөрөнгийг гэрээслэхэд түүний хэлбэр, гэрээслэл хийх ба түүнийг өөрчлөхөд Монгол Улсын хуулийг хэрэглэнэ.

Монгол Улсын Их Хурлын
дарга **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1994 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр

Улаанбаатар хот

ШИНЭЧЛЭН НАЙРУУЛСАН ИРГЭНИЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл. Шинэчлэн найруулсан Иргэний хуулийг 1995 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

2 дугаар зүйл. Иргэний хуулийн 5 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 8 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 22 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 23 дугаар зүйлийн 2, 10 дахь хэсэг, 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 32, 33, 34, 36 дугаар зүйл, 41 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 56 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 77 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 78 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 79 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 86 дугаар зүйлийн 7 дахь хэсэг, 116 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 135 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 141 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 143 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, 222 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 281 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 360 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан харилцааг өөр тухай шинэ хууль батлан гаргах хүртэл хугацаанд уг харилцааг зохицуулж ирсэн хууль, эрх зүйн бусад актын заалтаар зохицуулж байсугай.

Монгол Улсын Их Хурлын дарга

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1994 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр

Улаанбаатар хот

ХУУЛЬ, ХУУЛИЙН ЗААЛТ, ЗАРЛИГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ, ӨӨРЧЛӨХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Шинэчлэн найруулсан Иргэний хууль батлагдсантай холбогдуулан дараахь хууль, хуулийн заалт, зарлигийг хүчингүй болсонд тооцсугай.

1) БНМАУ-ын Ардын Их Хурлын 1963 оны 2 дугаар сарын 9-ний өдрийн тогтоолоор батлагдсан БНМАУ-ын Иргэний хууль;

2) БНМАУ-ын Иргэний хуулийг дагаж мөрдөх журмын тухай БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1963 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн 68 дугаар зарлиг;

3) БНМАУ-ын Иргэний хуулийн 359 дүгээр зүйлд өөрчлөлт оруулах тухай БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1970 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 212 дугаар зарлиг;

4) БНМАУ-ын Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1974 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн 271 дүгээр зарлиг;

5) БНМАУ-ын Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1990 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн БНМАУ-ын хууль;

6) БНМАУ-ын Иргэний хуульд нэмэлт оруулах тухай 1991 оны 6 дугаар сарын 3-ны өдрийн БНМАУ-ын хууль;

7) Гэр бүлийн хуулийн 16, 17, 18, 19, 20 дугаар зүйл;

8) Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 82 дугаар зүйлийн 1-ийн 1 дэх заалтаас «5» гэснийг.

2 дугаар зүйл. Улсын нотариатын хуулийн 16 дугаар зүйлийн 5-ын «46 дугаар» гэснийг «61 дүгээр» гэж, 45 дугаар зүйлийн «398 дугаар» гэснийг «421 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт» гэж, 51 дүгээр зүйлийн «388—390 дүгээр» гэснийг «415 дугаар» гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг 1995 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Монгол Улсын Их Хурлын дарга **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1994 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр

Улаанбаатар хот

ТОГТООЛ, ЗАРЛИГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. «БНМАУ-ын газар эдэлбэрийн хуулийг батлах тухай» БНМАУ-ын Ардын Их Хурлын 1971 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн тогтоол, «БНМАУ-ын газар эдэлбэрийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай» БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1983 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 248 дугаар зарлигийг Газрын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн түс тус хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Их Хурлын дарга **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

994 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газрын тухай уулийн 11 дүгээр зүйлийн 6 дахь хэсгийг дор дурдсанаар өрчлөн найруулсугай:

«6. Дархан цаазат газар болон байгалийн цогцолборт азрын хамгаалалтын горим, дүрэгалт болон нөөц газрын илийн заар, хамгаалалтын горим тогтоож, бичлэлтийг нь охион байгуулна.»

2 дугаар зүйл. Энэ хуулийг Тусгай хамгаалалттай газар утгийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн агаж мөрдөнө.

Монгол Улсын Их Хурлын дарга **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1994 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр

Улаанбаатар хот

ЗАРЛИГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. «Говийн их дархан газрын статус батлах тухай» БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1976 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 283 дугаар зарлигийг Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Их Хурлын дарга **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1994 оны 12 дугаар сарын 05-ны өдөр

Улаанбаатар хот

АГААРЫН ЗАЙД НИСЛЭГ ҮЙЛДЭХ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Агаарын зайд нислэг үйлдэх тухай Монгол Улсын хуулийн 3 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 7 дахь хэсэг нэмсүгэй:

«7. «Байлдааны зорилалттай агаарын хөлөг» гэж дайны зорилалтаар ашиглахаар үйлдвэрлэсэн зэвсэг, галт хэрэгсэл, тусгай төхөөрөмжөөр тоноглогдсон нисэх хэрэгслийг хэлнэ.»

2 дугаар зүйл. Мөн хуулийн 28 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 3 дахь хэсэг нэмсүгэй:

«3. Зэвсэгт хүчин, бусад цэрэгт байгаа иргэний агаарын хөлгийг энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан зориулалтаар ашиглаж болно.»

Монгол Улсын Их Хурлын дарга **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1994 оны 12 дугаар сарын 08-ны өдөр

Улаанбаатар хот

ХӨДӨЛМӨРИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хөдөлмөрийн хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 37 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 44 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг:

«1. Хөдөлмөрийн гэрээнд өөрөөр заагаагүй бол ажилтан нь ажлаас халагдах тухай өргөдлөө захиргаанд өгсөн өдрөөс хойш нэг сар өнгөрмөгц уг гэрээг цуцлагдсанд тооцно.»

37 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

«3. Төсөвт байгууллагын ажилтны хөдөлмөрийн хөлсний сүлжил, жишгийг Засгийн газар; бусад байгууллага, аж ахуйн нэгжийн ажилтны хөдөлмөрийн хөлсний сүлжил, жишгийг үйл ажиллагааныхаа үр дүн, хөрөнгийн бололцоог харгалзан тухайн байгууллага, аж ахуйн нэгжийн захиргаа тус тус тогтооно.»

44 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг:

«1. Ажилтны буруу биш шалтгаанаар гарсан сул зогсолтын хугацаанд түүнийг өөр ажилд шилжүүлэх боломжгүй бол хөлсийг хамтын гэрээнд заасан хэмжээгээр олгоно.

Хамтын гэрээнд заасан сул зогсолтын хөлсний хэмжээ нь уг ажилтны үндсэн тарифт хөлсний 60 хувиас болон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс доогуур байж болохгүй.»

2 дугаар зүйл. Хөдөлмөрийн хуулийн 37 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 6, 7 дахь хэсэг нэмсүгэй:

«6. Улсын үйлдвэрийн газрын даргын болон төрийн өмч давамгайлсан аж ахуйн нэгжийн ерөнхий захирлын хөдөлмөрийн хөлсний жишгийг Засгийн газар, орон нутгийн өмчийн болон уг өмч давамгайлсан аж ахуйн нэгжийн захирал (дарга)-ын хөдөлмөрийн хөлсний жишгийг тухайн шатны Засаг даргын саналыг үндэслэн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид тус тус тогтооно.

7. Эрх бүхий этгээд нь аж ахуйн нэгж, байгууллагын дарга, захирлын хөдөлмөрийн хөлсийг, түүнчлэн захиргаа нь ажилтныхаа хөдөлмөрийн хөлсний сүлжил, жишгийг тогтооход энэ зүйлийн 6 дахь хэсэгт заасан жишгийг үндэслэнэ.»

3 дугаар зүйл. Энэ хуулийг 1995 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Монгол Улсын Их Хурлын
дарга **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1994 оны 12 дугаар
сарын 08-ны өдөр

Улаанбаатар
хот

ИРГЭНИЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Иргэний эрүүл мэндийн даатгалын хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 8 дугаар зүйлийн 1, 5 дахь хэсэг, 12 дугаар зүйлийн 8 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/3 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

«2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан эмнэлгийн төлбөрүй тусламжийн зардлыг улсын төвлөрсөн болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.»

2/8 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

«1. Даатгуулагчийн төлөх хураамжийг дараахь байдлаар тооцно:

1) энэ хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2-т заасан даатгуулагчийн төлөх даатгалын хураамжийн хувь эмэгтэй тэдний хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын 6 хувиас хэтрүүлэхгүйгээр Засгийн газар жил бүр тогтооно;

2) энэ хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2-т заасан хувиараа хөдөлмөр эрхлэгчийн болон аж ахуйн нэгжийн эзний хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоны эхэнд тодорхой бус байвал адилтгах албан тушаалын алингийн зэрэглэлийг баримталж хураамжийг ногдуулан хөдөлмөрийн хөлс, орлогын гүйцэтгэлээр оны эцэст тооцож байна;

3) хувиараа хөдөлмөр эрхлэгч малчны даатгалын хураамжийг энэ зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар тогтоох эгөөд тогтоогдсон хураамжийн 50 хувийг төр хариуцаж, лдэх хэсгийг даатгуулагч өөрөө төлнө.»

3/8 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:

«5. Төсөвт байгууллагын ажилтны даатгалын хураамжийн 50-наас доошгүй хувьтай тэнцэх хөрөнгийг тухайн байгууллагын төсөвт; энэ хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3-т заасан малчны даатгалын хураамжийн 50-наас доошгүй хувьтай тэнцэх хөрөнгийг орон нутгийн төсөвт жил бүр тус тусгана.»

4/12 дугаар зүйлийн 8 дахь хэсэг:

«8. Энэ хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан даатгуулагчид даатгалын сангаас төлөх зардлын дээд хязгаарыг өмнөх жилийн ор хоногийн дундаж зардлаар 156 хоногоос багагүй байхаар тооцож Засгийн газар жил бүр тогтоож байна. Засгийн газраас тогтоосон дээд хэмжээнээс давсан зардлыг энэ хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1—8-д заасан даатгуулагчийн хувьд төрөөс хариуцаж, 1, 2 болон 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3-т заасан даат-

гуулагч өөрөө төлөх буюу сайн дурын нэмэлт даатгалаар нөхөн төлүүлнэ.»

2 дугаар зүйл. Иргэний эрүүл мэндийн даатгалын хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3-т «урьдчилан сэргийлэх тарилга» гэсний өмнө «төлөвлөгөөт» гэж, 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д «аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан» гэсний дараа «, аж ахйун нэгж, байгууллагын болон иргэний малыг тэдэнтэй байгуулсан гэрээний дагуу маллаж байгаа малчин» гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Иргэний эрүүл мэндийн даатгалын хуулийн 8 дугаар зүйлд дараахь агуулгатай 9, 10 дахь хэсэг нэмсүгэй:

«9. Аж ахуйн нэгж, байгууллагын захиргаа нь ажилтныхаа, багийн Засаг дарга нь малчдынхаа эрүүл мэндийн даатгалын хураамжийг бүрдүүлж даатгагчтай тооцоо хийж ажлыг зохион байгуулна.

10. Даатгалын хураамжийг төр бүхэлд нь буюу хэсэгчлэн хариуцаж байгаа иргэн хүсэлтээрээ даатгалын хураамжаа өөрийн хөрөнгөөс бүрэн төлж болно.»

4 дүгээр зүйл. Иргэний эрүүл мэндийн даатгалын хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг болон 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсгээс «хэвтэн (стационарт)» гэснийг, 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн «9/малчин» гэснийг тус тус хасаж, 8 дугаар зүйлийн 2, 6 дахь хэсэгт «7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3—9-д заасан» гэснийг «7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3—8-д заасан» гэж өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Энэ хуулийг 1995 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Монгол Улсын Их Хурлын
дарга **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1994 оны 12 дугаар сарын 9-ний өдөр

Улаанбаатар хот

ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Өмгөөллийн тухай Монгол Улсын хууль батлагдсантай холбогдуулан БНМАУ-ын Ардын Их Хурлын Гэргүүлэгчдийн 1986 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн 127 дугаар зарлигаар батлагдсан Монголын өмгөөлөх байгууллагын тухай БНМАУ-ын хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 1995 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Монгол Улсын Их Хурлын дарга **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1994 оны 12 дугаар сарын 12-ны өдөр

Улаанбаатар хот

ОРЛОГЫГ НЬ ТУХАЙ БҮР ТОДОРХОЙЛОХ БОЛОМЖГҮЙ АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУВИАРАА ЭРХЛЭГЧ ИРГЭНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татварын хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 33, 34, 35 дахь заалт нэмсүгэй:

33. Ердийн хөсгөөр үйлчилгээ хийх	500	300	150	100
34. Малын арьс шир, ноос, ноолуур болон				

бусад түүхий эдийг зуучлан цуглуулж худалдах	4000	3500	2000	1000
35. Савхин болон бусад эдлэл будах	800	600	200	50

2 дугаар зүйл. Энэ хуулийг 1995 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Монгол Улсын Их Хурлын
дарга **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1994 оны 12 дугаар
сарын 12-ны өдөр

Улаанбаатар
хот

БАНКНЫ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Банкны хуулийн 21, 41 дүгээр зүйлийн дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

«21 дүгээр зүйл. Монголбанкны тайлан тэнцэл, орлого, зарлагын төсөв

Монголбанк жил бүр өөрийн үйл ажиллагааны нэгдсэн тайлан тэнцэл, ашгийн хуваарилалт, орлого, зарлагын төсвийг Улсын Их Хуралд батлуулахаар оруулна. Ингэхдээ Засгийн газрын саналыг авсан байна.»

«41 дүгээр зүйл. Банкны санхүүгийн төлөвлөгөө, тайлан тэнцэл

Банк нь санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөгөө, үндэсний тайлан тэнцлээ тогтоосон журмын дагуу гаргаж Монголбанк, санхүүгийн байгууллагад ирүүлэн улсын төсөв мөнгөний үзүүлэлтэд тусгуулж байна. Жилийн тэнцэл ашиг, алдагдлын тайлангийн үзүүлэлт, маягтыг Монголбанк, Сангийн яамнаас тогтооно. Банк нь тайлангийнхаа хураангуйг хэвлэлд нийтлүүлнэ.»

2 дугаар зүйл. Энэ хуулийг 1995 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Монгол Улсын Их Хурлын дарга **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1994 оны 12 дугаар сарын 12-ны өдөр — Улаанбаатар хот

ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Онцгой албан татварын хуулийн 6 дугаар зүйлийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

6 дугаар зүйл. Онцгой албан татварын хувь, хэмжээ

1. Энэ хуулийн 4 дүгээр зүйлд заасан бараанд дараахь хувь, хэмжээгээр онцгой албан татвар ногдуулна:

Онцгой албан татвар ногдуулах барааны нэр, төрөл	Онцгой албан татварын хувь, хэмжээ		
	Эх орны үйлдвэрийн барааны үнэлгээнээс тооцох онцгой албан татварын хувь	Импортын барааны	
		үнэлгээнээс тооцох онцгой албан татварын хувь	нэгжид ногдуулах онцгой албан татвар (төгрөгөөр)
1. Хүнсний спирт	85	—	Литр тутмаас 3000
2. Бүх төрлийн архи	80	—	Литр тутмаас 1500
3. Бүх төрлийн дарс	30	—	Литр тутмаас 200
4. Бүх төрлийн тамхи	—	100	
5. Пиво	—	—	Литр тутмаас 180
6. Автобензин		15	
7. Дизелийн түлш		20	

2. Эх орны үйлдвэрийн хүнсний спирт, бүх төрлийн архи, дарсанд ногдуулах онцгой албан татварын хувь хэмжээг уг бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн ашигт ажиллагааны түвшин, зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, хэрэглээний байдлыг харгалзан Засгийн газар 20 хүртэл нэгжээр хорогдуулж болно.

2 дугаар зүйл. Онцгой албан татварын хуулийн 5 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 5 дахь хэсэг нэмсүгэй:

«5. Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 1-д заасан импортын барааны тогтоосон нэгжид онцгой албан татвар ногдуулна.»

3 дугаар зүйл. Онцгой албан татварын хуулийн 7 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 5 дахь заалт нэмсүгэй:

«5) гаалийн байгууллагаас зорчигчдод татваргүй нэвтрүүлэхийг зөвшөөрсөн хэмжээний хувийн хэрэглээний архи, тамхи.»

4 дүгээр зүйл. Онцгой албан татварын хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн «Импортын барааны . . . » гэснийг «Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2, 4-т заасан импортын барааны . . » гэж, 7 дугаар зүйлийн 3-ын «пиво,» гэснийг «эх орны үйлдвэрийн пиво,» гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Энэ хуулийг 1995 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Монгол Улсын Их Хурлын

дарга **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1994 оны 11 дүгээр сарын 1-ний өдөр | Улаанбаатар хот

Дугаар 76

МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙ ХУУЛЬ БАТЛАГДСАНТАЙ ХОЛБОГДУУЛЖ АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Иргэний хууль батлагдсантай холбогдуулан дараахь арга хэмжээг 1996 онд багтаан авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт даалгасугай.

1) хүчин төгөлдөр мөрдөж байгаа хууль тогтоомжийг Монгол Улсын Иргэний хуульд нийцүүлэх;

2) НҮБ-ын Олон улсын бараа худалдах, худалдан авах гэрээний тухай Венийн конвенцид нэгдэн орох асуудлыг судалж шийдвэрлүүлэх.

2. Монгол Улсын Иргэний хууль батлагдсантай холбогдуулан шинээр батлан гаргах шаардлагатай хуулиудын төслийг 1996 онд багтаан боловсруулж, өргөн мэдүүлэхийг Засгийн газарт даалгасугай.

Дарга **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1994 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр | Улаанбаатар хот

Дугаар 80

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ НЭМЭГДЭЛ БИЙ БОЛГОХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21 дүгээр зүй-

лийн 6 дахь хэсгийн заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Улсын Их Хурлын гишүүний нэмэгдэл бий болгон түүний хэмжээг 12000 төгрөгөөр тогтоож 1995 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн сар бүр олгож байсугай.

Дарга **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1994 оны 12 дугаар Улаанбаатар

Дугаар 83

сарын 01-ний өдөр хот

МОНГОЛ УЛСЫН 1995 ОНЫ ҮЛСЫН ТӨВЛӨРСӨН ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬ БАТЛАГДСАНТАЙ ХОЛБОГДУУЛЖ АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Засгийн газраас өргөн мэдүүлсэн Монгол Улсын 1995 оны улсын төвлөрсөн төсвийн тухай хуулийн төслийг Улсын Их Хурлаар хэлэлцээд ТЭМДЭГЛЭХ нь:

Санхүү, мөнгө зээлийн хүрээн дэх хямрал үргэлжилж, сахилга, хяналт суларч, мөнгөн гүйлгээний дэг журам алдагдаж, дотоодын аж ахуйн хүрээнд төлбөрийн чадвар доройтож, өр зээлийн гинжин холбоо үүсэн төсвийн алдагдал ихсэж байна. Төсвийн орлого тасарч төвлөрсөн төсвөөс орон нутгийн төсөвт болон эрүүл мэнд, нийгмийн даатгалын санд олгох татаасыг хугацаанд нь бүрэн олгож чадахгүй болсноос иргэдийн тэтгэвэр, тэтгэмж болон төсөвт байгууллагын ажилтны цалин хөлсийг олон сараар олгохгүй саатуулж байна.

Бүх шатны гүйцэтгэх байгууллагаас төсвийн гүйцэтгэлд тавих хяналт сулаас төсвийн хөрөнгийг үр ашиггүй зүйлд зарцуулах, төсвийн сахилга зөрчих явдал гарсаар байна.

Төсвийн зарлага, санхүүжилтэд бүтцийн гүнзгий өөрчлөлт хийж төсвийн хөрөнгийн зориулалтыг оновчтой болгох, нийгмийн үр өгөөжийг дээшлүүлэн төвлөрсөн төсвийн алдагдлыг бууруулах нь 1995 онд баримтлах төсвийн бодлогын үндсэн чиглэл мөн гэдгийг онцлон тэмдэглэж Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт даалгасугай:

1) төсвийн орлого, татварын баазыг бэхжүүлэх, татвараас хавтгайруулан хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэхийг багасгах, төлөвлөлтийг оновчтой болгох, орлогын нэмэгдэл эх үүсвэр бий болгох замаар төсвийн гүйцэтгэлийн явцад түүний тэнцлийг сайжруулах;

2) бүх шатны удирдлагын бүтцийг хянан үзэж, ажлын ачааллыг нягтруулах, аппаратын шат дамжлагыг цөөлох, орон тоог хорогдуулах чиглэлээр Улсын Их Хурлын 1994 оны 73 дугаар тогтоолын заалтыг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай санал боловсруулж 1995 оны 1 улиралд багтаан Их Хуралд танилцуулах;

3) төрийн өмч, төсвийн хөрөнгийн хуваарилалт, зарцуулалтад бүх шатны гүйцэтгэх байгууллагаас тавих хяналтыг чангатгах, төсвийн хөрөнгийг үр ашигтүй зүйлд зарцуулах явдлыг таслан зогсоох, түүнчлэн бүх шатны төсөв захирагчдад албан томилолтын болон унааны зардлын лимитийг 1995 оны 1 дүгээр сарын 1-нээс тогтоож хяналт тавих;

4) Завхан, Өмнөговь, Сүхбаатар, Ховд, Хэнтий аймгуудад иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар төсвөө хэлэлцэж батлахаас өмнө төсвийн орлого, зарлагын үзүүлэлтэд газар дээр нь судалгаа хийж орлого нэмэгдүүлэх, төвлөрсөн төсвөөс олгох татаасыг багасгах;

5) төрийн байгууллагад ажиллагсдын цалингийн сүлжээг шинэчлэн тогтоох;

6) сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг ашиглан малчид хөдөөгийн жижиг суурин цахилгаанжуулах асуудлаар тендер зарлаж, төсөл шалгаруулан 1995 оноос хэрэгжүүлж эхлэх;

7) төсвийн орлогын баазыг бэхжүүлж, орлого, татварыг төсөвт бүрэн авах, удирдлагын болон төсөвт байгууллагын давхардлыг арилгах, арвилан хэмнэлтийн хатуу горим тогтоож ажиллах чиглэлээр аймаг, нийслэл, сум,

дүүргийн 1995 оны төсвийг батлуулах зохион байгуулалтын арга хэмжээ авах;

8) амьжиргааны өртгийн өөрчлөлттэй уялдуулан тэтгэврийн хэмжээг өөрчлөх индексийг 1995 онд хагас, бүтэн, жилээр тогтоож мөрдүүлэх;

9) нийгмийн халамжийн сангаас жирэмсний болон амаржсаны тэтгэмж олгох журмыг тогтоож 1995 оны 1 дүгээр сарын 1-нээс мөрдүүлэх.

2. Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн биелэлтийг орон нутагт шалгаж, санхүүжилтийн оновчтой тогтолцоо бүрдүүлэх, санхүүгийн эх үүсвэрийн бүрдэлтийн талаар санал боловсруулж Улсын Их Хуралд танилцуулахыг Засгийн газар, Хүн ам зүй, эрүүл мэнд, хөдөлмөр, нийгэм хангамжийн байнгын хороонд даалгасугай.

3. Монгол Улсын 1995 оны төвлөрсөн төсвийн гүйцэтгэлд болон энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, шаардлагатай арга хэмжээ авч ажиллахыг Төсөв, санхүү, мөнгө, зээлийн бодлогын байнгын хороо (А. Базархүү)-нд даалгасугай.

Дарга **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1994 оны 12 дугаар сарын 1-ний өдөр — Улаанбаатар хот

Дугаар 84

ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 1995 ОНД БАРИМТЛАХ ЧИГЛЭЛИЙГ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Төрөөс мөнгөний бодлогын талаар 1995 онд баримтлах чиглэлийг хавсралт ёсоор баталсугай.

2. Монгол Улсын Засгийн газар, Монголбанкинд даалгах нь:

1) улсын гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх арга хэмжээ авч, гадаад төлбөр, тооцоо, өрийн асуудлыг Улсын Их Хуралд хагас, бүтэн жилээр танилцуулж байсугай;

2) банкны хуучин тогтолцооны үед үүссэн зээл, түүний хүү болон иргэдэд олгосон зээлээс хугацаа хэтэрсэн зээлийг нарийвчлан судлан үзэж тэдгээрийг барагдуулах тодорхой арга хэмжээ авч 1995 оны 7 дугаар сарын 1-ний дотор шийдвэрлэсүгэй.

3. Дор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монголбанкинд даалгасугай:

1) мөнгөний нийлүүлэлтийг удирдах мөнгөний хяналтын шууд аргаас шууд бус аргад шилжихтэй холбогдуулан нийт мөнгө, нөөц мөнгө, мөнгөний үржүүлэгчийн өөрчлөлт, уялдааг оновчтой тогтоож, дахин санхүүжилтийн болон хямдруулалтын цонхны механизмыг нэвтрүүлэх, заавал байлгах нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх, хүүгийн уян хатан бодлого явуулах, үнэт цаас гаргаж, түүний хоёрдогч зах зээлийг нээх зэрэг эдийн засгийн аргаар мөнгөний хяналтыг хэрэгжүүлэх ажлыг эрэлж дараалалтай зохион байгуулах;

2) банкны системийн бүтэц, тогтолцоо, удирдлагыг цаашид боловсронгуй болгох зорилгоор олон улсын санхүүгийн байгууллагаас техникийн туслалцаа авах талаар санал боловсруулах;

3) банкны байгууллагын ажилтан, албан хаагчдын ажлын хариуцлага, сахилга, дэг журмыг бэхжүүлж түүнд тавих хяналтыг эрчимжүүлэх.

4. Монголбанкны эх үүсвэрээс бүрдэж төрийн өмчид байвал зохих валютын гадаад цэвэр нөөцийн доод хэмжээг 25,0 сая ам. доллараар тогтоосугай.

5. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Улсын Их Хурлын Төсөв, санхүү, мөнгө, зээлийн бодлогын байнгын хороо (А. Базархүү)-нд даалгасугай.

Дарга **Н. БАГАБАНДИ**

Монгол Улсын Их Хурлын 1994 оны
84 дүгээр тогтоолын хавсралт

ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 1995 ОНД БАРИМТЛАХ ЧИГЛЭЛ

1995 онд төрөөс баримтлах мөнгөний бодлогын гол зорилго нь үнийн өсөлтийг бууруулах, төгрөгийн худалдан авах чадварыг тогтвортой байлгах, төлбөрийн тэнцлийг сайжруулах, эдийн засаг, нийгмийн хөгжлийн зорилт, улсын төсвийн бодлоготой нягт уялдаж, бүхэлдээ үйлдвэрлэл, үйлчилгээг нэмэгдүүлэх, дэд бүтцийг хөгжүүлэхэд чиглэгдэнэ.

Нэг. Мөнгөний эрэлт, нийлүүлэлтийн талаар

Эдийн засаг дахь мөнгөний эрэлт, нийлүүлэлтийг зохицуулан удирдахад мөнгөний шууд бус хяналтын аргыг өргөн хэрэглэж, 1995 оноос нөөц мөнгөний төлөвлөлтийн зарчмыг мөрдөж эхэлнэ.

Төв банкнаас арилжааны банкинд олгох зээлийн системийг өөрчилж, дахин санхүүжилтийн болон хямдруулалтын цонхны хэлбэрт шилжүүлэн, клирингийн зээлийг багасгах зарчим баримтална.

Заавал байх нөөцийн хэмжээг хангаж ажиллах талаар хуулиар тогтоосон үүргийг арилжааны банкуудаас хэрхэн биелүүлж байгаад тавих хяналтыг хүчтэй болгож, түүнийг тооцох аргачлалыг боловсронгуй болгоно.

Зах зээл дээрх мөнгөний илүүдэл нөөцийг татаж авах зорилгоор Төв банкны үнэт цаасыг арилжааны банкуудад үнэ хаялцуулан худалдах замаар нээлттэй зах зээлийн бодлогыг хэрэгжүүлж эхэлнэ.

Банкны систем дэх дотоодын цэвэр активын нийт хэмжээг 12 дугаар сард 70,5 тэрбум төгрөгөөс хэтрэхгүй, мөнгөний эргэлтийг 3,8 удаагаас доошгүй байхаар бодож, мөнгөний нийлүүлэлтэд тавих хяналтыг зохион байгуулна.

ХОЁР. Зээл, хүүгийн бодлогын талаар

Зээл, хадгаламжийн хүүг үнийн өсөлттэй уялдуулан эерэг түвшинд тогтоох замаар Төв банкнаас хүүгийн нэгдсэн уян хатан бодлого хэрэгжүүлнэ. Инфляцийн түвшин буурахын хэрээр зээл хадгаламжийн хүүгийн түвшинд өөрчлөлт хийж, үйлдвэрлэлийг дэмжих арга хэмжээ авна.

Эдийн засгийн бүтцийн тэргүүлэх чиглэлийн үйлдвэрлэлийг дэмжих, хувийн хэвшлийг цаашид хөгжүүлэхэд зээлийг түлхүү олгох нөхцөл бүрдүүлнэ.

Экспортыг нэмэгдүүлэх, хүнс, өргөн хэрэглээний барааны хангамжийг сайжруулах, ажлын нэмэгдэл байр бий болгох, импортын бүтээгдэхүүнийг орлох үйлдвэрлэл, үйлчилгээг нэмэгдүүлэхэд чиглэсэн үр ашигтай төслүүдийг тэргүүн ээлжинд зээлжүүлэх чиглэл баримтална.

Эргэж төлөгдөх баталгаатай, барьцаатай, хугацаатай, хүүтэй, тодорхой зориулалттай байх зарчмыг баримтлан, үйлдвэрлэлийн орчил, түүний хугацаа, улирлын онцлогийг харгалзан аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд зээлийг олгож, түүнд тавих хяналт шалгалтыг сайжруулж, зээлийг зориулалтын бус байдлаар зарцуулсан тохиолдолд зээл олголтыг зогсоох арга хэмжээ авч зээлийг олон улсын жишигт нийцүүлэн ангилж, чанаргүй зээлийн үлдэгдлийн хэмжээг байнга бууруулан зээлийн нэрлэсэн болон бодит хүүгийн зөрүүг багасгана.

Банкин дахь иргэдийн мөнгөн хадгаламжийн хүүг тооцох аргачлалыг боловсронгуй болгон хадгаламжийн хүүг зар бүр бодож олгодог журмыг арилжааны банк бүрийн үйл ажиллагаанд мөрдүүлнэ.

ГУРАВ. Валютын бодлогын талаар

Гадаад валютын зах зээлийн үйл ажиллагааг гүнзгийрүүлэн хөгжүүлэх, түүний ажиллах чадавхийг сайжруулах, өгрөгийн чөлөөт валюттай харьцах ханшийн бодит байдлыг хангахад чиглэсэн бодлого явуулна.

Монголбанкны валютын нөөцийг нэмэгдүүлж оны эцэст 6,6 сая ам. долларт хүргэнэ. Валютын нөөцийг оновчтой, үр ашигтай байршуулан нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх талаар арилжааны банкуудад туслалцаа үзүүлнэ.

Гадаад валютыг худалдах, худалдан авах ханшийн зөөлөн харьцааг тогтоож, гадаад валютын хадгаламжийн хүүг дэлхийн зах зээлийн жишигт ойртуулах арга хэмжээ авна.

Валютын гүйлгээний тайлан, мэдээ гаргах нэгдсэн журам тогтоож мөрдүүлнэ.

ДӨРӨВ. Төлбөр тооцооны талаар

Монголбанк, арилжааны банкийг холбож буй банк дунын мэдээллийн сүлжээг техник, технологи, зохион байгуу-

лалтын хувьд боловсронгуй болгож мэдээлэл дамжуулалтын найдвартай байдал, нууцлалтын түвшинг дээшлүүлнэ.

Монголбанк, арилжааны банкны бүртгэл тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу цогцолбороор нь өөрчилж олон улсын жишигт нийцүүлэх ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

Банкны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналт шалгалт (аудит)-ын тогтолцоо бий болгох эрх зүйн үндсийг бүрдүүлнэ.

Хууль, хяналт, санхүү, банкны болон холбогдох төрийн захиргааны бүх шатны байгууллага хамтран байгууллага хооронд үүссэн дотоодын өр, авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулна.

Бэлэн бус төлбөр тооцоонд нэвтрүүлж эхэлсэн векселийн гүйлгээг өргөжүүлэх, түүний эрх зүйн баталгааг хангах талаар арга хэмжээ авна.

ТАВ. Банкны тогтолцоог боловсронгуй болгож сайжруулах талаар

Арилжааны банкны дүрмийн сан дахь өмчийн оролцоог тогтоож, хувь нийлүүлэгчид оруулсан хөрөнгийн хэмжээгээр банкны үйл ажиллагааг удирдахад идэвхтэй оролцох боломжийг бүрдүүлэн, менежмент сулгай банкны удирдлагыг өөрчилж, банкны үйлчилгээг олон түмэнд улам ойртуулан хөнгөн шуурхай болгож, зээл, тооцоо, банкны бусад ажил үйлчилгээг зохицуулж буй хууль тогтоомж, дүрэм, зааврыг сурталчлах ажлыг сайжруулна.

Хувь нийлүүлэгчдийн зөвлөлөөс арилжааны банкны мөнгө зээлийн бодлогын чиглэлийг тогтоож, түүнийг хэрэгжүүлэх ажлыг арилжааны банкны удирдлага хариуцдаг байх зарчмыг хэрэгжүүлнэ.

Арилжааны банкны төлбөрийн чадварыг харуулсан зохистой харьцааны талаархи үзүүлэлтийг судлан үзэж, цаашид боловсронгуй болгох арга хэмжээ авна.

Арилжааны банкнаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгож байгаа зээлийн алдагдлыг бууруулах зорилгоор зээлийн мэдээллийн санг байгуулна.

Хууль тогтоомжийн хүрээнд Төв банкнаас арилжааны банкны үйл ажиллагаанд тавих хяналтыг хүчтэй болгохын хамт арилжааны банк бүрт дотоодын хяналт шалгалтын алба байгуулж үйл ажиллагааг нь тогтворжуулна.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1994 оны 12 дугаар сарын 2-ны өдөр | Улаанбаатар хот

Дугаар 85

ТЭТГЭВЭР БОДОХ ДУНДАЖ ХӨДӨЛМӨРИЙН ХӨЛСНИЙ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1995—1998 онд тэтгэвэрт гарах иргэн 1990 оноос хойшхи хугацааны хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоосоо тэтгэвэр тогтоолгохоор сонгосон бол түүнд дор дурдсан хугацааны хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджаас тэтгэвэр бодож байхаар тогтоосугай:

1) 1995 онд тэтгэвэрт гарах иргэнд ажилласан сүүлийн 3 жилийн доторхи дараалсан 12 сарын дундаж хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос;

2) 1996 онд тэтгэвэрт гарах иргэнд ажилласан сүүлийн 3 жилийн доторхи дараалсан 24 сарын дундаж хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос;

3) 1997—1998 онд тэтгэвэрт гарах иргэнд ажилласан сүүлийн 5 жилийн доторхи дараалсан 36 сарын дундаж хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос.

Дарга **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1994 оны 12 дугаар сарын 5-ны өдөр | Улаанбаатар хот

Дугаар 86

НОРМАТИВ ТОГТООХ ТУХАЙ

Нийгмийн даатгалын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн

2 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогоос нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх нормативыг тухайн жилийн нийгмийн даатгалын шимтгэлийн нийт орлогын 2,0 хувиар тогтоосугай.

Дарга **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1994 оны 12 дугаар Улаанбаатар

Дугаар 88

сарын 6-ны өдөр хот

ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТИЙН ТУХАЙ

Монгол Улсын Ерөнхий прокурор Үндсэн хууль зөрчсөн, Прокурорын байгууллагын тухай хууль Үндсэн хууль зөрчсөн тухай Үндсэн хуулийн цэцийн 1994 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн дүгнэлтийг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Прокурорын байгууллагын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 6, 2 дахь хэсгийн заалт Үндсэн хуулийн 56 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг зөрчөөгүй гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

2. Монгол Улсын Ерөнхий прокурор Н. Ганбаяр Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 12 дахь заалт, 56 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчсөн тухай Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хууль зүйн үндэслэлгүй гэж үзсүгэй.

Дарга **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1994 оны 12 дугаар сарын 6-ны өдөр | Дугаар 89 | Улаанбаатар хот

ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТИЙН ТУХАЙ

БНМАУ-ын Засгийн газрын 1991 оны 169 дүгээр тогтоолын зарим заалт Үндсэн хууль зөрчсөн тухай Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

«Засгийн газрын 169 дүгээр тогтоолтой холбогдсон маргааныг хянан хэлэлцсэн тухай» Үндсэн хуулийн цэцийн 1994 оны 08 дугаар дүгнэлтийн дүгнэх хэсгийн 1-д заасныг хүлээн зөвшөөрсүгэй.

Дарга **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1994 оны 12 дугаар сарын 6-ны өдөр | Дугаар 90 | Улаанбаатар хот

ӨРШӨӨЛ ҮЗҮҮЛЭХ ХУУЛИЙН ТУХАЙ

Улсын Их Хурлын гишүүн С. Зориг, Г. Ганболд нарын санаачилсан Өршөөл үзүүлэх тухай хуулийн төслийг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 7 дахь заалтын «б»-д заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Өршөөл үзүүлэх тухай хууль гаргах шаардлагагүй гэж үзсүгэй.

Дарга **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1994 оны 12 дугаар сарын 06-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар 91

ШАЛГАЛТЫН ДАГУУ АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Улсын Их Хурлын 1994 оны 73 дугаар тогтоолын дагуу 1994 оны улсын төвлөрсөн төсвийн зарцуулалт, хуваарилалтын байдлыг Сангийн яаманд шалгасан шалгалтын дүнгийн тухай Төсөв, санхүү, мөнгө-зээлийн бодлогын байнгын хорооны мэдээллийг Монгол Улсын Их Хурлаар хэлэлцээд ТЭМДЭГЛЭХ нь:

Монгол Улсын 1994 оны улсын төвлөрсөн төсвийн тухай хуулийн дагуу Засгийн газраас төсвийн орлого, зарлагийг улирлаар тооцон төлөвлөж, үүний үндсэн дээр төсвийн гүйцэтгэлийг зохион байгуулан ажиллаж байна.

Гэвч улсын төвлөрсөн төсвийн гүйцэтгэлийг зохион байгуулах ажилд багагүй зөрчил, дутагдал оршиж байгаа нь шалгалтаар илэрсэн байна.

Засгийн газар Монгол Улсын Төсвийн тухай хуулиар Засгийн газрын төслийг хэрэгжүүлэх хүрээнд төсвийн хөрөнгийг эргэж төлөгдөх нөхцөлөөр ашиглуулах талаар олгогдсон эрх хэмжээг хэтрүүлэн журам тогтоон мөрдүүлж, уг журмын хэрэгжилтэд тавих хяналтыг орхигдуулснаас их хэмжээний мөнгийг эргэж төлөгдөх төсвийн хөрөнгө гэсэн нэрээр олон аж ахуйн нэгж, байгууллагад бага хүүтэй удаан хугацаагаар судалгаа, тооцоо муутай олгосон байна.

Энэ нь төсвийн хөрөнгийг зориулалт бусаар ашиглах, зарим тохиолдолд зээлийн гэрээнд заагдаагүй зориулалтаар хувь хүн, хувийн компани улсын хөрөнгөөр бизнес хийх боломж олгожээ.

Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах зорилгоор Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Засгийн газар, түүний байгууллагуудын үйл ажиллагаанд илэрсэн зөрчил, дутагдлыг холбогдох албан тушаалтнуудын ажлын хариуцлагатай холбон Засгийн газрын танхимын хуралдаанаар хэлэлцэж санал дүгнэлтээ болон шалгалтын мөрөөр авсан арга хэмжээний тухайгаа Улсын

Их Хурлын чуулганы хуралдаанд 1994 оны 12 дугаар сарын 15-ны дотор танилцуулахыг Монгол Улсын Ерөнхий сайд (П. Жасрай)-д үүрэг болгосугай.

Дарга **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1994 оны 9 дүгээр сарын 09-ний өдөр

Улаанбаатар хот

Дугаар 112

Н. БАВУУГ ЭЛЧИН САЙДААР ТОМИЛОХ ТУХАЙ

Монгол Улсаас Оросын Холбооны Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдаар Надмидын Бавууг томилсугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч **П. ОЧИРБАТ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1994 оны 9 дүгээр сарын 09-ний өдөр

Улаанбаатар хот

Дугаар 114

Д. ЦАХИЛГААНЫГ ЭЛЧИН САЙДААР ТОМИЛОХ ТУХАЙ

Монгол Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдаар Дагвын Цахилгааныг томилсугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч **П. ОЧИРБАТ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1994 оны 9 дүгээр сарын 09-ний өдөр — Улаанбаатар хот

Дугаар 116

Л. УДВАЛЫГ ЭЛЧИН САЙДААР ТОМИЛОХ ТУХАЙ

Монгол Улсаас Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдаар Лувсанжамцын Удвалыг томилсугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч — П. ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1994 оны 9 дүгээр сарын 10-ны өдөр — Улаанбаатар хот

Дугаар 117

Х. ДАМДИНД МОНГОЛ УЛСЫН УРЛАГИЙН ГАВЬЯАТ ЗҮТГЭЛТЭН ЦОЛ ОЛГОХ ТУХАЙ

Кино урлагийн байгууллагад үр бүтээлтэй ажиллаж зэгчдийн талархал хүлээсэн уран сайхны болон баримтат олон арван киног мэргэжлийн өндөр төвшинд урлан бүтээж, монголын кино урлагийн санг арвижуулан, залуу уран бүтээлчдийг сургаж дадлагажуулахад оруулж байгаа хувь эмрийг нь үнэлж Улсын киноны төв нэгтгэлийн кино найруулагч Халтарын Дамдинд Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн цол олгосугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч — П. ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1994 оны 9 дүгээр сарын 10-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар 118

Ц. ҮЕНЧИД МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ЖҮЖИГЧИН ЦОЛ ОЛГОХ ТУХАЙ

Төв, орон нутгийн урлагийн байгууллагад үр бүтээлтэй ажиллаж, бүжигчин, жүжигчин, дуучны мэргэжлийг чадамгай эзэмшиж улсын хэмжээний уралдаан тэмцээнд удаа дараа тэргүүн байранд шалгаран ирэн бүтээлийн өндөр амжилт гаргаж, эх орныхоо соёл, урлагийг дотоод, гадаадад сурталчлахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Монголын үндэсний соёл, амралтын хүрээлэнгийн «Түмэн эх» чуулгын гоцлол дуучин Цэндийн Үенчид Монгол Улсын гавьяат жүжигчин цол олгосугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч **П. ОЧИРБАТ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1994 оны 9 дүгээр сарын 10-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар 119

Л. ОЮУНД МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ЖҮЖИГЧИН ЦОЛ ОЛГОХ ТУХАЙ

Дуулах урлагийг чадамгай эзэмшиж, ардын болон зохиолын дуу дуулаачдын улсын уралдаанд удаа дараа тэргүүн байранд шалгарч, эх орныхоо соёл, урлагийг гадаад орнуудад амжилттай сурталчлан төв, хөдөөгийн хөдөлмөрчид, малчид, тариаланчдад урлагаар байнга үйлчлэн, сайн дурын ирэн сайханчаас өндөр мэргэшлийн гоцлол дуучин

болтлоо олон жил үр бүтээлтэй хөдөлмөрлөж байгааг нь үнэлж Сэлэнгэ аймгийн «Сэлэнгийн долгио» чуулгын гоцлол дуучин Лхүндэвжанцангийн Оюунд Монгол Улсын гавьяат жүжигчин цол олгосугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч **П. ОЧИРБАТ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1994 оны 9 дүгээр сарын 17-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар 120

Б. АЛАГААД МОНГОЛ УЛСЫН ОЙН ГАВЬЯАТ АЖИЛТАН ЦОЛ ОЛГОХ ТУХАЙ

Ой, модны үйлдвэрлэлийн салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэх, мод үржүүлгийн ажлыг зохих технологийн дагуу хийж ойг нөхөн сэргээх, хөдөлмөрийн хамт олныг төлөвшүүлэн бүрдүүлэх, ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь өндрөөр үнэлж Дархан-Уул аймгийн Шарын гол дахь Ой, модны үйлдвэрлэлийн «Баялаг» хувьцаат компанийн ерөнхий захирал Бат-Өлзийн Алагаад Монгол Улсын ойн гавьяат ажилтан цол олгосугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч **П. ОЧИРБАТ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1994 оны 9 дүгээр сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар 123

Т. ЧИМЭДДОРЖИЙГ ЭЛЧИН САЙДААР ТОМИЛОХ ТУХАЙ

Монгол Улсаас Мьянмарын Холбооны Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдаар Тэрбишийн Чимэддоржийг томилсугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч П. ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1994 оны 10 дугаар сарын 14-ний өдөр

Улаанбаатар хот

Дугаар 129

САНААЧИЛГЫГ ДЭМЖИХ ТУХАЙ

Нэг. Монголын үндэсний соёл иргэншлийн түүхэн дэвшилттэй уламжлал, ёс заншлыг судлан сурталчилж сэргээх, тэдгээрийг нийт хүн төрөлхтний соёл иргэншлийн дээжистэй зохистой хослуулан хөгжүүлэх, ард түмний уе үеийнхний хүйн холбоог бэхжүүлэх талаар Монголын «Өв уламжлал-ёс заншил» хөдөлгөөн, Монгол Улсын Шинжлэх ухааны академиас гаргасан санаачилга, эдгээр байгууллагаас зохион байгуулсан «Өв уламжлал-ёс заншил» сэдэвт эрдэм шинжилгээ-практикийн бага хурлаас гаргасан «Үндэсний уламжлал-ёс заншлын асуудлаар түмэн олноо толилуулан эрмэлзэх зүйл хэмээсэн бичиг»-ийн үзэл санааг дэмжсүгэй.

Хоёр. Дурдсан асуудлаар монголын «Өв уламжлал-ёс заншил» хөдөлгөөн, Монгол Улсын Шинжлэх ухааны

академиас зохиож буй ажлыг бүх талаар дэмжин тэдэнд туслах, тэдэнтэй хамтран ажиллах, өөрсдөө санаачлан тодорхой үйл ажиллагааг идэвхтэй өрнүүлэхийг төр, олон нийт, шашин, аж ахуйн бүх байгууллага, иргэдэд уриалсугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч **П. ОЧИРБАТ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1994 оны 10 дугаар Улаанбаатар

Дугаар 130

сарын 14-ний өдөр хот

Л. САНЖААД МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ГАВЬЯАТ ЭМЧ ЦОЛ ОЛГОХ ТУХАЙ

Эрүүл мэндийн байгууллагад үр бүтээлтэй ажиллаж хүүхдийн хоол боловсруулах эрхтэн, бөөр давсагны мэс заслын маһай оронд урьд өмнө хийгдэж байгаагүй нарийн өвөгтэй аргуудыг эмчилгээний практикт амжилттай нэвтрүүлж, олон мянган хүүхдийг эмчлэн эдгэрүүлж, тэдний эрүүл мэндийг хамгаалахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Эх нялхсын эрдэм шинжилгээний төвийн хүүхдийн мэс заслын клиникийн ерөнхий зөвлөх эмч Лувсанийн Санжаад Монгол Улсын хүний гавьяат эмч цол олгоугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч **П. ОЧИРБАТ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1994 оны 10 дугаар сарын 25-ны өдөр — Улаанбаатар хот

Дугаар 140

И. ОЧИРБАЛЫГ ЭЛЧИН САЙДААР ТОМИЛОХ ТУХАЙ

Монгол Улсаас Арабын Бүгд Найрамдах Египет Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдаар Ишцогийн Очирбалыг томилсугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч **П. ОЧИРБАТ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1994 оны 10 дугаар сарын 25-ны өдөр — Улаанбаатар хот

Дугаар 141

Б. ШҮХЭРТЭД МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ЭДИЙН ЗАСАГЧ ЦОЛ ОЛГОХ ТУХАЙ

Банкны байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж чөлөөт хөрөнгийн үлдэгдлийг төвлөрүүлэн урт хугацаат зээлийн сан байгуулж олон арван шинэ үйлдвэрийг ашиглалтад оруулах, сүүлийн жилүүдэд байгуулагдсан хар төмөрлөг, алтны болон бусад үйлдвэр, объектыг байгуулахад зээл санхүүгийн туслалцаа үзүүлж банкны зээлийн хөрөнгийг үр ашигтай зарцуулан улсын эдийн засгийн нөөц чадавхийг дээшлүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Хөрөнгө оруулалт, технологийн шинэчлэлтийн банкны харьяа Түлш эрчим банкны орлогч захирал Балжиннямбуугийн Шүхэртэд Монгол Улсын гавьяат эдийн засагч цол олгосугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч **П. ОЧИРБАТ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1994 оны 12 дугаар сарын 06-ны өдөр | Дугаар 155 | Улаанбаатар хот

СЭНГИЙН ЭРДЭНЭД МОНГОЛ УЛСЫН АРДЫН УРАН ЗОХИОЛЧ ЦОЛ ОЛГОХ ТУХАЙ

Уран зохиолын салбарт үр бүтээлтэй ажиллаж, уншигч түмэнд үнэлэгдсэн олон арван өгүүллэг, туужж, роман, кино зохиол туурвиж Монголын уран зохиолд шинэ хэв шинжийн реализмыг гүнзгийрүүлэх, үргэлжилсэн үгийн уянгын болон сэтгэл зүйн богино хэлбэрийн зохиолыг хөгжүүлэхэд жинтэй хувь нэмэр оруулж байгаат үнэлж Сэнгийн Эрдэнэд Монгол Улсын Ардын уран зохиолч цол олгосугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч **П. ОЧИРБАТ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1994 оны 12 дугаар сарын 06-ны өдөр | Дугаар 156 | Улаанбаатар хот

ЦЭВЭГЖАВЫН ХАСБААТАРТ МОНГОЛ УЛСЫН СОЁЛЫН ГАВЬЯАТ ЗҮТГЭЛТЭН ЦОЛ ОЛГОХ ТУХАЙ

Уран зохиолын онол, арга зүйн олон ном, сурах бичиг зохион туурвиж дэлхийн нэртэй зохиолчдын шилдэг бүтээлүүдээс орчуулан монгол уншигчдын хүртээл болгож манай ронд утга зохиолын судлал, шүүмжлэлийг хөгжүүлэхэд руулсан хувь нэмрийг нь үнэлж утга зохиолын шүүмчлэгч,

орчуулагч Цэвэгжавын Хасбаатарт Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн цол олгосугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч П. ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1994 оны 12 дугаар сарын 06-ны өдөр

Дугаар 157

Улаанбаатар хот

ДҮГЭРЖАВЫН МААМД МОНГОЛ УЛСЫН СОЁЛЫН ГАВЬЯАТ ЗҮТГЭЛТЭН ЦОЛ ОЛГОХ ТУХАЙ

Уран зохиолын салбарт үр бүтээлтэй ажиллаж уншигч олны талархал хүлээсэн туульсын роман, тууж, өгүүллэг туурвин үргэлжилсэн үгийн зохиолыг хөгжүүлэхэд оруулж буй хувь нэмрийг нь үнэлж Дүгэржавын Маамд Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн цол олгосугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч П. ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1994 оны 10 дугаар сарын 5-ны өдөр | Улаанбаатар хот | Дугаар 173

Ц. ЖИГЖИДЖАВЫН НЭРЭМЖИТ БОЛГОХ ТУХАЙ

Соёлын яам, Сүхбаатар аймгийн Засаг даргын саналыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Монгол Улсын төрийн зүтгэлтэн, Монгол Улсын Ерөнхий сайд асан Цэнгэлтийн Жигжиджавын дурсгалыг мөнхжүүлэх зорилгоор Сүхбаатар аймгийн Халзан сумын 8 жилийн дунд сургуулийг түүний нэрэмжит болгосугай.

Монгол Улсын Ерөнхий сайд **П. ЖАСРАЙ**

Соёлын сайд **Н. ЭНХБАЯР**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1994 оны 10 дугаар сарын 6-ны өдөр | Улаанбаатар хот | Дугаар 175

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Архидан согтуурахтай тэмцэх тухай Монгол Улсын хуулийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. «Архинд донтох өвчтэй хүмүүсийг албадан эмчлэх байгууллагуудын ажиллах журам»-ыг хавсралтын ёсоор батлсугай.

2. Архинд донтох өвчтэй хүмүүсийг албадан эмчлэх байгууллагыг байгуулж ажиллуулах арга хэмжээг зохих нөхцөлийг бүрдүүлсний үндсэн дээр дэс дараатай хэрэг-

жүүлэхийг Эрүүл мэндийн яам (П. НЯМДАВАА), аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд **П. ЖАСРАЙ**

Хууль зүйн сайд **Н. ЛУВСАНЖАВ**

Засгийн газрын 1994 оны 175 дугаар тогтоолын хавсралт

АРХИНД ДОНТОХ ӨВЧТЭЙ ХҮМҮҮСИЙГ АЛБАДАН ЭМЧЛЭХ БАЙГУУЛЛАГУУДЫН АЖИЛЛАХ ЖУРАМ

1. Архинд донтох өвчтэй нь мэргэжлийн эмч нарын дүгнэлтээр тогтоогдсон, бусдын эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг зөрчсөн этгээдийг албадан эмчилгээнд явуулж эмчлүүлэхэд энэхүү журмыг баримтална.

2. Байнга архидан согтуурдаг этгээдийн талаар архинд донтох өвчтэй болсон эсэхийг нь тодруулж дүгнэлт гаргуулах хүсэлтийг сум, баг, хорооны Засаг дарга, аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, цагдаагийн байгууллага, иргэн эмнэлгийн байгууллагад гаргаж болно.

3. Байнга архидан согтуурдаг бөгөөд зөрчил гаргасан этгээдийн талаар архинд донтох өвчтэй болсон эсэх тухайд нь дүгнэлт гаргуулахтай холбогдуулан цагдаагийн байгууллага зохих хуулийн дагуу түүнийг түр албадан саатуулж болно.

4. Цагдаагийн байгууллагаас албадан саатуулсан этгээд архинд донтох өвчтэй эсэхийг нь тогтоосон дүгнэлтийг эмнэлгийн байгууллага 24 цагийн дотор гаргаж өгнө.

5. Бусдын эрх, эрх чөлөөг хохироож, нийтмийн хэв журмыг зөрчсөн, архинд донтох өвчтэй нь тогтоогдсон этгээдийг албадан эмчлэх тухай шийдвэр гаргуулахаар цагдаагийн байгууллага шүүхэд шилжүүлнэ. Ингэж шилжүүлэхдээ эмч нарын дүгнэлт, зөрчлийн тухай тэмдэглэлийг хамт хүлээлгэн өгнө.

Албадан эмчлэх тухай шүүхийн шийдвэр гарсны дараа
агийн байгууллага уг этгээдийг албадан эмчилгээ-
байгууллагад дор дурдсан бичиг баримтын хамт хү-
эж өгнө:

шүүхийн шийдвэрийн хуулбар;
мэргэжлийн эмч нарын дүгнэлт;
иргэний писпорт;
эрүүл мэндийн даатгалын дэвтэр.

Иргэний писпортгүй этгээдийг цагдаагийн байгуул-
албадан эмчилгээ хийлгэх хугацаанд багтаан зохих
ын дагуу иргэний бүртгэлд хамруулах арга хэмжээ

Эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй этгээдийн
д албадан эмчлүүлэх хугацаанд багтаан даатгалд
үүлах арга хэмжээг эмнэлгийн байгууллага авна.

Албадан эмчилгээг өвчтөнүүд эмчилгээнээс зайлсхийх
оргох боломж гаргуулахгүй байх шаардлага ханга-
цагдаагийн байгууллагад зохих дэглэмийн дагуу явуулна.
албадан эмчилгээний дэглэмийг Эрүүл мэндийн сайд,
агийн ерөнхий газрын даргын хамтарсан тушаалаар
ж мөрдүүлнэ.

. Цагдаагийн ажилтан нь албадан эмчилгээний дэг-
ийг сахиулах, гэмт хэрэг, хэв журмын зөрчлөөс сэргий-
аардлагын үүднээс Цагдаагийн байгууллагын тухай
д заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

. Эмчлүүлэгчийн ар гэрт гачигдал тохиолдсон тохиол-
түүнд чөлөө олгох эсэх тухай асуудлыг эмнэлгийн
шүүхэд тавьж шийдвэрлүүлнэ.

үүхийн шийдвэрийн дагуу эмчлүүлэгчийн чөлөөтэй
н хугацааг албадан эмчлүүлэх хугацаанд оруулж
хгүй.

. Эмчлүүлэгч нь энэ журам болон эмчилгээний дэглэ-
чанд сахиж, эмчийн зөвлөлгөө, цагдаагийн байгуул-
ажилтны шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.

. Албадан эмчилгээний байгууллага нь эмчлүүлэгчид
ног курс эмчилгээ хийсний дараа үр дүнг эмч нарын
лгөөнөөр хэлэлцээд шаардлагатай бол хугацааг сунган
гээг үргэлжлүүлэх асуудлыг шүүхэд тавьж шийдвэр-
э.

14. Албадан эмчилгээний байгууллага эмчлүүлэгчийн биеийн байдал, эмчилгээний үр дүнг харгалзан эмч нарын зөвлөлгөөнөөс эмчилгээг хугацаанаас нь өмнө зогсоох тухай саналыг шүүхэд тавьж болно.

15. Албадан эмчилгээний байгууллага эмчилгээ дууссан тухай эмчлүүлэгчийг харьяалах нутаг дэвсгэрийн наркологийн кабинет, цагдаагийн байгууллагад мэдэгдэнэ.

16. Эмчлүүлэгч нь асран хамгаалах хүнгүй, гэр орон-гүй, өндөр настай бол эмчилгээ дууссаны дараа эмчилгээ-ний үр дүнг хангах зорилгоор түүнийг зохих асрамжийн газарт шилжүүлэх тухай саналыг албадан эмчилгээний байгууллага нутгийн захиргааны холбогдох байгууллага, албан тушаалтанд тавьж болно.

17. Албадан эмчилгээ хийлгэсэн хүн согтууруулах ундааг үргэлжлүүлэн байнга хэрэглэснээс дахин албадан эмчлүүлэх тохиолдолд түүнийг төлбөртэйгээр эмчилнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1994 оны 10 дугаар сарын 12-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар 176

КОМИССЫГ ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. «Тахийг уугуул нутагт нь сэргээн нутагшуулах үндэсний комисс»-ын үүргийг өргөтгөж тахийг уугуул нутагт нь нутагшуулахаас гадна нэн ховор болон ховордож болзошгүй бусад ан амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх асуудлыг нэмж хариуцуулан тус комиссыг «Монголын ховор амьтныг хамгаалах үндэсний комисс» болгон өөрчлөн зохион байгуулж, комиссын даргаар нь Байгаль орчны сайдыг томилсугай.

2. Монголын ховор амьтныг хамгаалах үндэсний комисс (З. БАТЖАРГАЛ)-т даалгах нь:

а) эрдэм шинжилгээний болон олон нийтийн холбогдох байгууллага, их, дээд сургуультай тохиролцсоны үндсэн дээр эрдэмтэд, мэргэжлийн хүмүүсийг оролцуулан комиссын бүрэлдэхүүнийг 1994 оны 11 дүгээр сард багтаан баталж ажиллуулсугай.

б) өөрийн орны хийгээд гадаад орон, олон улсын ивээн тэтгэгч байгууллага, хүмүүстэй хамтын ажиллагааг өргөтгөх үндсэн дээр нэн ховор болон ховордож болзошгүй ан амьтдыг хамгаалах, өсгөн үржүүлэхэд зориулан хөрөнгийн эх үүсвэр бий болгох, уг хөрөнгийг үр ашигтай зарцуулах арга хэмжээ авч ажилласугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан «Комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай» Засгийн газрын 1991 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн 24 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд **П. ЖАСРАЙ**

Байгаль орчны сайд **З. БАТЖАРГАЛ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1994 оны 10 дугаар Улаанбаатар

Дугаар 177

сарын 12-ны өдөр хот

ТҮЛШ, ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮЙЛДВЭРҮҮДИЙН ТАЛААР АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Түлш, эрчим хүчний үйлдвэрүүдийн хөрөнгө, санхүүгийн байдлаас шалтгаалан 1994—1995 оны өвөлжилтөд ноцтой эрхшээл гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Нүүрсний уурхайнуудын найдвартай ажиллагааг хангахад зориулж 1994 оны сүүлийн улиралд 2000 тонн ди-

зелийн түлшийг 1995 оны эхний хагаст багтаан төлүүлэхээр «Улсын нөөцийн талаар авах арга хэмжээний тухай» Засгийн газрын 1992 оны 57 дугаар тогтоолын 4 дүгээр зүйлд заасан нэмэгдэлгүйгээр улсын нөөцөөс олгохыг Худалдаа, үйлдвэрийн яам (Ц. ЦОГТ)-д зөвшөөрсүгэй.

2. Шарын гол, Багануур, Шивээ-овоогийн нүүрсний уурхайн импортоор авсан тоног төхөөрөмжийн худалдааны албан татварыг чөлөөлөхийн хамт тэдгээр уурхайгаас улсын төсөвт төлөх байгалийн баялаг ашигласны татвар; орлогын болон худалдааны татварыг тухайн уурхайгаас борлуулсан нүүрсний орлого дансанд нь орсны дараа тооцон төлүүлж байхыг Сангийн яам (Д. ДАВААСАМБУУ)-д зөвшөөрсүгэй.

3. Нүүрсний уурхайнуудад Дэлхийн банк, Азийн хөгжлийн банкны зээлийн хөрөнгөөр 1992—1993 онд нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийн үнэ 1317,0 сая төгрөгийг улсын төсвийн хөрөнгө оруулалт хийгдсэнээр тооцож, уурхайнуудын дүрмийн санг дээрх хэмжээгээр нэмэгдүүлэхийг Сангийн яам (Д. ДАВААСАМБУУ), Эрчим хүч, геологи, уул уурхайн яам (Б. ЖИГЖИД)-д даалгасугай.

4. Аймгийн эрчим хүчний үйлдвэрүүдийг дизелийн түлшээр тасалдуулалгүй ажиллуулах, нүүрс таталтыг түргэтгэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор тэдгээр үйлдвэрийн 1994 оны төсвийн санхүүжилтийн дутуут энэ оны 10, 11 дүгээр сард багтаан нөхөн олгохыг Сангийн яам (Д. ДАВААСАМБУУ)-д, энэ оны 10 дугаар сарын 1-ний байдлаар аймгийн эрчим хүчний үйлдвэрүүдээс «Нефть импорт» концернд төлбөл зохих өрөнд дээрх санхүүжилтийг суутган тооцохгүй байхыг Худалдаа, үйлдвэрийн сайд Ц. ЦОГТ, «НИК» хувьцаат компанийн захирал Ж. Оюунгэрэл нарт даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд **П. ЖАСРАЙ**

Эрчим хүч, геологи, уул уурхайн сайд **Б. ЖИГЖИД**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1994 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр | Улаанбаатар хот | Дугаар 191

АЗИЙН СУПЕРКОМПЬЮТЕРИЙН СУДАЛГААНЫ ТӨВ БАЙГУУЛАХ ТУХАЙ

Монгол банктай урьдчилан зөвшөөрөлцсөний үндсэн дээр Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. АНУ-ын холбогдох хөрөнгө оруулагчидтай хамтран Монгол Улсад Азийн суперкомпьютерийн судалгааны төв байгуулах тухай Үндэсний хөгжлийн газрын саналыг зарчмын хувьд зүйтэй гэж үзсүгэй.

2. АНУ-ын Засгийн газрын Экспорт-импорт банкнаас Банкерз Траст банкинд гаргаж өгсөн зээлийн баталгаанд Монгол Улсын Засгийн газрын нэрийн өмнөөс давхар баталгаа гаргаж өгөхийг Монгол банк (Д. МОЛОМЖАМЦ)-д зөвлөсүгэй.

Монгол Улсын Ерөнхий сайд — **П. ЖАСРАЙ**

Монгол Улсын шадар сайд — **Ч. ПҮРЭВДОРЖ**

Монгол Улсын сайд бөгөөд Үндэсний хөгжлийн газрын дарга — **Ч. УЛААН**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1994 оны 12 дугаар сарын 21-ний өдөр | Улаанбаатар хот | Дугаар 212

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Нийгмийн даатгалын тухай хуулийн 32 дугаар зүйл, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр,

тэтгэмжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

«Даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөх, тэтгэвэр, тэтгэмж тогтоолгох хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын бүрэлдэхүүн, дунджийг тодорхойлох журам»-ыг 1 дүгээр хавсралтын, «Нийгмийн даатгалын шимтгэл төлснөөр тооцогдох хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлөх журам»-ыг 2 дугаар хавсралтын ёсоор тус тус батлагдсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд **П. ЖАСРАЙ**

Хүн амын бодлого хөдөлмөрийн сайд **Э. ГОМБОЖАВ**

Засгийн газрын 1994 оны 212 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

ДААТГУУЛАГЧИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ ТӨЛӨХ, ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ ТОГТООЛГОХ ХӨДӨЛМӨРИЙН ХӨЛС, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ОРЛОГЫН БҮРЭЛДЭХҮҮН, ДУНДЖИЙГ ТОДОРХОЙЛОХ ЖУРАМ

1. Даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөх, тэтгэвэр, тэтгэмж тогтоолгох хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын бүрэлдэхүүн, дунджийг тодорхойлоход энэхүү журмыг баримтална.

2. Нийгмийн даатгалын шимтгэл ногдуулах хөдөлмөрийн хөлсний бүрэлдэхүүнд дараахь үндсэн болон нэмэгдэл хөлс, шагналыг оруулж тооцно:

а) эрх бүхий байгууллагаас тогтоосон хөдөлмөрийн хөлс (цалин);

б) хөдөлмөрийн гэрээнд тохиролцсоны дагуу тухайн ажилтны авч байгаа хөдөлмөрийн үндсэн болон нэмэгдэл хөлс;

в) ажил мэргэжил, цол, хөдөлмөрийн хүнд, хортой болон халуун, газрын доорхи нөхцөл, бүс нутаг зэргийг харгалзан хууль тогтоомжийн дагуу олгож байгаа бүх төрлийн нэмэгдэл хөлс;

г) хөдөлмөрийн хөлсний болон шагналын сангаас үйлдвэрлэл, үйлчилгээ, ажлын үр дүнг харгалзан сар, улирлаар олгосон шагнал;

д) иргэд хоорондын гэрээгээр тохиролцсон хөдөлмөрийн үндсэн болон нэмэгдэл хөлс, шагнал;

е) тус улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаагаа явуулж байгаа гадаадын байгууллага, аж ахуйн нэгжид ажилладаг Монгол Улсын иргэний валютаар болон төгрөгөөр авсан хөдөлмөрийн үндсэн болон нэмэгдэл хөлс, шагнал;

ж) Монгол Улстай нийгэм хангамжийн салбарт хамтран ажиллах гэрээ бүхий гадаад оронд хувийн журмаар ажиллаж байгаа иргэний валютаар авсан хөдөлмөрийн үндсэн болон нэмэгдэл хөлс.

3. Нийгмийн даатгалын шимтгэл ногдуулах хөдөлмөрийн хөлстэй адилтгах орлого, түүний бүрэлдэхүүнд дараахь орлогыг оруулан тооцно:

а) хувиараа хөдөлмөр эрхлэгчид, чөлөөт уран бүтээлчдийн олсон нийт орлогын хөдөлмөрийн хөлсөнд ногдох хэсэг;

б) хувийн аж ахуйгаас бусдад бөрлуулсан бүтээгдэхүүний орлогын хөдөлмөрийн хөлсөнд ногдох хэсэг;

в) үндсэн ажил, үүргээс гадуур байгууллага, иргэдтэй гэрээгээр гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хөлс, орлого;

г) зохиол, уран бүтээлийн тоглолтын орлогоос уран бүтээлчдэд олгосон шагнал;

д) ээлжийн амралтын цалин хөлс, жирэмсний, амаржсаны болон хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж;

е) аж ахуйн нэгжээс ажиллагчдынхаа байр, орон сууц, унаа, хоол, түлээ, нүүрсний үнийн талаар үзүүлж буй хөнгөлөлт зэрэг хөдөлмөрийн хөлстэй адилтгах бусад орлого.

Энэ журмын 2 дугаар зүйлийн «е», «ж»-д заасны дагуу гадаад орны валютаар авсан хөдөлмөрийн хөлсийг Монгол банкнаас тухайн үед тогтоосон ханшаар төгрөгт шилжүүлэн тооцож шимтгэл ногдуулна.

4. Улсын төсвөөс зардлыг нь санхүүжүүлэн гадаад

оронд ажиллуулж байгаа Монгол Улсын байгууллага ажилладаг иргэдийн хувьд хөдөлмөрийн хөлсийг нь Монгол Улсын адилтгах албан тушаалын үндсэн ба нэмэгдэл шагналын хэмжээгээр авч үзэж тооцно.

5. Аж ахуйн нэгж, байгууллага ажиллагчдадаа бүтээгдэхүүнээр тооцож хөдөлмөрийн хөлсийг нь олгох тохиолдолд бичиг зүйлийг тухайн орон нутгийн бирж үнээр төгрөгт шилжүүлж шимтгэл ногдуулах хөдөлмөрийн хөлсийг тооцно.

6. Энэ журмын 3 дугаар зүйлийн «а», «б», «в» хэсэгт заасан орлогын хөдөлмөрийн хөлсөнд ногдох хэсгийг дорхойлохдоо нийт орлогоос нь бүх төрлийн материал зардал (түүхий эд, үндсэн болон туслах материал, хэрэг боловсруулсан зүйл, уур, ус, эрчим хүч, түлш, шатах сэлбэг хэрэгсэл, сав, баглаа боодол), татвар, шимтгэл -раамж, төлбөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ хөлсийг хасаж тооцно.

7. Энэ журмын 5 дугаар зүйлд заасны дагуу тооц хөдөлмөрийн хөлсөнд ногдох орлогын хэсэг нь Засг газраас тогтоон тухайн үед мөрдүүлж буй хөдөлмөр хөлсний доод хэмжээнээс бага буюу түүнийг тооцож ломжгүй нөхцөлд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ тооцож шимтгэл ногдуулахаар гэрээгээр тохиролцож б

8. Тэтгэвэр бодох хөдөлмөрийн хөлс, түүнтэй адил орлогын дунджийг тодорхойлохдоо Нийгмийн даатга сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 22 ду зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан журмаар тооцно.

Засгийн газрын 1994 оны 21
гаар тогтоолын 2 дугаар хав

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ ТӨЛСНӨӨ ТООЦОГДОХ ХУГАЦААНД НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ ТӨЛӨХ ЖУРАМ

1. Тэтгэврийн болон тэтгэмжийн даатгалын шимтгэ ажил олгогчоос болон даатгуулагч өөрөө төлсөн нийт цааны дээр шимтгэл төлсөн хугацаанд оруулан тооц

хуульд заасан бусад хугацааг нэмж тооцоход энэхүү журмыг баримтална.

2. Нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацаанд оруулан тооцохоор хуульд заасан хугацааны шимтгэлийг төлөх дөө дараахь журмаар тооцож тэтгэврийн болон тэтгэмжийн даатгалын санд оруулна:

а) хөдөлмөрийн гэрээгээр ажиллагч болон төрийн албан хаагч тухайн аж ахуйн нэгж, байгууллагын захиалгаар ажлаас чөлөөлөгдөж өмчийн хэлбэр харгалзахгүйгээр их дээд сургууль, коллеж болон мэргэжил дээшлүүлэх болгох курст суралцаж байгаа бол суралцах хугацааны жилд ногдох шимтгэлийг Засгийн газраас тогтоон мөрдүүлж буй хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцон ажил олгогчийн төлбөл зохих хувиар бодож захиалгаар суралцуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага нь жил бүрийн 1 дүгээр сард багтаан даатгалын зохих санд төлнө;

б) цэргийн жинхэнэ албыг байлдагч, түрүүчээр хаасан хугацааны шимтгэлийг Засгийн газраас тогтоон мөрдүүлж буй хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс ажил олгогчийн төлбөл зохих хувиар бодож, тэдний алба хааж буй анги, байгууллага нь нутаг дэвсгэрийн харьяалагдах нийгмийн даатгалын байгууллага (байцаагч)-ын зохих даатгалын санд төлнө. Энэ тохиолдолд нийгмийн даатгалын байгууллага (байцаагч) нь цэргийн албанаас халагдаж буй байлдагч, түрүүчид нийгмийн даатгалын дэвтэр нээн (хуучин дэвтэртэй бол түүн дээр нь) бичилт хийж төлсөн шимтгэлийн хэмжээг баталгаажуулна;

в) хүүхдээ асрахаар тэтгэмжтэй чөлөө авсан эхийн чөлөөтэй байх хугацааны шимтгэлийг аж ахуйн нэгж, байгууллага нь Засгийн газраас тогтоон тухайн үед мөрдүүлж буй хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс ажил олгогчийн төлбөл зохих хувиар тооцож сар бүр даатгалын зохих санд төлнө;

г) хууль бусаар ажлаас зайлуулагдан мөрдөгдсөн, хилс хэргээр хорих ял эдэлсэн даатгуулагчийн уг хугацаанд ногдох шимтгэлийг тухайн даатгуулагчийн хилсээр мөрдөгдөхийн болон ял эдлэхийн өмнө авч байсан хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджаас ажил олгогчийн төлбөл зохих хувиар бодож ажиллаж байсан аж ахуйн нэгж, байгууллага нь нэг удаа нийгмийн даатгалын санд

төлнө. Энэ талаар гарсан маргааныг шүүхээр шийдвэрлүүлнэ;

д) ажиллаагүй үедээ дайчлагдсан даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэлийг Засгийн газраас тогтоон мөрдүүлж буй хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцож ажил олгогчийн төлбөл зохих хувиар бодож тухайн сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын санхүүгийн хэлтэс (тасаг) сар бүр даатгалын зохих санд төлнө;

е) хууль бусаар ажлаас халагдсан хугацааны нийгмийн даатгалын шимтгэлийг тухайн даатгуулагчийн халагдахын өмнө авч байсан хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджаас ажил олгогчийн төлбөл зохих хувиар бодож буруутай этгээд нь уг даатгуулагчийг ажилдаа эргэж орсноос хойш нэг сарын дотор нэг удаа даатгалын зохих санд төлнө.

3. Зэвсэгт хүчин, хилийн болон дотоодын цэрэг, тагнуул, цагдаа, хорих ял эдлүүлэх байгууллагад генерал, офицер, ахлагч, түрүүч, байлдагчаар 10-аас доош жил алба хаасан иргэн өндөр насны тэтгэвэр тогтоолгох насанд хүрч өргөдлөө гаргасан нөхцөлд уг алба хаах хугацаанд төлөгдсөн байвал зохих шимтгэлийг алба хааж байх үеийнх нь хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тооцон тухайн цэргийн анги, байгууллагаас баталгаажуулсан тодорхойлолтыг үндэслэн харьяалагдах сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын санхүүгийн хэлтэс (тасаг) ажил олгогчийн төлсөн байвал зохих шимтгэлтэй тэнцэх хэмжээний хөрөнгийг холбогдох нийгмийн даатгалын байгууллагын даатгалын зохих санд нэг удаа төлнө.

Цэргийн албан хаагчийг цэргийн албанаас халагдах үед ажиллуулж байсан цэргийн анги, байгууллага ажиллаасан хугацааны хөдөлмөрийн хөлсний хэмжээг тодорхойлж баталгаажуулна.

4. Энэ журмын 2 дугаар зүйлийн «б» хэсэгт заасны дагуу олгох хөрөнгийн хэмжээг цэргийн анги, байгууллага; 3 дугаар зүйлийн дагуу олгох хөрөнгийн хэмжээг сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын санхүүгийн хэлтэс (тасаг) тус тус жил бүрийн төсөвтөө тусган олгоно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ТОГТООЛ

1994 оны 12 дугаар сарын 21-ний өдөр

Улаанбаатар хот

Дугаар 221

ХУДАЛДААНЫ ТАЛААР АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Дотоод зах зээлийн тогтвортой байдлыг хангах, худалдааны үйл ажиллагааг сайжруулах зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Нийслэл болон аймгуудад бөөний худалдааны үйлчилгээ зохион байгуулан аймаг, сум, дүүргийн нутаг дэвсгэрт худалдааны байнгын сүлжээ бий болгож тогтвортой ажиллуулахад чиглэсэн дор дурдсан арга хэмжээг Монголын эд хэрэглэгчдийн хоршооллын төв холбооны гүйцэтгэх хороотой хамтран авч хэрэгжүүлэхийг Худалдаа, үйлдвэрийн яам (Ц. ЦОГТ), нийслэл, аймгийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

а) хүн амын хэрэглээний болон үйлдвэрлэлийн зориулалттай бараа, бүтээгдэхүүнийг тогтвортой нийлүүлж хэрэглэгчдэд хүргэх худалдааны сүлжээг бүрдүүлэхэд нийслэл, аймаг, сумын нутаг дэвсгэрт ажиллаж байгаа аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаат чиглүүлэх удирдлага зохион байгуулалтын арга хэмжээг зах зээлийн эдийн засгийн харилцааны зарчимд нийцүүлэн дэс дараатай авч хэрэгжүүлэх;

б) хэрэглээний зүйлийн болон үйлдвэрлэлийн зориулалттай барааны бөөний худалдаат зохион байгуулахтай холбогдуулан нийслэл, аймаг, сум, дүүргийн хэмжээнд гол нэрийн бараа, бүтээгдэхүүнийг бөөнөөр нийлүүлэх хугацаа, хэмжээг тодорхой заасан графикийг мөрдүүлэхийн хамт хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдээс энэ талаар гаргаж буй санаачилгыг дэмжиж ажиллах;

в) мал, мах, ноос, ноолуур, арьс, шир, ангийн үс, үр гариа, төмс, хүнсний ногоог бөөнөөр бэлтгэх, нийлүүлэх ажлыг аймаг, сумын хэмжээнд зохион байгуулж, эдгээр бүтээгдэхүүний борлуулалтыг аль болох бөөний хэлбэрт оруулж бэлтгэлийн зүйлийн чанарыг сайжруулан аж ахуйн нэгжүүд болон хөдөөгийн хүн амын мөнгөн орлогыг нэмэгдүүлэх арга хэмжээ авах;

г) бөөний худалдааны үйлчилгээний хамрах х
үр дүнг аймгийн хэмжээнд улирал бүр дүгнэж, дүнг I
дийн төлөөлөгчдийн хуралд мэдээлж байх.

2. Улсын хэмжээгээр бөөний худалдааг өргөжү
худалдааны үйлчилгээг хүн амд жигд хүргэж, тогтв
явуулах ажлыг дэмжих зорилгоор худалдааны албан
варын жилийн орлогын 20 хүртэл хувиар «Худалдааг
жих сан» байгуулж сангийн хөрөнгийг худалдааны зээ
хэлбэрээр эргэлтэд оруулан ашиглах асуудлыг энэ онд
таан судалж шийдвэрлэхийг Сангийн яам (Д. ДАВААС
БУУ), Худалдаа, үйлдвэрийн яам (Ц. ЦОГТ)-д даалгас

3. Эд хэрэглэгчдийн хоршоодод байгаа гүйлгээгүй б
удаан гүйлгээтэй барааны үлдэгдэлд барьцаалан а
банкны хугацаа хэтэрсэн зээлийн 189,0 сая төгрөгийн ө
асуудлыг Монгол банктай тохиролцон шийдвэрлэхийг
гийн яам (Д. ДАВААСАМБУУ)-д даалгасугай.

4. Бөөний худалдааг дэмжих, улмаар зах зээлийн
тогтлын дагуу дотоод худалдааны тогтвортой сүлжээг
сын хэмжээнд бүрдүүлэхэд банкны зориулалтын зээ
эх үүсвэрийг арилжааны банкуудад тухай бүр гаргаж
байхыг Монгол банк (Д. МОЛОМЖАМЦ)-д зөвлөсүг

5. Хэрэглэгчдийн эрх ашигт нийцүүлэн худалдаа,
чилгээний дэг журам, соёлыг сайжруулах, цаашид ху
дааны үйлчилгээг мэргэжлийн хүнээр эрхлүүлэх зайл
шаардлагыг харгалзан худалдаа, үйлчилгээний мэргэж
боловсон хүчин бэлтгэх, давтан сургах ажлыг Зах зээ
колледжийн болон бусад сургалтын баазад тулгуурла
хион байгуулахыг Шинжлэх ухаан, боловсролын
(Н. ӨЛЗИЙХУТАГ), Худалдаа, үйлдвэрийн яам (Ц. ЦО
нийслэл, аймгийн Засаг дарга нарт даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд **П. ЖАСРАЙ**

Худалдаа, үйлдвэрийн сайд **Ц. ЦОГТ**

Сангийн сайд **Д. ДАВААСАМ**

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

оны 12 дугаар Улаанбаатар

Дугаар 177

1 02-ны өдөр хот

МОНГОЛ УЛСЫН ЗАХИРГААНЫ ХАРИУЦЛАГЫН ТУХАЙ ХУУЛИЙН 30[1] ДҮГЭЭР ЗҮЙЛИЙГ ТАЙЛБАРЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Захиргааны харицуцлагын тухай хуулийн дүгээр зүйлийг нэг мөр ойлгож зөв хэрэглэх зорилгоор гол Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

Монгол Улсын Захиргааны харицуцлагын тухай хуулийн дүгээр зүйлийг дор дурдаснаар тайлбарласугай:

. Энэ зүйлд заасан прокурорын «бүрэн эрх»-д хэрэг гэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт ж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцох үүргийн дагуу Монгол Улсын Прокурорын байгуул- н тухай хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Ир- й хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль болон д хуулиар прокурорт олгосон, эрх хүлээлгэсэн үүргийг оно.

. Мөн зүйлийн «бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь проку- санаатайгаар саад учруулсан» гэдэгт бүрэн эрхээ хэ- үүлэх хүрээнд хуульд нийцүүлэн тавьсан прокурорын длагыг биелүүлээгүй, прокурорт дуудагдсан этгээд этгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй, эсхүл үү хүрэлцэн ирэхэд зориуд саад хийсэн, хяналт тави- шаардлагатай баримт бичиг, мэдээ, судалгааг проку- үзүүлэх, гаргаж өгөхөөс татгалзсан, нуун дарагдуул- устгаж үгүй хийсэн, уг баримт бичгийг хуурамчаар сэн, мэдээ судалгааг зориуд худал ташаа гаргасан прокурор үйл ажиллагаагаа хэвийн явуулах нөхцөл лцоог алдагдуулахад чиглэсэн үйлдэл, эс үйлдэхүйг оно.

. Мөн зүйлийн «. . , хууль бус шийдвэр гаргуулахаар н шаардсан» гэдэгт хуульд заасан бүрэн эрхээ хэрэг- ж буй прокурорт хууль бус шийдвэр гаргах шаардлага р буюу бичгээр тавьж уг шаардлагыг эс биелүүлсэн

бол хуулиар зөвшөөрсөн болон зөвшөөрөгдөөгүй ямар нэг үйл ажиллагаа хариу явуулахаа мэдэгдэж тулгасан шинжтэй үйлдлийг ойлгоно.

4. Мөн зүйлийн «. . - хууль бус шийдвэр гаргуулахаар . - . заналхийлсэн» гэдэгт хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлж буй прокурорыг хууль бус шийдвэр гаргуулахын тулд алах, бие махбодид нь гэмтэл учруулах эд хөрөнгийг нь устгах, түүнчлэн бусад төрлийн хохирол учруулахаар сүрдүүлсэн, биеийн хүчний болон сэтгэл зүйн шинжтэй үйлдлийг ойлгоно.

5. Мөн зүйлийн «. . . хууль бус шийдвэр гаргуулахаар шахалт үзүүлэх» гэдэгт хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлж буй прокурорыг хууль бус шийдвэр гаргуулахаар өөрийнх нь буюу гэр бүлийн гишүүдийн амьд явах, сурах, ажил мэргэжил, оршин суух газар нутгаа чөлөөтэй сонгох болон бусад эрх, эрх чөлөөгөө эдлэх боломжийг хууль бус аргаар алдагдуулахад чиглэсэн үйлдэл, эс үйлдэхүйг ойлгоно.

6. Прокурорыг хууль бус шийдвэр гаргуулахаар тулган шаардсан, занадхийлсэн, шахалт үзүүлсэн зөрчил заавал биелэх боломжтой байсан эсэх, түүнчлэн прокурорт нөлөөлж чадсан эсэх нь зөрчил гаргасан этгээдэд энэ зүйлд зааснаар захиргааны хариуцлага хүлээлгэхэд саад болохгүй. Харин энэ зүйлд заасан зөрчил нь гэмт хэргийн шинжтэй бол тухайн этгээдийг эрүүгийн хуулийн зохих зүйл, хэсэгт зааснаар эрүүгийн хариуцлагад татна.

Ерөнхий шүүгч **Д. ДЭМБЭРЭЛЦЭРЭН**

Шүүгч **Д. БАТСАЙХАН**

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

1994 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар 178

ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН ЗАРИМ ЗҮЙЛД ЗААСАН ГЭМТ ХЭРГИЙН ХАРЬЯАЛЛЫН ТУХАЙ

Эрүүгийн хуулийн 86 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 112 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан гэмт хэргийг хянан шийдвэрлэх шүүхийн харьяаллыг нэг мөр ойлгох явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

1. Эрүүгийн хуулийн 112 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан гэмт хэргийг үйлдсэн гэм бурууtай этгээдэд «. . . наймаас арван таван жил хүртэл хугацаагаар хорих буюу цаазаар авах ял шийтгэнэ» гэж заасан нь Эрүүгийн хуулийн 6 дугаар зүйлийн «г»-д заасан онц хүнд гэмт хэрэгт хамаарах тул уул хэргийг аймаг, нийслэлийн шүүх анхан шатны журмаар хянан шийдвэрлэж байхаар тогтоосугай.

2. 1993 оны 8 дугаар сарын 1-ний өдрөөс өмнө үйлдэгдсэн, Эрүүгийн хууль (1987 оны найруулгын)-ийн 85 дугаар зүйлд зааснаар зүйлчлэгдсэн хэрэг нь Эрүүгийн хуулийн 86 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан бөгөөд онц хүнд гэмт хэрэгт хамаарч байгааг харгалзан уул хэргийг аймаг, нийслэлийн шүүх анхан шатны журмаар хянан шийдвэрлэж байх нь зүйтэй гэж үзсүгэй.

Ерөнхий шүүгч Д. ДЭМБЭРЭЛЦЭРЭН

Шүүгч Д. БАТСАЙХАН

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

Ерөнхий эрхлэгч **Н. Ринчиндорж**
Нарийн бичгийн дарга **Сан. Жаргалсайхан**
Гишүүд **Т. Баасансүрэн**
Ч. Бавуу
Б. Ганбат
Б. Янжинлхам

Техник редактор **Т. Сарантуяа**
Уншиж хянасан **Сан. Жаргалсайхан**
Б. Янжинлхам

Үйлдвэрт шилжүүлсэн 1995 оны 1-р сарын 11-нд. Өрөлтөд 1995 оны 1-р сарын 21-нд. Хэвлэлтэд 1995 оны 3-р сарын 6-нд. Хэвлэлийн хуудас 13,25. Хэвлэсэн тоо 4800 ширхэг.

Засгийн газрын хэвлэх үйлдвэр